



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр, Пүрэв гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	<b>1</b>
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	<b>2-9</b>
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	<b>10-152</b>
<hr/>	
1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	14-51
2. “Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	51-52
3. “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	52-53
4. “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Сонгуулийн ерөнхий хорооноос 2023.10.10-ны өдөр ирүүлсэн саналын дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо боловсруулсан/	53-61
5. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	152

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 19-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Б.Баттөмөр, С.Бямбацогт, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалмаа, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар;

Чөлөөтэй: С.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Д.Өнөрболор, Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Х.Болорчулуун, Г.Дамдинням, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Ш.Раднаасэд;

Хоцорсон: Ж.Бат-Эрдэнэ -06 минут, Б.Баярсайхан -08 минут, Х.Булгантуяа -09 минут, С.Ганбаатар -10 минут, Д.Ганбат -28 минут, Т.Доржханд -08 минут, Б.Жавхлан -02 минут, С.Одонтуяа -02 минут, Д.Сарангэрэл -24 минут, Ж.Сүхбаатар -3 цаг 39 минут, О.Цогтгэрэл -12 минут, Б.Энх-Амгалан -21 минут, Б.Энхбаяр -27 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Пүрэвдорж, Ц.Даваасүрэн нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Пүрэвдорж, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Ганхуяг, Х.Баделхан, Д.Тогтохсүрэн, Г.Амартүвшин, Ц.Сандаг-Очир, М.Оюунчимэг, Ш.Адъяаа, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Н.Ганибал, Ц.Цэрэнпунцаг, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Д.Ганбат, Д.Ганболд нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	23
Бүгд:	51

54.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.*

*Үдийн завсарлагааны цаг болсон тул хуралдаан 13 цаг 02 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 23 минутад эхлэв.*

**Хоёр.** *“Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл*

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** “Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 21  
Бүгд: 50  
58.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:29/

*Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав. “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

“Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 5 өдрийн завсарлага өгөв./14:31/

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын дөрөвдүгээрт оруулж, хэлэлцүүлэх горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32  
Татгалзсан: 19  
Бүгд: 51

62.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

*Дөрөв. “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Сонгуулийн ерөнхий хорооноос 2023.10.10-ны өдөр ирүүлсэн саналын дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо боловсруулсан/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах референт Ж.Оюунгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төслүүдийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Н.Алтанхуяг, Ш.Адъяаа нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран нар хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32  
Татгалзсан: 16  
Бүгд: 48  
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

**Г.Занданшатар:** “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 18  
Бүгд: 49  
63.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

**Г.Занданшатар:** “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 23  
Бүгд: 48  
52.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд М.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Соёлын дэд сайд М.Батбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Х.Хашбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасаням, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Цэвэлмаа, мөн хэлтсийн шинжээч Ш.Гүнсэндарь, мөн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын шинжээч Б.Цэрэнсодном, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэл

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны Ажлын албаны дарга Ц.Батгэрэл, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Оюун-Эрдэнэ, мөн хорооны Хилийн боомтын захиргааны Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Я.Дүгэржав, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, мөн газрын Тариф, татварын газрын гаалийн улсын ахлах байцаагч Д.Ганцэцэг, Татварын ерөнхий газрын Татварын удирдлагын хэлтсийн дарга Д.Цогтжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Алтансүх, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төслийн нэгжийн захирал Ч.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, төсвийн төслийн талаарх төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл тус бүлгийн зүгээс Монгол Улсын Ерөнхий сайдыг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлэгт оролцохыг хүсэж байгаа тухай санал хэлж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ажлын шаардлагын улмаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хуралдаанаас чөлөө авсныг хэлэв.

*Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 15 цаг 35 минутаас хуралдааныг даргалав.*

Илтгэл болон төрийн аудитын төв байгууллагын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Г.Амартүвшин, Д.Ганбат, Ж.Бат-Эрдэнэ, Э.Батшугар, Ц.Мөнхцэцэг, Д.Батлут, Н.Алтанхуяг, О.Цогтгэрэл, Н.Ганибал, Х.Баделхан, Г.Ганболд, Ж.Батжаргал, Б.Баярсайхан, Ш.Адъяаа, Б.Пүрэвдорж, Д.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг, Д.Тогтохсүрэн, Б.Бейсен, Х.Ганхуяг, М.Оюунчимэг, Н.Энхболд, Д.Сарангэрэл, П.Анужин, Н.Наранбаатар, С.Одонтуяа нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Соёлын дэд сайд М.Батбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд М.Ганбаатар, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төслийн нэгжийн захирал Ч.Батзориг нар хариулж, тайлбар хийв.



*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 20 цаг 40 минутаас хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа үг хэлэв.

**Г.Занданшатар:** Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан шаардлагыг хангасан байна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 42  
Бүгд: 50  
16.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан ажлын цаг дуусаж, гишүүдийн ирц танхимд хангалтгүй байгаа тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ажлын цаг дууссан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасны дагуу санал хураалтыг маргаашийн нэгдсэн хуралдаан хүртэл хойшлуулж, хуралдааныг завсарлуулав./20:59/

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын урилгаар Нийслэлийн Баянгол дүүргийн 10 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын “Үй цай” сургуулийн 10А ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Нийслэлийн Баянзүрх дүүргийн Социал демократ залуучуудын холбооны салбар зөвлөлийн гишүүд, Үндэсний номын сангийн ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн урилгаар Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 292 дугаар цэцэрлэгийн багш, ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Туваан, Н.Энхболд нарын урилгаар Төв аймгийн Баян-Өнжүүл сумын эмэгтэйчүүд, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан нарын урилгаар Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн урилгаар Нийслэлийн Баянгол дүүргийн ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” сургуулийн 11Ж ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн урилгаар Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр багийн ахмадууд, Баянхонгор аймгийн Баянцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид болон Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Нийслэлийн Налайх дүүргийн Монгол ардын намын Хяналтын зөвлөлийн гишүүд болон “Хүлэгт” ТББ-ын гишүүд, Нийслэлийн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 9 дүгээр ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн урилгаар Увс аймгийн оюутан, залуучуудын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхцоож нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 9 цаг 30 минут үргэлжилж, 72 гишүүнээс 54 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 20 цаг 59 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 08 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье. Ирц бүрдсэн тул 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя, 6 асуудал хэлэлцэнэ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. 2 дугаарт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ. 3 дугаарт Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. 4-т СЕХ-ны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай, Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүд, 5-д Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлтийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал, 6-д Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, асуудал нэмэх, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргасан бол Улсын Их Хурлын

даргад чуулган хийгдэхээс өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу 3 гишүүн саналаа ирүүлсэн байна. Ингээд Ширнэнбаньдын Адьшаа гишүүн ирүүлсэн бичигт дарааллыг өөрчлөхтэй холбоотой үг хэлэх тул зөвшөөрөл олгоно уу гэсэн санал байна. Ингээд Ширнэнбаньдын Адьшаа гишүүн үг хэлнэ.

**Ш.Адьяа:** Энд хүрэлцэн ирсэн та бүгдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр Монгол Улсын Их Хурал улсын төсвийг хэлэлцэж байна. Энэ төсөвтэй холбоотой олон шийдэх асуудал хуримтлагдсан байгаа. Түүний дотор Эрдэнэс таван толгойн 1072 хувьцаатай холбоотой асуудал өнөөдөр зайлиггүй энэ төсөвтэй уялдаж ярьж шийдэх, шийдэл гаргах асуудлын нэг гэдэг нь энэ бол тодорхой болж нийгэм, олон нийтийн байгууллагууд, иргэд энэ 1072 хувьцааны ноогдол ашгийн тухай, энэ 1072 хувьцааны эзэмшлийн тухай олон асуудал өнөөдөр төрийн бодлогын хэмжээнд шийдэх хамгийн шийдвэр гаргах асуудлын нэг болсон гэдэгтэй та бүгд санал нэг байгаа байх. Монгол Улсын Их Хурлын гишүүнийхээ хууль санаачлах бүрэн эрхийн хүрээнд энэ оны 3 дугаар сард иргэдээс худалдаж авсан ЭТТ-н 1072 хувьцааг иргэддээ буцааж олгож, Монгол Улсын иргэн бүр өмч хөрөнгөтэй байх энэ Үндсэн хуулийнхаа зарчмыг биелүүлэх бодлогын хүрээнд Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн барьсан. Энэ тогтоолын төслийг энэ төсөв батлахтай холбогдуулж мөн түүнчлэн Улсын Их Хурлын гишүүний хууль санаачлах энэ бүрэн эрхийн хүрээнд энэ асуудлыг Улсын Их Хурлын чуулганд хэлэлцүүлэх ийм саналыг би оруулж байна.

ЭТТ-н 1072 хувьцаа гэдэг энэ асуудал өнөөдөр нийгэмд олон шийдлийг хүсэж байгаа. Түүний дотор иргэддээ өмчлүүлсэн гээд байгаа тэр 1072 хувьцааны ноогдол ашгийг олгох асуудлыг энэ улсын төсвийн хууль хэлэлцэх үеэр шийдье. Ингэж шийдэхгүйгээс болж энэ төрийн өмч, өмчид ард түмний хяналт тавих хяналтын механизм чинь алдагдаж

байна. Дээр нь болбол 1072 хувьцаа гэдэг энэ төрийн өмчийн энэ бид нарын өмч хөрөнгөтэй байх энэ Үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлэх энэ бодлогыг энэ Улсын Их Хурал энэ төсвийн үеэр зайлшгүй хэлэлцэж шийдвэрлэх асуудал байгаа. Энийг бид анхааралтай, бодлоготой ард иргэдийнхээ төлөө энийг шийдэх ёстой гэж бодож байгаа. Бид нар ноогдол ашиг байна гээд цонхны цаанаас чихэр долоож байна гэдэг энэ үлгэрээр 1072 хувьцааны ноогдол ашиг байна шүү гэдэг энэ асуудлыг удаа дараа ярьдаг, ЗГ-аас ч ярьдаг, төрийн байгууллагаас ч ярьдаг. Гэтэл бид нар өнөөдөр энийг шийддэггүй, шийдлийг гаргаж ирдэггүй. Ийм учраас энэ 1072 хувьцааны ноогдол ашгийг ард иргэддээ өмчлүүлэх асуудлыг энэ Төсвийн хуулийн хэлэлцүүлгийн үед зайлшгүй шийдэх ийм саналыг Их Хурлын гишүүний хувьд би гаргаж байна. Энийг яаралтай шийдэх ёстой.

Бид 1072 хувьцааны 870 тэрбум төгрөгийг төмөр замд оруулсан гэдгийг бид албан ёсоор зарласан шүү дээ. Нүүрсний хулгайн үеэр энэ, энэ ЭТТ-н 1072 хувьцаа, ЭТТ-н хөрөнгө мөнгөний асуудал яасан бэ гэдэг энэ асуудал яригдахаар 870 тэрбум төгрөгийг иргэдийн ноогдол ашгийг төмөр замд оруулсан гэдэг. Тийм учраас энэ 1072 хувьцааны ноогдол ашигтай холбоотой, түүнчлэн энэ иргэдээс худалдаж авсан 1072 хувьцааныхаа тэр 500 гаруй мянга гаруй, 500 мянга гаруй иргэддээ энэ хувьцааг нь буцааж олгох асуудлыг энэ Улсын Их Хурал шийдэхийг би албан ёсоор дахин энэ хүсэлтийг хүргүүлж байна. Та нар өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т заасан тэр ард түмэн өмчдөө эзэн байх энэ Үндсэн хуулийнхаа зарчмыг ч гэсэн биелүүлэх ёстой гэсэн ийм байр суурийн үүднээс өнөөдөр би энэ Улсын Их Хурлын чуулганд энд үг хэлж, энэ хэлэлцэх дараалалд, энэ хэлэлцэх шийдэх асуудалд энэ 1072 хувьцааны ноогдол ашиг, түүнтэй холбоотой асуудлуудыг энэ Улсын Их Хурал энэ Төсвийн хууль хэлэлцэх үеэрээ шийдэхийг би хүсэж ийм хүсэлтийн дагуу өнөөдөр үг хэлж байгаа

юм, байна. Миний энэ хэлсэн үгийг хүлээж авч анхаарлаа хандуулна гэдэгт та бүгдэд итгэлтэй байна.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Монгол Улсын Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Франц Улсад айлчилсан. Энэ үеэрээ Орона компанитай ураны ордыг ашиглах талаар гэрээний протоколыг байгуулсан байгаа. Тэгэхээр ер нь бол гал атгасан улсууд бол хамгийн сайн хөгжилтэй байгаа. Дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй 10 орон нийт дэлхийн эрчим хүчний 87 хувийг үйлдвэрлээд, тэрнийгээ өөрсдөө хэрэглээд тэгээд хамгийн өндөр хөгжилтэй яваад байгаа юм. Тийм учраас энэ цаашдаа ч ер нь бол энэ цахилгаан машин болон бусад энэ цахилгаан эрчим хүчний хэрэглээ бол асар их нэмэгдэх нь. Тийм учраас энэ дэлхийн улс орнууд бол маш түрүүн хурдан энэ цөмийн реактор, цөмийн технологи руу орох нь хамгийн чухал гэж үзэж байгаа. Тэгээд манай 2 хөрш энд энэ тал дээр бол нэлээн өндөр хэмжээнд явдаг. ОХУ бол нийтдээ 38 реактортай цөмийн цахилгаан станцтай, урд хөрш болохоор 55 цахилгаан цөмийн реактор байж байгаа. Тэгээд дахиад 24-ийг одоо барьж явж байна. Тэгэхээр энэ дэлхий нийтийн тэр чиг хандлага руу манай улс маш яаралтай орох нь бол хамгийн чухал байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ ураны ордыг ашиглах энэ гэрээний протокол дээр бол маш амжилттай ажилласан. Амнатын татварыг 11 хувиас дээшээ 17-д өсөх тутамд нэг хувиар нэмсээр байгаад нийтдээ ер нь бол ураны хэрэглээ цаашдаа нэмэгдэнэ, дэлхийн зах зээлийн үнэ ч өснө гэж үзэж байгаа. Нийтдээ 19 хувийн Амнатыг авах ийм гэрээг гэрээний протоколыг зурж амжсан байгаа. Ер нь ажлын ЗГ-ын ажлын хэсэг энэ айлчлал болохоос өмнө 2 бүлгийн хуралдаан дээр орж танилцуулга хийсэн. Энэ танилцуулгаасаа илүү их бас тодорхой амжилтыг яг энэ Францад хийсэн яг тэр

уран Орана компанитай хийсэн тэр хэлэлцээр дээр бас нэг нэмэлт амжилтыг бас гаргаж чадсан шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй. Ер нь бол нийтдээ 12 тэрбум долларын төсөл байгаа. Цаашидаа бас энэ ордын бас нөөц нэмэгдэх боломжтой. Тэгээд энэнээс 3,5 тэрбум долларыг ямарваа нэгэн хөрөнгө оруулалт мөнгө төгрөг гаргахгүйгээр олно гэдэг бол энэ Амнатыг бас нэлээн өндөр тавьсны үр дүн гэж үзэж байгаа.

Өөрөөр хэлбэл нийт төслийн 30 хувийг ямарваа нэгэн санхүүгийн эрсдэл хүлээхгүйгээр авна гэдэг бол энэ дэлхийд байхгүй жишиг болж байгаа. Дэлхий даяар бол нэг энэ Амнат-ын дотор бол 5 хувь байдаг. Гэтэл энэ 19 хүртэл авна гэдэг бол маш өндөр амжилт гэж үзэж байгаа. Тэгэхээр цаашидаа нэг асуудал гарч ирэх нь ийм их өндөр хэмжээний шалгуур тавих нь бусад стратегийн уул уурхайн бүтээгдэхүүн дээр маш тийм өндөр шаардлага тавиад, олон хүн орж ирэхгүй байх ийм л нөхцөл рүү аваачсан сайн гэрээний протокол болсон гэж үзэж байгаа. Тийм учраас энэ ураны ордыг ашиглахтай холбоотойгоор ЗГ бусад яам тамгын газар мөн түүнчлэн агентлаг Монатом компани зэрэг энэ ажлын хэсгийнхэн яаралтай ажлыг ажлын хэсгээ хуралдуулаад, энэ протоколынхоо дагуу хөрөнгө оруулалтын гэрээний загварыг энэ он дотроо багтаагаад оруулж ирэх юм бол илүү амжилттай болох юм байна. Яагаад гэвэл ирэх жил сонгуулийн жил. Тийм учраас бид нар бол энэ эх орныхоо төлөө энэ эрчим хүчний тусгаар тогтнолын төлөө бид нар бас санаа зовних ёстой. Энэ эрчим хүчний тусгаар тогтнол бол бидний одоо, цаашдын үр хүүхдийн энэ Монгол орондоо баталгаатай амьдрах тэр боломжийг бий болгож байгаа зүйл. Тийм учраас энэ сайн хийгдсэн энэ гэрээн дээрээ янз янзын асуудал гадна дотнын нөлөөлөл орохоос өмнө энэ гэрээний загварыг, хөрөнгө оруулалтын гэрээний загварыг төслийг оруулж ирж Их Хурлаар батлуулах нь бол хамгийн чухал шаардлага болчихоод байгаа юм.

Тийм учраас гал атгасан улсууд л хөгжиж байгаа. Гал, хүн гал атгаад л энэ бусад амьтдаасаа хамгийн түрүүлж хөгжиж, өнөөдрийн энэ дэлхийг эзэгнэсэн ийм бодгаль болж хувирсан. Тийм учраас энэ гал атгасан улсууд хөгжиж байна. Тийм учраас манай Монгол бас яг энэ ураны ордыг ашиглахтай зэрэгцээгээр.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарын урилгаар БГД-ийн 10 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхан, ажил хөдөлмөр, амжилт бүхнийг хүсэн ерөөе. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлнэ.

**Ц.Даваасүрэн:** Та бүхнийхээ энэ өглөөний амгаланг эрье. Улсын Их Хурлаар 24 оны төсөв хэлэлцэж байгаатай холбогдуулж хэдэн үг хэлье. Би сая төсвийн хэлэлцүүлэгтэй холбогдуулаад бас тойрогтоо ажиллалаа. Би уг нь танд бичиг өгөөд явсан. Та 2 өдөр надыг улс орон даяар хайх шиг болно лээ. Ер нь иргэдийн оролцоог хангах ёстой юм. Тэгээд иргэдийн бас Улсын Их Хуралд хэлж өгөөч гэсэн 1, 2, 3 зүйлийг би Улсын Их Хурлын гишүүний хувьд та бүхэнд бас уламжлах нь зүйтэй. Ер нь хөдөөд бүхимдалтай хэд хэдэн бүүр нэг зайлиггүй шийдэх ёстой асуудлууд үүссэн байна. Малынхаа түүхий эдийн боловсруулах асуудал дээр анхаарал хандуулж өгөөч Их Хурал гэдэг зүйлийг их ярьж байна. Арьс шир үнэгүйдлээ, малын дайвар бүтээгдэхүүнүүд хаягдаж байна, бид нарыг ер нь үйлдвэртэй болгож өгөөч гэсэн зүйлийг их ярьж байна. Тэгээд энийг бүүр зориуд та Их Хуралд хэлж өгөөч гэсэн ийм зүйлийг хэлнэ лээ.

Мөн боловсролын салбар дээр нэг ийм зүйлийг яриад байна. Гишүүд бас энийг анхаарах хэрэгтэй л юм шиг байна. Хүүхдийн дотуур байрны хоолны зардал 4

мянган төгрөг байгаа юм. Тэгэхээр энийг бол 2 хуушуурын үнээр бид нарыг 3 удаа хоол өг, 2 удаа унд өг гэдэг ийм зүйл ярьж байна энэ байж болохгүй байна гэж. Бас нээрээ бодоод үзэхэд яг үнэн л байна л даа. 4 мянган төгрөгөөр бид нар хоол идэж чадах уу гэдэг асуудал шүү дээ. Цэцэрлэгийн мөн хоолны зардал 2400 байгаа тийм үү энэ чинь бас 2 удаа, 3 удаа хооллоход яах вэ гэж. Тэгэхээр ийм нэг бодит амьдралд нийцээгүй зүйлүүд дээр анхаарч өгөөч гээд.

Тэгээд 1 ийм зүйлийг хүсээд байна Их Хурлын даргаа. Ер нь бол хуулиараа тийм. Бид нар уг нь төсвийн хэлэлцүүлэгт иргэдийн оролцоог хангах ёстой юм. Төсвийн хэлэлцүүлэгт. Тийм учраас би бас энэ төсвийн хэлэлцүүлгийн явцад 1 долоо хоногийг энэ гишүүддээ нэг бас иргэдээ сонсох иргэдийнхээ оролцоог хангах боломжийг Их Хурлын дарга хангавал ямар байна вэ гэдэг зүйлийг хэлмээр байна. Яагаад гишүүд гишүүдтэйгээ уулзах энэ хэлэлцүүлэгт бас үгээ хэлэх ийм боломжийг олгооч гэдэг зүйлийг нэлээн ярьж байна. Та энийг бас нэг анхаараач. Та бол өөрөө намын жагсаалтад орно гээд тойргоо бол хаячих шиг боллоо л доо. Энэ бусад гишүүдээ бол оролцуулаад 1 долоо хоног явуулаад, тэгээд энэ яриад байгаа зүйлүүдийг нэг сонсохгүй бол нийгмийн бухимдал үнэхээр цэгтээ тулчихсан байна.

Ялангуяа энэ нэг залуу малчингүй болоод байгаа хөдөө орлогогүй болоод байгаа асуудал чинь бол энэ малын түүхий эд, арьс шир, махны үнэ нь доошоо болчихсон, орлогогүй газар залуучууд ирэхгүй ийм л болчихоод байна гэдэг зүйлийг. Ер нь ингээд хөдөө уулзалт хийхэд байна шүү дээ дандаа 45-аас дээш насны улсууд малчид. Тэгээд ерөөсөө залуучууд байхгүй болчихсон. Тэгэхээр энэ асуудал дээр ер нь Их Хурал анхаарч өгөөч, юу малчдын залуу малчин гэр бүлүүдийн энэ нэг НДШ мөн энэ залуучуудыг хөдөө орон нутаг руу ирээд ажиллахад нь тэр ажлын байрнаас гадна орон сууц гэдэг юм уу, байраар хангах энэ

зүйлүүдийг шийдэж өгмөөр байна гэсэн зүйлийг их ярьж байна. Тэгээд энэ удаа бол яах вэ ЗГ-аас бас нэг өргөсөн байгаа нэг зүйл бол 24 оны төсөвт хөдөөгийн нэмэгдлийг 20-оос 40 хувиар олгоё гэж байгааг бүүр төсөвт нь суулгаж өгөх. Энэ бол сайн зүйл.

Харин орон нутгийн давсан орлогоороо гэвэл энэ чинь орлогогүй татаастай газрууд бол өгч чадахгүй болчихоод байгаа юм байна. Тэгэхээр энэ зүйлийг бид нар бас хэлэлцүүлгийн явцад нэлээн анхааралтай ингэж хандахгүй болбол ер нь гишүүддээ, Их Хуралдаа л ханддаг юм байна шүү дээ иргэд чинь бол одоо. Та нар ингээд өгөөч, тэгээд өгөөч гэдэг энэ зүйлийг. Тэгээд ер нь хөдөөгийн боловсон хүчнүүд гадагшаа гарч байгаа, багш нар гадагшаа гарч байгаа гээд ингээд ер нь ялангуяа босоо тогтолцоогоор байгаа ажилчдын цалин нь хэвтээ тогтолцооноосоо доошоо орчихдог ч юм уу ийм нэг зохицуулалт шаардлагатай зүйлүүдээс болоод ажиллах хүчний хомсдол бий болж байгаа зүйлүүд энэ тэрийг та нар одоо энэ 24 оны төсвийг хэлэлцэж байх явцадаа анхаараач гэсэн зүйлийг иргэд нэлээн ярьж байна. Тийм учраас иргэдээ нэг сонсоод энэ төсвөө хэлэлцвэл яасан юм бэ гэсэн нэг ийм санал байна. Энийг бас та бүхэн анхаараач гэж ийм зүйлийг хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Адьшаа гишүүний асуудал нэмэх горимын санал бол тогтоолын төсөл санаачлагдаагүй, өргөн баригдсан тийм хуулийн төсөл, тогтоолын төсөл байхгүй учраас хэлэлцэх боломжгүй Тавантолгойтой холбоотой асуудлаар. Пүрэвдорж гишүүний хэлсэн тэр Оранотай холбоотой асуудлыг сонсох санал юм байна. Энэ бол чуулганаар өнөөдөр хэлэлцэхгүй, ирэх долоо хоногт хуваарь дээрээ ирээд тэр холбогдох Байнгын хороон дээрээ саналаа гаргаад сонсогдож болно. Даваасүрэн гишүүн чухал санал дэвшүүллээ. Ер нь энэ төсвийг Д-парламент дээр нээлттэй тавьчихсан

хавсралт энэ тэрийг нь бүгдийг нь үзэж байгаа. Бид 2 долоо хоногийн өмнө төсвийн хэлэлцүүлгийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, D-парламент дээр тавьж танилцуулга хийж, бүх сэтгүүлч иргэдэд мэдээлж санал авч байгаа, олон санал ирж байна.

Иргэдийн хамгийн гол нэг номерын тулгамдсан асуудал бол үнийн өсөлт байна. Үнийн өсөлт бүх хүний амьжиргаанд нөлөөлж байгаа. Ийм ч учраас НӨАТ-тай холбоотой асуудлыг хөндөж байгаа. НӨАТ-ын буцаан олголтын асуудал бол иргэдийн хамгийн их санал дэвшүүлж байгаа асуудал. Энийг дэвшүүлж ярьж байгаа. 2 дугаарт нь энэ малчдын асуудал маш тулгамдсан асуудал болж байгаа. Энэ хагас бүтэн сайнд би хөдөө орон нутагт ажиллаж, малчдын зөвлөгөөн, мянган малчдын чуулга уулзалтад оролцож тэдний санал бодлыг сонсох арга хэмжээ зохион байгуулна. Залуу малчдын улсын зөвлөгөөнийг Улаанбаатарт зохион байгуулж, оролцож санал бодлыг нь сонссон. Ерөөсөө залуу малчдын халаа байхгүй болсон. Малчдын өмнө тулгамдаж байгаа маш олон цогц асуудал байна. Бэлчээрийн доройтол, малчдын нийгмийн асуудал, залуу малчдын залгамж халаа, малчдын залгамж халаа байхгүй болж байгаа. Монголын баялаг бүтээгчдийн хамгийн том кластер бүлэг болох малчид бол 300512 малчин байна, 200 мянган малчин өрхийн асуудал байна. Түүхий эдийн үнэ, бэлтгэлийн тогтолцооны асуудал байна. Ийм учраас энэ малчдын корпорац, сум нэгдэл малчдын холбоо байгуулах санаачилга гаргаад хөдөө орон нутагт түрүүчээсээ байгуулаад ажлаа эхэлж байгаа. Ийм учраас хөдөөгөөс сонгогдсон гишүүд нэн ялангуяа нийлээд энэ 50-ийн бүлэг энэ хөдөөгийн сэргэлтийн ийм ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж байгаа. Энэ дээр бүх гишүүд идэвхтэй оролцоод, ингээд ер нь даацтай шийдэл гарахгүй болбол улс маань Улаанбаатар улс болох гээд байна. Асар том боломж байна. Энэ дээр бас онцгой анхаарал

тавихгүй бол энэ бас үндэсний аюулгүй байдлын ч асуудал болж байна.

Тэгээд энэ санаачилгад нэгдэж ажиллахыг уриалж байна гишүүдээ. Ингээд хэлэлцэх асуудалдаа орё. Нэн ялангуяа энэ төсөвтэй холбоотойгоор энэ асуудлыг онцгой анхаарч үзэхийг хүсье.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэх асуудалдаа орно. Хууль санаачлагчийн илтгэл, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Жавхлан:** Эрхэм Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Сүүлийн 3 жилийн хугацаанд дэлхий нийтийг хамарсан цар тахлын аюул, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдал түүнээс улбаалсан инфляцын дарамт зэрэг гадаад хүчин зүйлсээс шууд шалтгаалсан урьдчилан тааварлах боломжгүй бэрхшээлийг даван туулахад төсөв, мөнгөний бодлогыг чиглүүлж багц арга хэмжээнүүдийг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан үе шаттай авч хэрэгжүүлсний үр дүнд эдийн засаг цар тахлын өмнөх үед хүрч сэргээд байна. Тухайлбал уул уурхайн бүтээгдэхүүний

экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын болон засаглалын оновчтой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдэж, улмаар гадаад валютын албан нөөц 2023 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 4,1 тэрбум ам.долларт хүрч чадсан нь өмнөх оны мөн үеэс 1,3 тэрбум доллароор нэмэгдсэн үзүүлэлт юм.

Түүнчлэн дэлхий дахинд үүсээд байсан хүнс, эрчим хүчний үнийн огцом өсөлтийн гадаад шокоос иргэдийн бодит орлого амьжиргааг хамгаалах зорилгоор үнийг тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд инфляцын хурд харьцангуй удааширч, 2023 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,4 хувиар буурч, 10 хувьд хүрээд байна. Дээр дурдсан эерэг хүчин зүйлсийн нөлөөллөөр эдийн засгийн өсөлт инфляцын болон бусад эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийн түвшин 2023 оны төсвийн жилийн эцсийн эцэст одоогийн хүчин төгөлдөр төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан 2024 оны суурь түвшинээс давахаар байна. Тухайлбал 2024 оны батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд нүүрсний экспортын биет хэмжээг 50 сая тонн байхаар тооцсон хэдий ч 23 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 51 сая тонн нүүрс экспортолж байна. Иймд 2024 онд 60 сая тонн нүүрсийг экспортлох нөхцөл бодитоор бүрдээд байна.

Мөн уул уурхайн салбар болон түүнийг дагасан тээвэр худалдааны салбарын өсөлтийн нөлөөгөөр 2024 оны батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэл 6,5 хувьтай тусгагдсан байсан эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч, нэрлэсэн ДНБ 74 их наяд төгрөг байхаар төсөөлж байна. Тиймээс макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төсвийн бодлогыг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлаас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн

төсөөллийн тухай хуулийн зарим үзүүлэлтийг эдийн засгийн сэргэлттэй уялдуулан бодитой тооцон өөрчлөх шаардлага үүсэж байна. Төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуульд өөрчлөлт орсны орсноор ирэх 2024 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25,3 их наяд төгрөг, төсвийн нийт зарлага 27,4 их наяд төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2,1 их наяд төгрөгт буюу ДНБ-ий -2,8 хувьд, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангаж энэ хязгаарт багтаж байгаа болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын Үй цай сургуулийн 10 дугаар 10А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт сурагчид, багш нартаа сурлага, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлгийг



Төсвийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ. Монгол Улсын ЗГ-аас шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, боомтын сэргэлтийн хүрээнд хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, экспортыг эрчимжүүлэх, ОТ-н гүний уурхайн олборлолт хийгдэж, зэсийн баяжмалын агууламж өссөнөөр уул уурхай, түүнийг дагасан тээвэр, логистик, худалдаа, салбарын өсөлт нэмэгдэх, ингэснээр экспортын орлого өсөж, төлбөрийн тэнцэл сайжрах, гадаад валютын албан нөөц нэмэгдэж, валютын хани тогтворжих зэргээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд эергээр нөлөөлөхөөс гадна төсвийн орлого нэмэгдэхээр хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал ДНБ-ий өсөлт, эдийн засгийн бодит өсөлт, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, ЗГ-ын өрийн нийт хэмжээг нэмэгдүүлж байгаа шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Төсвийн хүрээний мэдэгдлийн эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн тооцоолол бодитой эсэх, төсвийн бодлого, мөнгөний бодлоготой уялдсан эсэх, хэрэглээний үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хэрхэн хамгаалах талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир өмнөх жилүүдийн төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан тоон үзүүлэлт нь гүйцэтгэлийн дүнтэй нийцсэн эсэх, төсвийн алдагдлын эх үүсвэрийг хэрхэн тооцсон, хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулан зардлыг бодитоор төлөвлөж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж төсвийн зардлын тэлэлт нь хэрэглээний үнийн өсөлтөд шууд нөлөөлж, бараа бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлж

байгаа тул ирэх оны төсвийн хүрээний мэдэгдлийг мөнгөний бодлоготой уялдуулсан эсэх талаар төсөл санаачлагчдаас асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батсуурь махны үнийг чөлөөлж, төрөөс махыг экспортлоход зоригтой шийдэл гаргаснаар төвлөрлийг бууруулж, орон нутгийг дэмжих боломж бүрдэнэ гэсэн санал хэлсэн болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72,7 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр, БХБ-ын сайд Цэрэнпилийн Даваасүрэн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, УУХҮ-ийн сайд Жамбалын Ганбаатар, ХНХ-ын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Соёлын сайд Чинбатын Номин, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны

дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, ШЕЗ-ийн дарга Ренчиндоржийн Онончимэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Хашгамбайн Хашбаатар, Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат, ТАЗ-ийн дарга Балдангийн Баатарзориг, СЗХ-ны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан, энэ чинь одоо юу болгоод хаячихсан байна. Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Гантөмөрийн Түвдэндорж, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Сангийн яамны ТНБД Жигжидийн Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалт бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров, Сангийн яамны санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг. Энэ бол Төсвийн хүрээний мэдэгдлийн ажлын хэсэг. Дараа нь төсөв хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж энэ төсвийн хүрээний мэдэгдлийн ерөнхий тоонуудын талаар

асуух юм байна уу? Жигжидийн Батжаргал гишүүнээр тасаллаа. Төсөв бол дараа нь хэлэлцэнэ шүү дээ. Энэ бол төсвийн хүрээний мэдэгдэл. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Энэ бол энэ хууль бол тэтгэврийн доод хэмжээг индексжүүлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал байгаа. Тэгэхээр энэ хуулийг 2021 оны 9 сараас өгсүүлж, олон нийтээр хэлэлцүүлээд 2022 оны 1 сарын 24-нд Их Хурлын даргад өргөн барьсан. Тэгэхээр энэ Тэтгэврийг индексжүүлэх тухай хуулийн ямар учиртайг би бас тайлбарлаж хэлж өгье. 2022 оны 2 сарын 1-ний өдөр тэтгэвэр 350 мянган төгрөг байж байгаад 500 мянган төгрөг болсон. Яг тэр 2 сарын 1-ний өдөр гурил 50 мянган төгрөг байсан. Тэгээд тэр 500 мянган төгрөгөөрөө 10 шуудай гурил авдаг болсон байхгүй юу. Тэтгэвэр нэмэгдсэний үр дүнд. Гэтэл жил хагасын дараа өнөөдөр тэтгэвэр 550 мянган төгрөг болсон боловч нөгөө гурил нь 120 мянган төгрөг болчихсон. Нөгөө 10 шуудай гурил авч байсан тэтгэвэр чинь одоо 4,5 шуудай гурил авах ийм болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ яаж байна гэхээр ЗГ 1 кармагаасаа мөнгө гаргаад май ахмадууд та нарын тэтгэврийг нэмлээ шүү гэж хэлчхээд нөгөө юугаараа яаж байна инфляцыг бий болгож байгаад хамаг мөнгийг чинь, хамаг тэтгэврийг чинь бүгдийг нь хураагаад авчхаж байна гэсэн үг байхгүй юу даа.

Тэгээд энэ асуудлыг яаж шийдвэрлэдэг юм бэ гэхээр Тэтгэврийг индексжүүлэх тухай хуулиар шийдвэрлэдэг юм. Энэ хуулийг бол дэлхийн 50 гаруй оронд хэрэглэдэг. Манай хажуу талын хөрш Орос, Хятад, Казахстан зэрэг улсууд хэрэглэдэг. Жишээ нь 2021 онд ОХУ-ын инфляц 8,3 хувь байсан. Тэгэнгүүт 22 оны 1 сарын 1-нээс 8,3 хувиар инфляцынхаа дагуу тэтгэврээ нэмчхэж байгаа юм. Тэгэхээр тэнд хэл ам асуудал гардаггүй. Тэгэхээр өнөөдөр энэ хуулийг бас ганцаараа бас нэг хэсэг ярьдаг байсан юу ЗГХЭГ-ын дарга

Амарбаясгалан бас энэ асуудлаар нэлээн ярьсны үр дүнд Нийгмийн даатгалын багц хууль дээр энэ асуудал тодорхой хэмжээгээр орж ирсэн. Тэгээд энэ миний энэ хууль хамтарч хэлэлцэгдээд батлагдсаны үр дүнд өнөөдөр энэ 2024 оны улсын төсвийн төсөөлөл дээр нийтдээ 10 хувиар энэ жилийн инфляцыг 10 хувиар тооцоод, 880 тэрбум төгрөгөөр ахмадуудын тэтгэврийг нэмэх асуудал орж ирж байна. Тэгэхээр энэ дээр бол нэг асуудал гарч ирж байна шүү.

Ялангуяа Булгантуяа сайд энэ дээр бас тодорхой хариулт өгөх байх. Энэ 10 хувиар инфляцын дагуу 10 хувиар тэтгэвэр нэмэгдэх нь, 880 тэрбум төгрөг тавигдах нь. Тэгэхээр энэ 10 хувиар тэтгэвэр нэмчихээр нөгөө нэг 2022 оных шиг бүгдэд нь 15 хувиар нэмчхэж болохгүй байхгүй юу даа. Хамгийн бага тэтгэвэртэй тэр хүмүүс дээр нь арай өндөр хувиар 15 хувиар, саяас дээш төгрөг төгрөгтэйд нь бол саяас 2 сая хүртэл нь 10 хувиар, 2 саяас дээш бол 5 хувиар нэмэх замаар тэр тэтгэврийн зөрөөгөө арилгах нь бас маш чухал байгаа шүү. Энэ дээр бас Жавхлан сайд яг энэ асуудлыг санаачилж оруулж ирснийхээ хувьд бас энэ та хоёр хоёулаа яг яаж нэмэгдэх юм бэ? Энэ хуулийн бас ач холбогдлыг жил болгон ингээд байнга хэрэгжүүлээд явах ийм заалт Нийгмийн даатгалын багц хуульд орж ороод батлагдсан байж байгаа. Тэгээд энэ дээр тодорхой хариулт өгөөрэй.

**Г.Занданшатар:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

**Б.Жавхлан:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Одоо уг нь төсвийн хүрээгээ хэдүүлээ ярьж байгаа, үдээс хойш л төсөө ярьж таарах юм шиг байна. Төсөв дээр би тийм нэлээн дэлгэрэнгүй тайлбар өгье. Ер нь бол ингэж байгаа шүү хууль дээрээ бүүр ингээд заачихсан байгаа юм. Инфляц үнийн өсөлттэй уялдуулж жил бүр нэмнэ гээд. Тэгээд одоо бид ямар ч байсан ирэх жил инфляцаа зорилтот түвшинд буюу

нэг оронтой тоо руу оруулна гээд зорьчихсон байгаа. Гэсэн хэдий ч бид 10 хувиар төсөвлөөд юмыг яаж мэдэх вэ тийм ээ ингээд төсөв дээрээ суулгаад төлөвлөөд Их Хурал руугаа өргөн барьсан байгаа. Тэгээд хэдүүлээ ингээд энүүгээр нь баталчих болов уу гэж ингэж найдаж байна. Төсөв батлагдсаны дараа таны хэлж байгаагаар хэрхэн яаж хуваарилж, ямар хувиар тооцож хийх вэ гэдгээ ЗГ дээр ярилцаад шийднэ. Тийм.

**Г.Занданшатар:** Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулна. Болчихсон байна. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

**Х.Ганхуяг:** Өглөөний мэнд хүргэе. Надад 3 асуулт байгаа юм. Энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотойгоор ЗГ-ын өр зээлтэй холбоотой асуудал байгаа юм. 1 дүгээрт Хуралдай бондын үлдэгдэл төлбөрийг 24 онд дахин санхүүжүүлнэ гэхчхэн байгаа юм, 392 сая долларыг гадаадын хөрөнгийн бирж дээрээс бонд гаргаж санхүүжүүлнэ гэхчхэн байгаа. Энэ ямар хүүтэйгээр, яаж санхүүжүүлэх гэж байгаа вэ?

2 дугаарт энэ төсвийн алдагдал санхүүжүүлэхтэй холбоотойгоор 3,7 их наядыг дотоодын хөрөнгийн бирж дээр дотоодод үнэт цаас гаргаж санхүүжүүлнэ гэхчхэн байгаа. Сая Улаанбаатар хот бол дотоод үнэт цаас гарахад бол ойролцоогоор 17,8 хувийн хүүтэйгээр бонд босгохоор тооцоолсон байсан. ЗГ бол миний бодож байгаагаар бас 15, 6 хувиар босох байх. Тэгэхээр манай энэ дотоодын арилжааны банкнуудын чөлөөт мөнгөн урсгал хэд байгаа юм бэ? ЗГ ямар хүүтэйгээр мөнгө босгох гэж байгаа юм бэ? Тэр нь тэгээд хувийн хэвшилд хэрхэн яаж нөлөөлөх вэ гэдгийг би бас нэг асуумаар байгаа юм. Мөнгөний бодлого бол асар хатуу орж ирнэ шүү. Монголбанк бол бид нар яг ийм алдагдалтайгаар төсөв баталлаа л гэх юм бол мөнгөний бодлого мэдэхгүй 13, 4 хувь руу давхиад л очих байх. Энэ арилжааны энэ дотоодын энэ энгийн

хувийн хэвшилд бол маш л хүнд тусах гээд байгаа шүү. Дотоодоос мөнгө зээлэх арилжааны хүү бол би бол миний бодож байгаагаар 20 хэдэн хувь дээр л очих гээд байна л даа одоо бол яг энэ чигээрээ бид нар төсвөө батлаад явчихвал.

3 дугаар асуудал энэ оффтейк гэрээтэй холбоотойгоор энэ Ганбат захирлын энэ мэдээлэл дээр сонссон л доо. 1,5 тэрбум долларын нүүрс нийлүүлээд оффтейк, 450 сая долларын алдагдал хүлээсэн гээд. 1,8 их наяд бараг 2 их наяд төгрөг. Одоо дахиад оффтейк гэрээгээр 1,5 тэрбум долларын нүүрсийг нийлүүлнэ гэж байгаа юм, 32 хувийн алдагдал хүлээж байгаа, хөнгөлөлт үзүүлж байгаа. Энийгээ ер нь хэзээ болих юм бэ? Мөнгө байхгүй л гээд байдаг дотоодоос зээлнэ л гэдэг, гадаадаас зээлнэ л гэдэг өөрсдийнхөө дотоод нөөц бололцоогоо зөв ашиглахгүй байгаа шүү. Энэ дээр би нэг мэдээлэл авчихмаар байна.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулна.

**Б.Жавхлан:** Төсвийн хүрээний мэдэгдэлтэй огт холбоогүй асуулт асуулаа. Хариулъя, хариулъя. Дотоодын бондын хүү ярих арай эрт байна Ганхуяг гишүүнээ. Алдагдлыг юугаар нөхөх вэ гэдэг асуудал ч гэсэн төсөв батлагдсаны дараа, он гараад төсвийн гүйцэтгэл гараад эхлэхээр төсвийн алдагдлыг нөхөх маш олон эх үүсвэрүүд байгаа. Энэ жил жишээ нь бид төсвийн давсан орлоготой жилийн эцэс рүү гарахаар байна. 22 онд бүүр 1 их наядын бид нар давсан орлоготой энүүгээр төсвийн алдагдлаа бууруулсан, 40 хувь бууруулж чадсан. Энэ жил ч гэсэн ер нь нэг нэр хавьцаа бид бууруулж чадахаар байгаа 23 онд. Та бодвол 24 оныхыг ярьсан байх, 24 онд ч гэсэндээ ер нь тиймэрхүү эх үүсвэр бас гарч ирэх ийм боломжтой, гадаад зээлээр ч төсвийн алдагдал дээр эх үүсвэр байж болно. Шаардлагатай бол дотоодын бонд гаргана. Тэгэхдээ дотоодын бонд бол мэдээж өндөр хүүтэй байгаа учраас энэ бол хамгийн сүүлийн хүнд хувилбар.

Өнөөдрийг хүртэл бид нар алдагдал дээр бол дотоодын бонд нэг төгрөг ч гаргаагүй байгаа. Тийм, тэгэхээр тэрийг ярих бол эрт байна.

Оффтейк гэрээ эд нар гэж байна. Оффтейк гэрээ шинээр хийгдсэн юм байхгүй байлгүй дээ. Ганбат дарга хариулчих уу, мэдээлэл өгчих.

**Г.Занданшатар:** Хавдисламын Баделхан гишүүн.

**Х.Баделхан:** Баярлалаа. Манай улсын бол эдийн засаг эрчимтэй сэргэж байна. Надад валютын нөөц бол 4 тэрбум төгрөг хүрсэн байна. Ирэх жилийн эдийн засгийн өсөлт бол 7 хувь хүрнэ гэж ингээд өөдрөг сайхан төсөөлөл байна. Миний асуух гэж байгаа асуулт бол энэ НӨАТ-тай холбоотой, сая Их Хурлын дарга бас хэллээ. Энэ ерөөсөө яг төсөв хэлэлцэж байгаа үед бол ард иргэдээс санал авч байна тийм ээ. Одоо дэмжсэн хүний тоо 100 мянга хүрэх л юм бол энэ асуудлыг Их Хурлаас ярих хэмжээнд хүрэх юм гэж ингээд яригдаад байна. Энэ ямар учиртай юм бэ? Буцаан олголт 2 хувь байсныг 5 хувь болгоно гэж. Хамгийн гол нь яг төсөв ярьж байгаа үед бол энэ асуудал яригдаж байгаа нь ямар учиртай юм бэ нэг?

2 дахь нь бол ер нь НӨАТ бол өнөөдөр төсвийн хэдэн хувийг бүрдүүлж байгаа, улсын хэмжээнд хэчнээн ААН байгаа, тэрнээс энэ НӨАТ төлдөг хэчнээн байгууллага байдаг юм ер нь? Ер нь нэг ёсондоо НӨАТ-ын төлбөрийн өнөөдрийн бүтэц, тэгээд саяын судалгаа бол ямар учиртай явагдаж байгаа судалгаа, эргэн төлөлтийг 5 хувь болгох тийм боломж байгаа юм уу? Энэ бол төсвийн өргөн барьсан төсөв дотор байхгүй огт яригдаагүй зүйл яагаад өнөөдөр яригдаж байгаа юм бэ гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** НӨАТ, гишүүнээс гишүүний асуултад хариулъя. НӨАТ ямар учиртай яригдаж байгааг би бас мэдэхгүй байна. Бас л сайн асуумаар л байгаа юм. Төсөв бид хугацаандаа ЗГ ингээд өргөн барьсан. Өргөн барьснаас хойш энэ сэдэв гарч ирсэн байна лээ. Тийм, тэгэхээр яагаад энэ сэдвийг төсөв барьсан хойно, ямар тооцоо судалгаатай, энэ чинь бол өөрөө татварын бүүр тогтолцооны асуудал шүү дээ. Тийм. Тэгэхээр татварын асуудал гэнэт ингэж хөндөгдөв үү гээд энэ сэдвийг хөндөж тавьж байгаа талаас асуусан нь дээр байх тэндээс л хариулах байх. Ямар учиртай ярьж байгааг би ёстой хэлж мэдэхгүй байна. Энэ одоогоор бидэнд ямар нэг мэргэжлийн энэ яам судалгааны байгууллага дээр ямар ч материал тооцоо судалгаа, ямар үндэслэл байна, хараахан ирээгүй байна. Бодвол удахгүй ирэх байх гэж ингэж найдаж байна. Тэгээд тэндээс харж байж бас энэ тооцоо судалгаа нь юун дээр үндэслэсэн юм бол, ямар боломж гэж харж байгаа юм бол? Цаашидаа энэ татварын тогтолцоо дээр, төсөв дээр ямар ачаалал ирэх юм бол энийгээ болно гэж үзэж байгаа юм уу, болохгүй гэж үзэж байгаа юм уу тэрийг нь нэг харж байгаад яримаар байгаа юм. Даанч тийм материал бидэн дээр ирээгүй байгаад байна. Статистик тоонууд асуулаа. Сая энэ Тэлмүүн дарга нэмээд тоонууд хэлчих үү?

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25, 26 оны төсвийн төсөөлөл хэлэлцэж байна. Бид нар нэг жил бүр л 9 тоо хөдөлгөдөг нэг ийм л жишиг бий болчхоод байгаа юм. Уул нь бол дагаж мөрдөх л ёстой л юм л даа. Би хамгийн чухал юм инфляц байгаа юм. Энэ дотроос. Сүүлийн 2021, 2022 онд чинь инфляц аягүй өндөр 15, 6 хувь хүртэл хүрч байсан. Үндсэндээ иргэдийн гар дээрх мөнгө тэр хэмжээгээр ханиш нь буурч байгаа ийм л зүйл л дээ. Тэгээд хамгийн чухал асуудал бол бид нар инфляцыг

тодорхой хүрээнд ялангуяа нэг оронтой тоон дээр барих л асуудал хамгийн чухал. Тэгээд инфляцад нөлөөлдөг нэг хэдэн хүчин зүйл байгаа юм. Би тэрэнтэй холбогдуулаад ЗГ-аас 3, 4 асуулт асууя гэж бодож байгаа юм.

1 дүгээр асуудал юу байна вэ гэхээр нефтийн асуудал байгаа юм. Энэ нефтийн бүтээгдэхүүн инфляцад нөлөөлж байгаа юм. Одоо гэхэд л бид нар энэ жилийн эцэс гэхэд 1 оронтой тоо руу орчихно л гэж ингэж л тооцоод л байгаа инфляцыг. Гэтэл энэ өвлийн түши гарч ирээд л 8, 900 төгрөгөөр бараг нэмэгдчихлээ шүү дээ. Тэгээд инфляцад нөлөөлдөг юм бол хамгийн түрүүнд энэ нефтийн бүтээгдэхүүн болчхоод байгаа юм. Хавар, намар 2 маш хүчтэй цохилт өгдөг болчхоод ингээд болохгүй. Мэдээж дэлхий нийтийн байдал хүнд байгааг бол бид нар ойлгож байна. Энэ дээр би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр Ганбаатар сайдаас асууя, Уул уурхайн сайдаас. Бид энэ нефтийн өөр эх үүсвэрийг бас хайж баймаар байна. 1 эх үүсвэртэй, тэгээд тэр нэмэгдсэн бол тэгээд нэмэгдээд л явдаг нэг ийм л болчхоод байгаа.

Гэтэл бид нар БНХАУ-д түүхий нефть өгч байна. Тэндээс нефть юу нефтийн бүтээгдэхүүн буюу шатахуун авах боломж байна уу үгүй юү, тэр талаар судалж ярьж байгаа, хөөрч байгаа асуудал байдаг юм уу үгүй юү? Нефтийн үйлдвэр маань хэзээ ашиглалтад орох билээ. Энэ бид нар өөр эх үүсвэр бас хайдаг энэ чиглэл рүү явахгүй бол ингээд цаашидаа нэг хэрэглэгчтэй байх асуудал бол үнэхээр сөрөг нөлөөлөл үзүүлээд байгаа юм. Энэ талаар ер нь манай УУХҮЯ барьж байгаа бодлогын асуудал байгаа юм.

Инфляцад 2 дахь юм бол экспортын бүтээгдэхүүний асуудал байгаа. Манай УУХҮЯ бол экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлд бол үнэхээр онцгой анхаарал тавьж байгаа. Тэгэхдээ бид нар дотооддоо үйлдвэрлэх асуудал үнэхээр

чухал байгаа. Энэ хүрээндээ би ОТ-н далд уурхай ашиглалтад орсон. Би үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж байгаа гэж бодож байгаа, гаргаж байгаа зэсийн хэмжээ нэмэгдэж байгаа гэж ингэж бодож байгаа. Энэ ОТ-н далд уурхай ороод үйлдвэрлэлийн хэмжээ хэрхэн нэмэгдсэн бэ гэдгийг би нэг асууя гэж бодож байна. Энэ төсвийн ном дээрээс бол тэр харагдахгүй байгаа юм.

2 дахь асуудал зэс хайлуулах үйлдвэрийн тухай асуудлыг бид нар их олон жил ярьдаг, ОТ-г дагаад гэж нэг ярьдаг, МАК-ийг дагаж ярьдаг, Эрдэнэтийг дагаж барина гэж ярьдаг. Тэгээд энэ талаар ер нь УУЯ судалгаа тооцоо хийгээд яг эндээ барина гээд тогтчихсон техник эдийн засаг, үндэслэл, зураг төсөв нь хийгдчихсэн бэлэн болчихсон ийм асуудал байна уу гэж би асууж байгаа юм. Ийм хэдэн зүйлийг асууя. Эдгээр нь бол нөгөө юу, инфляцынхаа тогтвортой байдал, валютын нөөц, ханшны тогтвортой байдалд нөлөөлдөг учраас би энэ хэдэн зүйлийг асууя. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд. Жамбалын Ганбаатар сайд хариулъя. УУХУ-ийн сайд хариулна.

**Ж.Ганбаатар:** Тогтохсүрэн даргын асуултад хариулъя. 1 дүгээрт дизель түлшний үнэ тэр 5, 600 төгрөгөөр бол өсөөгүй шүү, 200 төгрөгөөр өссөн. Тэр янз янзын байдлаар яг албан ёсны импортлогч компаниудаас аваагүй, гар дамжиж авах гэж байгаа авсан ч гэдэг юм уу эсхүл дараа төлбөрт энэ тэр гээд янз янзын байдлаар тэр нэг шатлал нь арай нэг өөр маягаар сая нэг хэсэг бол хомсодсон, та бол сайн мэдэж байгаа юм. ОХУ-ын ЗГ-ын тогтоолоос шалтгаалаад. Тэгээд энийг далимдуулаад 1 үнэ өсгөсөн тохиолдлууд байгаа. Тэгээд энэ дээр бол бага зэргийн асуудлууд бол байсан гэдгийг хэлье. Тэгээд түүнээс биш 200 төгрөг өссөн байгаа. Дизелийн үнэ бол 10 сараас бууна. Тогтохсүрэн гишүүнээ 10 сараас бууна. Яагаад буух вэ гэхээр шатахууны

нефтийн бүтээгдэхүүний үнэ бууж байна, ялангуяа Сингапурын бирж болоод Санкт Петербургийн бирж дээр бирж юу юуны үнэ бууж байгаа юм. Тийм учраас 11 сараас эхлээд дизелийн үнэ буугаад эхэлнэ, хамаагүй нөөцөлж болохгүй шүү гэдгийг би бол хэлье. Тэр бол тодорхой бууна гэдгийг бол хэлье.

2 дахь эх үүсвэр гэдэг дээр хариулт хэлье Тогтохсүрэн гишүүнээ. Хятад улсаас авч байгаа, аваад бараг энэ чинь 4 сар болж байна 92 дизель. Ер нь яагаад бүүр ингээд ОХУ-тай өрсөлдөхүйц хэмжээнд ирэхгүй байгаа шалтгааныг нь бол та сайн мэдэж байгаа 1 дүгээрт үнэтэй үнэтэй, 2 дугаарт тээвэрлэлт ложистикийн хувьд бол асуудалтай. Цаанаас ирээд дамжиж ачдаг, дамжуулан ачих юунууд хэрэгтэй. Гэхдээ ОТ болоод энэ томоохон уурхайнууд Евро 5 ангиллынхаа дизелийг бол урдаас авч байгаа. Манай ААН-үүд нийлүүлж байна. Энэ бол бид ямар ч байсан сая Ерөнхий сайд БНХАУ-тай ярилцлагатай тэр CNPC гээд төрийн өмчит компанитай нь энэ асуудлыг нэлээн яриад, энэ бол ингээд аль дэвийн эхэлчихсэн явж байгаа юм. Гэхдээ яг тогтворжиж өгөхгүй байна. БНХАУ-ын хувьд бол экспортоо бол квотоор гаргадаг. Тийм учраас энэ бас тогтвортохгүй, тогтворжиж өгөхгүй байгаа асуудлууд байгаа.

Зэс зэсээ мэдээж бид хайлуулах гэж байгаа. Би Үндэсний хорооны дарга. Та бас зөв хүнээсээ асуулт асуулаа. Тэгэхээр би зэс хайлуулах үйлдвэрийн хувьд бол 2, 3 байриил яригдаж байна. Эрдэнэт дээр бол ажил явчихсан байгаа. Эрдэнэт өөрийнхөө хэмжээнд 560 мянган тонн зэсийн баяжмал экспортолдог. Энэнийхээ хэмжээнд 100 100-аас 150 цэвэр зэс гаргах, энэ зэс хайлуулах үйлдвэр ийм хүчин чадалтай.

**Г.Занданшатар:** Ганибалын Амартүвшин гишүүн асуулт асууна.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Нэг хэд хэдэн асуулт Жавхлан сайдаас асууя.

Өрийн хэмжээ 24 онд ДНБ-ий 42,7 хувьтай тэнцэнэ гэж төсөөлж байгаа юм байна. Тэгэхээр энэ бол мэдээж хэрэг хуулиараа бол 60 хувийн лимиттэй хязгаартай байгаа. Энэ 42,7-гоо яг хурч чадах уу? Яагаад гэвэл бас том хөрөнгө оруулалт болон энэ төсвийн урсгал зардал нэмэгдсэн байна. Тодорхой хэмжээгээр бас шинээр эх үүсвэр бонд босгох шаардлага гаргах байх. Одоогийн байдлаар бол Америкийн төв банкны бодлогын хүү бол дээд түвшиндээ хүрсэн, шинээр гарах бонд бол нэлээн өндөр зардал хүүгийн зардалтай гарахаар харагдаж байна л даа. Тэгэхээр энэ дээр ямар төлөвлөгөө байна нэг тодруулаад өгөөч.

Төсвийн алдагдал 2 их наяд ДНБ-ий 2,8 хувьтай тэнцэхээр болж байгаа. Тэгэхээр энэ бол маш сайн үзүүлэлт ингэж харж байна. Сануулахад 2020 он 20 онд төсвийн алдагдал 12 хувьтай байсан шиг санагдаад байх юм. Тэгэхээр сүүлийн 3, 4 жилийн дотор ингээд төсвийн алдагдлаа нэлээн бууруулж чадсан байна гэж харж байна. Энийгээ тэгээд хэр сахилга баттай мөрдөж чадах вэ гэдэг дээр бас. Энэ төсвийн зардал нэлээн өсөж байна энэ. Энийг Жавхлан сайд нэг ямар шалтгаанаар өсөж байгаагаа бас тайлбарлаж өгнө үү? Миний харж байгаагаар болохоор одоо нийт 27,4 их наядын төсвийн зардлын 18,8 хувь нь бол тэтгэвэр тэтгэмж байгаа, цалин төсвийн байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал нь нийлээд 23,5 хувьтай, хүүхдийн мөнгө бол 5,7 хувь. Тэгэхээр энэ бас мэдээж хэрэг бид нар нөгөө Нийгмийн даатгалын багц хуультай холбоотой зардал өсөж байгаа байх. Төрийн албан хаагчдын цалин өсөлт бас нөлөөлсөн байх ингэж харж байна л даа. Тэгэхээр энэ тал дээр бас тодорхой яг 23 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй харьцуулахад 24 оны төсвийн зардал яаж нэмэгдэх вэ, ямар хэмжээгээр нэмэгдэх вэ? Гол нэмэгдэж байгаа шалтгааныг нь хэлж өгнө үү. Энийг яагаад асуугаад байна вэ гэхээр энэ нэмэгдэл чинь бол яалт ч үгүй цалин нэмж байгаа гэж би харж байна.

Цалин нэмэгдэнэ гэдэг чинь инфляцад бас тодорхой хэмжээгээр сөргөөр нөлөөлөх тийм эрсдэл байгаа. Нөгөө талаар Монголбанк бол 24 онд мөнгөний бодлогоо нэлээд чанга барихаар юм байна лээ шүү дээ. Бодлогын хүүгээ одоо байгаа түвшинээс илүү дээгүүр байх магадлалтай. Ер нь инфляцыг бол 6 хувь +, -2 хувийн ийм хязгаар дотор барина гэсэн тийм мөнгөний бодлоготой. Өөрөөр хэлбэл энэ бол нөгөө эдийн засгийн өсөлтийг бас сааруулах тийм бодлого байна гэж бид нар харсан. Төсвийн хөрөнгө оруулалт бол нийт ДНБ-ийг 12 хувь байна уу даа. Тэгэхээр харьцангуй бас төсвийн зардал тал дээр бол бага нөлөөтэй байна гэж ярьж байна.

Эцэст нь нөгөө НӨАТ-ын талаар би бас дахиад энийг асуугаадахъя л даа. 24 онд 6,4 их наядын НӨАТ-ын орлого төсөвт орж ирэх юм байна лээ л дээ. Тэгэхээр энэ жил 350 тэрбум урамшуулал өгсөн юм байна. Ирэх жил 400-аас 400 тэрбум орчим гэж би ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл И баримтад бүртгүүлсэн баримтаараа иргэд нь төлсөн НӨАТ-ынхаа 20 хувийг буцаад авна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр ингээд нэг санал асуулга яваад байгаа 50 хувь бол их том дарамт ирэхээр харагдаж байна. Энэ дээр бол Жавхлан сайд бас тодорхой тоо мэдээлэл байвал өгөөч? Баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалангийн урилгаар БЗД-ийн Социал Демократ Залуучуудын Холбооны салбар зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Монголын залуучуудын зүрхэнд, тархинд Монгол эх орны маргаашийн хувь заяа зураастайн учир ихэд хичээж хөдөлмөрлөж, мэдлэгт шунаж их амжилт гаргахыг хүсэн ерөөе. Хэн хариулах вэ? Болдын Жавхлан Сангийн сайд хариулна.

**Б.Жавхлан:** Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Ирэх жил

төсвийн хязгаар маань тусгай шаардлагын дагуу 60 хувиас доош байх ёстой, 60 хувьд багтах ёстой гэсэн үг. Бид Их Хурал дээрээс 3, 3 жилээр гадаад өрнийхөө юуг стратегийг батлуулаад ингээд явдаг байгаа. Сүүлийн 21 онд бид стратегиа батлуулаад энэ хүрээндээ явж байгаа. Гадаад өрийн хувьд бол Монгол Улс ЗГ маш сахилга баттай сайн явж байгаа шүү. Бид ингэсний үр дүнд стратегийнхаа хүрээнд байгаагийн тулд ЗГ-ын гадаад өрийн зээлжих зэрэглэл маань энэ хүнд үед маш тогтвортой байж ирлээ. Бид амжилттай ЗГ-ынхаа өрийг бууруулж ирсэн. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын ЗГ-ын үед бид 3 жилийн хугацаанд нийтдээ 11,9 их наяд төгрөгийн гадаад өр зээлийн зохицуулалтыг хийсэн. Үүнээс 4,8 их наядыг бид дахин санхүүжилт хийсэн, хүү үндсэн өр нийлээд 6,5 их наяд төгрөгийн төлбөр төлсөн байгаа. Ингэсний үр дүнд бид ДНБ-д эзлэх өрийн маань эрсдэлийн үзүүлэлт болох энэ хувь хэмжээ амжилттай бууж байгаа. Энд мэдээж 2 талаасаа нөлөөлнө. ДНБ маань өөрөө тэлж даац нь томорч байгаа. Ингээд орон зай ч тэлж байгаа. Харин тэр орон зайгаар бид өрөө бол нэмээгүй байгаа. Ингээд 42,7 хувь дээр бол ирэх жил бол барина гэсэн ийм нөөц төлөвлөгөөтэй гэсэн үг. Ирэх жил бол шинээр гарах 2 өрийн хэрэгсэл байна.

1 дүгээрт нийслэл 500 тэрбум төгрөгийн бондоо энэ жил батлагдсаныхаа дагуу ирэх жил гаргах ийм ажлаа төлөвлөсөн байгаа. Мөн бид Дорнодын цахилгаан станцыг яаралтай дуусгахгүй бол энд хугацааны хувьд бол ер нь жоохон баларч байгаа шүү. Бид ковидын үед бүтээн байгуулалтын юмнууд нь хойшилчихсон, ингэж мунгинаж байтал Хятад тал нөгөө нүүрсний цахилгаан станц, нүүрсний ямар ч том зээл гаргахгүй гэдгийгээ 1 сарын 1-нээс гээд зарлачихсан. Энэ нэгэнт эхэлчихсэн төсөл байгаа учраас яах вэ энэ дээр чи харж үзье. Гэхдээ та нар ЗГ-ын баталгаа гаргахгүй бол бид нар мөнгө өгч чадахгүй шүү гээд ингээд хэлчихсэн байж

байдаг. Тэрэн дээр 50-аас 70 сая долларын ийм ЗГ-ын өрийн баталгаа гаргаж таарах байх. Ингээд л болж байгаа юм. Ингээд бид нэмэлт янз бүрийн эрсдэлтэй зүйл байхгүй учраас 42,7 дээрээ бол бид барина гэж байгаа юм.

Түүрүүн нээрээ Ганхуяг гишүүн асуусан тэр Хуралдай бонд дээр бид ер нь 50-аас 60 хувь дээр нь *refinance* хийж таарах байх. 200-аас 250 сая доллар дээр нь боломж байвал аль болох төсөв дээрээсээ шууд төлөөд үндсэн дүнг нь бууруулчихъя гэсэн нөөц.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Дутуу байна гэнэ, хариулах хүн байна уу? Ажлын хэсгээс Жавхлан сайд товч тодорхой хариулъя, нуршаад байна. Сангийн яам тодорхой байж сурах хэрэгтэй. Амартүвшин сайд Амартүвшин гишүүн тодруулж асууя нэг минут.

**Г.Амартүвшин:** Цагтаа багтаж хариулж чадсангүй л дээ. Зардал өссөний шалтгааныг нэг маш тодорхой хэлээд өгөөч. 2 дугаарт НӨАТ НӨАТ-ын талаар. 3 дугаарт зээлжих зэрэглэл Б байгаа тийм ээ. Тэгэхээр ямар нөхцөлд манай зээлжих зэрэглэл дээшлэх вэ сайжрах вэ?

**Г.Занданшатар:** Түвдэндорж 81 Эдийн засгийн хөгжлийн сайд хариулах уу? Эдийн засгийн хөгжлийн дэд сайд.

**Г.Түвдэндорж:** Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Сүүлийн бас ойрын 3 жилийн хугацаанд бол Монгол Улс бас эдийн засгийн цар тахлаас үүдэлтэй амаргүй сорилтуудыг бол авч байсан гэсэн хэдий ч бас зээлжих зэрэглэлийг болбол нэг түвшиндээ болбол хадгалж, амжилттай бас хадгалаад явж байгаа. Цаашид бол өрсөлдөөнийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийг сэргээх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар ер нь эдийн засгийн орчныг сайжруулах тал дээр бол зээлжих зэрэглэлийг, өрсөлдөөнийг, зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлнэ гэж



нэмэгдүүлэхийн төлөө бол ЗГ бол чармайн ажиглана.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

**Ц.Сандаг-Очир:** Би энэ төсвийн хүрээний мэдэгдлээс 9 тооноос энэ ЗГ-ын өрийн асуудлыг л тодруулах гээд байгаа. Тэгээд бид нар энэ ЗГ 11,8 их наядын өр барагдууллаа гээд. Тэгсэн хэр нь ЗГ-ын нийт өр бас эсрэгээрээ жишээ нь 23 оны 5 сарын 31-нд батлагдсан төсвийн хүрээнд мэдэгдлээр өнөөдөртэй харьцуулахад ингээд 5 их наядаар нэмэгдчихсэн өр, 25 онд бид нар ахиад 5, 26 онд ахиад 5 их наядаар ингээд зөрүүлж нэмээд л яваад байгаа юм. Тэгээд 1 талаасаа өрөө дарж байгаа боловч нөгөө талаасаа ахиад орлого нэмэгдэж төсөв тэлэхийн хэрээр ЗГ-ын өрийн хэмжээ бас нэмэгдээд яваад байгаа. Тэгээд нөгөө тусгай шаардлагадаа 60 хүртэл хувьдаа барьж байгаа гээд байгаа боловч нэг талаасаа төсөв дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдэхийн хэрээр өрийн хэмжээ буурахгүй байгаа. Тэгэхээр ядаж 59 хувь гэхэд л 600, 700 тэрбум төгрөг нэг хувь бууруулахад л 600, 700 тэрбум төгрөгийн асуудал яригдана шүү дээ. Тэгээд нөгөө тусгай шаардлагаа барьж байгаа гээд.

Хэрвээ ЗГ энэ ЗГ-ын өрийн хэмжээг зөвхөн дээд таазаар нь бариад л яваад байх юм бол цаашидаа Төсвийн тогтвортой байдлын хуулиараа ер нь жил болгон нэг хувиар бууруул ч гэдэг юм уу ингэж өөрчлөлт оруулах шаардлагатай юм уу? Тэгэхгүй бол тэгээд яг ингээд дээд талын таазанд нь тулгачхаад л ингээд яваад байгаа болохоор чинь энэ ЗГ-ын бодит өрийн хэмжээ чинь ерөөсөө буурахгүй байна шүү дээ. Өрийг нь нэг талаас дараад байдаг нөгөө талаас төсөв тэлэхийн хэрээр өрөө бас нэмэгдүүлээд л яваад байна. Тэгээд энэ дээр бас та бүхэн маань юу гэж бодож байгаа вэ? Ер нь цаашидаа энэ өрийн бодит хэмжээгээ яаж бууруулах юм бэ? Тэгээд дандаа ингээд

энэ нэг тоо өссөн хэмжээгээрээ, бодит өссөн хэмжээгээрээ байгаад яваад байх юм уу? Энэ дээр нэг хариулж өгөөч.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Болдын Жавхлан Сангийн сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Түрүүн Амартүвшин гишүүний асуултад дутуу хариулчихсан, товч тодорхой хариулъя. НӨАТ-ын асуудлыг бид сайн мэдэхгүй байна. Төсөв өргөн барьснаас хойш энэ асуудал гарч ирсэн. ЗГ дээр бол энэ НӨАТ болон Татварын хууль аль ч хууль дээр хөдөлгөөн хийх ямар нэг тийм бодлого бол байхгүй байгаа. Тэгэхээр НӨАТ-ын асуудал тавьж байгаа тэнд ямар тооцоо судалгаа байгаа юм тэндээс асуувал мэдээлэл өгөх болов уу гэж бодож байна.

Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Тэр ийм шүү Сандаг-Очир гишүүнээ. Төсвийн юу өрийн хэмжээ нэмэгдээд байгаа зүйл биш шүү. Таны саяын тоо тавьдаг тоо чинь бол нөгөө төсвийн, өрийн хязгаараараа хязгаараараа тооцсон тэр номинал дүн орон зай нь өөрөө нэмэгдэж гаргасан тэр тооцоо байхгүй юу. Тэрнээс биш өрийн өөрийнх нь номинал дүн нь бол тогтвортой байгаа. ДНБ тэлэх хэрээр тэрэнд эзлэх яг өрийн бодит хэмжээ нь хувь хэмжээгээр бол энэ чинь буураад явж байгаа шүү дээ. Энэ жил 45 хувь, хойтон 42 хувь ингээд буураад явж байгаа. Тэрнээс биш 60 хувиа тултал нь ашиглаад өрөө нэмчихсэн асуудал бол ерөөсөө огт бас байхгүй. Тэр орон зайг л тавьж харуулсан ийм тоо байгаа.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

**Ц.Сандаг-Очир:** Тэгвэл та 24 оны төсвийн хүрээний мэдэгдэлд ЗГ-ын бодит өр 60 хувийнхаа яг хэдэн хувьд байх юм, 25-д онд хэд байх юм, 26 онд хэд байх юм гэдгээ нэг тодорхой хэлж өгөөч.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд тодорхой хэлж өгье.

**Б.Жавхлан:** Тодорхой хэлье. 24 онд 42,7 хувь, 25 онд энэнээс ч бага болоод явна ДНБ тэлэх хэрээр 40 хувиас доош ороод явна.

**Г.Занданшатар:** Энэ Бямбарагчаагийн Тэлмүүн дарга түрүүн дээрээс хойш гар утсаараа тасралтгүй л оролдож суулаа. Сая *Irad*-аа дэлгэчихлээ. Энэ 9 сард Нэмэгдсэн өртгийн албан татварын талаар Сангийн яамнаас Бямбарагчаагийн Тэлмүүнээс тодруулга асуусан. Долоо хоногийн өмнө энэ чуулган дээр асуусан, танайд туслахад өгсөн гэж худлаа хэлсэн. Ер нь Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд 20 хүртэл хувийг буцаан олголт зарцуулна гэсэн өдөр тутам гэж заасан байгаа. Дээр нь 10 хүртэл хувийг урамшуулал олгоно. Үндсэндээ хуулиараа бол 30 хүртэл хувийг буцаан олгох бололцоотой байгаа. Энэ жилийн төсөв төлөвлөснөөр 7,7 хувь байгаа энэ хувь. 2020 онд ДНБ 37 их наяд байсан. Одоо 24 онд төлөвлөсөн нь 74 их наядаар төлөвлөсөн, 2 дахин өссөн байгаа биз. Энэ дефлятор аа тооцоод, инфляц ханшаа тооцоод, энэний бодит өсөлттэй уялдуулахад иргэдийн төлж байгаа НӨАТ 2,5 дахин өссөн. 2020 онд нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 2,2 их наяд байсан шиг гэж санаж байна. Энэ жил 6 их наядаар төсөвлөсөн. 5,7 их наяд гэж байгаа боловч хасалтаа тооцоо үзэхээр 6,1 их наяд байгаа байх. Энэ бараг 2,5 ДНБ-ий өсөлт НӨАТ-ын орлогын өсөлт 2 шууд хамааралтай байх ёстой. ДНБ бол нэмэгдсэн өртгийн нийлбэр шүү дээ. Тэгэхээр энэ 2 шууд хамааралтай байх ёстой. Нөгөөдөх нь 2,5 дахин өссөн байгаа.

Гэтэл НӨАТ-ын буцаан олголт 2020 онд 330 тэрбум байсан билүү, энэ жил 490 тэрбум төгрөг төлсөн байгаа. Экспортын болон ААН-үүдийн буцаан олголтыг хасвал иргэдэд очиж байгаа нь 410 тэрбумаар төлөвлөсөн байсан байх. Ингээд тооцоод үзэхээр байна шүү дээ

энэ хоёрынхоо өсөлтийн хурдыг л харьцуул л даа. Энэ чинь далд эдийн засаг ямар хэмжээтэй байгааг харуулж байгаа. Бүх ААН давхар тайлан баланстай болсон. Энэ тоон дээр чинь харагдахгүй. Татварын ерөнхий газрын зүгээр хажууд байгаа тэр алт мөнгөний дэлгүүрүүдээр ороод үзээрэй бүгд НӨАТ-гүй байгаа. Энийг 2019 онд ОУВС-тай ч яригдаж байсан асуудлууд, 4 жил яригдаж байна.

Яах вэ Сангийн яам бол төсвийн орлого бүрдүүлэх талдаа бол ийм байр суурь баримтлах нь зүй ёсных. Харин Эдийн засгийн хөгжлийн яам бол энэ дээр ямар байр суурьтай байдаг юм. Энийг Түвдэндорж дэд сайд бас энэ эдийн засгийг тэлнэ ил болгоно энэ бас нэг талдаа бүртгэлийг ил тод болгоно. Валютын сантай хийж байсан тэр үеийн юуг харахад бол өрхийн амьжиргаанд эергээр нөлөөлнө, хэрэглээг дэмжсэнээр хэрэглээ нь эдийн засгийг дэмжинэ. Яг энэ үед бол хамгийн зөв зүйтэй алхам байж болохоор, эдийн засгийн эерэг тал сөрөг талыг нь харьцуулсан судалгаанууд байгаа. Статистикийн газрын судалгаа байгаа. Үндсэндээ 6,1 их наяд төгрөг далд эдийн засагт 3,5 зүгээр л 3,5 их наяд, тэр НӨАТ 8900 ААН-ээс байна шүү дээ үндсэндээ 2,8 их наяд төгрөг бол НӨАТ төлөгч биш байна, 340 тэрбум төгрөгийн НӨАТ-ын чөлөөлөлт байна, 6,1 их наядын борлуулалтаас 6 аравны тэрбум төгрөгийн НӨАТ-ын орлого нэмэгдэх бололцоо байна. Яг бодит тоон дээр 2,8 их наяд төгрөг НӨАТ төлөгч биш байгаа. 9,7 их наяд 8600 ААН НӨАТ төлөгч 50 саяас дээш орлоготой мөртөө НӨАТ төлөгч биш байгааг чөлөөлөгддөг болон НӨАТ бүтээдэггүй хэсгийг хасахаар хамгийн муугаар нь тооцоолоход байна шүү дээ 2,8 их наяд гээд байгаа.

Одоо энэ ногоон автобус энэ тэрээс чинь болоод иргэдийн татвар төлөх шударга ёсны зарчим эрс унасан ингээж урамшуулахгүй л бол. Энийгээ болбол бас хуульд бол тэгэхээр би гол юманд зүгээр өөрчлөлт орохгүй. Хуульд 20, 30 хүртэл байна, 30 хүртэл гэж

байгаа юм. Энэ зүгээр л. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Яг төсвийн хүрээний мэдэгдлийг нь бид нар нөгөө 24 оны батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд өсөлтийг 6,5 гэж тооцоолж байсан бол сая энэ эдийн засгийн өсөлт нэлээд гайгүй үзүүлэлттэй, нүүрсний экспорт нэмэгдсэн тооцоолж байснаас гээд ярьж байна, 50 сая тонн гэж байсан бол өнөөдрийн байдлаар бараг 53 сая болж байна гээд ярьж байна л даа. Тэгээд ДНБ-ий нэрлэсэн үнийг 74 их наяд болгож ингэж орж ирж байна. Тэгэхээр эдийн засгийн энэ өсөлт, дээрээс нь сая төсвийн хүрээний мэдэгдлээр Сангийн сайд бас хэлж байна. Инфляц энэ инфляцын хурд харьцангуй удааширах хандлагууд байна гээд хэлж байна л даа. Тэгээд бид би бас энэ төсвийн хүрээний мэдэгдэл, аудитын дүгнэлт энэ тэрийг хараад үзэхэд ингээд эдийн засагт өсөлт нь тоон үзүүлэлтээр байгаад байгаа хэр нь нийгмийн бүх сегментэд энэ нь нөлөөлж очихгүй байгаад байна л даа.

Сая хэлж байна. Юмны үнэ өндөр хэвээр байгаад байдаг, иргэдийн орлого яг хэвээрээ байгаад байгаа. Сая 7 сарын 1-нд нөгөө бага орлоготой хүмүүсийн цалин хөлсийг нь бага зэргээр нэмсэн, тэтгэвэр бас тодорхой хэмжээгээр зөрөөтэй нэмэгдсэн байгаа. Одоо ирэх онд сая энэ төсвийн хүрээний мэдэгдэлд бас тэгж байна л даа. Эдийн засгийн өсөлт сэргэлттэй уялдуулаад бодит тооцоо хийх шаардлага үүсэж байгаа гээд. Тэгэхээр 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл энэ бодит тооцоо гэдэг дээр яг юуг хэлж байгаа вэ? Энэ нөгөө иргэдэд энэ эдийн засгийн өсөлт маань ёстой нөлөө үзүүлээд айлын тогоо, айлын гал тогоо руу хаалгаар ороод, тухайн хүний карманд нь нөлөөлөх яг бодит юм яаж орох вэ? Энэ дээр би яг тодорхой асуумаар байх юм. Яагаад гэвэл өнөөдөр сая хэлж байна. Инфляц үнийн өсөлттэй уялдаад цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж хөдөлдөг байна, тэтгэвэр хөдөлдөг байна гээд ЗГ бол мэдэгдсэн.

Сая Сангийн сайд 8 зуугаад тэрбум төгрөг төсөвлөж байгаа. Энүүгээр 10 хувиар тэтгэвэр тэтгэмжийг нэмэх тооцооллыг бас ямар ч байсан гэж оруулж байгаа гэж байна. Гэхдээ энэ эдийн засгийн 74 их наяд гээд энэ тооцооллууд өсөлт 6,5 гэсэн бол 7 хувь гээд нэмэгдэж байна. Тэгэхээр энэ маань өөрөө нөгөө 10-хан хувь дээр гээд, дээрээс нь тог цахилгааны үнэ 2 дахин нэмэгдчихлээ гээд иргэдээс мэдээллүүд ингээд ирж байгаа. Үнэхээр тог цахилгааны үнэ сая нэмэгдэж байгаа. ААН-үүдийн ба тог цахилгаан зун нэмэгдсэн. Одоо иргэд ингээд хувь айлуудынх нэмэгдээд эхэлчихлээ л дээ. Энэ чинь өөрөө нөгөө энэ эдийн засгийн өсөлт уг нь иргэдэд л очиж байж, хуримтлал үүсэж байх ёстой байхад энэ хуримтлал үүсгэдэггүй байгаад байна. Арилжааны банкууд гадагшаа зээл бодитоор бас гаргаж чадахгүй байгаад байна. Зээлийн хүү өндөр хэвээрээ байгаад байна. Тэгэхээр яаж энэ төсвийн хүрээний мэдэгдлээрээ бид саяын таны хэлж байгаа эдийн засгийн энэ өсөлтийг бодит тооцоолол уялдах энэ нь өөрөө иргэнд бодитоор амьдралд нь нөлөөлөх болгох вэ? Энийг бид маш тооцоотой хиймээр байна.

Сая валютын нөөц гэхэд л 1 аравны нэмэгдсэн, 4 аравны ингээд өнөөдөр чинь бараг 4 тэрбум ам.доллар-т хүрлээ гэж байна шүү дээ, 1,3 тэрбумаар нэмэгдсэн гээд. Валютын нөөц нэмэгдлээ гэдэг. Гэтэл энэ нефть бүтээгдэхүүний үнэ бас өсчихсөн л ингээд байгаад байдаг. Тэгээд энэ 2-ын балансыг бид яаж барих ёстой юм. Төсвийн хүрээний мэдэгдлээ төсөвтөө, мөнгөний бодлоготойгоо уяад энэ өөрөө иргэнд тэр цалинд нь, тэтгэвэрт нь яг юмны үнэ дээр очмоор байна л даа. Гэтэл эргээгээд ингээд юмны үнэ өсөөд байгаа, сая би хэлж байна тог цахилгааны үнэ өсчихлөө гээд. Тэгээд яаж энийг ингэж зөв тооцоолох ёстой юм бэ? Энэ дээр би бас салбарын хүмүүсээс бодит мэдээллийг авахыг хүсэж байна.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн өсөлтийн талаар Эдийн засгийн хөгжлийн яамнаас бэлдэж байгаарай. Урсгал зардал 4,9 их наяд буюу өмнөх оныхтой харьцуулахад 22 хувиар өссөн байгаа. Таны асуугаад байгаа асуулт хариулт нь энэ тоон дотор байгаа юм шүү. 4,9 их наядын 65 хувь нь яг ард иргэдийн гар дээр шууд очих цалин тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдэл байгаа. Та бид 2 хоёрхон сарын өмнө 7 сард төсвийн тодотголоор энэ оны сүүлийн хагас жилд цалин тэтгэвэр тэтгэмжийг нэмсэн. Тэнд 1,7 их наядыг хоёулаа баталсан. Энэ маань ирэх жил бүтэн жилээрээ болохоор 3,4 их наяд болоод нөгөө 4,9-ийнх чинь 65 хувь нь ингэж тайлбарлагдана.

20 хувь нь болохоор Боловсролын хууль болон Нийгмийн даатгалын багц хууль гээд хуулиар заалт орсон батлагдсан шууд төсвийн нөлөөллүүд орж ирнэ. Ялангуяа Нийгмийн даатгалын багц хууль батлагдсантай холбогдуулж шинэ заалтууд орсон. Шинэ зохицуулалтууд орсон. Энэ дээр төсвийн урсгал зардал нэмэгдэнэ, төсвийн татаас нэмэгдэнэ. Нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ харж байгаа эцэг эхчүүдийн НДШ-ийг төр 100 хувь дааж байна. Нөгөө 7 жилийг 5 жил болгосон. Малчдын 50 хувь гээд 2 хувийг мөнгөжүүлнэ гээд нийтдээ 485 тэрбум төгрөг шууд орж ирж байгаа гэсэн үг. Шууд орж ирж байгаа. Боловсролын багц хууль дээр ч гэсэн нөгөө багш нарын 5 жил тутам өгдөг тэтгэмжийг 3 жил болгосон, багш нарын хүүхдүүдийг мөн төрөөс даадаг сургуулийнх нь сургалтынх нь төлбөрийг төлдөг болсон гээд ийм шууд зардлууд орж ирж байна. Энэ дээр нэмэх нь мөн ирэх жил болох нэг удаагийн үйл явдлууд байгаа. Олимп байна, сонгууль байна, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын нэг удаагийн тэтгэмжүүд тавигдана гээд мөн уул уурхай дээр бид нар нэг

удаагийн томоохон урсгал зардлуудыг тавьж байж, бид энэ хайгуулын болон бид эрдэс баялгаа эргэлтэд оруулах ийм томоохон алхам хийхгүй бол энэ олон жил бид нэлээн хайгуулын бодлогоо алдсан гэх мэт ийм зардлууд бол 25 хувь нь байгаа.

Нөгөө сонгуулийн жил бүтээн байгуулалтыг огцом өсгөөд амсуулж тавиад дараа дараагийн төсөвт хүндрэл учруулах гэж байна гээд ийм хардлагууд ярьдаг. Тэгвэл хөрөнгө оруулалтын зардал ердөө 300 тэрбум, 4,9 их наядын дөнгөж 6 хувь нь л байгаа. Ингээд 4,9 их наяд маань бол зайлшгүй бид бодлогын хувьд яг таны асууж байгаа өрх гэр лүү, айл өрхөд очих ийм төсвийн бүх сувгууд дээр очиж байгаа гэсэн үг. Ер нь бид инфляцтай уялдуулж чадваас ер нь төсвийн нэг төгрөг болгон төсвийг дэмждэг, эдийн засгийн хөгжлийг дэмждэг ийм зүй тогтолтой байдаг.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Үндэсний номын сангийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан, номын цагаан буян үргэлж дэлгэрч байх өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлъя. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна. Байж байгаарай.

**Ш.Адьшаа:** Өнөөдөр /үг тасрав/

**Г.Занданшатар:** Адьшаа гишүүнийг шинээр эхлүүлчих, түр байж байгаарай. Тодруулж хариулъя гээд байна. Эдийн засгийн хөгжлийн дэд сайд Түвдэндорж, Гантөмөрийн Түвдэндорж 81.

**Г.Түвдэндорж:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Хагас жилийн байдлаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт 6,4 хувь байна, манай төсөөллөөр жилийн дүнгээр 6 хувь байхаар төсөөлж байгаа, 24 оныг оны төсөөллийг эдийн засгийн өсөлтийг бол 7

хувьд хүрч өснө гэж бол тооцоолж байгаа. Үүнд ямар өсөлтүүд нөлөөлөх вэ гэхээр уул уурхайн салбарын өсөлт 17 хувиар, уул уурхайн бус салбар 5,5 хувиар өсөхөөр байж байгаа. Хамгийн гол энэ яг тантай бол санал нэг байна. Эдийн засгийн өсөлт тоон дүнгээрээ өсөөд байдаг, иргэдийн орлого амьжиргаа дээр яг төдийлөн энэ эдийн засгийн өсөлт болбол наалдахгүй хүртээмжгүй байдлууд болбол байгаад байгаа гэдэг асуудлууд байгаа. Тэгэхээр ЗГ-аас баримталж байгаа бодлогын хувьд болбол ерөөсөө эдийн засгийг төрөлжүүлэх шаардлагатай. Уул уурхайгаас, манай эдийн засаг бол уул уурхайн салбараас түлхүү гол эдийн засгийн өсөлтүүдийг гаргадаг, экспортын орлогууд бол уул уурхайн салбараас гардаг байж байгаа.

Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яамнаас 2024 оны жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа иргэдийн орлогыг хамгаалах зорилт тавьж, үүнийхээ хүрээнд бол экспортыг нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг илүү нэмж, эрчимжүүлж гаргах, яг экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр бол зорилт тавин ажиллаж байгаа. Үүнийхээ хүрээнд бол гааль, боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөгжлийн асуудлуудыг нэмэгдүүлэх ийм бол зайлиггүй шаардлагууд байгаад байгаа юм. Хамгийн гол асуудал болбол уул уурхайн салбарын эдийн засаг иргэдийн ажиллах хүчний 5 орчим хувийг бүрдүүлдэг 60-аас 70 мянган хүн уул уурхайн салбарт ажилладаг. Бусад салбарууддаа болбол энэ эдийн засгийн өсөлт нь болбол наалдахгүй байгаад байгаа.

Тэгэхээр ерөөсөө ХАА-н салбар, аялал жуулчлалын салбар, тээвэр үйлчилгээ, барилгын салбаруудыг бол бодлогоор дэмжих болбол зайлиггүй шаардлага байгаа. Иргэдийг иргэдэд энэ эдийн засгийн өсөлтийг хүртээхийн тулд бол ерөөсөө 2 замаар хүртээнэ гэж болбол бодож байгаа. 1 дүгээрт бол

мэдээж төсвийн бодлогоороо дамжуулна. Төсвийн бодлогоор цалин, тэтгэвэр, тэтгэмж үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх, хүн амын өсөлт, үнэ тарифын өөрчлөлттэй холбоотой зардлуудыг тусгаж болбол төсвийн бодлогоороо дамжуулж хэрэгжүүлэх болбол зайлиггүй шаардлага байгаа. Уул уурхайн салбараас олж байгаа орлогыг хуримтлуулаад, Үндэсний баялгийн сангийн тухай хууль хуулийн төсөл болбол явж байгаа, төсөл болбол ажлын хэсэг бол байгуулагдаад ажиллаад явж байгаа. Үүгээрээ дамжуулж Эрдэнэт, Тавантолгой төрийн өмчит энэ уул уурхайн салбар гол орлого олж байгаа компаниудаас олж байгаа.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулъя.

**М.Оюунчимэг:** Сая Түвдэндорж дэд сайд ч хэллээ. Сангийн сайд хэлээд байна л даа. Нөгөө мөнгөний бодлого, төсөв, төсвийн хүрээний мэдэгдлүүд чинь хоорондоо уялдах ёстой. Өнөөдөр тоон үзүүлэлтүүд нь хүртэл зөрөөтэй байгаад байна шүү дээ. Монголбанк бол түрүүн хэлж байна ер нь л жоохон ингээд болгоомжтой эдийн засгийн өсөлтийг хүртэл 6,5, ДНБ-ий нэрлэсэн үнийг 70 их наяд гэж жишээ нь харахад, энд 74 их наяд гээд. Тэгээд сая Сангийн сайд хэлээд байна урсгал зардал 4,9 их наядын 65 хувь цалин хөлс тэтгэвэр тэтгэмжид явж байгаа. Энэ чинь зүгээр нөгөө угаасаа төсөвт суудаг болохоос цалин хөлс л тэтгэвэр тэтгэмжийн байдаг болохоос биш яг нэмэгдээд ингээж орж ирж байгаа зүйлүүд бас биш байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нар нөгөө нэг энэ эдийн засгийн өсөлттэй уялдаад, инфляц энэ цалин хөлсний доод босгыг илүү жоохон нэмээд ороод ирчих бололцоо энэ эдийн засгийн өсөлттэй уялдаад байгаа юу? Энийг бид нар төсөв, төсвийн хүрээний мэдэгдэлдээ уг нь тусгачих бололцоо байна уу гэж би асуугаад байгаа

юм л даа. Тэрнээс биш энэ чинь нөгөө доод босго, багш нарынх.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Тэгээд яг юу асуучхав. Та 2 наанаа ярьчихаж болохгүй байгаа юм уу? Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Харин би уг нь хэлээд л байгаа юм, тэгээд заавал микрофон дээр хариулт авна гээд байгаа юм. Би микрофон дээр хариулья. Сая хоёрхон сарын өмнө хоёулаа сууж байгаад цалингийн сууриудаа нэлээн нэмчихсэн шүү дээ. Тэгэхээр бид нар ийм ойр ойрхон ингээд дахиад л нөгөө инфляц руугаа очиж очоод чөтгөрийн тойрог руу явж байгаа юм л даа. Гэсэн хэдий ч бид ирэх жил 10 хувиар цалин, тэтгэвэр тэтгэмжийг нь инфляцтай уялдуулж нэмэхээр ингэж тооцож төсвөө өргөн барьсан байгаа. Та багш нарын цалинж ярьж байх шиг байна. Энд Боловсролын сайд хариулах байх. Мөн ХНХ-ын сайд нэмээд хариулчих байх. Тэгэхээр 4,9 их наяд буюу энэ төсвийн энэ нэмэгдэл энэ урсгал зардлыг ер нь 70 хувь нь таны ярьж байгаагаар яг өрхийн эдийн засгийн боломжийг нь нэмэгдүүлсэн, дэмжсэн ийм л төсвийн бодлого байгаа шүү.

**Г.Занданшатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

**Ш.Адьяшаа:** Энэ Уул уурхай сайдаас юм асууя. Уул уурхай сайд байна уу? Өнөөдөр улсын төсөв бид хэлэлцэж байна Улсын Их Хурал. Энэ Улсын Их Хурлын төсөв хэлэлцэх үед бас энэ бодлогын шинж чанартай олон асуудлыг энд оруулж ирэх, ярилцах ийм шаардлага байна гэж үзэж байгаа. Энэ төгрөгийн ханиш бол их суларсан. Энэ төгрөгийн ханиш суларсантай холбогдуулж энэ валютын нөөцийг нэмэгдүүлэх талаар энэ Монгол Улсын Сангийн яам, Монголбанкнаас ямар асуудлыг авч хэрэгжүүлэх гэж байна гэдэг талаар нэг хариулт авмаар байгаа юм. Яагаад гэхээр уул уурхайн энэ бүтээгдэхүүн бид экспорт дээр 17 хувь нэмэгдүүлээ гэдэг ийм асуудлыг өнөөдөр энэ хариуцлагатай

хүмүүс яриад байна л даа. Гэтэл өнөөдөр энэ ОТ бусад энэ уул, экспортод гаргаж байгаа энэ ашигт малтмалын төлбөр чинь Монгол Улсын банк санхүүгээр орж ирдэггүй, энийг оруулж ир гэж олон удаа ярьсан. Гэтэл энэ дээр ямар ч асуудал оруулж ирдэггүй, цаасан дээр л бид нар өнөөдөр ингээд л тэдэн сая доллар тэдэн тэрбум долларын ийм ашигт малтмал зарлаа гээд байдаг, Монгол Улсын банкаар орж ирэхгүй. Үүнээс чинь болоод энэ төгрөгийн ханиш суларч байна гэдгийг бид удаа дараа ярьж байгаа. 4 жилийн өмнө бид нар 2 мянган төгрөгөөр худалдаж авсан юмаа өнөөдөр 20 мянган төгрөгөөр худалдаж авч байна. Тэгээд энэ дээр энэ төрийн захиргааны Төв банк энэ банк санхүү хариуцсан энэ Монголбанк ямар асуудал байна гэдэг талаар нэг хариулт авъя.

Дээр нь өнөөдөр энэ 1072 хувьцааны асуудал ярьж байгаа. Энд энэ БЭТ байж байна. Тэр иргэдийн 1072 хувьцааны ашигтыг хэзээ өгөх юм бэ? Тэр төмөр зам руу оруулчихлаа бид нар 870 тэрбум төгрөг гээд, энэ БЭТ-ээс энийг би асууя. Дээр нь өнөөдөр энэ нефтийн хомсдол болж байгаа. Ер нь цаашидаа ч болох байх. Тэгэхээр энэ Энэтхэгийн засгийн газраа газрын хөрөнгө оруулалтаар нефть боловсруулах үйлдвэрийг бид барина гэж 5, 6 жил ярьж байна. Гэтэл энэ нь энэ нефть боловсруулах үйлдвэрийг барих явцад Монгол Улсын ЗГ, Уул уурхайн яам тодорхой ийм мөнгө оруулах ийм үүрэг хүлээсэн юм шиг байгаа юм. Хэдэн төгрөгийн санхүүжилт хийх үүрэг хүлээгээд, бид нар бол хэдэн төгрөгийг нь энэ хийчхээд байна гэдэг нэг хариулт авмаар байна. Энэ нефтийн үйлдвэрийг бид оруулахгүйгээр олон асуудал байгаа л даа. Энэ нефтийн үйлдвэр дээр. Энэ талаар асуулт асууя.

Дээр нь бол өнөөдөр ажиллах хүчний хомсдолд орсон Монгол Улс. Тэгээд энэ хомсдолоо бид арилгахын тулд төсвийн бодлогоор энэ ажиллах хүчний хомсдолыг бууруулахын тулд ямар

төсвийн бодлого энд барьж явж байна гэдэг энэ асуудлуудаар хариулт авмаар байна.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? ОТ-н татварыг яагаад оруулж ирэхгүй байгаа юм бэ гэж байна, 1 их наяд билүү хэд билээ? Тэр чинь нөгөө маргаантай байгаа асуудлыг хэлж байна уу? Яг тодорхой алийг нь хэлж байгаа юм бэ та? Татварын маргааныг ярьж байна уу аль эсвэл өөр юу авъя гээд байгаа юм бэ? Хэн хариулах вэ? Адьшаа гишүүний асуултад хариулах хүн байна уу? Танд ч хамаагүй л дээ энэ. Жамбалын Ганбаатар сайд.

**Ж.Ганбаатар:** ОТ-н асуудлаар бол Монгол Улс Амнат авч байгаа, зэсээсээ болоод алтнаасаа. Энийг бол Уул уурхайн яам хариуцлагатайгаар хэлье. Бусад асуудал дээр нь Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам хариулах байх. Монгол Улс ОТ-н гаргаж байгаа баялгаасаа бол Ашигт малтмалын хуулийн дагуу авах ёстой татвараа бүгдийг нь авч байгаа. Зарим хүмүүс нөгөө алтаа зүгээр гаргачихлаа гээд тэгдэг юм байна лээ. Алтаа бол зүгээр гаргадаггүй амнатаа бол тултал нь авч байгаа гэдгийг хэлье. Тэр нефтийн үйлдвэрийн хувьд бол зээлээр хийгдэж байгаа. Энэтхэгийн ЗГ-ын зээлээр хийгдэж байгаа асуудал. Тэгээд баригдах хугацаа нь, та байж байгаарай. Тэгээд ер нь бол баригдах хугацаа нь 2, 3 жилээр, энэ бол коронатай л холбоотой. Тэгээд нөгөө хугацаа хойшилсон. Өнөөдөр бол та баригдана гэж яригдаад байгаа гэж ярьж байна Адьшаа гишүүнээ, баригдаж байгаа шүү, очиж үзэх хэрэгтэй, очиж үзэх хэрэгтэй, хамт явж болно. Хамт яваад очоод үзэх хэрэгтэй, чадлаараа баригдаж байгаа.

Тэгээд хоолойны асуудал бол харин нэлээн сайн явж байгаа. Үйлдвэрийн барьж байгаа процессын асуудал бас Коронагаас болоод нэлээн бас ганц, 2 жил хойшилсон зүйлүүд бол байна. Тэгээд дизелийн юм уу нефтийн хувьд хомсдол бол үүссэн юм бол байхгүй шүү Монгол Улсад. Сая бол харин ОХУ-аас гэв гэнэт

шийдвэр гарсан, тэгээд бид харин нөөц сайтай байсны үр дүнд бараг та надаас асууж байсан санагдаж байна. Бичгээр ч ирсэн байх. Энэ Ангарскийн үйлдвэр 2, 3 сар зогсох нь, та ямар бэлтгэлтэй байна вэ? Манай яам бэлтгэлтэй байсны хүчинд 20, 20 хоног бид ямар нэгэн асуудалгүйгээр энэ хомсдол үүсгэхгүйгээр гарсан. Одоо бол жигдэрсэн. Гэхдээ асуудлууд бол бага сага байна. Зарим колонкууд бол зарим нь бол байна, зарим нь байхгүй байна. Энэ бол бас ААН-үүдтэй холбоотой асуудлууд бол байгаа. Энэ долоо хоногоос бол жигдэрчих байх гэж бодож байна. Хариулж дууслаа.

**Г.Занданшатар:** Бензин шатахуун асуудалгүй болсон. Тэгэхдээ энэ татварын газар хариулсан нь дээр байх. Тэгвэл Бямбарагчаагийн Тэлмүүн хариул, сайд тултал нь авдаг гээд хэлчихлээ шүү дээ амнат. Эрдэнэттэй адилхан төлж, өөрсдөө л юманд уналаа шүү. Тэгвэл Эрдэнэттэй адилхан авч байгаа юм байна гэж бид ойлгох нь байна шүү дээ тийм ээ. Өсөн нэмэгдэх Амнатыг цэс дээр Эрдэнэт төлж байгаа, тэгээд ОТ яг адилхан төлж байгаа юм уу, төлөхгүй, байгаа юмыг тултал нь авч байгаа гээд хэлчихвэл та нар тэгээд. Тэгвэл тэр хуулиа өөрчлөхгүй юү. Ганзоригийн, Адьшаа гишүүн. 1072 хувьцааг хэн хариулах юм бэ? 82 Жигжидийн Ганбат ТНБД.

**Ж.Ганбат:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. ЭТГ компанийн нийтдээ юуны 81,51 байна Эрдэнэс Монгол компани, 2012 оны 4 сараас өмнө төрсөн 2511332 иргэн бол 18,43 хувь нь эзэмшиж байгаа. Энэ компани бол өмнө нь 2019 оны ноогдол ашигийг 20 онд бол олгож байсан юм байна лээ. Нэг хүнд бол нэг иргэнд 96 мянган төгрөг олгож байсан. Ингээд 180 гаруй тэрбум төгрөгийг бол 19 оны ашгаас 20 онд тараасан. Ингээд 20, 21 онд ковидын үе гэж болоод 22 оны ашгаас бид иргэдийн ноогдол ашиг орох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа энэ оны 4 сард хуралдаад онцгой дэглэм дууссаны дараа

энэ асуудлыг авч үзье гэдэг ийм байдлаар бол шийдвэрлэсэн байгаа.

Яах вэ бид бол энэ ноогдол ашгийг бол компанийнхаа зарим, зарчмын дагуу яах вэ санхүүгийн тайлан гараад, аудит ороод тэрний дараа бол ноогдол ашгийг тараах нь бол зүйтэй юм гэдэг ийм байр суурийг бол баримталж байгаа. Тэгээд яах вэ засгийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр бол онцгой дэглэмийн дараа бол энэ асуудлыг 22 оны ноогдол ашгийг иргэдэд тараах асуудлыг шийдвэрлэнэ гэдэг ийм бол шийдвэр гаргачихсан учраас энэ онцгой дэглэмийн дараа энэ асуудлыг авч үзнэ гэдэг ингэж байгаа. Тэгэхээр бол өгнө. Ийм байдлаар байгаа.

Төмөр замд 20, 21 оны ноогдол ашиг энэ тэр гээд ЭТТ компани яах вэ яг төмөр зам, Гашуун сухайт төмөр зам, Тавантолгой төмөр замд бол санхүүжигч байдлаар бол оролцоод, нийтдээ бол яг энэ төмөр зам дээр бол 3,2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг бол саяын 2 хэлдэг төмөр зам дээр бол Эрдэнэс таван толгой компаниас бол санхүүжүүлсэн байгаа. Яах вэ ЭТТ компани бол энэ оруулсан хөрөнгөө бол бид буцааж бол хөрөнгө оруулалтаа нөхнө гэдэг ийм байдлаар бол тооцоо юмнууд нь хийгдээд, ингээд бол ажиллаад явж байгаа.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд. ОТ-той бол.

**Б.Жавхлан:** Адьшаа гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье. Тэр нефт боловсруулах үйлдвэр гишүүнээ ийм байгаа шүү. Энэ 3 төрлийн санхүүжилт байгаа юм, 3 хэсгээс бүрдэж байгаа юм. Монголын тал гэж байна, зээлээр санхүүжүүлж байгаа хэсэг байна, газрын тос дамжуулах хоолой гээд ийм 3 хэсэг санхүүжилт байгаа юм. Сая бүтээн байгуулалтын хувьд бол яг ковидын үед сая Ганбаатар сайдын хэлж байгаа үнэн ер нь бол саатсан ковидын үед. Одоо бол саадгүй цаашаа явж байгаа. Энэ жил ялангуяа бид нар энэ гадаад зээлээр

санхүүжүүлэх хэсэг дээр нь бол нэлээн дэвшилттэй ажлуудыг хийж амжууллаа. Бүтэн дүнгээрээ явж байсан бол бид нар ЕРС 1, 2, 3, 4 гээд салгаад зэрэг санхүүжүүлж эхлэхээр ийм их сайн дэвшилттэй дараагийн алхмаа хийсэн. Тэрний дагуу эхний санхүүжилтүүд нь буюу нэмэлт санхүүжилтүүд нь шүү ингээд 10 сараас бүх төслүүд дээрээ зэрэг эхэлж байгаа нь их сайн хэрэг. Монголын талынх нь бол Хөгжлийн банкин дээрээс хийгдээд явж байгаа, нийтдээ 248,7 тэрбум төгрөг санхүүжих ёстой юм байгаа юм. Энэ нь бол графикийнхаа дагуу явж байгаа. Гэхдээ бүтээн байгуулалттай нь холбоотойгоор Хөгжлийн банкны бас зээлжих хуулийн хязгаараас болоод бас удаашраад байгаа талууд байгаа. Гэхдээ хүндрэлгүй зүйл гэж юу байх вэ энэний цаана бол гарна. Тэгээд том бүтээн байгуулалтын ажил бол саадгүй явах ийм шат руугаа орсон.

**Г.Занданшатар:** Ямар ч байсан тэгвэл ОТ-н татварыг тултал нь авч байгаа 1 их наядын татварын маргааны асуудал шийдэгдээд төсөвт тусгасан гэж бид ойлголоо шүү. Төсөв дээр тэрнийг ярья. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. Сая тултал нь авч байгаа гэж авчихсан гэж хэлсэн. Төсөв дээр л ярья, харья.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хуралд 2024 оны төсөвтэй холбогдуулаад бас энэ төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн төсөөллийн хуулийн төслийг бол хэлэлцэж байна. Тэгэхээр би зүгээр 1, 2, 3 зүйлийг онцолж хэлэх гээд байгаа юм. Энд юу гэхээр 1 дүгээрт төсвийн хүрээний мэдэгдэл гэвэл өөрөө энэ макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт. Ирэх оны төсөөлөл, таамаглал өөрөө ямар байх вэ, ирэх онуудад бид нар ямар эдийн засгийн бодлого баримтлах вэ гэдэг гол үндсэн ерөөсөө бодлогын баримт бичиг бол энэ төсвийн хүрээний мэдэгдэл байгаад байгаа.

Тэгэхээр бид нар Улсын Их Хурлаас дөнгөж энэ зун 7 сарын 7-нд батлагдсан



төсвийн шинэчлэлийн хуулиудын хүрээнд бол төсвийн хүрээний бодлогын баримт бичгийг хэн нь баталдаг байх юм, хэн нь боловсруулдаг байх юм, хэн нь төсөөлж оруулж ирдэг байх юм энэ чиг үүргийн гол ялгаа заагуудыг бид нар нэлээн гаргаж өгсөн. Яах вэ нэг талдаа 7 сард баталсан ч гэсэн бид нар энэ ирэх оноос бол бүрэн утгаар хэрэгжих ёстой байгаад байгаа юм. Тэгэхээр би хэлэх гээд байгаа гол зүйл юу вэ гэхээр бид нар ерөөсөө төсвөөсөө өмнө эхэлж бид нар заавал ч үгүй төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг хэлэлцдэг байх энэ дэгийг энэ өнгөрсөн оноос хийгээд тогтоож эхэлсэн байгаад байгаа шүү. Өмнө нь бол та бүхэн гишүүд бүгдээрээ мэдэж байгаа байх, төсөв хэлэлцдэг дагалдсан баримт бичиг шиг дараа нь дараагийн 7 хоногт нь төсвийн хүрээнийхээ мэдэгдэл, түүний өөрчлөлтүүдийг хэлэлцдэг байсан. Тэгэхээр бид нар энэ жилээс эхлээд гол бодлогынхоо баримт бичигтээ бид нар өөрчлөлт оруулах юм уу үгүй юм уу, тэрийгээ эхэлж яриад, тэрэн дээрээсээ үндэслээд дараа жилийнхээ төсвийг төсөвлөдөг энэ хандлагын өөрчлөлтийг төсвийн хүрээний шинэчлэлийн хуулиудын хүрээнд бол 1 дүгээрт хийсэн байгаад байгаа юм.

Хоёрдугаарх гол асуудал би энд өнөөдөр Эдийн засгийн хөгжлийн яамны гол бодлогын газрын дарга нар, хэлтсийн дарга нар гол хүмүүс би энэчээ байгаа болов уу гэж харж байна. Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам дараа жилээс эхлээд төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулдаг болж байгаа. Өмнөх хуулийн хүрээнд бол Сангийн яам бол боловсруулж орж ирж байсан бол дараа жилээс энэ гол ерөөсөө макро эдийн засгийн үндэслэл тооцоолол төсөөллийг Эдийн засгийн хөгжлийн яам оруулж ирнэ. Эдийн засгийн хөгжлийн сайд нь асуултад хариулдаг болно. Та бүхэн жил тойрч бүх тооцоо судалгаа, тооцооллуудыг бол хийдэг болох энэ чиг үүргийг бол бид нар энэ хуулийн хүрээнд бол гаргаж өгсөн байгаад байгаа юм. Яагаад вэ гэхээр бид нар шинэ Эдийн

засгийн хөгжлийн яамтай болсон. Иргэд ч, бид бүхний хувьд ч хүлээлт байгаад байгаа. Эдийн засгийн хөгжлийн яам макро эдийн засгийн гол ерөөсөө судалгаа төлөвлөлтүүдийг гаргадаг байх үндсэн чиг үүрэгтэй болсон.

Тэгэхээр би та бүхнийг Эдийн засгийн хөгжлийн яамыг бол одоогоос эхлээд энэ бэлтгэлээ хангаж яг энэ макро эдийн засгийг тогтворжуулах бодлогынхоо судалгаануудыг би хийж эхэлсэн, хүний нөөцөө бүрдүүлсэн, эдийн засгийнхаа тэр загварчлалуудыг тооцоолол моделиудыг болбол гаргаад хийгээд явж байгаа гэж би харж байгаа. Хэрэв яг Макро эдийн засгийн газрынх нь дарга нь ч гэдэг юм уу энэ хүн бол та бүхэн бас бид нарт мэдээлэл өгөөрэй. Та бүхэн жил тойрч яг Монгол Улсын макро эдийн засгийн цаашид 5 жил байна уу, дараа жилтэй холбоотой байна уу, тооцоо судалгаа дүн шинжилгээг тогтмол хийдэг байх ёстой байгаад байгаа юм. Эдийн засгийн ямар загварчлалыг ашиглаад байгаа юм бэ? Магадгүй хэд хэдэн загварчлал дээр тооцоод, хэд хэдэн хувилбаруудыг гаргаад ингээд хийдэг байх энэ үндсэн үүрэг болбол гарч ирсэн байгаад байгаа шүү гэдгийг хэлэх гээд байгаа юм.

Яагаад вэ гэхээр ерөөсөө бид нарын хувьд болбол асуудал болбол байна. Макро эдийн засаг дээр нэг талдаа. Өөрөө жижиг эдийн засагтай, нээлттэй эдийн засагтай нэг талдаа давуу тал нь. Гэсэн мөртөө гадаад худалдаа хөрөнгийн урсгалаа бараг бүрэн либералчилчихсан, эдийн засгийн өрөөсгөл бүтэцтэй байгаад байгаа. Тэгэхээр энэ болгон бид нар өөрөө өөрсдийнхөө энэ онцлог дээр суурилсан энэ загварчлал модель л хэрэгтэй байгаад байгаа юм. Би зүгээр нэг жишээг хэлэхэд яагаад төрийн зохицуулалт, энэ бодлогын уялдаа, зохицуулалт хэрэгтэй байгаад байна энийг хийх ёстой газар нь Эдийн засгийн хөгжлийн яам байна байх ёстой байгаад байна, зангилаа газар нь өөрөө энэ байх ёстой байна гэдгийн зөвхөн нэг жишээг хэлэх гээд байгаа юм. Адаглаад

ажиллах хүчинтэй холбоотой асуудлууд дээр эдийн засгийнхаа ерөнхий төлөвлөлтийнхөө хүрээнд бид нар шаардлагатай мэргэжилтнийхээ тоог нь тооцооллыг нь гаргаж, түүндээ таарсан боловсролын элсэлт гэдэг юм уу, татаас эдлүүлэх байдаг юм уу энэ бодлогоо гаргах ёстой байгаад байгаа юм. Тэгэхээр та бүхэн чинь яг энэ судалгаагаа хийж чадаж байна уу?

**Г.Занданшатар:** 83.

**Л.Энх-Амгалан:** Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Хуулийн батлагдсан хувилбарыг аваад үзээд танилцаад явж байгаа. Эдийн засгийн төсөөллийн хувьд бол тодорхой загварууд хөгжүүлээд мөн дээр нь цаашидаа яг эдийн засаг яаж хөгжих юм бэ гэдэг бодлогын чиглэлээ тодорхойлоод, тэр хүрээндээ зорилтот өсөлт болон бусад макро төсөөллүүдээ тодорхойлоод ингээд ажиллаж байгаа. Дараа жил бол төсвийн хүрээний мэдэгдлийг манайхаас хуулийн дагуу оруулж ирэх байх.

**Г.Занданшатар:** Санхүү төсвийн судалгааны газрын дарга нь Золбоо хариулдаггүй юм уу, судалгаа байна уу гэж асуусан шүү дээ. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

**Г.Тэмүүлэн:** Үгүй ээ би зүгээр Эдийн засгийн хөгжлийн яамнаас асууж байгаа юм. Гол асуудал бол ерөөсөө энэ эдийн засгийнхаа яг бодлого талаасаа гол зохицуулалт хийж байх ёстой төрийн энэ зохицуулалтыг чинь хийж байх ёстой зангилаа газар чинь Эдийн засгийн хөгжлийн яам байх ёстой. Тэгэхээр ерөөсөө цаашидаа энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой, эдийн засгийн тооцоололтой холбоотой асуудлыг танай яам дан ганц хариуцаж оруулж ирдэг ирж байдаг байх ёстой, бүх тооцооллыг хийдэг байх ёстой. Яг үүнд чиглэсэн хүний нөөцөө бүрдүүлж, магадгүй доороо тэр судалгааны

хүрээлэнтэй байж Монгол Улсын магадгүй хамгийн гол ерөөсөө энэ бодлогын тооцоо судалгааг хийдэг байх энэ хүний нөөцийг бэхжүүлж, бодлогынхоо судалгааны хүрээлэнтэй ч гэдэг юм уу доороо энэ төвтэй байх энэ бодлогуудыг та нар хийх ёстой байгаад байгаа юм шүү. Яг энэ чиглэл дээрээ байж чадаж байна уу л гэдэг асуудлыг асуугаад байгаа юм.

Гэтэл дараа жил орж ирсэн яг бахь байдгаараа ч гэдэг юм уу, юу гэдэг юм шинэ яам бүрдсэн байж болно. Гэхдээ бид нар хугацаа өгөөд байгаа шүү дээ та бүхэнд. Бүтэн нэг жилийн дараа, дараа жилийн хавар 3 сард орж ирэхэд Эдийн засгийн хөгжлийн яам энэнд бэлэн байх ёстой байгаад байгаа юм. Эндээ хүн хүчээ зарцуулж, та бүхэн төлөвлөж чадаж байна уу?

**Г.Занданшатар:** Хариулт нь тодорхой юм байна, бэлдэж байгаа гэж хэлээч гэж байна. Тэгээд л тэгж л хэлэх юм байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн. Тэгж лавлах юм байна.

**О.Цогтгэрэл:** 24 оны төсөв орж ирж байна. Төсвийн зарлага 27 их наяд тэгээд ард иргэд энийг бас хэдий хэмжээний их тоо гэдгийг бас мэдэхгүй байх. Зөвхөн өнгөрсөнтэй харьцуулах юм болбол 20 оны төсөв 13,9 их наяд байж 20 оноос 4 дэх жил рүүгээ энэ парламентын хугацаанд Монгол Улсын төсөв 2 дахин нэмэгдэж байна. Төрийн зарцуулах мөнгө 4 жилийн дотор 2 дахин нэмэгдэх нь. Тэгэхээр энэ хугацаанд Монгол Улсын эдийн засаг 2 дахин өссөн билүү, ард иргэдийн орлого 2 дахин өссөн билүү гэдэг асуулт л яг энгийн харьцуулалт энэний цаана л ингээд явах нь. Тэгээд оруулж ирж төсөв оруулж ирж байгаа нөхдүүд тайлбарлахдаа төсвийн орлого нэмэгдэж байна гэдэг. Жишээ нь энэ дотор ганц л тоо ирэх жилийн дунджаар зэсийг 9 мянган доллароор тооцож байгаа юм байна. Өнөөдөр сүүлийн нэг сар лав тэр чигээрээ 7800, 900 орчим доллартой л байгаа байх. Тэгээд бүтэн жилийн

дунджаар тэгээд Хятадын эдийн засаг удааширч байна, зарим томоохон салбаруудад нь хямрал гарч байна гэдэг. Тэгээд 9 мянган долларын эрэлттэй байна гэдэг энэ хоосон төсөөллийн орлого дээр нөгөө талд нь ингээд баахан өндөр зарлага төлөвлөчихсөн нэг ийм нөхцөл байдалтай.

Тэгээд саяын нэмэгдэж байгаа тэр их хэмжээний олон их наядын төсвийн зарлагыг ард иргэдэд зарим цалин, тэтгэвэр, тэтгэмжээр очно гэнэ. Үгүй ээ энэ чинь очлоо, нөгөө талд нь инфляцыг л өдөөж байгаа шүү дээ одоо яг. Өнгөрсөн хугацаанд тэр төсвийн тодотгол ч гэсэн ийм л болсон, инфляцыг л өдөөж байгаа. Энэ мөнгүүд баруун гараараа энэ мөнгийг өгөөд зүүн гараараа буцаагаад суйлаад л авч байгаа шүү дээ нөхцөл байдал. Тэгээд ч ер нь өнгөрсөн хугацааны төсвийн бүхий л бодлого дээр бид нар бас эргэж харах ийм нөхцөл байдал шаардлагууд үүсэж байгаа. Төсвөөр асар их хэмжээний байшин барилга барихаар тэрийг дагаад тийм ажлын байр бий болдоггүй юм байна гэдгийг бид нар бас харлаа шүү дээ. Төсвөөр баахан халамж өгөөд байхлаар ядуурал буураад байдаггүй юм байна гэдгийг бас харлаа шүү дээ. Баахан халамж өгсөн, ядуурал хэдээс хэд болж буурсан юм бэ, төсвийн баахан байшин барилга барьсан энийг дагаж хэчнээн ажлын байр бий болсон юм бэ, энэ чинь болохгүй, төсвөөр явж байгаа энэ бодлогууд бүүр зарчмаараа бодлого маань буруу байгаад байна шүү дээ.

Тэгвэл энэ ховор хомс уг нь байх ёстой энэ орлого, зарлагыг бид нар зүй зохистой юунд зарцуулах ёстой байсан билээ? Яг одоо өнөөдөр ингэж баруун гараараа төсөв цалин тэтгэвэр нэмээд, зүүн гараараа энийг нь суйлж авч байхын оронд одоо бид нар энэ эрчим хүчнийхээ асуудал дээр дорвитой шийдэл гаргая л даа. Гадаад улс орнууд нүүрс санхүүжүүлэхгүй гээд Монгол Улс Эрдэнэс энэ Тавантолгой дээр ч хийж чадахгүй, 5 дугаар цахилгаан станц гээд эх үүсвэр байхгүй л гэж байна. Энэ энд

чинь саяын тэр төсвийн нэмэгдлийн талаар нь бараг энийг хийчих л юм байна шүү дээ. Энэ чинь зөвхөн эрчим хүч чинь хөгжлийг боомилгогч хүчин зүйл болчихоод байна. Энэ утаа түгжэрэл энэ бүх юм чинь эрчим хүчнээсээ болж байна. Гэтэл энэ зорилтот энэ том ажил үйл хэрэг байхад бид нар яагаад энэ рүүгээ энэ төсвөөсөө бас хандаж байгаа боддоггүй юм.

Тэгэхдээ яах вэ төсвөөр ийм зүйл хийхийг би миний хувьд болбол бас зөв гэж бас боддоггүй. Тэгэхдээ яг өнөөдөр эрчим хүчний салбар маань үнийг нь барьчихсан, тэнд гадна, дотнын хөрөнгө оруулагч орж ирэх боломжгүй энэ нөхцөлд өөр яг яалтай билээ. Гол тэр бодлогыг нь үзүүр яг энэ улс оронд өнөөдөр хөгжил дэвшилд хэрэгтэй болчихоод байгаа, хөгжлийг боомилчихоод байгаа, хөгжлийг боомилох биш өвөлдөө бараг лаа барьж магадгүй болчихоод байгаа гэх мэтийн энэ олон зүйл рүүгээ бид нар чи яагаад чиглүүлэхгүй ингэж газрын нэг тарааж хаяж, тэгээд энэ нь эргээд инфляцыг өдөөж, үнэгүйдлийг өдөөсөн ийм бодлогыг энэ төсөв болоод энэ төсөвтэй холбоотой хэдэн жилийн төсөөллүүд дээр яг ийм байдалтай явах ёстой юм бэ? Энэ дээр энэ бодлогын өөрчлөлт гэдэг зүйл гарч ирэх ёстой юм биш үү? Энэ яагаад, яагаад төсвийн бодлого нэг ийм төвлөрөлгүй зүгээр бүхнийг шийдэх гэсэн, тэгсэн мөртөө тэр орлого хүртэл үндэслэлгүй ингээд үндэслэлгүй гэж. Тэгэхдээ тэрийг хэн ч мэдэхгүй, гүйцэтгэлээрээ л гарч ирнэ л дээ. Тэгэхдээ л өнөөдөр 7 мянга байгаа зэсийг ирэх жилийн дундаж 9 мянга гэж төсөөлж тавьж байгаад газрын нэг тараасан нь яг л ийм л төсөв, ийм л төсвийн төсөөлөл орж ирж байна л гэж бодож байгаа. Тэгээд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулт өгье.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ер нь том эдийн засгийн агуулгаар нь бол тантай санал нийлж байна асуудлууд дээр. Гэхдээ төсвөө хэдүүлээ нэг сайн хараад унших

юм болбол ер нь таны агуулгууд ер нь суусан байгаа шүү. Ер нь нэлээн ханатай суусан байгаа. Зэсэн дээр ийм байгаа шүү тогтоол гишүүнээ энэ чинь тэнцвэржүүлсэн үнэ гэж бид нар авдаг байхгүй юу. Энэ 9 мянга чинь бол зах зээлийн үнэ, аль багаар нь бид нар орлогоо тооцоолдог гэсэн үг. Тэнцвэржүүлсэн үнэ маань 7386 байгаа. Тэгэхээр энэ 24 оны төсвийн орлого маань зэс дээр бол 7386-гаар шүү. Нүүрс дээр 140 гэж байгаа, тэнцвэржүүлсэн үнэ маань 180 байгаа, багаар нь 140-өөр авсан байгаа. Бид нар орлогоо тооцоолохдоо тэнцвэржүүлсэн орлогоо тооцоолохдоо тэнцвэржүүлсэн үнэ буюу сүүлийн 17 жил, энэ жил, дараагийн 3 жил энэ дунджаар нь авдаг. Тэр үнэ нь бодит үнэ рүүгээ нэлээн дөхөж очсон ийм үнэ байгаа. Тэр 9 мянга бол зах зээлийн үнэ шүү.

Эрчим хүч дээр 100 хувь, 200 хувь ч тантай санал нийлж байна. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ер нь хамгийн тулгамдсан асуудал болбол энэ эрчим хүчний сэргэлтийн асуудал байгаа. Бид эрчим хүчээ тэлэхгүйгээр энэ боомосоо салахгүйгээр аж үйлдвэрийн сэргэлт, зам, замын зам боомтын сэргэлт гээд бусад сэргэлтийг бид ярих ямар ч боломж байхгүй. Тийм ч учраас ирэх жилийн хөрөнгө оруулалт 1,1 их наяд төгрөг эрчим хүчин дээр байгаа, хамгийн том хөрөнгө оруулалт ийшийгээ байгаа шүү. Хүмүүс энэ зөвхөн энэ нөгөө төсвийн ном дээрээс хараад төсвийн төсвөөр дамжуулж байгаа зарцуулалт хийж байгаа тэр хөрөнгө оруулалтаар л хязгаарлаж хараад байгаа юм. Тэн дээр нэмэх нь гадаадын зээл тусламжаар хийгдэж байгаа маш том төсөл, хөрөнгө оруулалтууд байгаа эрчим хүч дээр.

Бид сургууль, цэцэрлэгээ болбол төсөв дээрээсээ бариад сурчихсан. Эрчим хүчний нэг төсөл гэхэд л 50 сая доллар, 90 сая доллар гээд томоохон хөрөнгө оруулалтуудыг богино хугацаанд шаарддаг. Энийг бол төсөв дээрээс бид шууд зарцуулалт хийж чадахгүй. Тийм учраас гадаадын зээл тусламж, гаднын

хөрөнгө оруулалтаар баригддаг ийм томоохон салбар юм байгаа юм. Онцлогтой салбар. Энэ жил бид яаж ийж байгаад Дорнодынхоо цахилгаан станцыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Эрдэнэбүрэн хойтон эхэлнэ, Тавантолгой дулааны цахилгаан станц, Эрдэнэс тавантолгойн дулааны цахилгаан станц ирэх жил эхэлнэ гээд ийм томоохон проектууд явна. Улаанбаатар хотод 3, 4 дүгээр цахилгаан станцын өргөтгөлүүд мөн ирэх жил бид эхлүүлэхээр гадаад талдаа хөрөнгө, эх үүсвэрүүдээ хайгаад хэлэлцээрийн түвшинд ингээд явж байгаа. Яах аргагүй ирж эрчим хүчний энэ сэргэлт, эрчим хүчний салбарын өсөн нэмэгдэж байгаа энэ эрэлт хэрэгцээг хангах бүтээн байгуулалтуудын ажлууд бол үнэхээр яг тулчихсан ажил байгаа. Энэ дээр бол бид онцгой анхаарч ингэж ажиллаж байгаа.

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Харин тийм ээ тэр тийм юмны сэргэлт гээд л баахан юм ярьдаг. Яг одоо боомтын сэргэлт л гэх юм. Энэ олон тавьсан төмөр замууд нь яг өнөөдөр хөрөнгө оруулалт биш, зардал болчихсон, ганц нь ч холбогдоогүй, ирэх жил ч холбогдохгүй юм байна лээ одоо явж байгаа мэдээллээр болбол. Эрчим хүчний сэргэлт л гэх юм. Яг энэ дээр нь бодитой ЭТТ дээр хэд ч гэлээ тийм том дүнтэй биш л юм байна лээ. Тэрийг нүүрсээр санхүүждэг гээд гаднынхан санхүүжүүлдэггүй. Гэтэл манайхан энийг барьж аваад үнэхээр л эрчим хүчийг сэргээх гэж байгаа юм болбол энийг маш яаралтай хөрөнгө оруулалтыг нь шийдмээр л байна шүү дээ. Үнэхээр бүүр болохгүй болбол тэгээд зээл тусламж ч гэсэн тийшээгээ шууд ормоор байна шүү дээ. Гэтэл одоо энэ чинь яг одоогоор шийдэлгүй л хэчнээн удаа тендер зарлаад, хэдэн удаа буцчихсан ч гэлээ өнөөдөр шийдэлгүй л явж байгаа юм байна лээ шүү дээ одоо жишээ нь Тавантолгой нүүрсний цахилгаан станц. Тэгэхээр яг энэ бүхэн дээр ингэж бодитой гол зүйл рүүгээ

төвлөрөхгүй болбол одоо үндсэндээ энэ орж ирж байгаа төсөв болбол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар сайд.

**Ж.Ганбаатар:** Цогтгэрэл гишүүнээ сүүлийн 4 өдрийн байдлаар бол зэсийн хани 8035 доллар байгаа л даа. Тэр 7 мянга гэдэг нь таны хүмүүст ойлгуулах 7 мянга руу 7900 руу 2 хоног л орсон, одоо буцаад өсчихсөн байгаа. Энэ, бид нар ер нь үнийг тооцохдоо USGS гээд энэ АНУ-ын геологийн алба, Канадын судалгааны байгууллагуудын үнийг л хардаг юм шүү дээ. Тэгээд 30 оноос эхлээд зэсийн нийлүүлэлт эрэлтдээ хүрэхгүй, та өөрөө сайн мэдэж байгаа. Тэгээд хөрөнгө оруулагч нар зэс рүү манайд үнэхээр хэтийн төлөвлөлттэй талбайнууд их байна. Зэсийн геологийн тогтолцоо сайтай байна, хөрөнгө оруулах сонирхол маш их байгаа. Ирээдүйд энэ зэс орохгүй бүтээгдэхүүн ч байхгүй байна. Барилга юу байдаг юм бүх л нарийн технологи, гэр ахуйн бүтээгдэхүүн гээд. Зэсийн хувьд бол сая бол нэг жоохон зүгээр баяжмалын илүүдэл болсон юм байна лээ, түүр хугацааны. Энийг бол манай яам хэлээгүй шүү гэдгийг бас тодруулж хэлье.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулъя нэг минут.

**Б.Жавхлан:** Тодруулга дээр нэмэлт мэдээлэл өгье. Хэрвээ төмөр зам яриад төмөр замын холболт ярих юм болбол энийг хэн нь хэдэн жил саатуулсан гэдгийг, хэн хэдэн жил гацаасан гэдгийг ярина шүү. Энийг улс төржүүлж энийг ярихгүй байгаа шүү. Харин ч энийг чинь холбох гэж сүүлийн 2 жил бид нэлээд хичээж ажиллалаа. Тэгсний үр дүнд ажлууд нэлээн урагшиллаа. Ялангуяа Гашиунсухайт дээр цаанаас ирчихсэн төмөр зам 10 жил бид нарыг хүлээж байгаа шүү дээ. Ингээд удахгүй бүтээн байгуулалтын ажлууд нь эхлэх гэж байна.

Тэр эрд ЭТТ-н цахилгаан станцын хэлэлцээрүүд нь болбол амжилттай хийгдсэн. Төсөв санхүүжилтүүдэд нь бол бэлэн болсон, ТЭЗҮ бэлэн болсон. Одоо Төрийн худалдан авах ажиллагааны хуулийн дагуу процесс явагдаж байгаа. Бид тэнд янз бүрийн гадна талаас нөлөөлөх ямар ч боломж байхгүй. Ингээд энэ шалгаруулалт нь амжилттай болоод гүйцэтгэгч нь тодорхой болоод ирэхээр бүтээн байгуулалтын ажил нь харин хугацаандаа түргэн шуурхай болоосой билээ. Тийм.

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

**Н.Ганибал:** Төсвийн хүрээний мэдэгдэл. Ер нь бид нар Эдийн засгийн хөгжлийн яамтай болсноороо ер нь Монгол Улсын эдийн засагт ямар өөрчлөлтүүд оруулах, энэ асуудлуудаа ер нь ярьж байна уу? Энэ нэг яам байгуулагдаад ингээд живээд алга болчих юм. Өнөөдөр бид нар энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр ч гэсэн орж ирж байгаа хэдэн орлогын эх үүсвэрүүд нь уул уурхайн хэдэн бүтээгдэхүүнээ байгаа гайгүй ханштай хэдийгээ л яриад сууж байгаа. Өнөөдөр тэр яагаад алтаа ярихгүй байгаа юм бэ? Яагаад өнөөдөр дэлхий нийтэд алтны үнэ өсөөд байхад энэ алтны асуудал дээр ямар бодлогын ажил явж байгаа, энийгээ ямар хүрээнд авч байгаа гэдэг асуудал яагаад яригдахгүй байгаа юм бэ? Яагаад өнөөдөр зөвхөн болж байгаа нүүрс, тэгээд зэс, төмрийн хүдэр гурваа л яриад байгаа юм.

Өнөөдөр яг энэ бүтээгдэхүүнийг тээвэрлэдэг гол асуудал, түүнийг дагасан хөгжил нь бол угаасаа дэд бүтцийн л хөгжлийн асуудал байгаа. Тэн дээр яагаад томоохон өөрчлөлтүүдийнхээ асуудлыг ярихгүй байгаа юм бэ? Байгаа, болж байгаа, машинаар зөөж байгаа тэр хэдэн бүтээгдэхүүнийхээ асуудлыг өнөө хэмжээнд нь л яриад байдаг ийм л эдийн засгийн бүтэцтэй улс орон болчихлоо. Өнөөдөр бид нар төсвийн нийт орлогын маань ихэнх хувь нь бол зөвхөн уул уурхайн

бүтээгдэхүүн экспортод гаргаснаар бий болгож байгаа юм. Тэгээд энэ дээр өнөөдөр ямар бусад салбарууд яагаад яригдахгүй байгаа юм бэ? Яагаад энэ ХАА яригдахгүй байгаа юм, яагаад махны экспорт яригдахгүй байгаа юм бэ? Энэ дээр юу хийж байгаа талаараа яагаад ингэж ярихгүй байгаа юм бэ, яагаад нөгөө эдийн засгаа солонгоруулна, бусад орлогуудыг бий болгоно гээд Эдийн засгийн хөгжлийн яам байгуулагдсан энэ асуудлуудаа ярихгүй ингээд, одоо ингээд юу гэдэг юм сайд нь хаана байгаа юм бэ? Саяын асуулт хариулж байгаа хэдэн газрын дарга хүмүүс нь нэг бид нараас асууцих вий дээ гэсэн байдалтай ингээд суугаад байх юм. Та хэд чинь ингээд яамаа байгуулчихсан, одоо алж байх ёстой шүү дээ. Асуудлаа ярьж байх ёстой шүү дээ. Ийм, ийм асуудлуудыг бид нар ингэж гаргаж ирж байна, төсвөө ингэж тэлж байна, эдийн засгийн хувьд ДНБ-ээ ингэж өсгөж байна гээд. Тэгээд яагаад энэ ДНБ нь өнөөдөр 7 хувиар тооцоод оруулаад ирж байгаа юм бэ?

Уг нь олон улсын санхүүгийн байгууллагууд Валютын сан Монгол Улсын төсвийн ДНБ-ий өсөлтийг 4,5 гээд тооцоолсон юм байна. Дэлхийн банк яах вэ 6 хувь гэсэн юм байна, АХБ 5,9 гэгчихсэн. Монголбанк сая мөнгөний бодлого оруулж ирэхдээ эдийн засгийн ДНБ-ий өсөлтийг 6 хувь гэж оруулж ирсэн. Тэгсэн өнөөдөр төсөв дээр 7 хувь болчихсон. Энэ дээр нэг хардалт төрж байна шүү. Өнөөдөр төсвийг нэмэгдүүлэхийн тулд ДНБ-ийг 7 хувь болгож өндөр хувьтайгаар өсгөж оруулж ирээд, ингээд төсвийн алдагдлыг бага юм шиг харуулах гэсэн ийм орлого юм уу гээд хараад байна шүү. Энэ дээр та нар ер нь ямар бодолтой байна вэ? Энэ дээрээ та бүхэн нэг хариулт хэлээч.

Ер нь бид нар төсвийг 2,8, ДНБ-ий 2,8 хувьтай тэнцэхүйц хэмжээний төсвийн алдагдал өнөөдөр оруулж ирчхээд сууж байгаа. Уг нь Тогтвортой байдлын тухай хуульд бол 2 хувиас хэтрэхгүй гээд заачихсан байгаа. ОУВС бол хөгжиж байгаа уул уурхайн түүхий

эдээс хамааралтай төсөвтэй улс орон ер нь ДНБ-ий нэг хувиас хэтрэхгүй байж өнөөдөр бас дараагийн хөгжлийн тухай, тогтвортой байдлын тухай ярина гээд ингээд заачихсан байгаа. Энэ дээр бас асуулт хариулт авъя.

Тэгээд ер нь хөдөө орон нутагт бол ер нь мөнгөний хани үнэхээр унаж байна. Хуучин манай малчид бол нэг төлөг зараад 3 шуудай цагаан будаа авдаг байсан бол нэг төлгөө зараад 1 шуудай цагаан будааг худалдаж авч чадахгүй болчихоод байна. Ер нь гар дээрээсээ малчид маань махаа зарахад 3 доллароор зардаг ийм жишиг байсан, өнөөдөр бол 3 доллароор зарна гэвэл 10500-гаар зарах ёстой 1кг махаа. Харамсалтай нь 6 мянгаас хэтрэхгүй ийм борлуулалтыг хийгээд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 202 дугаар цэцэрлэгийн багш, ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сайн сайхныг хүсэн ерөөе. Хэн хариулах вэ? Түвдэндорж, Гантөмөрийн Түвдэндорж Эдийн засаг, хөгжлийн сайд, дэд сайд.

**Г.Түвдэндорж:** Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдаад бодлогын хувьд болбол урт хугацааны хөгжлийн бодлого, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлно. Үүнтэйгээ уялдуулаад жилийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж ажилладаг болж байгаа. Өнгөрсөн хугацаанд 2 өнгөрсөн 3, 4 жилийн хугацаанд болбол дэлхий нийтээр болбол цар тахлын хүндрэлтэй ийм сорилтууд болбол ихээр ирсэн. Энэ үр дүнд болбол манай Монгол Улсын эдийн засагт болбол нэлээн сорилтууд орж ирсэн байж байгаа. Тэгээд энэ үүднээс эдийн засгийн манай улсын хамгийн доод түвшиндээ 4,6 хувьд эдийн засаг -4,6 хувьд хүрсэн, инфляц 19, 16,9 хувьд хүрч өссөн ийм байдалтай

өнгөрсөн оны сүүлээр байсан. Үүнтэй холбоотойгоор гадаад валютын нөөцийг ихэсгэх ажлын хэсгийг болбол ЗГ-ын тогтоолыг болбол өнгөрсөн 2022, 2022 оны 10 сард болбол тогтоолыг батлаад, ажлын хэсэг байгуулаад ажилласан байж байгаа. Үүнийхээ үр дүнд болбол өнөөдрийн энэ эдийн засгийн сэргэлт, эдийн засгийн өсөлтийг болбол 2023 оны энэ өсөлтүүдийг авчирч чадсан.

Эдийн засгийн зөв бодлогыг хэрэгжүүлж, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр бүхий л төрийн байгууллагуудын уялдаа холбоо, гаалийн гааль, боомтын нэвтрэлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөр зам, ачаа тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх энэ маш олон асуудлуудыг өнгөрсөн жилийн хугацаанд авч хэрэгжүүлсний үндсэн дээр экспорт болбол үлэмж хэмжээгээр нэмэгдсэн байж байгаа. 2,4 тэрбум ам.доллар-т хүрч унасан валютын нөөц байсан өнгөрсөн 10 сарын сүүлээр. Энэ оны 9 сарын сүүлээр гэхэд 4,1 тэрбум ам.доллар-т хүрч эдийн засгийн өсөлт 6,4 хувьд хүрч өссөн ийм үзүүлэлттэй байж байгаа.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас улсын эдийн засгийн төлөвлөгөө төсөөллийг харахдаа болбол аль болох өөдрөг өөдрөгөөр харж асуудлыг төлөвлөж байх ёстой. Өнгөрсөн олон улсын байгууллагууд болон Монгол Улсын эдийн засгийг болбол 22 онд 2,6 хувийн өсөлттэй гарна гэсэн ийм сөрөг ийм хандлагатай үзүүлэлтүүдийг харуулж байсан болбол 22 оны сүүлээр 22 онд 5 хувь төрж өссөн байж байгаа. Экспортыг 23 онд нүүрсний экспортыг 19 оны түвшинд хүргэхээр төсвийн төсөлд болбол 36 сая тонн нүүрс экспортолно гэдэг ийм төсвийн төсөлд болбол тусгаж байсан. Эдийн засгийн хөгжлийн яамнаас экспортыг нэмэгдүүлэх шаардлагатай.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууна.

**Н.Ганибал:** Тийм ер нь зүгээр асуудлуудаа энэ салбар хоорондын уялдааг та нар хангах ийм үүрэг чиглэл байгаа байлгүй дээ. Би тэр Энх-Амгалан гээд Макро эдийн засгийн асуудал хариуцсан энэ газрын даргын асуудлыг тэр ХАА-н салбар, МАА-н салбар дээр ярьж байсан ярицлагыг сонссон. Аягүй зөв л бодолтой юм байна лээ. Тэгээд та нар энэ бодол чинь зөв байгаад, энийг чинь энэ ЗГ чинь хэрэгжүүлээд энэ үйл ажиллагаагаа явуул л даа. Энэ ХААЯ-ндаа энэ гаргасан тэр чиглэлээ өгөөд, тэр махны үнийг чөлөөлөх, энэ арьс ширний үйлдвэрлэлийг юу хувийн хэвшлийг дэмжих, дэд бүтцийг нь төрийн мөнгөөр хийх гээд ингээд энэ ажлуудаа яг бодит ажил болго. Зүгээр одоо ингээд эдийн засгийг солонгоруулах тэлэх асуудал дээр байр сууриуд нь ингээд зөв байгаа мөртөө энэ ЗГ хоорондын уялдаа холбоо чинь бүүр явахгүй байна. Зөвхөн нүүрс, зэс, төмрийн хүдэр гэсэн гуравхан асуудал дээр ингээд төсвөө бариад орж ирээд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Түвдэндорж, Гантөмөрийн Түвдэндорж Эдийн засгийн хөгжлийн дэд сайд хариулна.

**Г.Түвдэндорж:** Тантай бол санал нэг байна. Эдийн засгийн хөгжлийн яамнаас экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх чиглэлээр болбол онцгойлон анхаарч ажиллаж байгаа. ЗГ дээр сүүлд 233 дугаар тогтоолыг гаргаж, бизнесийн орчныг сайжруулах талаар бүх салбар бүр дээр байгаа хууль журам, журмуудыг сайжруулах, хүнд суртал, хүнд суртлыг арилгах энэ асуудлуудыг шийдвэрлэх ажлууд дээр болбол онцгойлон анхаарч байгаа юм. Сүүлийн 233 дугаар тогтоолын хүрээнд авч хэрэгжүүлсэн ажил дээр ХАА-н салбарыг эрчимтэй хөгжүүлэх, махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр бол ажиллаж байгаа. Үнэ тарифыг болбол чөлөөлөх шаардлагатай. Ер нь бол эдийн засгийн либералчлалын бодлого болбол явуулах шаардлагатай байж байгаа. Бүхий л салбар дээр болбол ер нь эдийн засгийн,

төсвийн татаас хэлбэртэй болбол явж ирсэн нь бол үнэн. Ялангуяа ХАА-н салбар дээр мах, сүү, тариа, будаа, урамшуулал одоо бүх асуудал дээр болбол ийм татаасан хэлбэртэй явж байгаа.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас эдийн засгийг либералчлах, эдийн засгийг төрөлжүүлэх энэ бодлого дээр болбол хатуу бодлогын байр суурь болбол баримталж явж байгаа. Цаашид болбол нийтийн тээвэр болон хотын эдийн засгийг либералчлах энэ асуудлаар бас онцгойлон анхаарч ажиллаж байгаа. Үүний үр дүнд болбол энэ онд махны экспорт болбол 2 дахин нэмэгдсэн байж байгаа. Цаашид уламжлалт МАА-г эрчимжсэн МАА-тай хослуулан хөгжүүлэх талаар, хөгжүүлэх ёстой. Үүн дээр төрийн бодлого болбол зайлшгүй шаардлагатай. Өвс тэжээлийг хангах энэ асуудал дээр болбол эрчимжсэн МАА дээр болбол зайлшгүй болбол чухал байдаг. Үүн дээр бол төрөөс тоног төхөөрөмжийг, хадлан тэжээлийн тоног төхөөрөмжийг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн асуулт асууна. Түвдэндоржоо.

**Ц.Цэрэнпунцаг:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн төсөөлөл бол бид нар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуультай бодлоготой болсон. Энийгээ бол хангахад чиглэсэн, энэтэйгээ уялдаа холбоотой ийм төсөөлөл байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр чинь зүгээр яг тодорхой 1, 2, 3 асуулт энэ 24 оны энэ хүрээ Төсвийн хүрээний мэдэгдэл дээр байгаа. Мөн 25, 26 онууд дээр энэ төсөөлөл дээр байгаа нэг 2, 3 тоон дээр тодорхой асуулт асуумаар байна.

Хэрэглээний үнийн, үнийн өсөлтийн түвшин гээд 8,5 гээд ингээд 24 ондоо тавьчихжээ. Сая Мөнгөний бодлогын орж ирсэн тийм ээ, Мөнгөний бодлого Монголбанкнаас бол яах вэ 24 ондоо дан оронтой тоонд оруулна гээд

онилчихсон байгаа. Тэгтэл өнөөдрийн байдлаар энэ сарын байдлаар бид нар чинь давхар тоондоо л байгаад байна шүү дээ инфляц. Тэгээд энэ инфляц өнөөдөр бид нарт юунаас болж байна гээд тэгэхээр зэрэг бид нар худалдааны тэнцэл гадаад худалдаа бол ашигтай байгаа тийм ээ, төлбөрийн тэнцэл ашигтай гарч байгаа 8 эхний 8 сарын, 9 сарын байдлаар. Өнөөдөр энэ бид нар энэ төсөв дээр төсвийн алдагдалтай ингээд 2 аравны хэд байна вэ, 2,1 их наяд төгрөгийн алдагдалтай батална гээд байгаа юм. Тэгэхээр зэрэг хамгийн гол нь энэ 8,5 гэчихсэн тоо чинь аль хэр бодитой тоо юм бэ? Тэгээд цаашаагаа бүүр 25 онд 6, 6, 26 онд 6, 6 гээд тавьчихсан байна. Ингэхээр зэрэг энэ бид нарт өнөөдөр хамгийн том асуудал болоод байгаа энэ төсөөллөө та нар юу гэж бодож байгаа юм бэ? Энэ дээрээ нэг тодорхой хариулт өгмөөр байна. Яагаад энэ 8,5 гээд энэ тоог бүүр ойрхноор нь ярья л даа. Төсвийн хүрээний мэдэгдэл 24 оныхоо 8,5 гээд тавьчихсан юм бэ? Яг энд бид энэ 8,5-д барих ийм боломж энэ бид нарын энэ төсөв чинь олгож байгаа юм уу? Энэ төсвийн төлөвлөлт энэ зардал чирэгдэл чинь энд энэ нөхцөлийг энэ таатай орчныг бүрдүүлж чадах юм уу гэж асуулт байна 1 дүгээрт.

2 дугаарт одоо энэ нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээ ингээд 27 аравны 27 их наяд 360 тэрбум. Ингээд дараагийн жилүүдэд 25 онд 29,417, 26 онд 30, бараг 31 их наяд гээд ингээд тавьчихсан. Тэгэхдээ ДНБ-д эзлэх хувиараа 37, 24 ондоо бол 37 хувьтай, 34, 25 онд 35, 26 онд 34 гээд нэг нэг хувиар буулгаад тавьчихжээ. Тэгтэл энэ бид нарын энэ зарлага чинь ингээд яах вэ абсолют тоон дээрээ бол нэмэгдээд явчихна. Энэ ДНБ-д эзлэх хувиараа багасаад явчихна гээд тавьсан нь бол цаанаа манай хувийн хэвшлийнхнийгээ энэ боломжийг олгосон өсөлт би хувийн хэвшилээс бий болгоно гээд харж байгаа юм байна. Тэгтэл хувийн хэвшлийнхнийг тэгж өнөөдөр өсөж бий болгох, эдийн засгийн өсөлт бий болгох тэр боломжийг нь энэ бид нарын өнөөдрийн төсөв олгож



байгаа юм уу, тийм орон зай бий юу хувийн хэвшлийнхэнд та нар юу гэж харж байна вэ?

Өнөөдөр хувийн хэвшлийнхэнд хэдэн хувийн хүүтэй мөнгө очиж байна тийм үү, банкнууд бодлогын хүү өндөр байгаа учраас бүгдийг нь аваачаад Монголбанкн дээрээ ингээд байрицуулчихсан тийм ээ. Эрсдэл байхгүй. Хувийн хэвшлийнхэнд мөнгө олдохгүй байна.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Эдийн засаг, хөгжлийн сайд, дэд сайд Гантөмөрийн Түвдэндорж хариулна.

**Г.Түвдэндорж:** Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн тооцоолол инфляц ДНБ-ий өсөлтийн талаар болбол Эдийн засгийн хөгжлийн яамнаас болбол зөв тооцоо, зөв тооцоолсон байж байгаа. Өнгөрсөн оны сүүлээр гэхэд 17 орчим хувийн инфляцтай байсан, одоо 10 сарын байдлаар болбол 10, инфляц 10 хувьд бол аажмаар буурч байгаа. Энэ ондоо нэг оронтой тоонд хүрэх зорилтыг болбол тавиад ажиллаж байгаа. Гэсэн хэдий ч бас дэлхий гадаад орчин нөхцөл байдал дээр инфляцын нөлөө олон улсын мөнгөний хатуу бодлого энэ геополитикийн асуудалтай холбоотой хүнсний хангамжийн өсөлт зэргээс болбол сорилтууд болбол өндөр байгаа. Манай улсын хувьд болбол хамгийн чухал асуудал болбол инфляц дээр гадаад валютын ханиш дээр маш сайн анхаарч ажиллах ёстой. Үүн дээрээ экспорт дээр гол бодлогоо анхаарч экспортын орлогыг барьж чадах юм болбол валютын ханишийг болбол цаашид болбол тогтвортой 8,5 хувьд 24 онд хүрэхээр болбол тооцоолсон байж байгаа.

Гадаад валютын ханишийг барьснаар болбол хүнсний экспорт импортоос хамааралтай бүтээгдэхүүнүүдийн импорт инфляцыг болбол барих болон бууруулах ийм боломж болбол бүрдэнэ гэж харж байгаа. Төсвийн бодлогоор болбол төсвийн

бодлого өөрөө нийгмийн шинж чанартай, нийтийн төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, халамж, төсвийн төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэх чиглэлээр болбол төсвийн ихэнх зарлага явдаг. Төсвийн бодлого өөрөө ч энэ нийгмийн нийтийн чиглэл рүү болбол чиглэх нь зүйтэй байдаг.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт дээр болбол төсөв төсвөөс болбол хөрөнгө оруулалт хийж, ямар нэгэн санхүүжилтүүдийг бол олгох бол, олгох боломжгүй. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт дээр хөрөнгө оруулалтын бодлого, худалдааны бодлого дээр тулгуурлаж чөлөөт зах зээлийн зарчмаар хөгжүүлэх, мөнгөний хямд эх үүсвэрийг өрсөлдөөнт энэ салбар дээр оруулж ирэх шаардлагатай. Нэг үгээр хэлбэл шууд гадаадын хөрөнгө оруулалтын банкныг байгуулах, худалдааны чөлөөт бодлогыг баримтлах, хөрөнгө оруулалтын гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжиж болбол ажиллах болбол зайлшгүй шаардлага байгаа. Тэгэхээр хувийн хэвшлийнхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа дээр төр өөрөө төрийн дэмжлэг болбол төрийн хязгаар.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн тодруулж асууна. Нэг минут.

**Ц.Цэрэнпунцаг:** Түвдэндорж сайд бусад хариултаа дараа нь гүйцээгээд өгчхөөрэй нэг. Хамгийн гол миний асуугаад байгаа юм нь хувийн хэвшлийнхэнд зээл олдохгүй байна тийм ээ. Тэгэхээр зэрэг хувийн хэвшлийнхэн хөрөнгө оруулалт хийж чадахгүй байна. Дараа тэр хойд дараа дараа 25, 26-нд авчрах тэр өсөлтийг чинь хувийн хэвшлийнхнээс харахад хэцүү болчхоод байна шүү гэж байна. Тэгэхээр цаашидаа ер нь энэ төсөв дээр бид нар хувийн хэвшлийнхнийхээ авч байгаа зээлийн хүүг энэ төсөвт суулгах

замаар бид нар энэ дэмжлэг үзүүлэх ийм боломжууд та нар бодож үзсэн үү? Энэ дээр бас юу гэж бодож байгаа юм бол?

Ер нь төсвийн төсвөөр дамжуулж бид нар орлогын дахин хуваарилалт хийдэг тийм ээ. Тэгээд энэ 7 хувийн өсөлт маань бид нарын төсөв энэ 25 оны төсөв энэ 7 хувийн өсөлтийг яаж айл өрхийн үүдээр оруулах ийм бодлоготой юм бэ, ямар арга замуудаар, ямар зарчмаар энэ 7 хувийн өсөлт айл өрх болгоны үүд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоохон та байж байгаарай. Хэн хариулах вэ? Түвдэндорж Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Гантөмөрийн 81.

**Г.Түвдэндорж:** Гишүүний асуултад нэмж хариулъя. Ер нь болбол хувийн хэвилийг дэмжих бусад уул уурхайн бус салбаруудыг дэмжих бодлого болбол хамгаас чухал байж байгаа. Ажиллах хүчний 90 орчим хувь нь болбол үйлчилгээ, барилга, ХАА-н салбаруудаар болбол байдаг. Тэгэхээр энэ салбарууд хөгжихгүй байгаа гол шалтгаан нь болбол ЖДҮ-лэл, жижиг дунд бизнесийн ийм зах зээл өөрөө байдаг. Иргэдэд болбол уул уурхайн салбарын өсөлт эдийн засгаас орж байгаа өсөлт болбол төдийлөн хүрдэггүй. Тэгэхээр энэ хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд бусад салбарууддаа тэтгэх болбол ЗГ-аас хэрэгжүүлж байгаа ийм шаардлагууд байж байгаа.

Тэгэхээр салбаруудыг татааснаас чөлөөлж, эдийн засгийн чөлөөт либерал бодлогуудыг хэрэгжүүлж, цэвэр эрүүл ийм эдийн засгийн тогтолцоо руу шилжих болбол зайлиггүй шаардлага байгаа. Ялангуяа манай ХАА-н салбар болбол бид болбол уламжлалт ХАА-н эдийн засагтай орон. Тэгэхээр ХАА-н салбарыг болбол цаашид хөгжүүлж хөгжүүлэх нь болбол зайлиггүй болбол шаардлага болбол байгаад байгаа. Тэгэхээр бидэнд болбол маш их боломжууд байж байгаа. Мах, сүү, ХАА-н гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуур бусад дайвар

бүтээгдэхүүнүүдийг боловсруулж яг экспортод гаргах энэ хэрэгцээ шаардлагууд болбол байгаа. Тэгэхийн тулд иргэдийн малчны хотоос авхуулаад бодлогыг болбол чиглүүлж, тэндээс эхэлж дэмжих болбол зайлиггүй шаардлагууд, бүрэн вакцинжуулах шаардлагатай, хадлан тэжээл өвс тэжээлийг нь бол бэлдэж өгч байх ёстой, эргээд эрчимжсэн МАА-г хөгжүүлэх энэ чиглэл рүү болбол ЗГ-ын бодлого болбол чиглэж байгаа.

Мөн эдийн засгийн 7 хувийн өсөлтийг яаж иргэдэд хүртээх вэ гэдэг асуудал дээр бол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25, 26 оны төсөөллийг үзэл баримтлалынх нь хувьд бол дэмжье. Тэгээд Их Хурлын ажлын хэсэг дээр нэлээн нягталж үзнэ биз гэсэн ийм байр суурьтай байна. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн хүрэх түвшнийг бид дунд хугацаанд нь харж төсөөлөөд түүнийгээ баталж байгаа. Тийм учраас үүнийгээ бид илүү их тогтвортой барих замаар л тавьж байгаа зорилтуудаа хангах бололцоо боломж бүрдэнэ. Энэ тал руугаа чиглэсэн эрх зүйн зохицуулалт буюу тэр төсвийн шинэчлэлийн хүрээнд тодорхой шинэчлэлүүдийг хийсэн. Энэ үүнийг 25 оноос эхлээд нэлээн тогтвортой бариад ирэхээр зэрэг энэ тал дээрх асуудлууд нэлээн зөв шийдэл зохицлоороо явах байх гэж би ингэж харж байна. 2, 3 зүйл байгаад байгаа юм.

1 дүгээрт энэ үнийн өсөлт инфляцын асуудлыг бид зөв л хармаар байгаад байгаа гэж бодоод байдаг би бол. Энэ мөнгөний бодлого, төсвийн бодлого хоёроо хооронд нь зөв уялдуулж, тэгээд энэ эдийн засгийн тавьж байгаа зорилтуудаа хангах, тэгэхдээ энэ эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн

хоорондын уялдаа хангалтыг бий болгох ийм л асуудал байгаад байгаа л даа. Өнөөдөр бодлогын хүү, инфляц 2 өөрөө бараг 3 функтын зөрөөтэй явж байгаа билүү дээ энэ чинь би тэгж бодоод байгаа. Тэгэхээр энэ бодлогын хүү чинь өөрөө эргээд эх үүсвэрээ өртөгжүүлээд байгаа юм биш үү гэдэг асуудал үүсээд байгаа. Үүн дээр ер нь манай эдийн засагчид, санхүү юу Эдийн засаг, хөгжлийн яамныхан ер нь ямар байр суурь бодлоготой яваад байгаа юм бэ гэдэг асуудал.

2 дугаарт ерөөсөө энэ мөнгөний өөрийнх нь худалдан авах чадвар гэдэг юм уу энэ асуудал чинь нэмүү баялгийн бүтээлтээр л баталгаажиж явдаг л ийм л зүйл шүү дээ. Тэгэхээр зэрэг бид яалт ч байхгүй уул уурхайн бус энэ баялаг үйлдвэрлэлтийн салбарыг илүүтэй дэмжих тухай л асуудал байгаад байгаа юм. Гэтэл тодорхой хүүгийн зөрөөг нь төрөөс дэмжинэ гээд хөрөнгө тавьчхаад, энэ баялаг бүтээдэг салбар луу гаргах зээлийн тодорхой тоо тогтоод явахаар зэрэг гарч байгаа зээл бид нарын тавьж байгаа зорилтод хүрэхгүй байгаад байгаа байхгүй юу. Энэ жил гэхэд ХАА-н салбар, энэ боловсруулах салбар луу I их наяд төгрөгийн зээл гарна гэж тооцоолсон. Сая мөнгөний бодлогын хэлэлцүүлэг дээр тодруулахаар зэрэг 0,5 их наяд л гарсан байгаад байна шүү дээ үндсэндээ 50 хувь л ашиглагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр хэмжээгээр бид нарын харсан өнөө эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд чинь хангагдахгүй болчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг хэдүүлээ яаж үндсэн үзүүлэлтүүдээ хангах тэр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийнхээ хэрэгжилтийг бүрэн гүйцэд болгох вэ гэдэг асуудал дээр гол асуудал байгаад байна. Үүнийгээ ер нь юу гэж харж, яаж төсөөлөөд байна вэ гэдэг асуудал.

Дараагийн зүйл төсвийн алдагдал. Энэ бол үндсэндээ бид нарын өрийг нэмэгдүүлээд байгаа үйл явц. Тэгэхээр аль болохоор төсвийн алдагдлыг тэр хуулиар

зөвшөөрөгдсөн таазын түвшинд нь барьчих биш, аль болохоор л бууруулаад, төсвийн алдагдалгүй явах л ийм л үйл явц байх ёстой. Хамгийн муу.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Жавхлан сайд хариулах уу? Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Гантөмөрийн Түвдэндорж хариулъя.

**Г.Түвдэндорж:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгээд ер нь болбол төсвийн бодлого, мөнгөний бодлого хоорондоо уялдаатай явж байгаа. Төсөв болбол сүүлийн 21,22, 23, 24 гурав, дөрвөн жилийн хугацаанд харахад болбол төсөв болбол байнга тэлж ирж байгаа. Эргээд ДНБ ч гэсэн тэлж байгаа. Үүнтэйгээ холбоотой төсөв болбол тэлж явж байгаа. Үүний төсөв тэлж байгааатай холбоотой бас цалин, тэтгэвэр тэтгэмж нэмж байгаа, урсгал зардлууд болбол нэмэгдэж байгаа энэ асуудал дээр болбол мэдээж нөгөө талдаа мөнгөний бодлого болбол мөнгөний бодлогын бодлогоо болбол чангатгаж явах нь болбол зүйтэй. Тэгэхээр болбол өмнөх хэвийн явж байсан ийм эдийн засаг сүүлийн хэдэн жил бол байгаагүй. Инфляц болбол бүх улс орнуудын тулгамдаж байсан, тулгамдаад байгаа асуудал болбол өнөөдөр болж байгаа.

Тэгэхээр мөнгөн төсвийн бодлоготой уялдуулаад мөнгөний бодлого цаашид ямар ч байсан дараагийн 2024 онд болбол мөнгөний хатуу бодлого болбол баримталж явах нь болбол зөв. Хэрвээ сулруулах юм болбол эргээд энэ инфляцыг өдөөх ийм асуудал гарна. Инфляц өсвөл орлого багатай өрхүүдэд хүндээр тусна, шууд нөлөөлнө. Иргэд дээр ирж байгаа худалдан авах бараа бүтээгдэхүүний үнэ бол өснө, төгрөгийн ханиш сулрах ийм эрсдэлүүд болбол тулгарна. Тэгэхээр эдийн засгийн бодлогын хувьд болбол цаашид болбол ямар ч байсан 2024 ондоо хөрөнгө, Монголбанкны бодлогын хүүгийн зорилтот түвшиндээ хүрээгүй нөхцөлд мөнгөний хатуу бодлогыг болбол барьж явах нь зүйтэй гэж болбол харж байгаа.

Төсвийн шинжтэй үйл ямар нэгэн үйл ажиллагааг бол Монголбанк болбол хэрэгжүүлэх нь хуулиараа хориотой байж байгаа. Түрүүн Цэрэнпунцаг гишүүн асуусан. Ямар, зээлийн хүүгийн татаасыг өгч явах нь бол өөрөө эргээд төсвийн шинжтэй, төсөв мөнгөний бодлого 2 бол хоорондоо ингэж хутгалдаж байгаа асуудлууд байж байгаа. Тэгэхээр энийг болбол тусдаа явуулах нь болбол зүйтэй байгаа. Тэгээд цаашид болбол инфляцыг болбол нэг оронтой тоонд барих ийм зорилтоо болбол хэрэгжүүлнэ. Монгол Улсын хувьд экспортоо нэмэгдүүлэх, гаргаж экспортод гаргаж болох бүхий л бараа бүтээгдэхүүнүүдийг юу л байна бүгдийг зарж гаргах л энэ бол ийм бодлого болбол зайлшгүй шаардлага байгаа. Тэгэхээр экспортыг төрөлжүүлэх, ХАА, аялал жуулчлал, тээвэр, ИТ-ийн салбар гэх мэт.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр юу л байгаад байна л даа. Төсвийнхөө бодлогоор бид эрэлт талаа дэмжихээд байгаа юм ер нь бол. Тэгэхээр зэрэг мөнгөний бодлогоороо үйлдвэрлэл хангалт талаа дэмжих бодлого нь илүү явах ёстой юм байна. Энэ талынх нь үйл явцыг харах гэхээр зэрэг наад бодлогын хүү, инфляц 2-ын чинь зөрөөгөөр дахиад өөрөө эх үүсвэрээ өртөгжүүлчээд байгаа учраас инфляцаа зорилтот бид нарын яриад байгаа нэг оронтой тоо руу оруулж ирэх гэхээр бараг нэг талдаа чөдөр ч болж байгаа юм шиг ийм л юм харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийгээ яаж уях юм гэдэг л асуудал бидэнд хамгийн гол зүйл байгаад байна.

Энэ ХАА-н салбарыг бид сайн дэмжих ёстой юм. Өөрөө өөр дээрээ үйлдвэрлэл нь явж байдаг, тэр үйлдвэрлэлийнх нь баялгийг бид боловсруулах замаар нэмүү өртөг шингээж, ёстой өрсөлдөх чадварыг нь л бий болгох тухай л.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Би нөгөө нэмэлт мэдээлэл өгөх гэсэн юм. Ер нь үе үеийн Сангийн сайд нар л энэ төсвийн шинэчлэл, реформыг хийхийг төлөвлөж, зорьж ирсэн байдаг. Тэгээд өөр өөрсдийнхөө хүч боломжоор бас ч үгүй шинэчлэлүүдийг хийж ирсэн. Харин энэ удаа Улсын Их Хурал, Төсвийн байнгын хороо маань яг төсвийн шинэчлэлийн хүрээнд энэ эрх зүйн шинэчлэлтүүдийг маш сайн хийж өглөө. Энд бол бид Сангийн яам салбараараа талархалтай хандаж байгаа шүү.

Ялангуяа энэ Эдийн засгийн хөгжлийн яам гээд бид тусдаа томоохон ийм бодлогын яам гарч ирсэн. Эдний үйл ажиллагааг илүү тодорхой болгох, эдийн засаг хөгжлийг томоор нь агуулгаар нь томъёолж, дунд, урт хугацааныхаа зорилтыг тодорхой болгох чиглэл дээр бол энэ яам маань ажиллах ёстой. Төсвийн хүрээний мэдэгдлийг бол ингээд ирэх жилээс Эдийн засгийн хөгжлийн яам хийж ирнэ. Тэгэхээр эхнийх нь 5 сард өргөн барина, тэр болтол хугацаа байна. Эдийн засгийн хөгжлийн яам маань эндээ сайн бэлдэж байгаа. Мэдээж бид ч гэсэн өнөөдрийг хүртэл хийж ирсэн ажлаа шилжүүлэхдээ бас тусалж, дэмжинэ. Тийм. Ийм учраас Тэмүүлэн дарга, Батжаргал гишүүдэд бид талархалтай хандаж байгаа шүү. Энэ хийсэн шинэчлэлтүүд чинь үр дүнгээ өгнө гэдэгт бид эргэлзэхгүй байгаа юм. Тийм.

**Г.Занданшатар:** Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25, 26 оны төсвийн төсөөллийг хэлэлцэж байна. Тэгээд энийг бол яах вэ үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, батлах л ёстой байх гэж ингэж бодож байна. Энэ ирэх 24, 25, 26 онд ер нь Монгол Улсын эдийн засаг ямар байх юм, хэдий хэмжээний хөрөнгө мөнгө олж чадах юм гээд л яриад байна. Тэгээд хэдхэн л зүйл

дээр эргэлдээд байгаа юм. Алт, зэс, нүүрс, төмөр, тэгээд долларын ханш, инфляц гээд. Гэтэл чинь Монгол Улс чинь өөрөө ХАА дээр тогтсон эдийн засагтай. Энэ малыг ерөөсөө ярихгүй юм, энэ махны асуудлыг ерөөсөө ярихгүй юм. 2022 оны жилийн эцэст 70, 71 сая малтай, төл нь орвол бараг тэгээд 100-гаад сая малтай болчихоод байна. Тэгээд энэ махны экспортыг дэмжье, махны үнийг хэдэд хүргэе гэж ерөөсөө ганц ч хүн ган хийхгүй.

Тэгээд одоо энэ орон нутгаас нэр дэвшсэн гишүүн болсон гишүүд энэ Даваасүрэн гишүүнээс бусад нь бас дуугарахгүй юм. Хэнээс айгаад байдаг юм, юунаас айгаад байдаг юм. Ингээд ЗГ-аар махныхаа ханшийг албадангаар бариулчихаад, хөдөөгийнхөө ард иргэдийг зориудаар ядуу байлгах нь хэний асуудал юм, хэнд хэрэгтэй юм бэ? Эдийн засгийг либералчилъя, чөлөөлье л гээд байдаг. Тэгээд гол эдийн засгийн бүтээгдэхүүнийхээ үнийг ингээд албадангаар бариад байдаг. Тэгээд одоо энэ төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн төсөөлөлд нь махны экспортыг хэдэд хүргэнэ, махны экспортоос тэдэн төгрөгийн орлого орно гэж бүүр ерөөсөө дуугарахгүй байгаа байхгүй юу. Нүүрсээ хэдэд хүргэнэ, нүүрсний үнийг төчнөөнөөр тооцож байна, алтыг төчнөөнийг гаргана, алтны үнийг төчнөөнөөр тооцож байна л гээд яриад байгаа юм, газар ухах, бэлэн юм л ашиглах гээд байгаа юу гэхээс зэрэг бэлэн байгаа ард иргэдийнхээ амьдралыг дээшлүүлье, энэ 70 сая малынхаа жилд 30 орчим саяд төл авч байна. Ядаж 30 сая мал борлуулъя, эргэлтэд оруулъя, 40 сая мал борлуулъя, эргэлтэд оруулъя, хөдөөгийн ард иргэдийнхээ амь амьжиргааг дээшлүүлье гэж ингэж ерөөсөө ерөөсөө дуугарахгүй юм. Төсөөлөлд нь ч байхгүй юм. Энэ ямар учир байдаг юм бэ?

Хөдөөд бол олон юм нэхэхгүй байгаа шүү дээ. Зээл авъя гэж байна, зээл өгөх боломжгүй байна. Хүүгээ бууруулъя гээд хүүгээ бууруулж болохгүй байна. Тэгвэл гар дээр байгаа бүтээгдэхүүнийг

нь экспортод гаргах боломжоор нь дэмжээд өг л дөө. Түүхийгээр нь гаргаж болдоггүй юм бол ямар байдаг юм боловсруулаад гаргах, лаазалсан мах ч болтугай хийгээд, ингээд гаргахгүй бол үнэ хаана тогтдог вэ гэхээр эрэлт, нийлүүлэлтийн муруй дээр л тогтдог. Тэгээд нийлүүлэлт нь ихэсчхээд байна. Социализмын үед 25 сая мал гэж ярьж байсан, одоо 4 дахин өсчхөөд, жил болгон тэр хэмжээний мал төлөөр орж ирээд байгаад, ингээд үнэ нь унаад байхад энийг экспортолъя, дэлхийн зах зээл дээр гаргая, олон улсад гаргая гэж ерөөсөө дуугарахгүй юм. Ийм учраас ирэх он жилүүдэд жишээлбэл 24 онд, жишээлбэл 23 оны эцэс хүртэл хэдэн тонн махыг гадаадад гаргах юм, 24 онд хэдэн тонн хэдэн сая тонн мах, хэдэн сая малыг эргэлтэд оруулах юм бэ? Энэнээс хэдий хэмжээний орлого олох юм бэ? Энэ тал дээр байгаа тодорхой мэдээлэл авмаар байна.

Дээр нь энэ ЗГ махны үнийг барьдгаа боль. Яахаараа ингэж хүмүүсийн өвлийн хүйтэн, хаврын шуурга, аагим халуун, нүүдэл суудал, отор нүүдэл энд үйл тамаа барчихаад, тэгээд одоо тэр махных нь үнийг ЗГ өөрөө ингээд бариад байна гэдэг бол өөрөө шударга ёсонд нийцэхгүй юм гэдгийг хэлэх гэсэн юм. Асуултад.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. Батсуурь гишүүнээ та юунд бухимдаад байгаа юм бэ? Тэр маханд, мах бол зах зээл аягүй либерал болчихсон байгаа шүү дээ. Бид зун, сая Аубакир гишүүн хэлж байна. Ажлын хэсэг ахалж байгаа сайн үр дүн гарсан. 168 сая долларын мах экспортолсон өнгөрсөн жил. Амьдаар нь экспортлох квот урьд нь бол квот нэлээн хязгаартай байсан тэр квот байхгүй болчихсон шүү дээ, одоо чөлөөтэй. Та Сүхбаатар аймгаас хэдэн хонь, хэдэн үхрээ яаж экспортолмоор байна, урд талд чинь зах зээл байгаад

худалдан авагчаа олох юм бол та маргааш ч гаргасан болно. Тэр яамнаас квотлохоо больчихсон шүү дээ, чөлөөтэй. Та мэдээлэл нэлээн хоцроод яваад байх шиг байна. Тэгээд дэмий юманд бухимдаад байх юм.

Тэр махны үнийн асуудал болбол яах вэ би бол тантай бас санал нийлдэг юм шүү. Махыг бол айхтар тэгж үнийг нь барих болбол бас тийм сайн зүйл биш. Ер нь бол зах зээлийнх нь жамаар нь л орхих ёстой юм байгаа юм. Нийлүүлэлтийг нь яг эцсийн хэрэглэгчдэдээ хүрэх, дундуур нь тэр дундын ченжүүд байхгүй болгох гээд энд нэг л яг худалдааны логистикийн тээврийн зохион байгуулалтын л асуудал байх шиг байгаа юм. Зүгээр энэ зохион байгуулалтыг л бид нар хийх ёстой. Тэгээд үнийг хүчээр барих болбол тийм сайн зүйл биш, тантай санал нийлж байна.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя эхлээд. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Баян-Өнжүүл сумын эмэгтэйчүүдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт эхчүүд, эмэгтэйчүүддээ энэ хорвоогийн хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс. Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна, 1 минут.

**Ж.Батсуурь:** Энэ дээр бухимдаад байгаа зүйл байхгүй. Зүгээр ер нь орон нутагт очиход хөдөөд хүмүүсийн юмны үнэ, амь амьжиргаа хэцүү байна. Энэнээс ганцхан гарах гарц болох, гарц нь ерөөсөө махны үнийг ЗГ бариад байна, арай жоохон өндийнгүүт нь ингээд нөөцийн мах, янз бүрийн шалтаг шалтгаан яриад энийгээ болиоч гэж хэлсэн юм 1 дүгээрт.

2 дугаарт Эдийн засгийн хөгжлийн яам чинь Төсвийн 24, 25-ны төсөөлөл, Төсвийн хүрээний мэдэгдэлд чинь махны экспортыг нэмнэ, төдөөс төдий

хэмжээний орлого олно гэсэн ерөөсөө юм байхгүй байна л гэдгийг хэлсэн байхгүй юу. Тэгэхээс өөр одоо юу гэдэг юм энэ дээр бухимдаад, би бухимдлаа ч гээд та нар тэрний үнийг өсгөчих биш. Хэдийгээр олон жил боомилж ирсэн шүү дээ энэ квотын асуудал, дөнгөж сая л больж байна, больж байна. Ерөөсөө бодлоготойгоор квот тавиад, тэрийгээ хэдхэн компаниар хэрэгжүүлж, хөдөөгийн ард иргэдийн махны үнийг барина.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Гантөмөрийн Түвдэндорж хариулна.

**Г.Түвдэндорж:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. Тантай бол санал нэг байгаа. ХАА-н салбарт болбол МАА-н салбарыг болбол хөгжүүлэх, ялангуяа махны экспортыг нэмэгдүүлэх энэ чиглэлээр болбол цаашид хөгжүүлэх манай Монгол Улсын хувьд болбол бүрэн маш их боломжууд бол байж байгаа. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яамнаас ХАА-н салбартай холбоотой арьс шир, ноос ноолуурын тохируулгын зохицуулалтын тогтоолыг болбол өнгөрсөн долоо хоногт бол оруулж, хүчингүй болгосон байж байгаа. Мөн мах экспортлох квотын асуудлыг оруулж, квотын квот тогтоодог асуудлыг болбол хүчингүй болгосон байж байгаа. Үүнтэй холбоотойгоор экспорт болбол нэмэгдсэн байж байгаа. Ковидын өмнөх түвшинтэй харьцуулахад энэ оны 9 сарын сүүл гэхэд болбол нийт 56 мянган мах тонн мах болбол экспортод гарч, ковидын өмнөх түвшинээс 2 дахин нэмэгдсэн байж байгаа. Тэгэхээр цаашид 2024 онд ХАА-н салбарын өсөлтийг 6 хувьд хүргэж өсгөх ийм тооцооллыг болбол хийсэн байж байгаа. Ингэхийн тулд болбол ХАА-н зөв эдийн засгийн бодлого бол явуулна. Чөлөөт, либерал ийм бодлогыг болбол ХАА-н салбар дээр шинэчлэл бол зайлиггүй хийх бол шаардлагатай байж байгаа. Энэ бүх одоо энэ ХАА-н салбар дээр маш олон төрлийн татааснууд байдаг. Энэ татааснуудыг чөлөөлж, бодлогын цогц

шинэчлэлийн ажлуудыг хийхээр 24 оны төлөвлөгөө, Төсвийн хүрээний мэдэгдэл дээр болбол тооцсон.

ХАА-н татаасаас чөлөөлөх ноос ноолуур, арьс шир, нөөцийн мах, улаан буудай, ноолуур ноолуурын урамишуулал, сүүний урамишуулал гэх мэтийн маш олон ийм татааснуудыг үе шаттайгаар чөлөөлөх, зах зээлийн зарчмаар.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Яах вэ Хөдөө аж ахуйн сайд бол өчигдөр 5 дахь өдрийн мэдээлэл дээр бол энэ квотыг чөлөөлчихсөн, махны экспортыг квот дээр тогтоохгүй гэсэн энэ тэр мэдээлэл хийсэн л дээ. Тэгээд ХАА-н сайд өнөөдөр өвчтэй байгаа юм байна. Энэ 2 цагийн юун дээр ХАА-н сайдыг дууд, тэгээд тодорхой хариулъя. Тэгэхдээ нэг зүйлийг анхаарахыг хүсэж байна. Энэ нь ч 300 мянган малчин өрхийн ч асуудал биш, нийт хүн амын хүнсний хангамжийн асуудал байдаг учраас дэлхий даяараа л ХАА дээр тусдаа бодлого хэрэгжүүлдэг. 1 дүгээрт энэ бол улирлын шинж чанартай бүх эдийн засгийн төрөл дээр зээлийн болон татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн ийм зохицуулалт хийдэг журамтай. Жишээлбэл мах бэлтгэлийн үеэр ингээд яг малчдын махны үнэ уначхаад, энэ мах бэлтгэл хийж байж хавар мах хомсодсон үед нөөцийн мах бэлтгэхээс өөр аргагүй л болно шүү дээ. Энэ чинь Улаанбаатар хотын иргэдийн хүнсний хангамжийн асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр үнийг чинь энэ зохистой бодлого, квотын бодлого энэ тэр чинь зохицуулалтаа л бид хийж чөлөөлж, тэр Махны холбоо, холбогдох хүмүүст нь хийж, энэ хувийн хэвшлийн оролцоотой хийхгүй байгаа болохоос биш тэгээд л Улаанбаатарт махны үнэ өсөөд, махыг чөлөөллөө гэдэг чинь энэ чинь малчдадаа ч наалдаагүй, дунд нь ченжүүдийн л бизнес болчихдог.

Тийм учраас энэ дээр бас нэг их туйлихрахгүй, зөв бодлогодоо хандахгүй болбол хавар л махны үнэ өсөөд байгаа шүү дээ, махныхаа бэлтгэлийг л хийхгүй

бол, тэр малчдад ч наалдахгүй. Тэгэхээр энэ юмнуудаа бас зөв яахгүй бол бүгдийг нь ингээд татаасгүй болгоод л, улаан буудай тарихаа болиод 90-ээд оны үед бид нар юу боллоо. Тийм учраас ХХАА-н салбар бол бас төрийн дэмжлэг, зохицуулалт зайлигүй шаардлагатай байдаг л салбар л даа. Дашидондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Энд төсвийн хүрээний ийм мэдэгдэл ингээд л бид нар ингээд л ярилцаад л сууж байхад нэг их баярлаад байх юм ерөөсөө алга. Нөгөө л яг чиг хандлага ярьдаг барьдаг юмнууд энэ төсөв чинь бол яг л хуучин хэвээрээ л байна. Бодлогын чанартай яг тэр ард иргэдэд хүрэх өөрчлөлт шинэчлэлт бол ерөөсөө алга. Энэ юм бахь байдгаараа л үргэлжлэх нь. Уул нь бол Монголын ард түмэн, Монголчууд маань амандаа алтан халбага амсаад төрчихсөн ийм л ард түмэн байхгүй юу. 3-хан сая 500 хүн. Энэ 2 том эдийн засгийн дунд нь байгаа. Тэгээд энэ төсвийн бодлого, мөнгөний бодлого чинь хоёулаа шал хоёр өөр байна. Нийцэж байгаа ч юм алга. Төсөв бол тэлээд байна, мөнгөний бодлого нь бол хавчаад байна. Тэгээд энэ хувийн хэвшилээ түшиж ажиллах энэ орон зай чинь улам багасаж байна.

Цаашидаа ч энэ төсөв чинь ДНБ-д эзлэх юм нь энэ хэвээрээ байх юм уу, улам л өсөөд байх юм уу? Төрийн албан хаагчдын тоо чинь өсөөд байх уу? Миний ойлгож байгаагаар ДНБ-д эзлэх хувь чинь 40-өөд хувь болчихлоо. Төрийн өмчтэй компаниудыг нэмбэл бараг 60 болно. Тэгээд энэ давхар дээлтэй сайдуудын бизнестэй нийлбэл бараг 70, 80 хувь болно. Ер нь хувийн хэвшил 20-хон, хорьхон хувийн зайд л эргэлдэж байна шүү дээ. Ийм л хүнд нөхцөлтэй байна. Сүүлийн 7, 8 жил бол дандаа алдагдалтай баталлаа. Тэр хэмжээнд нь баталчхаж болдоггүй юм уу, ямар орлоготой юм. Үгүй ээ одоо яагаад, нөгөө боомт чинь сэргэсэн үү? Боомтын сэргэлт гээд байгаа, баахан сэргэлтүүд яриад байгаа. Хэрэв сэргэсэн юм бол яагаад 100 сая тонн нүүрс гаргаж

болохгүй байгаа юм. Сүүлийн хэдэн жил бол та хэд бас нэг юу юм даа Монголын ард түмний заяа юм уу даа. Уул уурхай, гарч байгаа уламжлалт бүтээгдэхүүний үнэ бол маш сайн байгаа шүү дээ. Нөгөө урд хөрш маань хаалгаа цэлийтэл нээчихсэн байгаа шүү дээ. Бүх юмыг чинь авъя л гэж байгаа ийм таатай нөхцөлд ингээж ажиллана гэдэг чинь тааруу байна.

Тэгээд бас гэрэл гэгээтэй юмнууд байна. Тухайлбал манайх НӨАТ-ыг бол баталж байсан. Жавхлан сайд их баярлаж талархсанаа илэрхийлж байгаа харагдана лээ. Үгүй ээ бас тийм л байх хэрэгтэй. Манай АН оруулж ирсэн. Гэхдээ энэ бол хяналтынх байсан. Одоо бид нар тэнд жоохон өөрчлөлт хийх хийх үү гэвэл хийх ёстой. Та нар амар хялбар татвар хураагаад сурчихжээ. Тэгээд л энэ одоо манай парламентаас явуулж байгаа 100 мянган хүний санал аваад өөрчилье гэдэг зөв. Энэ Занданшатар дарга маань гишүүн маань үнэхээр нэг бас Америкт нэг сургууль курс өгөөд ирсэн юм шиг болчихлоо. Сайн байна. Тэр 5 хувийн татварыг нь буцаая гэдэг зөв байхгүй юу. Тэр 600 тэрбум чинь ороод ирнэ Жавхлан сайдаа зоволтгүй. 3 сая 500 мянган татварын байцаагчтай боллоо гэсэн үг. Ард иргэд чинь өөрсдөө энэ эдийн засгийн мэдлэг нь тэлнэ, өснө. Хэдхэн том компаниас авах биш, уул уурхайгаас авах биш, тэр хүмүүс чинь өөрсдөө оролцоод ирэхээрээ миний төсвийг хаана яаж зарцуулж байна гээд хяналтаа тавина, шал өөр эрх зүйн орчин бүрдэнэ. Энийг дэмжих ёстой юм шүү. Иргэд чинь өөрсдөө оролцъё гэж байна шүү дээ. Тэгэхгүй бол энэ төсөв чинь бараг л тал нь л ажил болж байна шүү дээ. Бусдыг нь идчихэж байна, луйвардчихаж байна, ямар ч хариуцлага алга байна. Ийм маягаар ингээд цаашаа яваад байж болохгүй байна. Тэгвэл нэг шоронгоор дүүрэн баахан авлигачидтай, тэгээд нэг эсвэл торгож бариад гаргачихдаг.

Энэ жил Улаанбаатар хот гэхэд чинь автобусгүй өвөлжих нь байна шүү дээ. Тэгээд л ахиад л Улаанбаатар хотын

бонд гаргаж байна. Өнөөдөр энэ хувийн хэвшил 1 хувийн хүүтэй зээл дээр та нар нэг оронтой тоон дээр аваачна гээд л баахан юм болоод байсан хаана байна вэ, байхгүй шүү дээ. Монголбанкны мөнгөний бодлого 13 хувь дээр байна, сүүлийн 24 сар инфляцтай байна. Үгүй ээ энэ чинь энэ төсөв, энэ бүх мөнгөний бодлого чинь буруу яваад байгаагийн илрэл шүү дээ. Ямар ч гаднын хөрөнгө оруулалт орж ирэхгүй байна. Энэ бүхнийг та нар юу гэж бодож байна вэ? Энийгээ нэг өөрчилж болохгүй юу? Ингээд л хэлээд л яриад байх юм. Ард түмэн чинь амьдрал нь өдөр өдрөөр доройтоод л байх юм. Маш их мөнгө орж ирээд байдаг, тэрийг төсөв дээрээ овоолоод байдаг, илүү ч орж ирэх бололцоотой шүү дээ. Яагаад 100 сая тонн нүүрс гаргаж чадахгүй байгаа юм бэ? Боомт чинь ингээд сэргэлээ гэж үзэхэд хэцүү л байна шүү дээ. Миний харахад бол. Нэг иймэрхүү бас нэг өргөн хүрээнд яримаар байна. Дараа.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Сайхан үг хэллээ. Гочоогийн Ганболд гишүүн. Асуулт, Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Ганбат гишүүнийхээ асуултад хариулъя. Баярлалаа, баярлалаа. Энэ тэр НӨАТ-ын асуудлаас эхэлье. Энэ бол нэг тойргийн асуудал бол биш шүү, энэ бол улс орны энэ татвар, төсвийн бүрэн бүтэн байдал, энэ тогтолцооны асуудал яригдах учраас тооцоо судалгаа байвал ярилцъя л гэж байгаа шүү дээ. Төсөв өргөн барьсан хойно гэнэт гарч ирсэн сэдэв байна лээ. Та нар ярилцсан байгаа юм шиг байна, тэгээд бид, манай дээр болбол ийм юмны судалгаа тооцоо ерөөсөө огт ирээгүй байгаа. Тийм. Тэгэхээр тэрийгээ харж байгаад хэдүүлээ ярилцъя. Ер нь болбол төсөв нэгэнт өргөн барьчихсан үед одоо байгаа энэ орон зайгаараа харахад болбол бодлогын хувьд ч тэр, тогтолцооны хувьд ч тэр ч боломжгүй л асуудал байгаа.

**Г.Занданшатар:** Жавхлан сайд тойрог ярихгүй шүү, улс төржихгүй шүү.



Сангийн сайд зүгээр тооцоо судалгаа яривал ярь. Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдахгүй шүү. Гишүүдийн ярьж байгаа санал бодолд хүндэтгэлтэй хандаж сур. Тойрог гэж юу яриад байгаа юм. Улсын Их Хурлын гишүүдийн үг хэлж байгаа эрхэд яагаад халдаад байгаа юм та. Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя. Хариулт хэлэхгүй, тойрог яриад байна шүү дээ.

**Г.Ганболд:** Бид нар уг нь их чухал асуудал ярьж байгаа юм л даа. Тэгээд төсвийн төсөөлөл, төрийн мөнгөний бодлого эд нар дээр ерөөсөө ач холбогдол өгөхгүй юм. Энэ чинь уг нь болбол бид нар хоорондоо нэг хэдэн тоо 9-хөн тоо ярьж байгаа асуудал биш. Энэ гадаадын хөрөнгө оруулагчид, дотоодын ААН-үүд, иргэд энийг харж байж ирэх оныхоо ажлыг төлөвлөдөг зүйл шүү дээ. Төрийн мөнгөний бодлого ямар байх юм, хани ямар байх юм, инфляц хэдэн хувьтай байх юм, төсвийн алдагдал хэдэн хувь байх юм, орлого, зарлага нь хэд байх юм гэдгийг тооцоолж байж ирэх онд хөрөнгө оруулалт хийх юм уу, мөнгөө банканд хадгалуулах юм уу, валютаар хадгалах юм уу, төгрөгөөр хадгалах юм уу бүх асуудлаа шийддэг зүйл шүү дээ. Тэгээд ач холбогдол өгөхгүй нэг ингээд 9 тоон дээр ингээд яриад яваад байдаг. Ямар тооцоо судалгаатай хийж байгаа нь өмнөх юмнууд дээр нь олигтой харагдахгүй байгаа юм. Жишээлбэл ирэх онуудад инфляцыг 6 хувьд барина гээд, яг ямар тооцооллоор энэ 6 хувь гэж оруулж ирж байгаа юм бэ? Одоо энэ дэлхий нийтийн нөхцөл байдал чинь энэ дайн байлдаан чинь улам өргөжсөөд байна. Хүнсний өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн өсөх л хандлагатай байгаа шүү дээ. Ямар тооцооллоор энэ 6 хувь гэж оруулж ирж байгаа юм бэ? Хойтон өдийд хэрэв 6 хувь барьж чадаагүй байх юм бол хэн хариуцлага хүлээх юм бэ энэ дээр?

Ер нь болбол энэ 9-хөн тоогоо жаахан олон болгомоор байгаа юм. Ер нь бол манай улсын энэ экспортоос хамаарч байгаа хамаарлуудаа энэ хүснэгтдээ

оруулмаар байна. ХАА-н салбарын өсөлтүүдээ бас энд оруулмаар байгаа юм. Цалин хөлсөнд нь яг яаж төсөөлж байгаагаа бас оруулмаар байгаа байхгүй юу энэ 9-хөн тоон дээр. Тэгээд би зүгээр энэ дээр гол асуух гээд байгаа юм. Ирэх онд бид нар бол нийгмийн халамжийн асуудлуудаа инфляцтай уялдуулаад нэмэгдүүлнэ гээд хуульчилчихсан байгаа. Гэтэл энэ Нийгмийн халамжийн хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг бууруулна гээд орчихсон байна шүү дээ ирэх онуудад, 569,6, 590 гээд энэ 9 дэх тоон дээрээ хар л даа тоогоо. Тэгэхээр яах юм бэ ирэх онд энэ халамжууд буурах юм уу, халамжууд буурах юм уу? Тэгэхээр энийг бас хэдүүлээ тодорхой энэ тоонууд тавихдаа жаахан бас нэлээн тооцоо судалгаатай юмнууд тавьж баймаар байгаа юм.

Ер нь манай энэ ДНБ-д энэ уул уурхайн хамаарал яг хэдэн хувьтай байна вэ? Тэр дундаа энэ нүүрсний хамаарал яг хэдэн хувьтай байгаа юм бэ? Гэтэл бид нар энэ нүүрсийг чинь гол импортлогч улс бол Хятад. Эрчим хүчний гол хэрэглээгээ манайхаас авч байгаа нүүрсээр хангаж байгаа. Гэтэл эдний бодлого юу гэхээр зэрэг одоо болбол цөмийн эрчим хүчний реактор луу маш олон реактор барьж байна шүү дээ. Гэтэл тэрний тэжээл болох энэ ураныг нь бид нар экспортлох асуудалд нэг ёсондоо бол бид нар нүүрстэйгээ өрсөлдөх юмаа ингээд өгөх гээд явж байна л даа. Гол гаргаж байгаа юмнуудаа. Тэгэхээр энэ ойрын үед энэ нүүрсний хамаарал ер нь яг энд тогтвортой байхаар, 25 он хүртэл хэр тогтвортой байхаар байгаа юм бэ, ийм тооцоо судалгаа байгаа юм уу? Энэ ураны үйлдвэрлэл чинь манай гол экспортын орлогыг олж байгаа нүүрсэнд маань нөлөөлөх нөлөөлөл байна уу үгүй юү? Энийг яг тооцоолсон зүйл байна уу гэдгийг асууя.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Шатарбалын Раднаасэд, Бямбасүрэнгийн Энх-Амгалан нарын урилгаар Говь-Алтай

аймгийн Дэлгэр сумын ЗДТГ-ын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Алтайчууддаа эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Дэлгэрийн тал шигээ дэвжиж авахыг хүсэн ерөөе. Болдын Жавхлан сайд хариулна.

**Б.Жавхлан:** Ганболд гишүүний асуултад хариулъя. Урантай холбоотой тооцоолол бол ирэх оны төсөв дээр бол огт байхгүй шүү. Тийм. Тэгэхээр хэрвээ нэмэлт орлогууд орж ирвэл сайн хэрэг. Одоогоор энэ чинь дөнгөж гэрээ хэлэлцээр дээр яригдаж байна. Төсвийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын гэрээ Улсын Их Хурал дээр орж ирэхээр илүү их тодорхой юмнууд болох байх. Одоо бол дөнгөж тооцоолол төдий л байгаа.

Нүүрс нийт төсвийн орлогын 29,5 хувийг уул уурхайн орлогоос бүрдүүлж байна. Үүний 16 хувь нь нүүрсний орлогоос бүрдүүлж байна гэсэн үг. Ер нь яах вэ шууд буюу шууд бусаар болбол энэ орлогыг дахиж тооцоолж гаргах юм болбол ер нь 60, 70 хувь дээр очихоор, ер нь уул уурхайгаас хамааралтай төсвийн орлого бол нэлээн өндөр болсон. Тэр хэмжээгээр эдийн засаг маань бас нэлээн гадаад шокоос хамааралтай, энэ өсөлтүүд бол тэр хэмжээгээр бас хэврэг. Тийм учраас бид цаашидаа энэ эдийн засаг, ялангуяа төсөв дээрээ бол маш болгоомжтой энийгээ тогтворжуулах тал дээр бид ажиллах ёстой байгаа.

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар УУХҮ-ийн сайд хариулна.

**Ж.Ганбаатар:** Ганболд гишүүний асуултад хариулъя. Тэр ураны хувьд ямар төсөөлөлтэй байгаа вэ, нүүрстэй чинь өрсөлдөх юм биш үү, үгүйсгээд явчих юм биш үү гэсэн. Энэ гэхдээ манай нийт экспортын яг нүүрс дээр бол бараг 90 хувь нь коксожсон нүүрс байгаа. Голцуу гангийн үйлдвэрүүдэд хэрэглэгддэг. Гэхдээ сүүлийн үед ганг бас тэр цахилгаан зуухаар энэ тэр хайлуулж байгаа асуудлууд бас нэлээн давамгай явж

байгаа. Гэхдээ манай яг Эрдэс Тавантолгой гэх юм уу, манай энэ коксожсон нүүрсний чанар бол ер нь бол цаашидаа бол бид бол 30, 40 жил хэрэглэгдэх бүрэн боломжтой гэж харж байгаа юм. Тэгээд энд олон талын судалгаанууд байдаг юм байна лээ л дээ.

Тэгэхлээр ураны хувьд бол цахилгаан станцууд атомын станц болно, болоод явах чиглэл нь байгаа юм биш үү гэдэг дээр бол санал нэг бол байна. Тэгэхээр уранаа ч хөгжүүлэх ёстой, коксожсон нүүрснийхээ ч явах ёстой. Ер нь бол эрчим хүчний нүүрсний хэрэглээ ч гэсэн бол байгаа. Бид л өөрсдөө л 30 онд л дуусах гээд байна л гээд байгаа боловч ер нь бол эрчим хүчний нүүрс буцаад Европт хүртэл хэрэглэгдэж л байгаа л даа. Яах вэ хүсэл бол хэрэглэхгүй байхыг хүсэж байна. Тэгэхдээ хэрэгцээ бол байна шүү дээ. Тэгээд хэрэгцээгээ яаж давах вэ, хүсэл бол эрчим хүчний салбарт бол эрчим хүчний нүүрс хэрэглэмээргүй байна. Гэхдээ хэрэгцээ шаардлага бол гаргалгаагаа бол одоогоор бас олохгүй л байна л даа. Тийм учраас бид нарын хувьд бол эрчим хүчний нүүрснийхээ импортыг нэмэгдүүлэх бодлого барьж байна. 3-хан хувь байдаг байсан юм эрчим хүчний нүүрс. Энэ жил бид бараг 9 хувь хүртэл нийт экспортын 9 хувийг эрчим хүчний нүүрс экспортолж байгаа. Хариулт өгсөн байх гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэлх гишүүн үг хэлж болно. Дараа нь санал хураалт явуулна, гишүүд чуулганы танхимд цуглая. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

**Д.Ганбат:** Ер нь бол нэгэнт улсын төсөв ярьж байна. Хоногтой, хугацаатай ийм зүйл. Мэдээж хэрэг тэгээд өмнө ингээд явчихсан юм чинь одоо тэгээд сүүлийн удаа энэ юмыг нь тэгээд батлаад л явуулдаг байх даа. Угаасаа та нар ч бас

тэгээд 60 хэдүүлээ улс. Гэхдээ энэ дээрээс бол ард түмэн бас дүгнэлтээ хийх ёстой. Цааш цаашидаа бид нар энэ хандлагаа өөрчлөх ёстой. Ялангуяа энэ парламентаас Их Хурлаас явуулж байгаа тэр ард түмний саналыг авдаг, энэ үйл ажиллагаанд оролцдог, энэ улс орноо төлөөллөө бид нараар дамжуулж удирдахаас гадна өөрсдөө бас оролцдог энэ зүйл нь одоо дэлхий нийтэд жишиг болчихоод байна шүү дээ. Тийм байж харилцан тэнцлийг олж ингэж явах ёстой. Энэ хандлага болбол зөв байна гэж үзэж байгаа юм.

Нөгөө талаараа бол энэ хувийн хэвшил, энэ бүх зүйлд чинь бол үнэхээр энэ мөнгөний бодлого, энэ улсын төсөв энэ сүүлийн хэдэн жил явж байгаа энэ байдлаас чинь болоод банкнаас зээл аваад үйл ажиллагаа явуулах ийм орон зай байхгүй болчихсон. Хувийн хэвшилүүд дээшилж дэвшиж байгаа юм алга. Нөгөө залуучууд маань улс орноосоо ингээд зугтсан байдалтай ийм л нөхцөл байдал байна шүү. Энд чинь энэ төсвийн бодлого, мөнгөний бодлого бүгд л нөлөөлж байгаа шүү дээ бидний баталж байгаа хуулиуд. Тэгэхээр энийг эргээд харах цаг болсон цааш цаашидаа гэдэг зүйлийг бас хэлж, яримаар байна.

Нөгөө талаараа бол энэ хугацаанд бол одоо ирэх жилүүдэд ч гэсэн үнэхээр тийм үр дүнтэй, ард нийтэд хэрэгтэй, улс орныг урагшлуулсан ийм үйлдвэрүүд баригдахгүй юм байна. Тухайлбал малын, малаас гарч байгаа бүтээгдэхүүнийг боловсруулах энэ юм бол тэгээд тэр Хөгжлийн банкаар дамжаад юу ч биш болоод л Дарханд дууслаа шүү дээ. Жишээлбэл одоо бид нар зэсийн бол нэлээн гайгүй тоглогч. Цаашидаа ч зэсийн үнэ сайжрах шинжтэй байна. Гэтэл энэ талаар бол бодож байгаа, зэсийн үйлдвэрийг цэврээр нь гаргах энийг барьж байгуулах, энэ талаар ажиллаж байгаа ийм юм санаанд хүртэл байхгүй байна. Энийг л ард түмэн шүүмжлээд яриад байна. Бүгдээрээ л нэг төр засгийг харсан, халамж харсан ийм л хүмүүс болох гээд

байдаг. Тэр өгч байгаа халамж нь гэхэд бол ерөөсөө амьдрал ахуйд нь хүрэхгүй, та нар нэг ингэсхийгээд байж бай, бид нар дээгүүрээ нэг хулгайлж бариад ингээд явчихъя гэсэн ийм маягтай л юм ингээд байдаг. Энэ байдлаас чинь болж хүмүүсийн итгэл найдвар ингээд тасарч байна.

Тэгээд энэ төсөвт чинь тэр Соёлын яаман дээр ямар ч их мөнгө тавьчихсан юм бэ дээ. Үгүй ээ энэ нэг ангид 3 ээлжээр хичээллэж байхад тэр соёлын төвүүд энэ тэр жоохон хойшоо байж болдоггүй юм уу? Тэр кино энэ тэр хийх гэж байгаа ийм мөнгө төгрөгийг хойшлуулж болдоггүй юм уу? Боловсролын яам тэр яагаад хүүхдүүдийг ялгаад байна вэ энэ улсын төсөв дээр. Нөгөө хамтралын бухыг буудна гэдэг шиг л, хамтралжих хөдөлгөөнөөр манай бухыг дайрлаа гэдэг шиг. Үгүй ээ тэр аав ээж нь сайн ажиллаад, үр хүүхдээ хэдэн төгрөг төлөөд сургуульд явуулж байгаа юмыг тэр хоол ундыг нь ч хасаад л, Монгол Улсын иргэний хувьд, тэр хувьсах зардлыг нь ч хасаад л, тэрүүгээр нэг попроод л энэ чинь буруу шүү дээ. Миний хүүхдүүд хувийн сургуульд явдаггүй л дээ, ач нар энэ тэр. Тийм учраас би ашиг сонирхлын зөрчилгүй болохоор хэлж байгаа шүү.

Нөгөө Үндсэн хуулийн зүйл, заалт чинь унаад байна шүү. Иймэрхүү нэг ч гэсэн хүүхэд сайн байг л даа Монгол хүүхэд. Тэгэхгүй бүгдээрээ л энэ 4 уулан дотроо хордоод л, тэгээд ингэж байж болохгүй шүү дээ. Ингэж тайраад л, нэг нь сайн байвал дагаад л бүгд сайжирна. Тэр эх эцэг нь сайн байсны төлөө тэд нарыг ингэж шийтгэдэг барьдаг энэ юмаа боль та нар. Та нар асуудалд нэг арай л буруу хандаад байх юм. Энэ та нарыг нэг сольж байж л нэг, АН-ыг гаргаж байж л нэг аятайхан болох юм шиг байна. Тэрийг 24 онд Монголчууд мэдэж байгаа. Мааш их мэдрэмжтэй ийм ард түмэн. Гэхдээ та нар бас нэг бүлэгтэй байх байлгүй дээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Энэ Төсвийн хүрээний мэдэгдэл одоо санал хураалт явуулна. 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай нийцэхгүй, шаардлага хангахгүй байна гэж бол бас хэлэлцэхгүй байж болно, буцааж болно. Ийм байдалтай байх юм бол.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. Хамтралын бухыг мөргөсөн гээд нударганы бухыг буудсан. 54,9 хувийн саналаар төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ. Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд ишлэжүүлж байна.

13.02 цаг

Завсарлага, 14 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ.

2023 оны 10 дүгээр сарын 19, Пүрэв гараг,  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
14 цаг 23 минут.

### **ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын намрын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Төсөв хэлэлцэхийн өмнө, төсөв хэлэлцэхэд ЗГ-ын гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ байх ёстой.

### **Хоёр. “Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын**

Ингээд хэлэлцүүлэгт бэлдэхийн өмнө Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх хэлэх нь зүйтэй гэж Даргын дэргэдэх зөвлөлөөр шийдсэний дагуу шийдвэрлэе. Энэ жижиг асуудал байгаа учраас. Тогтохсүрэн даргаа Даргын дэргэдэх зөвлөлийнхөө хурлын юуг шийдвэрээр ингээд Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцье. ТББХ-ны санал, дүгнэлтийг Пүрэвдорж гишүүн байхгүй байна. Та танилцуулчих уу? ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд гишүүн танилцуулна, Төрийн байгуулалтын байнгын хороо.

**Г.Ганболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5, 28.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.5 дахь хэсэгт заасныг болон Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржийг Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын

дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурийг тус дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 81,8 хувийн саналаар дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төсөл хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг сонгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар иргэний бүртгэл дээр суурилсан сонгогчийн бүртгэлийг хөгжүүлэхэд УБЕГ-тай хамтран ажиллах талаар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлэх санал байхгүй байна. Ийм учраас Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэнэ үү. Санал хураалт явуулъя. 58 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.5

дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржийг Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурийг тус дэд хорооны гишүүнээр баталсугай.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй. Ингээд Батсуурь гишүүн, гэсэн ийм тогтоолын төсөл байна. Уншиж танилцууллаа. Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Ингээд Жамбын Батсуурь гишүүн маань Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргаар сонгогдох учиртай. Тэгээд баяр хүргэе, амжилт хүсье. Хяналт, сонгуулийн хяналтыг одоо сөрөг хүчиндээ өгч байна гэсэн үг шүү энэ чинь.

14.29 цаг

**Гурав. “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** Өнөөдрийн хэлэлцэх асуудалд байсан Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг бас АН-ын бүлгийн гишүүдийн хооронд нөгөө орж, гарч өөрчлөлт орох ёстой байсан. Тэгэхээр энэ асуудал дээр бид нар бас тодорхой шийдвэр хараахан гараагүй байгаа тул энэ асуудлыг долоо хоногоор хойшлуулж өгнө үү.

**Г.Занданшатар:** АН-ын бүлгийн саналаар, горимын саналаар санал

хураалт, завсарлага өгчихье тийм ээ. Ажлын 5 хоногийн завсарлага өгч, хойшлууллаа.

14.31 цаг

Тогтохсүрэн даргаа.  
Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн  
горимын санал гарна.

**Д.Тогтохсүрэн:** Төсөв хэлэлцэхийн өмнө би тэр СЕХ-ны орон тооны дээд хязгаар тогтоох тухай тогтоолын төслийг хэлэлцээд шийдчихвэл яасан юм бэ гэж бодож байна. Яагаад гэхээр төсөв чинь одоо ингээд нэг эхэлчихээр их олон хүн үг хэлнэ, тэгээд санал хураадаггүй. Тийм учраас ингээд орой 7, 8, 9, 10 ч хүргэж магадгүй. Тийм учраас тэр асуудлыг урагш нь татаж хэлэлчихээд, тэгээд хойшоогоо бол үндсээ төсвөө явчихъя гэж ингэж бодож байна. Тийм учраас тэр СЕХ-ны дээд орон тооны дээд хязгаар тогтоох тухай асуудлыг урагшлуулаад хэлэлчихье гэдэг горимын санал гаргаж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 62,7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Дөрөв. “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Сонгуулийн ерөнхий хорооноос 2023.10.10-ны өдөр ирүүлсэн саналын дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо боловсруулсан/**

Горимын санал дэмжигдсэн тул СЕХ-ны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай, Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын

тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ. Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу СЕХ-ноос 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 1/342 тоот албан бичгээр ирүүлсэн саналын дагуу СЕХ-ны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасныг баримтлан боловсруулж, ТББХ 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг хуулийн дагуу СЕХ нь улс төрийн намын санхүүжилт, түүнд тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. СЕХ тус хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд уг чиг үүргээ хэрэгжүүлэх, Тамгын газар, бүтцийн нэгж байгуулах, орон тоог шинэчлэн батлах шаардлага үүссэн гэж үзсэн байна.

Байнгын хороонд ирүүлсэн саналтай холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт СЕХ-ны ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно гэж

заасны дагуу ТАЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 01/22 52 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн СЕХ-ны Тамгын газар орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон түүнтэй холбогдуулан Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар тогтоол, Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын 2019 оны 18 дугаар тогтоолын хавсралтад тус тус өөрчлөлт оруулах Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг боловсруулсан болно.

СЕХ-ны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд СЕХ-ны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 60 албан хаагчтай байхаар, холбогдох төсөв, үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын ЗГ-т даалгах зохицуулалтыг тусгасан.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганболд СЕХ-ны бүтэц зохион байгуулалтыг шинэчлэхдээ сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, батлагдсан хуулиудыг тайлбарлан таниулах, мэдээлэх чиг үүрэгтэй мэдээлэл сурталчилгаа, судалгаа, сургалтын төвийг бэхжүүлэхэд анхаарсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг Улсын Их Хурлаар батлагдсан хуулиудын хэрэгжилтийг хангах ажлыг хэрхэн зохион байгуулж байгаа талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар СЕХ-ны хараат бус байдлыг хангах, улс төрийн намуудын төлөвшил, дотоод ажлыг бэхжүүлэх хүрээнд Хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоож өгөх нь зүйтэй

талаар, Улсын Их Хурлын гишүүн Доржханд Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн баталсан хуулиудын талаарх мэдээллийг улс төрийн нам, иргэд, сонгогчдод тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, сонгогчдод мэдээллийг бүрэн хүртээмжтэй болгоход анхаарч ажиллах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын хүрээнд улс төрийн намын санхүүжилт түүнд тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийн нэгж байгуулах, Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэх нь зүйтэй талаар үг хэлж, саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь СЕХ-ны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай, Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай болон Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

СЕХ-ны Тамгын газрын орон тооны дэд хэсгээр тогтоох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүн СЕХ-ны дарга Пүрэвийн Дэлгэрнаран. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Содномын Чинзориг, Ширнэнбаньдын Адышаа гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн асуулт асууна, үг хэлнэ.

Асуулт, үг нэг явж байгаа. Асуулт асууж, үг хэлнэ.

**С.Чинзориг:** Төсөв дээр ЗГ-ын гишүүд үг хэлж болохгүй гээд байх юм. Одоо энэ дээр нэг үг хэлье дээ. Энэ Энхболд дарга энэ би нэг буруу зарчим яваад байна гэж яриад байсан юм даа. 19 онд ч гэсэн бас ийм тогтоол орж ирэхэд нь би бас байр сууриа илэрхийлж л байсан. Одоо ингээд шүүхийн ерөнхий, шүүхийн Тамгын газрын дарга, Цэцийн Тамгын газрын дарга эд нар гээд албан тушаалтнууд чинь уг нь болбол захиргааны ажилтнууд шүү дээ. Ажлын албаны дарга нарыг энэ Улсын Их Хурлаас төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа тогтоодог энэ зэрэглэл рүү ингээд оруулдаг ийм нэг буруу жишиг яваад удаж байна л даа. Одоо дахиад СЕХ-ны Тамгын газрын даргыг бас одоо Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэл тогтоох тухай Их Хурлын тогтоолоор оруулж ирж байна л даа. Энэ улам буруу жишиг л яваад байгаа юм.

Энэ ажлын Тамгын газрын дарга гэдэг чинь болбол яг л захиргааны л ажилтан шүү дээ. Ажлын албаны дарга л байхгүй юу. Тэгээд ийм одоо улсуудыг чинь ингээд энэ Их Хурлаас тогтоодог ангилал, зэрэглэл рүү оруулаад, ийм буруу жишиг яваад байгаа. Ингээд үргэлжилж байгаа юм байна. Тэгээд ийм буруу жишиг яваад байгаа юм. Тэгсэн атлаа энэ төрийн Үндсэн хуулийн байгууллагууддаа бас Их Хурал тэгш бус одоо хандаад байгаа юмнууд байна шүү дээ. Дээд шүүхийн асуудлууд, Цэцийн асуудлууд Тамгын дарга нь бүгдийг нь одоо энэ ангилал зэрэг рүү оруулчихсан. Тэгсэн атлаа адилхан одоо Үндсэн хуулийн байгууллага прокурорын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын даргыг тэгээд энэ ангилал, зэрэглэл рүүгээ оруулахгүй л яваад байгаа юм. Тэгээд яагаад одоо Улсын Их Хурал ингээд Үндсэн хуулийн байгууллагууддаа, төрийн байгууллагууддаа тэгш бус одоо хандаад, ингээд ялгамжтай хандаад байгаа юм бэ? Нэг хэсгийг нь болохоор

бүгдийг нь Тамгын даргыг нь энэ төрийн өндөр албан тушаалтны ангилал, зэрэглэл түүнтэй адилхан албан тушаалтны зэрэглэл рүү оруулаад байдаг. Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын даргыг болохоор ингээд үлдээгээд байх юм. Энэ чинь одоо ҮХЦ-тэй адилхан, Дээд шүүхтэй адилхан л Үндсэн хуулийн байгууллага шүү дээ.

Тэгээд Их хурал өөрөө ингээд төрийн байгууллагууддаа тэгш бус одоо ялгамжтай хандаад байгаад байх юм би энийг ойлгохгүй юм. 19 онд энэ тогтоол баталж байсан би бас байр сууриа илэрхийлж л байсан. Тэгээд ТББХ энийг дараагаар нь бас авч үзье, анхаарах ёстой асуудлын нэг мөн л гэсэн. Тэгээд энийгээ одоо хамтад нь одоо оруулаад ирж болдоггүй юм уу? Тэгээд яагаад одоо ингээд Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын даргыг нь энэ одоо ангилал зээлд оруулахгүй үлдээгээд бусад нь одоо бүгд ингэж ороод болоод байна шүү дээ. Энэ дээр одоо бас энэ ТББХ юу гэж үзэж байгаа юм бэ? Тэр Ерөнхий прокурорын газрын Тамгын даргыг энэ Үндсэн хуулийн байгууллагуудын адилхан Тамгын газрын дарга нартай адилтгаад энэ ангилал, зэрэглэл рүү нь оруулчхаж болохгүй, бусдыг нь оруулаад, нэгийг нь ингээд үлдээгээд байдаг энэ одоо ямар учир шалтгаан байгаа юм бэ?

Ингээд Их Хурал өөрөө энэ Үндсэн хуулийн байгууллагууддаа тэгш бус одоо хандаад байж болохгүй шүү дээ. Энийг одоо Байнгын хороо юу гэж үздэг юм бэ? Би 19 онд энэ тогтоол батлахад нь ер нь болбол буруу тийшээгээ явж байна гээд шүүмжилсэн юм. Энэ үргэлжлээд байдаг. Тэгсэн атлаа тэр төрийн Ерөнхий прокурорын Тамгын газрын даргыг энэ ангилал, зэрэглэл рүү нь оруулчихгүй ингээд ялгамжтай хандаад, үлдээгээд байх юм. Энэ одоо яагаад ингээдэг юм бол гэдгийг тодруулаад, тодруулмаар байх юм. Энийг одоо оруулах боломж байгаа юм уу байхгүй байгаа юм уу?



**Г.Занданшатар:** Хариулт. ТББХ-н дарга Нямаагийн Энхболд гишүүн асуултад хариулна.

**Н.Энхболд:** Хариулъя. ТББХ-гоор орж ирсэн асуудлуудыг бид нар санаачлаагүй, зөв буруу эсэхийг одоо хэлж мэдэхгүй байна. Санаачилж оруулж ирсэн хууль, яагаад санаачилж оруулж ирсэн бэ гэхээр Үндсэн хуульд өөрчлөлт орсон, сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт орсон. Үүрэг хариуцлага нь нэмэгдэж байгаа, өмнөхтэй харьцуулахад. Ялангуяа энэ Намуудын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдоод СЕХ-ны зүгээс намуудын үйл ажиллагаанд хяналт тавих, хамтарч ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангахад болбол тусгайлсан их чухал үүрэг гүйцэтгэдэг ийм үүрэг хариуцлагатай болсон. Энэний дагуу СЕХ-ноос СЕХ-нд чиглэл өгөөд, СЕХ хамтраад энэ тогтоолын төслүүдийг оруулж ирж байгаа юм. Дахиад хэлэхэд бид нар яг одоо дангаараа ТББХ-ны зүгээс юм уу, Их Хурлын зүгээс харьяа байгууллагууддаа ялгавартай хандаж байгаа зүйл байхгүй.

Нөгөө талаар Их Хурлын харьяа байгууллага л бол бүх юмнууд нь адилхан байх ёстой гэсэн тийм зарчим ч байхгүй. Эрх зүйн зохицуулалтад ямар өөрчлөлт орж байна, үүрэг хариуцлага нь яаж нэмэгдэж байна, энэ байгууллагын үйл ажиллагаанаас дараа дараагийн юмнууд яаж хамаарахаар байна гээд олон зүйлүүдийг л тал талаас нь бодож байж л оруулж ирж байгаа л даа. Түүнээс зөвхөн одоо Их Хурлын харьяа байгууллага гэдэг үүднээс энэ асуудалд хандаагүй гэдгийг хэлье дээ.

Зүгээр нэмээд хэлэхэд энэ тооны хязгаарын тухай асуудал байгаа. Энийг бас СЕХ-ны даргатай, удирдлагуудтай ч ярьсан. Дээд хязгаар 60 байна гээд заавал одоо 60 болго гэсэн үг биш үү. Яг одоо хуулиар шинээр бий болсон үүрэг хариуцлагатай чинь холбоотой ямар функцүүд танай байгууллага дээр нэмэгдэх нь үү, тэр хэмжээгээр тэгээд

хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж чадах тийм хүчин чадлынхаа хэмжээнд л энэ асуудалд хандаарай гэдгийг хэлсэн байгаа. СЕХ ч үүнийг ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя.

**С.Чинзориг:** Би болбол Энхболд даргын байр суурьтай санал нийлэхгүй л байна. Их Хурал тэгээд өөрөөсөө Их Хурлаас байгуулагддаг байгууллагадаа заавал ижил тэгш хандах ёстой гэсэн зарчим байж болохгүй гэж болохгүй шүү дээ. Энэ чинь ерөөсөө байж болохгүй зарчим шүү дээ. Их Хурал өөрөө энэ Их Хурлаас байгуулагддаг байгууллагууддаа тэр тусмаа Үндсэн хуулийн байгууллагууддаа ижил тэгш хандах ёстой. Энэ чинь болбол суурь зарчим шүү дээ нэг дэх асуудал.

2 дахь асуудал энэ төрийн өндөр албан тушаалтнууд гэдэг чинь дандаа улс төрийн албан тушаалтнуудын л ангилал зэрэглэл шүү дээ. Энэ СЕХ-ны Тамгын газрын дарга гэдэг чинь бол төрийн захиргааны ажилтан, Ажлын албаны дарга шүү дээ. Яг төрийн захиргааны ажил хийдэг энэ төрийн захиргааны албан хаагчдыг ингээд улс төрийн албан тушаалтнуудтай адилтгаад ангилал, зэрэглэлийг нь тогтоодог чинь буруу шүү дээ. Цаашидаа наад Тамгын газрын дарга чинь бүгд одоо улс төрийн албан тушаалтанд л одоо болоод явна гэсэн үг шүү дээ. Энэ одоо маш том буруу жишиг рүү л практик л яваад байгаа юм даа Энхболд даргаа.

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд дарга хариулъя.

**Н.Энхболд:** Нэг зүйлийг орхигдуулсан байна. Энэ зэрэглэл, зиндаа тогтоох юман дээр ТАЗ-өөс заавал саналыг нь авч байгаа. Тэгэхээр би түрүүн хэлсэн, прокуророос ийм санал ерөөсөө ирээгүй. Төрийн албанд хүргүүлээгүй, ТАЗ-өөс манайд санал ирүүлсэн юм

байхгүй байна. Тэр одоо буруу зөвийн тухай асуудал болбол яах вэ гишүүн болгон янз бүрийн саналтай байж болох байх, бололгүй яах вэ тийм. Их Хурал ингээд л шийдээд л явж байгаа шүү дээ олонхоороо. Байнгын хороо шийдээд л, бүгдээрээ буруу гэж үзэж байгаа болбол тэрний дагуу л асуудлыг нь оруулбал бүгдэд нь жигд ханд, нэг нь л ингэсэн бол бусдыг нь бүгдийг нь ийм болго гээд асуудлууд орж ирэх байх. Улсын Их Хурал бүхэлдээ гишүүдийнхээ олонхоор шийдээд л явж байгаа асуудал гэдгийг хэлэх байна. Гишүүн болгон янз бүрийн байр суурьтай байж болно. Тэрэнд бас хүндэтгэлтэй хандаж.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Н.Алтанхуяг:** Нэг асуулт байгаа. Энэ нэг хууль батлаад л ингээд л орон тоо нэмээд л явах юм даа. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор СЕХ улс төрийн намын санхүүжилт түүнд тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. Тэгээд Тамгын газрын бүтцийн нэгж байгуулах, орон тоог шинэчлэн батлах шаардлага үүссэн. Энэ нэг дампуу юмаа ерөөсөө больж болохгүй юм уу? Ард түмний ахуй амьжиргаа ийм байна, юмны үнэ өдрөөс өдөрт өсөөд нэмэгдээд хүнд хэцүү байна гэххээд л орон тоогоо нэмээд л, энэ хэдэн хүн байсныг 60 болгох гээд байгаа юм бэ тэрнийгээ хэл дээ. Энхболд дарга дахиад л бөөрөнхий юм ярьж байгаа нь 60 хүртэл гэдэг чинь 60 гэсэн үг биш шүү гэж. Дандаа генералд нь тултал хийдэг шүү дээ наадуул чинь. Та нар одоо ийм энгийн юм одоо худлаа үнэн ярихаа болимоор юм энэ Их Хурал дээр.

Энэ улс орны ахуй амьдрал, ард түмний ахуй амьдрал, юмны үнийн өсөлт, энэ төсвөө ярья. Одоо энэ дарга нарын орон тоог нь нэмж өгөөд, байгууллагынхаа эд нар чинь бас булхай луйвар хийдэг газар. Тэгээд дээр нь одоо эд нарын албан тушаалыг нь баталгаажуулаад дээш нь тавьж өгөөд,

боливол яасан юм бэ? Та нар одоо нэг ийм 60 хэд өөр хийх ажилгүй юм уу? Би бол ёстой эсэргүүцэж байна, боль. Та нар тэр байгаа орон тоондоо багтаагаад хий. Тэр санхүүжилтийн хяналт тавьдаг зарим ажлыг нь тэр аудит гээд бас байгууллага байгаа шүү дээ. Тэр лүү функцийг нь өгөөд хийлгээд, та нар хяналтаа тавина биз. Ийм энгийн юмаар хийчих юмыг чинь л одоо ингэж хайран цаг, энэ дарга нарын орон тоо нэмдэг, төрийн албан хаагчдын тоог нэмдэг, энэ дарга нарын эрх хэмжээг ингэж ямбажилдаг, ямбыг нь нэмэгдүүлдгээ бол зогсоо.

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд дарга хариулна.

**Н.Энхболд:** Энийг зүгээр юунд СЕХ-нд илүү эрх мэдэл, илүү ачаалал илүү үүрэг хариуцлага хүлээлгэх гэж бид нар бодож оруулж ирж байгаа асуудал биш. СЕХ ч өөрөө ингэж хандаагүй. Нөгөө хуульдаа тэгээд заачихсан байхгүй юу Алтанхуяг гишүүнээ. СЕХ ийм үүрэг гүйцэтгэ гээд, бид нарын түрүүний та бидний хамтраад баталсан хуулиар СЕХ ийм, ийм ажлуудыг хий гээд заачихсан юм. Тэгэхээр та батлаагүй байж болно. Их Хурал олонхоороо баталчихсан, тэр хуулийн дагуу л бид нар оруулж ирж байгаа. Шаардлагатай гэж үзвэл жишээ нь энэ тэр намуудын юманд хяналт тавих энэ ажлуудыг нь тэр Дээд шүүх нь байна уу эсхүл аудит аудитын газар байна уу хийж байх ёстой, ингэж болохгүй гэдгийг нь хуулиа санаачлаад Их Хурлаар дэмжүүлээд, батлуулаад явах боломж нь бас Улсын Их Хурлын гишүүдэд байгаа.

Давтаад хэлэхэд түрүүн гарчихсан хуулиа л хэрэгжүүлэх үүднээс бид нар ийм хуулийн төсөл, тогтоолын төсөл оруулж ирж байгаа юм гэдгийг л хэлье. Ер нь яах вэ бүх юмыг одоо төсөв, санхүү, ард түмний амьдралтай холбож ярьж болно л доо ямар ч асуудлыг. Гэхдээ энэ СЕХ-ны ажлаас өөрөө нөгөө аливаа сонгуулийн хүлээн зөвшөөрөх байдлыг зохион байгуулж хийхэд маш том үүрэг гүйцэтгэдэг учраас энэ байгууллагыг бас

зүгээр нэг л тийм зохион байгуулалтын л асуудал хариуцдаг байгууллага гэж хэлэхэд хэцүү байгаа юм. Энийг та бид нар бүгдээрээ мэднэ. Яаж ажиллаж байна, асуудалд яаж хандаж байна, элдэв одоо сонгуультай холбоотой маргаан гарвал үүнийг яаж шийдэж байх вэ гэдэг дээр маш том үүрэг гүйцэтгэдэг. Үүгээрээ нөгөө сонгуулийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, тэрний дараах одоо юу гэдэг юм төр засгийн хүлээн зөвшөөрөх байдал, улс төрийн тогтвортой байдлыг хангахад томоохон үүрэг ордог байгууллага учраас энэ дээр бид нар бас анхаарал тавих нь зүйтэй л гэж үзэж байгаа юм.

**Г.Занданшатар:** Мөнхцэцэг гишүүн нэмж хариулах байсан юм уу? Энэ чинь I дүгээрт Чинзориг сайдаа энэ чинь улс төрийн албан тушаалтан болж байгаа хэрэг биш шүү дээ. АТГ-ын дарга, аудитын дарга энэ тэр гээд төрийн өндөр албан тушаалтны зэрэглэл, СЕХ-н дарга адилхан л байдаг. Тийм. Тэгээд АТГ чинь улс төрийн албан тушаалтан болж байгаа хэрэг биш. Орон тоо нэмж байгаа асуудал чинь бас Сонгуулийн хууль, Улс төрийн намын тухай хуулиар улс төрийн намын санхүүжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй болчихсон, ил тод байдлыг нь хангах үүрэгтэй болчихсон. Тэгээд сургалт, судалгаа явуулах, сонгуулийг шударга зохион байгуулах олон үүрэг функцүүд нэмэгдсэнтэй холбогдуулж орон тоо нэмж байгаа л гэж тайлбарласан энд бичсэн байна шүү дээ уул нь тэрнийгээ. Зочид танилцуулаад, дараа нь Ц.Мөнхцэцэг гишүүн. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяагийн урилгаар БГД-ийн Эрдмийн өргөө сургуулийн ИЖ ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт багш, сурагч нартаа сурлага, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ Улс төрийн намын тухай хуулиар сонгуулийн төв байгууллага хуучны одоо зүгээр

сонгууль зохион явуулдаг бусад үед хийсэн ажил багатай байдаг энэ байдал нь өөрчлөгдсөн. Тэр Алтанхуяг гишүүн асуугаад байна. Улс орны байдал хэцүү байна гэж. Үнэхээр 30 жилд Монголын одоо улс төрд ямар ч хариуцлага хүлээдэггүй, нийгмийн өмнө үүрэг хүлээхгүй, ард түмэндээ тайлагнадаггүй, санхүүгээ тайлагнадаггүй ганц байгууллага бол улс төрийн нам байсан. Тэгээд улс төрийн нам, тэр дотроо одоо намаас зохион байгуулж байгаа сонгууль бол тэр чигтээ хөрөнгө мөнгөний өрсөлдөөн байсан. Аль хөрөнгө мөнгөтэй эсвэл тодорхой бүлэглэлүүд энэ засгийн эрх нь гарч байсан. Тийм учраас бид нар энэ намыгаа өөрчлөхгүй болбол намуудын санхүүжилтийг ил тод болохгүй болбол Монгол Улсын ардчилал энэ хөгжлийг бол ярих боломжгүй. Тэгээд энэ сонгуулийн одоо энэ ерөнхий байгууллага бол улс төрийн намын санхүүжилтийг хянана, дээр нь намын дотоод ажил байна уу юу гэдгийг хянана.

Энэ дотор нэг жишээ хэлмээр байна. Дөнгөж саяхан АН-ын Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны одоо Ерөнхийлөгчийн сонгууль боллоо. Хэвлэлд байгаа мэдээллээр болбол нэр дэвшигч нараасаа 60 сая төгрөгийн дэнчин авсан тухай мэдээллүүд гарч байна. Гэтэл энэ бол одоо Улс төрийн намын тухай хуулиар бол хориотой, 2024 оны I сарын I-нээс эхлээд хэн нэгэн мөнгөтэй этгээд намд мөнгө хандивлаж, дэнчин өгч нэр дэвших энэ байдлыг бол халж байгаа. Үүнд хяналт тавих цор ганц байгууллага болбол сонгуулийн төв байгууллага.

Дээрээс нь одоо бид нар бүгд нэгдэж байна, 90 онд ч юм уу, 94 онд ч юм уу намаа байгуулаад, тэрнээс хойш нэг ч удаа их хурлаа хийгээгүй, намын гишүүддээ ажлаа тайлагнаагүй, Монголд хийсэн ажлаа нэг ч тайлагнаагүй намууд зөндөө байна. Тэгэхээр эдгээр намуудыг чинь хариуцлагатай болгохын тулд иргэдийн маань одоо хүлээлт байгаа, намууд ер нь юу хийдэг юм бэ, улс орны одоо хөгжлийг эсвэл бялуу хуваах

зорилготой байгууллага юм уу гэдэг энэ шүүмжлэлийг давахын тулд бид нар намыг өөрчлөх ёстой. Ингэхгүйгээр энэ одоо Монголын ардчилал гэдэг юм уу, ер нь ардчилсан тогтолцоо явах боломжгүй. Тийм учраас эдгээр одоо шинэ үүрэг функцүүд сонгуулийн төв байгууллагад ирж байгаа. Энэ бол олон улсын жишиг. Тэгэхээр бид нар бол сонгуулийн төв байгууллага маань иргэдийн улс төрийн боловсролд, намуудын хяналт, тэр намын дотоод ардчилал, хүний эрх гээд их өргөн хүрээтэй шинэ ажлыг хийх учраас яах аргагүй төсөв, орон тоог нь бид нар бол хангалттай тавьж өгөх ёстой. Энэ маань одоо эргээд Монголын ард түмэнд, Монголын ирээдүй, хөгжлийн бодлого, бодлогоор өрсөлддөг намуудыг бий болгоход хэрэгтэй учраас энэ ТББХ болбол дэмжсэн санал байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

**Г.Занданшатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьяа:** Энэ СЕХ-ны бүтцийн тухай асуудлыг оруулж ирж байна л даа. Энийг одоо ярих ямар шаардлага байгаа юм бэ? Энэ ТББХ-ны даргын байр суурьд би их гайхалтай гайхиширалтай байна. Энэ Чинзориг гишүүн анх удаа нэг үнэн юм ярилаа шүү дээ, анх удаа шүү. Тэгээд ингээд энэ байдалд Их Хурлын энэ ТББХ-ны үйл ажиллагаанд дүгнэлт хийсэн ийм эрүүл шүүмжлэл тавьсан Чинзориг гишүүн. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн бүтцийн байгууллага болох Монгол Улсын ерөнхий прокурорынхоо Тамгын газрын даргыг энэтэй зэрэгцүүлж оруулж ирэх асуудлыг оруулж ирэхгүй байгаа шүү дээ.

Тэгээд одоо Чинзориг бид 2 зарчмын зөрөөтэй санал гаргаад оруулж ирье гэвэл батлах юм уу? Дээр нь энэ Мөнхцэцэг гишүүн одоо юу яриад байна вэ? Бид нар СЕХ-ны бүтэц, орон тооны тухай ярьж байхад тэр АН-ын дотоод сонгууль ер нь ямар хамаатай юм энд. Ийм юм битгий ярь Мөнхцэцэгээ. Энэ СЕХ-ны бүтэц ярьж байгаа. Тэгтэл ийм одоо утгагүй юм яриад би энийг

эсэргүүцэж байна. Тэгээд одоо ийм утгагүй юм яриад, сүүлд нь одоо юу ярих гээд байгаа юм бэ энэ чинь одоо. Тэгээд одоо заавал энэ СЕХ-ны тэр Тамгын газрын дарга өндөр албан тушаалтан байхаар шударга ажилладаг, өндөр албан тушаалтан биш байхаар шударга бус байх юм уу? Та нар энэ Хэмнэлтийн хууль гэж юм ярьж байгаа. Тэгээд дээр нь энэ бүтцээ багасгая гэж ярьж байгаа. Улс төрийн намуудын тухай хууль, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль дээр чинь ийм юм байхгүй байгаа шүү дээ. Тэгээд өнөөдөр нэг орон тоо бүтэц л заавал оруулж ирдэг, өндөр албан тушаалтан байхаар л одоо сайхан байдаг ийм юмыг оруулж болдог юм уу?

Монгол Улсын Их Хурлын ТББХ бол хуулийн хэрэгжилтэд хяналт тавина, хууль яаж хэрэгжиж байгааг хяналт тавина. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо, харилцан хоорондын уялдааг зохицуулна, хууль нэг мөр байхыг ойлгоно гэж би ойлгож байгаа. Монгол Улсын Их Хурал хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг төрийн эрх барих дээд байгууллага шүү дээ. Тэгээд энд нэг хоорондоо нэг үл ялгах маргаан тэмцээний асуудал биш. Би энэ СЕХ-ны энэ яг 60 хүн яг юу хийх гээд байгаа юм бэ? Энэний яг задаргааг нь авмаар байна. Тэгж байж өнөөдөр ярих ёстой шүү дээ. 60 хүн гээд. Энэ 60 хүн чинь яг юу хийх юм бэ? СЕХ-ны тухай яривал зөндөө л юм байгаа. Сайн, муу байгаа бид нар 30 жилийнхээ алдаа дутагдал дээр. Тэгэхдээ СЕХ болбол одоо яг бие даасан ажиллах тийм боломж нь байдаг юм уу байдаггүй юм уу, би эргэлздэг.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Энэ хэд байсан юм, хэд болчихсон юм гэж түүрүүнээс хойш асуугаад байгаа, энийг хариулчих хүн байдаг юм уу? Дэлгэрнараран дарга 83 хариулъя.

**П.Дэлгэрнараран:** Адьяа гишүүний асуултад хариулъя. СЕХ яг одоогийн байдлаар болбол 35 орон тоотойгоор тоо батлагдаж ингэж ажиллаж байгаа.

Тэгээд Улс төрийн намын хуулийг дагаж Сонгуулийн төв байгууллагын хуульд өөрчлөлт орж, энэ Сонгуулийн төв байгууллагын хуульд 10 чиглэлийн одоо хуулийн үүрэг биш ээ, хэрэгжүүлэх ажлын чиглэл төв байгууллагад оногдож байгаа. Тэгээд энийгээ бол бид нар нормчлоод бүтцээ зураад, ажлын байрны ерөнхий тодорхойлолт зургуудыг гаргаад ингээд үзэхээр болбол Улс төрийн намын хуулийн хэрэгжилтийг хангах 2 бүтцийн нэгж одоо Тамгын газар дотор хэрэгтэй. Энэ 2 бүтцийн нэгж маань 12, 12 хүний бүрэлдэхүүнтэй байя. Ингээд энэ 12 хүнийхээ бүрэлдэхүүнийг нэмэхээр 60 орчим болж байна. Тэгэхдээ бид нар энэ 60 орон тоог болбол батлагдсан өдрөөс эхлээд л одоо бид нар төсөв мөнгө нэхээд л, энийг болбол шууд 60-аар нь ачаалахгүй юм байгаа юм.

Хуулийн хэрэгжилт маань болбол 2, 3 үе шаттай. 2024 оны 1 сарын 1-нээс ер нь хууль маань хэрэгжиж эхлэх учиртай. 24 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр бол одоо төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, санхүүгийн хяналт, үйл ажиллагааны хяналтын ийм ажлууд эхлэх учиртай. 25 оны 1 сарын 1-нээс төрөөс үзүүлэх санхүүжилтийг олгож эхлэх учиртай. Тэгэхээр болбол энэ тавигдсан дээд хязгаараа л зөвхөн батлуулъя. Тэгээд энэ дээд хязгаартаа болбол шууд тулгахгүй. Бид нар болбол шаардлагатай орон тоо, ажлын байруудаа бол бий болгоод, Төрийн албаны хуулийн дагуу болбол шалгаруулж, томилоод ингээд үе шаттайгаар энэ орон тоонуудаа томилж явна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд дарга нэмж хариулъя. Тэгээд санал хураалт явуулна.

**Н.Энхболд:** Их Хурлын Төрийн байгуулалтын хороо төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо мэдээж ярина. Түүнээс гадна тухайн байгууллагуудын үүрэг, тэгээд нийгмийн өмнө хүлээх хариуцлагад

нь нийцсэн бүтэц, зохион байгуулалт, зэрэг зиндаатай байх тухай асуудлыг бас ярина. Хууль дээр Их Хурлын тухай хуульд энэ байгаа. Тэрнийхээ дагуу манай Байнгын хороо авч хэлэлцсэн. Сая 2, 3 удаа Мөнхцэцэг ч ярилаа, СЕХ-ны дарга ч ярилаа. Үнэхээр энэ хууль хуулиуд шинэ гарсан, бид нарын тэр баталчихсан хуулиудаар зөндөө ярьж байгаад Дээд шүүх асуудлыг нь хариуцдаг байх уу, аудит хариуцдаг байх уу, хаана энэ Намуудын тухай хуулийн хэрэгжилтийг одоо зангидаж байх вэ, наана байвал улс төрийн талаасаа, эдийн засгийн талаасаа, бусад талаасаа зөв гэж зөндөө ярьж байгаад гаргачихсан хуулийнхаа дагуу л энэ СЕХ-нд, тэгж ярьж байгаад л Сонгуулийн хороонд энэ том үүргүүдийг хүлээлгэчихсэн. Тэрний цаадах нийгмийн ач холбогдлынх нь талаар сая Мөнхцэцэг гишүүн хэлсэн. Би тэрэн дээр олон юм хэлээд бид яах вэ 1 дүгээрт тайлбар.

2-т сая асуулаа. Одоо ингээд прокурорын асуудал ороод ирвэл яах вэ гээд. Санал гараад ТАЗ-өөс тэр тал дээр нь дүгнэлт гараад, ингээд ороод ирвэл бид нар энэ прокурорын асуудлыг бид нар авч хэлэлцэхгүй гэхгүй л дээ. Зүгээр санаачилдаг газар нь болбол манайх биш ийм л байгаа. Яг одоо та зарчмын зөрөөтэй санал гаргаад, прокурорыг бас ийм болгоё гэж санал хураалгаж болохгүй, болохгүй гэдгийг нь та өөрөө мэдэж байгаа. Аливаа хууль ном журмынхаа дагуу шийдвэр ном журмынхаа дагуу боловсруулагдаад, холбогдох шат дамжлагуудаараа дамжаад, санал авах газруудаасаа аваад, энд тэндээс санал авна гэдэг чинь нөгөө уялдаа холбооны тухай л асуудал шүү дээ. Тэгээд ороод ирвэл тэрийг бас одоо бид нар прокурорын асуудал асуудлыг хэлэлцэхгүй гэж хэн ч, хаана ч хэлээгүй л байгаа шүү дээ. Тэгэхээр яг өнөөдөр болбол та тийм санал гаргаад, тэрүүгээр бид нар санал хураалгаж болохгүй л гэж хариулах гэсэн юм. Тийм. Хууль зөрчинө хэдүүлээ. Хууль хэлэлцдэг дэгээ зөрчилдчихнө. Тийм.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Тэгээд тоо толгойгоо тодорхой сайн хариулж чадахгүй бол энийг зүгээр хойшлуулах юм уу? Тэгээд тодорхой хариулахгүй, 60 ямар учиртай юм энэ тэр гэдгээ хариулахгүй болохоор. Болох ч юм шиг, болохгүй ч юм шиг тэгээд л нэг хууль буруутай юм шиг л юм яриад явчихлаа сүүлдээ. Санал хураалт явуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зочид танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэнгийн урилгаар Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр багийн ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт ахмадууддаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

2.Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Тогтоолын төслүүд батлагдлаа.

15.04 цаг

**Тав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/**

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна. Хуулийн төслүүдийн талаарх илтгэлийг Монгол улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Эрхэм Монголчууд аа, ард түмний төлөөлөх эрхийн илэрхийлэл болсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Манай Засгийн газар байгуулагдсан цагаасаа Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн 30 жилийн нийгэм, эдийн засгийн явцад бүхэлд нь үнэлэлт дүгнэлт өгч, шинэ 30 жилийн эхлэлийг зөв тавих суурь реформын шинжтэй асуудалд үндсэн анхаарлаа хандуулсаар ирлээ. Мэдээж 30 жилийн бугшсан асуудал 3 жил бүтэн засагдахгүй ч, иргэдийн мэдэх эрх хангагдаж, нийгмийн дүгнэлт зөв чигт тогтож эхэлж байгаа нь саяхан 21 аймгаар иргэдтэйгээ илэн далангүй санал шүүмжлэл өрнүүлж 8-аас 10 цаг орчим үргэлжилсэн уулзалтын үеэр мэдрэгдлээ. Парламентын гишүүд ч хамт байсны хувьд надтай дүгнэлт ижил байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Монголын ард түмэн улс төрчдийн хэн нь юуны төлөө зорьж байгааг, хэн нь хөшигний цаана тээг хийж байгааг, хэн нь хоосон дүр үзүүлэн жүжигж байгааг, хэнийх нь биеийн хэлэмж, нүдний харц үнэн бас худал байгааг нэгэнт таньдаг болжээ. Ард иргэд өнөө маргаашийн асуудлаас илүү улс орны ирээдүйн тухай шударга нийгмийг цогцлоон бүрдүүлэх тухай, хүн бүрд хууль тэгш үйлчлэх тухай, өнгөрсөн алдааг засаж залруулж, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцох тухай илүүтэй ярилаа. Ард иргэд 30 жилийн өмнө нийгэмд солигдож,

хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлоохын төлөө хичээсэн ч эргээд харахад хэдхэн хүн баяжсан, хууль тэгш үйлчилдэггүй, шударга бус, авлигажсан, үүрэг хариуцлагагүй, салан задгай нийгэм бүрэлдэн бий болсонд сэтгэл зовниж байгаагаа илэрхийллээ.

Иргэд Монголын ард түмний хагас 100 жил бүтээсэн баялгийг өмч хувьчлал нэрийн доор цэнхэр, ягаан тасалбараар хэдхэн хүн завшсан нь өнөөдрийн баян ядуу ялгаатай асуудал туйлдаа хүрч, нийгэм хагаралдаж бие биеэ үзэн ядах суурь нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж байна. Ард иргэд олон 100 жил газрын хөрснөө бүрэлдэн бий болсон байгалийн баялгийн лицензүүдийг мөн л энгийн иргэдэд хүртээлгүйгээр шударга бусаар хуваан залгиж, цаашилаад төрийг нь засагтай, парламенттай, шүүхтэй нь, улс төрийн намуудтай нь худалдан авах системийн авлигын тогтолцоо бүрдсэнийг ч том зургаар нь бүрэн ойлгож, үүний нэг тод илэрхийлэл бол Эрдэнэтийн 49 хувийн худалдан авалт байсан гэдгийг мөн хэлж байна. Өнгөрсөн 30 гаруй жилийн нийслэлийн болон байгалийн тусгай хамгаалалттай газруудад хууль бусаар цэцэглэн хөгжсөн, газрын наймаа ч тэгш бус нийгмийг бий болгосон олон үндсүүдийн нэг салаа мөчир мөн гэдгийг нийгэм мөн дүгнэж байна. Нэг үгээр хэлбэл нийгмийн шилжилтийг далимдуулж өмч хувьчлал, эрдэс баялгийн лиценз, газрын наймаа, өнөөдрийн тэгш бус байдал, баян ядуугийн эрс ялгаа нийгмийн бухимдлыг суурийг нь тавьсан гэдэг нийгмийн дүгнэлт нэгэнт бодитоор бий болжээ.

Энэхүү дүгнэлт нийгэмд бүрэн төлөвшиж чадаагүй байсан учраас өмч хувьчлал, байгалийн баялаг газрын эздийн өмнө Монгол төр хүчгүйдэн сааралтаж, ЗГ-ын дундаж нас 1,5 жил байсан нь энэхүү авлигын системтэй шууд холбоотой нь ойлгомжтой юм. Тэд тоглогчид өөрчлөгддөг ч гэсэн тоглоом өөрчлөгдөхгүй гэдэг системийн авлигын дүрмээр тоглосоор Монгол Улсын 30

жилийг зөвхөн өөрсдөдөө ашигтай, ард иргэдэд эдийн засгийн хүртээмжгүйгээр бий болгон манантуулж боолчилж бас чадсан юм. Олны хүч оломгүй далай гэж Монголын ард түмэн ярьдаг билээ. Олон түмний хүч ордны хуйвалдааныг үргэлж ялсаар ирснийг буурал түүх нотолдог. Хэрэв авлигажсан тогтолцоотой хийх энэхүү тэмцэл үр дүнд хүрч, эдийн засгийн хүртээмж нэмэгдэж дундаж давхарга тэлэхгүй бол нийгэм өөрөө өөрийгөө засах өөрчлөлт рүү ороход нийгмийн сэтгэл зүй бүрэлдэн бий болсонд авлигын энэхүү тэмцлийг сааруулж буй бүлэглэлийн гар хөл болсон шат шатын хувалзууд, тэдний цаана байгаа эзэд нь бодит дүгнэлт хийгээсэй гэж хичээнгүйлэн хүсэж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Шинэ сэргэлтийн бодлого бодитоор хэрэгжиж, авлигатай хийх тэмцэл эрчимжсэнээр эдийн засгийн тоон үзүүлэлтүүд өдөр өдрөөр сайжирсаар байна. 2021 оны төсвийн жил цар тахлыг даван туулахад илүүтэй чиглэгдсэнийг бид бүхэн мэдэж байгаа. Тухайн үед эдийн засгийн өсөлт -4,7 хувь байлаа. Улсын төсөв 20 гаруй хувиар тасарч, 1992 оноос хойш тулгарч байгаагүй эдийн засгийн сорилттой та бид хамтдаа энэ танхимд тулж байсан. Тус төсвийн жил вакцинжуулалтыг татан авчрах, эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийг бүхэлд нь шинэчлэхэд улсын төсвийн бодлого бүхэлдээ чиглэгдэж байсан билээ. Цар тахлын тохиолдолд эзлэх нас баралтын хувь олон улсын дунджаас 5 дахин бага байж, бус нутгийн бусад улс орнуудтай харьцуулахад 1,5 жилийн өмнө эдийн засгаа нээж чадсан нь 2021 оны төсвийн бодлого тавьсан зорилтдоо хүрсэн гэж дүгнэж болох юм. 2022 оны төсвийн жилд Монгол Улс цар тахлын хязгаарлалтыг бүрэн цуцалснаас хойш яг 10 хоногийн дараа ОХУ Украины дайн эхэлсэн нь манай улсын хувьд цар тахал дайн зэрэгцсэн хүндхэн сорилтыг бидэнд авчирсан.

Эдийн засгийг тогтворжуулахын тулд шинэ сэргэлтийн бодлогыг хамтдаа баталж, боомтын хүчин чадлыг өргөтгөж бүхнийг экспортод гэсэн уриатайгаар ажиллаж, Төсвийн хэмнэлтийн хуулийг эрчимжүүлж ажилласны үр дүнд эдийн засаг 4,8 хувиар өссөн. Мөн 2022 оны төсвийн жил ОТ-н 2,3 тэрбум ам.долларын өр тэглэгдэж, гүний уурхай ашиглалтад орж, шинэ 4 төмөр замын боомтын бүтээн байгуулалтын ажил эхэлсэн. 2023 оны төсвийн жил Монгол Улс олон улсын олон жилийн хугацаанд бугшсан далд эдийн засгаа ил болгох, авлигын тэмцлийг илүү эрчимжүүлэхэд бүхэлдээ энэ жил чиглэсэн гэж ойлгож болно. 2023 онд ДНБ 62,4 их наядад хүрч, нэг хүнд ноогдох ДНБ анх удаа 5 мянган ам.долларт хүрсэн. Төсвийн орлого анх удаа 1,8 их наядаар давж, үүнийг бид нар хамтдаа тодотгол хийж цалин, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэхэд зарцуулсан.

Эдийн засгийн өсөлт 6,4 хувь болж Хөгжлийн банкны эргэн төлөлт 1,4 их наядыг давж, Мазаалай бондын 500 сая ам.доллар, Гэрээг бондын 800 сая ам.доллар, Чингис бондын 1 тэрбум ам.долларын өрийг бүрэн төлж дуусгасан. Улсын төсөв энэ жил мөн оны эцэс гэхэд 1,8 орчим их наядаар давж биелж төлбөрийн тэнцэл анх удаа 530 орчим сая доллароор эерэг гарлаа. Энэ бүхэн бол авлигатай хийсэн тэмцлийн шууд үр дүн мөн эдийн засаг эрүүлжиж байгаагийн бодит илэрхийлэл гэж үзэж болно. Төсвийн жил бүхэнд ЗГ-ын бодлогыг дэмжиж ажилласан Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэндээ ЗГ-ын нэрийн өмнөөс талархаж байгаагаа илэрхийлье.

Бид өнгөрсөн 3 жилийн бодлогын үр дүнд цар тахлыг амжилттай даван туулж, дайны хүнд үед эдийн засгийн өсөлтөө хадгалж, авлигатай хийх тэмцлээ эрчимжүүлж, далд эдийн засгийн хөшигийг хуулж, эдийн засгийн хүртээмжтэйгээр тэлэх суурь нөхцөлийг

бүрдүүллээ. Энэ амжилтад тулгуурлаж 2024 оны улсын төсөв бол Хот ба хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг дэмжих суурь агуулгатайгаар боловсруулагдан та бүхэнд танилцуулагдаж байна. 2024 онд эдийн засаг 7 хувиар өсөж, ДНБ 74 их наядад хүрч, нэг хүнд ноогдох ДНБ 6 мянган ам.долларыг давна гэж төсөөллөө.

Улсын Их Хурлын гишүүд зөвхөн тойрогт хандсан хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам болон олон улсын байгууллагуудын зөвлөмжид үндэслэн шинэ сэргэлтийн бодлогын хөдөөгийн сэргэлтийг дэмжсэн 5 тойрог багц дэд бүтцийн төслийг эхлүүлж байгаа нь 2024 оны төсвийн жилийн гол онцлог гэж үзэж байна. Мянганы замын их бүтээн байгуулалтын ажлыг Монголчууд бид 23 жилийн дараа бүрэн хэрэгжүүлж дуусгаж чадлаа. Энэ бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн Намбарын Энхбаярын ЗГ болон үргэлжлүүлсэн Ерөнхий сайд ЗГ бүхэнд оролцсон бүх хүнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мянганы зам бол Мянгужингийн үлгэр биш харин 7 мянга гаруй үргэлжилсэн бодит бүтээн байгуулалт болсон гэдгийг энэхүү төслийг бүрэн дуусгаж байгаа ЗГ-ын тэргүүний хувьд онцлон тэмдэглэж хэлэхийг хүсэж байна.

Мянганы замын дараагийн том алхам бол хөдөөг сэргээх 5 тойрог зам юм. Энэ нь аймгийн төвүүдийг хооронд нь, мөн холбогдсон аймгийн төвүүдийг хилийн боомтуудтай холбох төсөл гэж ойлгож болно. Энэ төслийн хүрээнд 2024 онд 1300 гаруй километр авто замын төслийг шинээр эхлүүлэх болно. Хөдөөгийн сэргэлтийг дэмжсэн орон сууцжуулалт, төрийн албан хаагчдын урамшууллын систем хотын шинэ эрх зүйн орчин, тойрог хурдны зам зэрэг цогц асуудлуудыг хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах 2024 оны улсын төсөвт тусгалаа. Дэлгэрэнгүй асуултуудад Сангийн сайд болон Ажлын хэсэг хариулт



өгөх учир үгээ ингээд товчилъё. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа Ерөнхий сайдад. Одоо төсвийн талаарх төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Занданбат:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ. Монгол Улсын ЗГ-аас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг 7 зорилтын хүрээнд хянаж дүгнэхэд аудитын зорилго чиглэсэн.

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу төрийн аудитын байгууллага нь өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитаар 1 албан шаардлага, 8 зөвлөмж өгснөөс төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн оны төсвийн төсөлд тохируулан жил бүр өөрчлөхгүй байх талаар өгсөн албан шаардлага, төсвийг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын шаардлагад нийцсэн байдлыг үнэлэх шалгуурыг тогтоох талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргаж байна. 1. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан төсвийн төсөл нь Үндсэн хуулийн 25.1.7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхэд ЗГ-аас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна. Мөн ЗГ-ын өрийн үлдэгдэл ДНБ-д эзлэх харьцаа 2024 онд 40,7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын бодлогод бодлогын зохистой харьцаанд байна.

2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэхэд. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289,8 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүх бүтээгдэхүүний 34,2 хувь, нийт зарлага 27 их наяд 360,5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70,8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий -2,8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ. Иймд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай эсхүл ашигтай байх, тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус

ДНБ-ий өсөлтийн дунджийн аль их аль эхээс хэтрэхгүй байх, ЗГ-ын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна.

3.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-д заасан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн эсэхэд. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлалд нийцэж буй ч улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 71 хувь нь төсвийн төсөлд байгаа нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бүрэн тусгагдаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн дараах аудитын дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд 1.Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөлд хүргэж болзошгүй байна. 2.Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлолгүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна. 3.Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. 4.Гадаад өрийг төсөвт үзүүлэх

ачааллыг гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн зарлагын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

5.Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны урсгал зардлын төсөвт төсвийн хязгаарыг хэтрүүлэн төлөвлөсөн 48,6 тэрбум төгрөгийн зардлыг бууруулах боломжтой байна гэж үзэж байна. 6.Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, нэг маягаар болон жишиг магадлалтай 153 төсөл арга хэмжээг тус тус тусгасан байна. 7.Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, улсын комисс барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих хяналтын тогтолцоог сайжруулан субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна. Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт бүтэн тусгуулахад анхаарах. Өмнөх аудитаар толилуулсан төсвийн төслийг Үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх аргачлал шалгуур үзүүлэлтийг холбогдох хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгах тухай өгссөн асуудлыг энэ жил дахин толилуулж байгааг анхаарахыг хүсэж байна.

Монгол Улсын ЗГ дараа оны төсвийн төслийг боловсруулж, Улсын Их

Хуралд өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд, Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төсөл боловсруулах тухайн үе дэх хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх. Төсвийн төлөвлөлтийн дунд ба урт хугацааны төлөвлөлтийг төсвийн алдагдлыг 2 хувиас бага байлгах эдийн засгийн зохист харьцааг баримтлан төсвийн тогтвортой байдлын үндсэн зарчмыг хангаж, төсөвт үзүүлэх гадаад өрийн ачааллыг бууруулж, төлөвлөлтийг сайжруулах. Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх. Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр Төсвийн хуульд тусгаж баталсан төсөл арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллах. Барилга байгууламжийн зураг төсөл, магадлал хийх ажлыг зохион байгуулах, бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, улсын комисс хүлээн авах үйл ажиллагаанд субъектив сөрөг нөлөөлөлгүй байлгах тодорхой нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулж эрсдэл үүсгэхгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч, хэрэгжилтэд нь хяналт тавих. Төсвийн төслийг Тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн эсэх, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтийн үйл ажиллагааг улс орон нутгийн хэмжээнд үр дүнтэй

хэрэгжүүлж, удирдан зохион байгуулах. Гадаадын зээлийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хэлэлцээрт орж буй төсөл арга хэмжээнд эдийн засгийн үр ашгийн тооцоог хийж, ач холбогдлоор нь эрэмбэлж, санхүүжүүлэх журам арга аргачлал боловсруулж, хуулийн хэрэгжилтийг хангах. Хөгжлийн бодлогод нийцүүлсэн, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж чадавхыг сайжруулах гэсэн эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллахыг хүсье.

Төсвийн төслийн зорилго хангагдаж байгаа эсэх, иргэдийн тэгш байдал шударга хуваарилалтын үүргээ төсвийн харилцаагаар биелүүлж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт гаргахад одоогийн мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчноос шалтгаалан хүндрэлтэй байгааг 2020-оос 2022 оны төсвийн гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтүүдэд удаа дараа тусгасан болно. Иймд төсвийн үр дүнг хөтөлбөр тус бүрээр хэмжиж болохуйц шалгуур үзэлтийг үзүүлэлтийг тодорхойлж, тохирсон зардлыг батлах, үр дүнг төсөв захирагч нар бодит бодитоор тайлагнаж түүнд тавих хяналтыг сайжруулах хэрэгтэй байна. Олон улсын турилага, аудитын зөвлөмж, онолын ойлголтуудын давуу талыг харгалзан үр дүнд чиглэсэн төсөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг мөн салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлэн бий болгох үр өгөөж, ач холбогдлыг хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож, хүрэх үр дүнг богино, дунд хугацаагаар тодорхойлж үйл ажиллагааг хэмжсэнээр төсвийн зардлын ашиглалт үр өгөөж нэмэгдэнэ гэж үзэж байна. Үүний тулд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг нээлттэй, ил тод байлгах, шат шатын хэлэлцүүлэг зохион байгуулах, үр дүнг тооцох, эрсдэлийн удирдлагын төлөвлөлтийг бий болгох эрх зүйн шинэ орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг Улсын Их Хурлын

эрхэм гишүүд та бүхэн анхааралдаа авна уу. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг эхлээд танилцуулчих уу? Тэгээд дараа нь та горимын саналаа гаргана. Одонгийн Цогтгэрэл гишүүн АН-ын бүлгийн дарга горимын санал хэлнэ.

**О.Цогтгэрэл:** Монгол Улсын 24 оны төсөв орж ирж байна. Төсөв гэдэг чинь өөрөө зөвхөн бараг нийт эдийн засагт бол онцгой үүрэгтэй. Энэний цаана татварын бодлого ч явж байгаа. Энэ тэгээд зөвхөн төсөв биш, өөрөө нийгэм, эдийн засгийн хамрах хүрээ асар өргөнтэй. Энэ 24 оны төсвийн анхны хэлэлцүүлэг болоод төсөвт хамаарах маш олон албан тушаалтнууд энд ирчихсэн байна. Тэгээд манай АН-ын бүлгийн гишүүдийн зүгээс гарч байгаа санал Ерөнхий сайдыг энэ хуралдаанд оролцуулж өгөөч. Ерөнхий сайдаас энэ анхны хэлэлцүүлэг явж байгаа нэгдсэн төсвийн ерөнхий үзэл баримтлалын талаар хүртэл асуух олон асуулт байгаа учраас Ерөнхий сайдыг энэ төсвийн энэ анхдугаар хэлэлцүүлэгт оролцуулж өгөөч. Бид нар Ерөнхий сайдаас асуумаар байна гэдэг саналуудыг манай гишүүд гаргаж байна. Ийм учраас Ерөнхий сайдыг энэ хуралдаанд оролцуулж өгөөч.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан, Сангийн сайд Болдын Жавхлан, ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр, БХБ-ын сайд Цэрэнпилийн Даваасүрэн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Соёлын сайд Чинбатын Номин, УУХУ-ийн сайд Жамбалын Ганбаатар, ХНХ-ын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Цахим, хөгжил харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Монгол Улсын сайд, Олимп нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, ШЕЗ-ийн дарга Ренчиндоржийн Онончимэг,

Шүүхийн сахилгын хорооны дарга Хашгамбайн Хашбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат, ТАЗ-ийн дарга Балдангийн Баатарзориг, СЗХ-ны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан, ҮСХ-ны дарга Батмөнхийн Батдаваа, УЕП-ын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Максимын Чинбат, ХЭҮК-ын дарга Жаргалсайханы Хунан, СЕХ-ны дарга Пүрэвэгийн Дэлгэрнаран, ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Бямбажавын Ганбат, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Гантөмөрийн Түвдэндорж, Гадаад харилцааны дэд сайд Гомбосүрэнгийн Амартүвшин, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Батлан хамгаалахын дэд сайд Батсүхийн Баярмагнай, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Лувсангийн Халтар, ХХААХҮ-ийн дэд сайд Мөнгөнцогийн Ганхүлэг, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Цэвээнжавын Батбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг, ГЕГ-ын дарга Рэгжийбуугийн Отгонжаргал, Монгол Улсын ҮХЦ-ийн Тамгын газрын дарга Даньхүүгийн Баянбилэг, Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга Содномцэрэнгийн Заяадэлгэр, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Батцэнгэлийн Энх-Амгалан, Сангийн яамны ТНБД Жигжидийн Ганбат, БОАЖЯ-ны ТНБД Сүхбаатарын Цогтгэрэл, ЗТХЯ-ны ТНБД Сандагдоржийн Батболд, ЭХЯ-ны ТНБД Нансалын Тавинбэх, ҮАБЗ-ийн Ажлын албаны дарга, бригадын генерал Дашиживаагийн Ариунболд, УЕП-ын Хэрэг эрхлэх газрын дарга Сүрэнжавын Гансэлэм, АТГ-ын Тамгын хэлтсийн дарга Заграагийн Баасанням, Үндэсний Аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалт, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор Ядамын Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах

үндэсний хорооны Ажлын албаны дарга Цогтгэрэлийн Батгэрэл, Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын ТЗУГ-ын дарга Бавуудоржийн Алтансүх, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны Ажлын албаны даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Пүрэвийн Оюун-Эрдэнэ, УУХЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга Мэлсчойгийн Мэндбаяр, ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Даваажавын Гантуяа, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг, Татварын ерөнхий газрын Татварын удирдлагын газрын дарга Дамдинпүрэвийн Цогжаргал, БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, дэд хурандаа Бадраагийн Оюунгэрэл, ЗТХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Найдангийн Цэвэлмаа, ЗТХЯ-ны санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан шинжээч Шаравсамбуугийн Гүнсэндарь, ЗТХЯ-ны Авто замын бодлогын зохицуулалтын газрын шинжээч Бямбарагчаагийн Цэрэнсодном, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны Хилийн боомтын

захиргааны санхүү Захиргаа, санхүү аж ахуйн хэлтсийн дарга Ядамжавын Дүгэржав, ГЕГ-ын Тариф, татварын газрын гаалийн улсын ахлах байцаагч Дашицэрэнгийн Ганцэцэг, Шүүхийн сахилгын хорооны Санхүү төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах референт, ерөнхий нягтлан бодогч Бадарчийн Ариунжаргал.

Ерөнхий сайд хойшлуулишгүй ажлын улмаас Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга бусад сайдууд ингээд оролцож асуултад хариулна гээд одоо чөлөө аваад, сая үгээ хэлээд явсан. Засаг төрийн зайлишгүй ажил гарсныг хүндэтгэн үзэхийг АН-ын гишүүдээс хүсье. Илтгэл, дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд бүртгүүлнэ үү. Даваажанцангийн Сарангэрэл гишүүнээр тасаллаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Энэ хөрөнгө оруулалт дээр.../үг тасрав/

**Г.Занданшатар:** Цогтгэрэл гишүүнээр тасалсан юм байна. Батсуурь гишүүн байна. Доороос.

**Ц.Сандаг-Очир:** Үнийн зөрөөнөөс үүдэлтэй магадлал хийлгэсэн, аудитаар баталгаажсан ийм хөрөнгө оруулалтын ажлууд бас ороогүй байна. Энэ талаар одоо аудитаар орчихсон, магадлал хийлгэчихсэн хэчнээн хөрөнгө оруулалтын ажил байна, төсөвт өртөг нь хэд байна, энийг одоо хэрхэн яаж ирэх жилийн төсөвт суулгах вэ энийг нэгд асууя.

2-т Эрчим хүчний сайд одоо байхгүй байна. Эрчим хүчний сайдаас асуумаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хариуцлагагүй мэдэгдэл хийсэн. Одоо ирэх жил тэр төсөвт энэ туршилт хийх гээд байгаа хэд хэдэн орон нутгууд байгаа. Үгийн алдаа гаргасан уу, үнэхээр одоо тийм зүйл ярьж байгаа юу? Хэд хэдэн орон нутгуудад эрчим хүчний

сайжруулсан түлш туршилт хийнэ гэж байгаа. Энэ туршилтын ажлыг ер нь ард иргэд дээр хийдэг юм уу, лабораторид хийдэг юм уу? Тэр дундаа үгийн алдаа нь болохоор Дархан, Дарханд хийнэ, бүүр болохгүй бол Багануурт хийнэ гэж ингэж хариуцлагагүй хэлсэн. Энэ одоо ард түмнийг Багануурын 30 мянган ард иргэдийг дорд үзсэн, Үндсэн хуулийн ялгаварлан гаргасан ийм хариуцлагагүй мэдэгдэл шүү. Энэ инээдэм биш. Эрчим хүчний сайдыг одоо бас албан ёсоор тэр хэвлэл мэдээллийн хэрэгслээр уучлалт гуйхыг шаардаж байгаа. Тэр туршилтаа тэр хийдэг газраа хийгээрэй гэж хэлэх гэж байгаа юм. Тэр одоо хэдэн төгрөгийн төсөв энэ туршилтад нь суусан юм, хаана хаана хийх гэж байгаа юм энийг бас нэг тодруулж өгөөч гэж ийм 2 асуултад хариулж өгөөч.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Асуултад хэн хариулах вэ? Болдын Жавхлан сайд хариулна.

**Б.Жавхлан:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. 2020, 21, 22, 23 гээд энэ ковидын жилүүдэд юмны үнэ айхтар өндөр болж төслүүд төсвөөр санхүүжүүлж байгаа энэ төслүүд бол үнийн өсөлтөд нэрвэгдсэн. Гэхдээ одоо энэ төслүүдээ амжилттай дуусгахын тулд төсөв дээр одоо багагүй ачааллыг сүүлийн 2 жил дараалан авч байгаа шүү. Гэхдээ энийг бас одоо зах замбараагүй бид нар ингээд орж ирсэн болгоноор нь төсөв дээр бас аваад байж болохгүй, давхар давхар хянах хэрэгтэй, аудитлах хэрэгтэй. Ёстой нөгөө ҮХЦ-ээс дээш хөх тэнгэр гэдэг шиг бид нарын хувьд бол одоо аудитдаа найдаад л хамгийн эцсийн одоо шатанд аудитаараа нягтлуулж байгаа, хянуулж байгаа. Ингээд л төсөв өргөн барих сүүлийн мөч хүртэл 9 сарын

29-ний одоо ажлын цаг дуустал бид аудитаасаа ирсэн, хянагдсан бүх төслүүдийн энэ одоо магадлан хийгдсэн үнийн өсөлтүүдийг одоо төсөвтөө тусгаад ингээд өргөн барьсан байгаа. Тэрнээс хойших дээр бол одоо ЗГ оролцох, бид нар одоо энд тайлбар тавих боломж байхгүй. Тийм. Тэгэхээр Их Хурал дээр асуудлууд нь яригдах байх л гэж бодож байна. Туршилтын талаар хэн Тавинбэх сайд ирсэн байсан.

**С.Одонтуяа:** Хэн нэмж хариулах вэ? Нэмж хариулах хүн байна уу? 1 дүгээр микрофон Тавинбэх ажлын хэсгийн гишүүн, 1 дүгээр микрофон.

**Н.Тавинбэх:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Тэгээд Улаанбаатар хотод гэр хороололд халаалтын зориулалтаар ашиглаж байгаа сайжруулсан шахмал түлшийг сайжруулах зорилгоор сайжруулсан шахмал түлшний түүхий эдэд хагас кокс ашиглахаар бид туршилт хийсэн. Хагас кокс гэж юу вэ гэхээр зэрэг үйлдвэрийн аргаар нүүрсийг шатаах үед ялгардаг хорт бодис дэгдэмхийг ялгаад авчихсан ийм л бүтээгдэхүүн байгаа. Энэ болбол Монголчууд бид нарын одоо хийж байгаа нээсэн эсвэл хэрэглэх гэж байгаа технологи огт биш. Дэлхий нийтээрээ одоо нүүрсэнд ийм хагас коксжуулж одоо боловсруулалт хийж ашиглаж байгаа. Тэгээд энийг л одоо ашиглаж байгаа хэрэг. Лабораторид энд сайжруулсан шахмал түлшний түүхий эдийг хагас кокс ашиглахыг болбол ашиглаж бид нар бол туршилт хийсэн. Мааш сайн үр дүн гарсан. Энэ үр дүнг бид нар түүхий нүүрс түлэх үед сайжруулсан шахмал түлшинд нийтлэг ашиглах үед бүтээсэн сайжруулсан шахмал түлштэй харьцуулж гаргасан байгаа. Тэгээд энэ ажлыг нийслэлийн одоо Нийслэлээс гарах бондоос бондын хөрөнгөөс тодорхой хэмжээгээр санхүүжүүлэхээр тохирсон. Харамсалтай нь одоо нийслэлийн бонд хүндэтгэн үзэх шалтгаанаар тодорхой хугацаанд саатсан учраас одоогоор энэ ажил зогсчоод байгаа. Улсын төсөвт

ямар нэг байдлаар энэ ажилд санхүүжилт тусгасан зүйл огт байхгүй гэдгийг хэлье.

Маш сайн түлш дэлхий нийтээрээ хэрэглэж байгаа технологи гэдгийг би дахиж хэлье. Ганицхан хүндрэлтэй асуудал бий. Энэ болбол үнэтэй. Монгол Улсад одоогоор хагас кокс үйлдвэрлэдэг хэд хэдэн ялангуяа одоо хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд байгаа боловч үйлдвэрлэл явуулах хэмжээнд бүтээгдэхүүн нийлүүлж чадахгүй учраас үйлдвэр хагас коксын үйлдвэр барих хүртэл бид нар боломжтой улсаас импортоор авъя л гэдэг ийм санал дэвшүүлээд явж байсан юм.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Сандаг-Очир гишүүний асуулт дээр нэмж хариулъя. Тоонуудаа орхичихсон байна шүү уучлаарай. Ингээд бид нар ингээд нэг гүрийж байгаад 23, 24 онд нийтдээ 214, 638 гэдэг чинь 851 төслийн нийтдээ 863 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн нэмэгдлийг төсөвт одоо ингээд ачаалал авч байгаа гэсэн үг. Тэгэхээр одоо аль болох энэ төслүүдээ амжилттай одоо буцуухан дуусгах, энд одоо оролцсон тэр ААН-үүдийг хохиролгүй болгох, ялангуяа барилгын материалын үнийн өсөлттэй холбоотой ийм хүндрэлийг төсөв дээр бас ачааллыг нь хуваалцаж ингэж явах ийм бодлогын хүрээнд юм байгаа юм шүү. Зүгээр АН-ын бүлгийн хэвлэлийн төлөөлөгч гээд нөхөр бүр аягүй их зардал гаргаад хичээл зүтгэл гаргаад манай бүр Дархан руу баг явуулаад баахан тэнд бичлэг хийгээд, нэвтрүүлэг хийгээд өчигдрөөс эхлээд цацаад эхэлсэн байна лээ. Бүр 2 төслийн нэр зааж байгаад. Тэр төсөвт өртгийн нэмэгдлүүдийг чинь Сангийн яам хийдэггүй шүү.

Барилгынх нь барилгын одоо Барилгын хөгжлийн төв, замынх нь Зам, тээврийн хөгжлийн төв гээд, эрчим хүчнийхэнд Эрчим хүчний хөгжлийн төв

гээд мэргэшсэн төсөвчид бие даасан ийм институт тэнд хийгддэг. Энэ мянга гаруй төслүүд чинь бүгд тэнд хийгдсэн байгаа. Ингээд бид нар төсөв өргөн барих хүртэл аудитлагдсан бүх магадлангуудыг оруулсан байгаа. Тэрэн дотор ч гэсэн одоо Дарханы төслүүд орчихсон яваа. Сангийн сайд Дарханд төрсөн гээд тэд нар хохироод үлдэж болохгүй. Ингээд л багтаад явж байгаа шүү Цогтгэрэл даргаа. Танай бүлгийн хэвлэлийн төлөөлөгч гэж залуу ийм юм явуулаад байгаа шүү. Тэрийг одоо би хэн гэж үзэх вэ? Бүлгээс явуулж байгаа гэж би арай бодохгүй л байна.

**С.Одонтуяа:** Сандаг-Очир гишүүн тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Жавхлан сайдаа ойлгож байгаа. Олон одоо төслүүдийн үнийн зөрөөг өнгөрсөн 23 он, 22 онд шийдэж явсан. Энэ чинь бол компаниудын алдагдлыг л тодорхой хугацаанд нөхөж байгаа шүү дээ. Тэгээд бас төсөв өргөн барихаас хойш, барьснаас хойш бас аудит дээр хянагдаад ингээд явж байгаа миний одоо авсан мэдээллээр бол 50 гаруй хөрөнгө оруулалтын ажлууд одоогоор аудит дээр хянагдчихсан байна гэсэн ийм мэдээлэл авсан. Тэгэхээр энийг бас одоо төсвийн ажлын хэсэг дээр бас тодорхой ярина биз дээ гэж ингэж бодож байна. Энэний цаана дандаа л одоо хөрөнгө оруулалт хийсэн компаниудын эрх ашгийн асуудал яригдаж байгаа гэдгийг нэгд хэлье.

Боловсролын сайдаас 2-т асууя. Ирэх жилийн төсөв дээр энэ багш нарын компьютерын асуудлыг хэрхэн яаж шийдэхээр хөрөнгө оруулалтыг яаж байгаа юм нэг. 2-т үдийн цай хөтөлбөр хүүхдийн одоо энэ нэг хүүхдэд ноогдож байгаа төсөв мөнгө хаанаа ч хүрэхгүй байна, тэр илчлэг одоо хоол тэжээлийн шим тэжээлийн юундаа хүрэхгүй байна гэдэг асуудлыг олон одоо сургуулиас ярьж байгаа. Энэ дээр одоо та.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Энх-Амгалан сайд хариулах уу?

**Л.Энх-Амгалан:** Сандаг-Очир гишүүнээ ийм байгаа. Ямар ч байсан манай салбар дээр одоо 2012 оноос хойш баригдаад ашиглалтад орохгүй байгаа маш их удааширч байгаа энэ өгсөн хөрөнгө оруулалт дээр бас бид нар нэлээн дүгнэлт хийгээд нийт одоо 187 төсөл арга хэмжээ дээр нэмэлт хөрөнгүүд шаардлагатай юм байгаа юм байна гээд. Энийг болбол бид нар бас тодорхой мэргэжлийн байгууллагуудаар дүгнэлт хүргүүлээд одоо ямар ч байсан 187 төсөл арга хэмжээнээс энэ 2024 оны төсөв дээр бол бид нар ямар ч байсан нэг ийм 140 орчим одоо төсөл арга хэмжээ дээр магадлан хийлгээд, Үндэсний аюулгүй, Үндэсний аудитын ерөнхий газраас бас дүгнэлт гаргуулаад ингээд хүргэчихсэн байж байгаа. Сая Жавхлан сайдын хэлж байгаа нөгөө төсөвт өртгүүд нь нэмэгдэж байгаа 800 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр дээр болбол энэ сургууль, цэцэрлэг удааширалтай байгаа сургууль, цэцэрлэгийн асуудлууд хийгдээд, 24 оны улсын төсөв дээр асуудал нь шийдэгдэнэ.

**С.Одонтуяа:** Мэндчилгээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Налайх дүүргийн МАН-ын хяналтын зөвлөл болон Хүлэгт ТББ-ын гишүүдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Яг асуулт асууж байхад нь таарлаа. Одоо Ганибалын Амартүвшин гишүүн асуултаа асууна.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. 2024 оны улсын төсвийг хэлэлцэж байна. Ер нь бол том зургаар улсын 24 оны төсөв бол нэлээн тэлсэн байдалтай орж ирж байна. Хөрөнгө оруулалт улсын төсвийн хөрөнгө оруулалт бол түүхэн одоо хамгийн дээд хэмжээнд батлагдахаар орж ирж байна

л даа. Гэхдээ энэ хөрөнгө оруулалтын нийт төсвийг харахаар арга хэмжээ төслүүдийг яг нийслэл Улаанбаатартай холбоотой ямар одоо 2, 3 чухал сэдвүүд байна л даа. 1 дүгээрт энэ Ерөнхий сайд сая газрын наймааны талаар ярилаа. Яг үндсэндээ газрын наймааны хамгийн том хохирсон дүүрэг чинь Хан-Уул дүүргийн нэг болчихоод байна л даа Зайсан, Яармаг. Зайсангийн айлын, одоо Зайсанд амьдардаг өрхүүд одоо хүртэл нэгдсэн усан санд холбогдоогүй байдаг. Цэвэр усны санд. 2 дугаарт Яармагийн зарим хотхонууд бол одоо хүртэл зэвтэй устай амьдарч байгаа. Тэгэхээр энийг засаж залруулах шинэ хөрөнгө оруулалт хийх ямар төсвүүд суусан байна вэ?

2 дугаарт Нүхтийн замаас хойшоо Туул гол дээгүүр баригдаж байгаа гүүр болон энэ шинэ замыг ер нь энэ төсөвт би олж харсангүй л дээ. Энэ нэг бол нийслэлд суусан уу аль эсвэл орхичихсон уу?

3 дугаарт энэ ер нь нийслэл Улаанбаатарын замын түгжрэлтэй холбоотой ямар төсөлд төсөв суусан юм бэ? Ерөөсөө 1 том тийм төсөв харагдахгүй байна л даа. Зам, тээврийн сайд харамсалтай байхгүй байна. Эрчим хүч, эрчим хүч одоо жишээлбэл Яармагт дахин төлөвлөлттэй холбоотой шинэ хотхон хороолол ашиглалтад орж байгаад эрчим хүчтэй холбож өгөхгүй байна л даа. Ачаалал дийлэхгүй байна гээд. Тэгэхээр энэ Улаанбаатар энэ нийслэлийн энэ эрчим хүчний хангамжийг энэ өвөл болон цаашид одоо яаж сайжруулах юм бэ? Ямар хөрөнгө оруулалт суусан юм бэ, суугаагүй юм уу?

Эцэст нь Зөвшөөрлийн тухай хууль. Бид нар Зөвшөөрлийн тухай хуулийг шинэчилсэн. ААН-үүдийн дарамт одоо чирэгдлийг бууруулахаар том хууль, эрх зүйн шинэчлэлт хийсэн гэж бодож байгаа. Гэхдээ яг амьдрал дээрээ энэ зөвшөөрлийн шинэ тогтолцоо чинь хэрэгжихгүй байгаад байна л даа. Одоо хүртэл компаниуд нөгөө хуульд заасан хугацаанд зөвшөөрлөө авч чадахгүй



байгаад байна. Тэгэхээр энэ энэнтэй холбоотой цахимжилт, зөвшөөрлийн процессыг цахимд одоо яаж холбох юм бэ? Энэний төсөв нь ямар хэмжээний төсөвт суусан юм бэ?

Эцэст нь энэ зун нийслэл чинь үер усны том гамшигт нэрвэгдсэн л дээ. Энэтэй холбоотой ямар нэгэн арга хэмжээ авч байгаа юу? Ямар нь, ирэх жил одоо дахиад үер буух юм бол нийслэлийн иргэдээ одоо яаж хамгаалах гэж байгаа юм, ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Энэтэй холбоотой ямар төсөв суусан юм бэ? Ийм нэг асуултууд байна. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Салбарынхан, юу хариулах хүмүүс юугаа өргөөд, микрофоноо өргөөд, тэгээд нэрээ, албан тушаалтайгаа. Хэлээд хэн хариулах вэ? 86 юу? 86 дугаар микрофон.

**Ч.Чимидсүрэн:** Гишүүний асуултад хариулъя. Нийслэл дээр болбол улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт 27 хувь нь бол суусан байгаа. Хотын хувьд болбол төслийн хувьд бол 251, 51 төслийн нийт одоо 714,3 тэрбумын төсөл байгаа. Үүнээс болбол 79 төсөл болбол шинээр болбол суусан байгаа.

**С.Одонтуяа:** Дараагийнх нь хэн хариулах вэ? ЭХЯ-наас Тавинбэх Эрчим хүчний ТНБД.

**Н.Тавинбэх:** Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Чадлын дутагдалд орсон гэдгийг их олон дахин хэлж байгаа. Өөрөөр хэлбэл хэрэглэдэг хэрэглээ бидний үйлдвэрлэлээс давчихсан. 23-аас 24 оны өвлийн их ачааллаас өмнө бид нар Улаанбаатар хотын дулаан болоод цахилгаан хангамжийн хүртээмж чанарыг сайжруулах зорилгоор ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 230мвт-аар цагийн багтаамжтай батарейн цэнэгт хураагуурыг Сонгино станц дээр ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Дулааны хангамжийн хувьд болбол бид Амгалан дулааны станцыг одоо байгаа зуухнуудтай ижил

хүчин чадлаар 116мвт-аар хүчин чадалтай 1 зуухаар өргөтгөх ажлыг бас энэ онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Тэгээд энэ онд энэ 2 эх үүсвэр ашиглалтад орчихвол ямар ч байсан 23-аас 24 оны өвлийн их ачааллыг болбол бид нар хэвийн давчих боломжтой болно.

Гэхдээ энэ өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг одоо байгаа хэрэглээг найдвартай хангана гэсэн үг биш гэдгийг бас хэлье. Хэрэглээ бас цаашидаа нэмж, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан эх үүсвэрүүдийг цаг хугацаа алдалгүйгээр ашиглалтад оруулахгүй бол өнөөгийн байгаа чадлын дутагдалтай нөхцөл байдал үргэлжилсээр байх болно гэдгийг хэлье.

**С.Одонтуяа:** Дараагийнх нь хэн хариулах вэ? 81 Түвдэндорж.

**Г.Түвдэндорж:** Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Тусгай зөвшөөрлүүдийг цахимжуулах асуудлуудын талаар асуулаа. Эдийн засгийн хөгжлийн яаман дээр нийтдээ 240 гаруй тусгай зөвшөөрлийг цахимжуулах ажил хийгдэж байгаа. Энэ үйл явц нь Сангийн яам, гааль, Хууль зүйн яамны одоо тусгай зөвшөөрлүүд болбол бүрэн цахимжсан байж байгаа. Ингээд энэ асуудлаар сар бүр ЗГ-ын хуралдаан дээр явцын талаар танилцуулаад явж байгаа. Тэгээд ер нь болбол тусгай зөвшөөрлийг цахимжуулах, ил тод болгох, нээлттэй болгох нь хүнд суртлыг багасгах, хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагаа явуулахад илүү хялбар болгох тал дээр болбол ажиллаж байгаа.

**С.Одонтуяа:** Дараагийнх нь хэн хариулах вэ? Нөгөө үер усны гамигийн талаар асуугаад байсан. Та хариулах юм уу? Даваасүрэн сайд хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Би одоо тэр үерийн далангийн юугаар нийслэлд төсөвт нь ямар мөнгө суусныг бол сайн мэдэхгүй байна. Зүгээр ер нь энэ үер усны

холбогдолтойгоор бид нар инженерийн бэлтгэл ажил гээд энэ үер үерийн хамгаалалт мөн одоо бас энэ ус зайлуулах байгууламжуудын мастер төлөвлөгөөг сая өнгөрсөн 5 сард батлаад, нийслэлд бол хүргүүлсэн байгаа. Тэр мастер төлөвлөгөөгөөр бол уг нь 24, 25 оны төсөвт 3 их наяд төгрөг шаардлагатай юм байна лээ. Тэгэхээр ийм мөнгөө одоо яаж тусгаж байгааг бол би зүгээр нийслэлийг сайн мэдэхгүй байна. Ер нь бол тийм хэрэгцээ шаардлагатай гэдэг ийм мастер төлөвлөгөө бол гарсан байгаа. Энэ хүрээнд бас нэг хийгдэх гэж байгаа ажил болбол Сэлбийн дагуух Сэлбэ сэргэлт гээд одоо далан байгуулах далангийн дагуу зам тавих ийм ажил байгаа. Энэ ажил бол нийслэл бонд гаргаж санхүүжүүлэх байх. Тэгэхээр энэ төсөвт бол суухгүй, нийслэлийн бондоор санхүүжүүлнэ гэж байсан. Бонд гаргах үйл явц нь ямар байгааг би сайн мэдэхгүй байна. Уг нь энэ нийслэлээс ер нь энэ төсөв дээр хүн оролцуулахгүй юм уу? Тэгээд төсвөө туссан эсэхээ нийслэлийнхэн одоо бас сайн ярьж авах хэрэгтэй шүү дээ. Энэ хэлэлцүүлгийн явцад өөрсдийнхөө одоо энэ төсвийн хөрөнгө оруулалтын асуудлаа ямар байгаа юм, уг нь хүн байлгах шаардлагатай л юм байна даа.

**С.Одонтуяа:** Амартүвшин гишүүн тодруулъя.

**Г.Амартүвшин:** Би тодруулчихъя. Эрчим хүчтэй холбоотой Тавинбэх сайд сайдаас бас тодруулаад асуучихъя. Ер нь одоо тэгээд баригдаад дуусаад ашиглалтад ороход бэлэн болсон барилгуудаа яах юм бэ? Энэ жилдээ багтаж техникийн юуг нь өгөх юм уу, нөхцөлийг нь өгөх юм уу, нэгдсэн одоо сүлжээнд холбогдох юм уу үгүй юм уу? Өөр ямар нөөц боломж байна вэ гэдэг тал дээр бас тодруулаад өгөөч.

**С.Одонтуяа:** Тавинбэх ТНБД.

**Н.Тавинбэх:** Эх үүсвэрийн хувьд бол бид нар Улаанбаатар хотын

хэмжээнд дулаан дээр ч, цахилгаан дээр ч болбол дутагдалтай байгаа. Тийм учраас бид нар техникийн нөхцөлийг тодорхой хязгаарлалттайгаар олгож байгаа. Нэгэнт олгочихсон техникийн нөхцөлийн хувьд болбол холбоно. Тэгэхдээ одоо өвлийн их ачааллаас хойш журмын дагуу бол эхэлчихсэнээс хойш болбол түр хугацаагаар түдгэлзүүлж байгаа. Улаанбаатар хотын хэмжээнд ямар хүндрэлтэй асуудал байна гэхээр зэрэг техникийн нөхцөл авахгүйгээр одоо маш олон барилга барилга байгууламж ашиглалтад орж байна. Тэгээд энэ ашиглалтад орчихсон хойноо дулаан цахилгаанд холбогдох асуудлыг тавьж байгаа. Энийг бол бид одоо зөвшөөрөхгүй. Тийм. Энэ болбол одоо энэ хүндрэлтэй байдлыг, зэргэлдээ байгаа одоо бусад хэрэглэгчдийн цахилгаан, дулаан хангамжийг эрсдэлтэй нөхцөл байдалд оруулж байгаа хэрэг. Тийм учраас бид зөвшөөрөхгүй байгаа. Тийм одоо техникийн нөхцөл аваагүй, тэгээд барилга байшингаа барьчихсан тийм улсууд бас цөөнгүй байна. Эд нарыг бол олгохгүй. Түрүүн асуусан эх үүсвэрийн талаар асуулт дээр нэг.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Дутуу хариулчихсан юм уу? Тавинбэх дарга гүйцээгээд хариулчих. Тамгын газрынхан нийслэлээс бас хүн дуудмаар юм байна. Одоо энд ерөөсөө түгжрэлийн л хүн байна.

**Н.Тавинбэх:** Эх үүсвэрийн хувьд би хийгдэж байгаа 2 эх үүсвэрийн хувьд хэлсэн. Зүгээр энэ жилийн төсвийн хувьд бол бид санал хүргүүлсэн томоохон ажлууд болбол төсвийн хүрэлцээ муутай гэдэг шалтгаанаар болбол одоо бас Сангийн яаман дээр дэмжигдэхгүй явж байгаа. Тухайлбал одоо дулаан хангамжтай холбоотой, ДЦС 4.1 зуухаар өргөтгөх ажил, ДЦС 3-ын дунд даралтын хэсгийг өргөтгөх гэх мэт одоо нэн шаардлагатай байгаа ажлууд бол тусаж чадаагүй гэдгийг хэлье. Хэрвээ энэ саяын 2 эх үүсвэр дээр одоо бас нэр дурдсан ажлуудыг хийхгүй болбол энэ станцуудын хэвийн үйл ажиллагаа доголдох ийм

эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа гэдгийг хэлье. Энэ болбол нэлээд их хөрөнгө шаардсан ийм хөрөнгө оруулалтын ажлууд байгаа.

**С.Одонтуяа:** Дашдондогийн Ганбат гишүүн асуултаа асууна.

**Д.Ганбат:** Яах вэ ер нь бол жилээс жилд ингээд төсөв улам тэлээд томроод ороод ирдэг. Энэ 27,1 их наядын зарлагатай, 25 их наядын орлоготой, 2,1 их наядын алдагдалтай ийм төсөв орж ирж байна л даа. Энэ Монгол Улсын түүхэнд ийм том төсөв орж ирж байгаагүй байх. Тэгээд энэ төсөв маань нэг ийм болчхоод байгаа юм. Би нэг эхлээд нэг улс орны хэмжээнд яриад, дараа нь би аймаг руугаа ороод ярьчихъя гэж бодож байна. Татвар төлөгчид маань юм уу, байгалийн баялаг болохоор аль болохоор ингээд л нөгөө нэг юу байгаа шүү дээ, компанийн захиралдаа, захирал нь ажилчдадаа та нар ингээд л улам сайн ажиллаад л бай, тэгээд л би жил болгон гоё машинаа солиод байна гэдэг шиг л ийм л юм болчхоод байгаа юм л даа. Ахиад сайн ажиллаарай гэдэг шиг. Тэгээд одоо энэ ДНБ-ий 2 төгрөгийн нэг нь л одоо улсын төсөв зарцуулж байна шүү дээ. Тэгээд энэ улс орны одоо тэр хэцүү хүнд байдал сайжирч байна уу? Өнөөдөр эрчим хүч бол бараг аваарын горимдоо ороход ойртчихсон байна гэж ойлгож байгаа. Энэ өвлийг яаж давах вэ? Асуудалгүй давж чадах уу үгүй юу?

Сая Ерөнхий сайд байсан бол бас би энэ байгалийн хий манай Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр явах гээд байна уу явахгүй юм уу? Нөгөө талаараа бид нар одоо боомтын сэргэлт, энэ төмөр замаа сэргээх гээд оролдоод байдаг, баахан мухар төмөр замтай. Яг тэр дэлхийн том зах зээлтэй эдийн засагтай нийлж чадсан ийм замаа тавьж чаддаггүй. Энэ УБТЗ маань 2 салаа болгочихмоор байдаг. Цахилгаанд нь оруулчихмаар байдаг, ийм юмаа хийж чадахгүй байна. Одоо гэхэд гадуур гэхэд 92, 95 бензин байхгүй болчихсон ийм байдаг. Тэгтэл одоо бараг

л арваад жилийн өмнө эхэлсэн тэр юу чинь байхгүй л байна шүү дээ. Газрын тосны үйлдвэр чинь хэзээ ч орох юм. Тэгээд энэ Улаанбаатарын ард иргэдийг чинь нөгөө бараг л харх болгочихсон тэр Налайх, Багануур туршилтад орж байх ёстой ч юм шиг нэг тиймэрхүү маягтай ингэж хандаж байна. Нэг үр дүнтэй ажил аягүй бага байна шүү. Ийм их мөнгө зарцуулж байгаа мөртөө.

Баянхонгор аймагт бол бас бид нар бүхэн гайгүй ажил хийж байгаа. Санал санаачилга гаргаж байгаа гишүүд бол. Тухайлбал ХАА-н кластер төсөл бол маш зөв хэрэгтэй төсөл гэж дэмжиж байгаа. Тэгээд нэлээн ч юм хийгдэж байгаа. Түүн дээр тэр инженерийн шугам сүлжээний зураг нь хийгдчихсэн бүх юм нь болчихсон байдаг. Тэгээд зарлахдаа бол орхиод зарлачихсан юм байна лээ. Тэр аймаг, орон нутгийн нөхдүүд одоо хаана нь ч хариуцлага байхгүй байсан юм, тэрийг нь мэдэхгүй байна. Тэр юм одоо орсон уу ороогүй юу? Энийг хийхгүй бол өмнө нь оруулсан тэр мөнгө төгрөг чинь бол хөрөнгө оруулалт чинь бол бас нэг их сайн болж чадахгүй. Тэгээд тэнд одоо хийгдэж байгаа тэр мах ногооны зоорь нь одоо хурдан түргэн орчихмоор байна, ингэний сүүний үйлдвэр орчихмоор байна гэх мэтчилний ийм ажлууд байна. Энэ дээр одоо яаж анхаарч байна вэ?

Тэгэхгүй л бол одоо ахиад л бас л нэг үг хэлчихье дээ. 2024 оны 6 сард одоо сонгууль болох гэж байна. Тэгээд энэ иргэд чинь одоо ингээд л босоход энэ найр чинь ингээд дуусах нь байна шүү нөхдүүд ээ. Тэгэхээр энэ үлдэж байгаа 8 сарын хугацаанд наад төсвөө сайн базаад сайн ажил хийчихмээр байна гэсэн ийм зүйлийг одоо бас анхааруулж хэлье.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Ганбат гишүүнээ одоо гэрээр болбол ингээд 4 ханатай гэр, 5 ханатай гэр, 6 ханатай гэр гээд л

томроод л байна л даа. ДНБ Сүүлийн 3 жилийн дотор ер нь 2 дахин томорлоо. Энэ дотор одоо инфляц нөлөөлсөн ч зүйл байна, яг бодит өсөлт ч байгаа. Харин энд одоо ДНБ дотор байдаг ер нь 1/3 гэсэн ийм харьцаагаар барьдаг төсөв маань энийгээ дагаад л нэмэгдэж байгаа юм. Тэрнээс биш эдийн засгийнхаа тэлэлтийг гүйцээж давж давхиад байгаа, хадуурч давхиад байгаа төсөв гэж огтоос байхгүй байгаа. Хэрэв бид зөв хийж чадвал төсвийн нэг төгрөг болон эдийн засгийнхаа өсөлтийг дэмжиж байдаг, хувийн хэвшилээ ч дэмжиж байдаг, төрийн үйлчилгээгээ тасалдуулахгүй явуулах ийм үүрэгтэй үндсэн үүрэг нь төсөв маань. Энэ үүргийнхээ дагуу л явж байгаа.

10 жилийн өмнө нийт ДНБ-ий 1/3 харьцаатай л байсан, ирэх оны төсөв маань мөн тэр харьцаагаа л барьж байгаа. 74 их наядад ДНБ маань хүрнэ. Үүний 1/3 дээр бид нар 27 их наяд ийм төсөв байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл ийм том тэлэлтийг дийлэх, давж гарах, одоо ачааг нь үүрэх ийм төсөв л гэж ойлгоорой та. Бид Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд нэлээдгүй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлж байгаа. Энэ жил ч тэр, ирэх жил болбол нэлээд тийм дорвитой эхэлнэ. Та үдээс өмнө эрчим хүч ярьсан би хариулж амжаагүй. Үнэн эрчим хүч бидний хамгийн тулгамдсан сэргэлт хийх салбар болчихоод байгаа юм. Тийм ч учраас ирэх жил эрчим хүчний салбарт хамгийн том бүтээн байгуулалтууд хийгдэнэ, үргэлжилнэ, 1,1 их наяд. 1,1 их наяд. Үүний дараа зам, тээвэр 750 тэрбум, БХБЯ салбар мөн 750-аад тэрбум төгрөгийн ийм хөрөнгө оруулалтууд хийгдээд явах юм байгаа юм.

Тэрэнд одоо яг таны одоо саяын ярьсан тэр аж үйлдвэрийн бодлого, баялаг бүтээгч нарыгаа дэмжсэн суурь одоо ийм дэд бүтцүүдийгээ тэлэх ялангуяа энэ эрчим хүч дээр болбол ийм бүтээн байгуулалтуудыг үргэлжлүүлнэ. Ойрын жилүүдэд бид одоо эрчим хүчний салбар дээр шинэ эх үүсвэр станц

нээгдэж, бүтээн байгуулалт бол хийгдэж амжаагүй байгаа, ажлууд хийгдэж байсан. Харин энэ жил бид одоо амжаад багтаад Дорнодынхоо цахилгаан станцыг ашиглалтад оруулчих гээд ингээд үзээд байгаа шүү сайн мэдээ. Улаанбаатар хотын 3, 4 дүгээр цахилгаан станц, Эрдэнэбүрэн, Эрдэнэс таван толгойн цахилгаан станц мөн одоо энэ Дорноговьд баригдаж байгаа нефт боловсруулах үйлдвэр ч гэсэн өөрөө одоо станцтай, 90 сая долларын өртөгтэй ийм 50мвт, 50 байх аа, станц баригдах ийм ажлууд эхлээд явна. Тэгэхээр энэ салбар дээр бол нэлээдгүй сэргэлт хийгдэнэ гэж харж байгаа.

Баянхонгор аймгийн хувьд бол та сайн ажиллаж байгаа, сайн ажиллаж байгаа. Баянхонгорын гишүүд бол одоо аймагт хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд дээр бол бидэн дээр одоо байнга л тийм юм хиймээр байна, ийм юм хиймээр байна гээд ер нь бодлогын ийм саналуудаа ирүүлж байгаа. Тэгээд сая мөн Ерөнхий сайдын баг очиж ажилласан. Тэр үеэр ард иргэдийн эрэмбэлж санал ирүүлсэн бүх төсөл арга хэмжээнүүд бүрэн суусан байгаа шүү. Энэ дотор таны саяын хөндсөн тэр дулааны станцын тэгээд дэд бүтэц 2 дугаар хэлхээ инженерийн шугамуудад бүрэн тавигдсан байгаа. Тэгээд ойрын хугацаанд төсөвт ажил ингээд хийгдээд явахаар Баянхонгор аймаг бол одоо барилгажих, орон сууцууд баригдах ийм маш том боломж нээгдээд явах юм байгаа юм. Тэр тухайлан асуусан төслүүдийн талаар Чимидсүрэн дарга хариулчих.

**С.Одонтуяа:** 86 Сангийн яам.

**Ч.Чимидсүрэн:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа ХАА-н үйлдвэрийн каластер байгуулах төсөл байгаа. NDM гээд компани болбол гүйцэтгэж байгаа, 21-ээс 25 онд болбол хэрэгжих. 21, 22 онуудад бол 3,9 тэрбумын санхүүжилтийг бол авсан байгаа. Энэ онд 6,9 тэрбум батлагдсанаас 5,4-ийг нь

болбол авсан байна. Ажлын явц 62,1 хувийн гүйцэтгэлтэй байна. Төсөвт өртгийн нэмэгдлийн хувьд Үндэсний аудитын газраар 3,3 тэрбумаар болбол нэмэгдсэн. Тэгээд төсөвт өртөг нь болбол одоо 15,2 тэрбум болж өргөн баригдсан байгаа.

**С.Одонтуяа:** Мэндчилгээ, зочид танилцуулчихъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 9 дүгээр ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Ганбат гишүүн тодруулъя нэг минут.

**Д.Ганбат:** Жоохон тойрч хариулаад байх шиг байна. Тэр ХАА-н кластер дэд төслийн инженерийн шугам сүлжээг нь энэ улсын төсөвт тавиулаагүй байгаа. Энийг тодруулаад тавихгүй бол өмнө нь оруулсан 10, 20 тэрбум төгрөг үр дүнгүй болчихно шүү. Тийм, тэрийг анхаараарай.

Нөгөө тал дээр бол би бас нэг юм тодруулмаар байна. Энэ Боловсролын яам, Соёлын яам гээд байна. Хүүхдүүд маань 3 ээлжээр хичээллээд байдаг, тэгэхэд одоо Соёлын яам маань ямар юманд одоо хэр их мөнгө тавиад байгаа юм бэ? Энэ дээр одоо анхаармаар байна. Тэгээд тэр хувийн сургууль, цэцэрлэгийн хувьсах зардал, хоолны мөнгө төгрөгийг нь хасаад байгаа юм уу, яагаад байгаа юм бэ, ямар учиртай юм бэ? Энэ чинь одоо нөгөө Үндсэн хуулийн зүйл заалтаар ямар нэгэн ард иргэдийг нийгмийн гарлаар нь ялгаж салгаж болохгүй гэсэн ийм хуулийн зүйл, заалттай шүү дээ. Монгол Улсын иргэн, Монгол Улсын хүүхэд л бол бүгд л адил хэмжээнд л байх ёстой. Тэр аав ээж нь сайн ажиллаад хүүхдээ сайн.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Боловсролын сайд Энх-Амгалан, Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Ганбат гишүүнээ одоо цөмөөрөө нэг ийм ойлголттой болмоор байна. Монгол Улс ер нь тэр чигээрээ бүх сургуулиуд нь 3 ээлжид орчихсон юм шиг, бүх сургуулиуд нэг ангид одоо 50-аас 60 хүүхэд хичээллэж байгаа юм шиг нэг ийм буруу ойлголтоо цөмөөрөө больё Ганбат гишүүнээ. Тэгэхээр одоо яг үндсэндээ болбол яг өнөөдрийн байдлаар яг өнөөдөр нийслэл дээр 3 ээлжийн эрсдэл дээр үүссэн, 3 ээлжээр хичээллэж байгаа 6 сургууль байгаа, 6 сургууль. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд одоо төрийн өмчийн 680 сургуулиас 6 сургууль л 3 ээлжийн эрсдэлд орсон, 6 сургууль. Ингээд 686 сургууль дээр нийт 25 мянган манай мэргэжлийн хэлээр бүлэг, бид нарын ярьж сурснаар анги. 26 мянган ангиас одоо мянга хүрэхгүй анги дээр л одоо юу 45-аас дээш хүүхэдтэй ийм ангиуд суралцаж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ жил өнгөрсөн 2 жил одоо ямар ч байсан бид нар энэ цэцэрлэгийн хүртээмжийг.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Сайдад нэг минут нэмж өгье. Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Цэцэрлэгийн хүртээмж дээр бид нар ямар ч байсан одоо том дэвшил гарсан гэж ойлгож байгаа. Ямар ч байсан өнөөдөр Улаанбаатар хотод И-Монгол одоо платформаар бүртгүүлсэн бүх хүүхдүүдийг одоо бид нар ямар ч байсан цэцэрлэгээр хангаж байгаа. Сүүлийн 2 жилд хийсэн одоо том одоо ажил гэж ойлгож болно. Энэ дээрээ бид нар бас нэмж энэ 3 ээлжид орох эрсдэлтэй сургуулиудын одоо эрсдэлийг яаж бууруулах вэ гэдэг дээр энэ зунжингаа бид нар бас тодорхой ажиллалаа. Өнөөдөр улсын хэмжээнд нэг ойрын хугацаанд, ойрын хугацаанд би ярьж байгаа шүү. Ойрын хугацаанд болбол 67 одоо сургууль 3 ээлжийн эрсдэлд орох ийм болон ийм эрсдэлүүд үүсэж байна. Ер нь яагаад 3 ээлжийн сургуулийн эрсдэл үүсээд байна вэ гэхээр 12 дугаар ангийг одоо 30-аас 35 мянган хүүхэд төгсөхөд, 1 дүгээр ангид

доороосоо 70-аас 75 мянган хүүхэд орж ирж байгаа. Ингээд жил бүхэн 30-аас 35 мянган хүүхдийн зөрөө одоо гарч ирж байгаа учраас энэ ачаалал 5 жил үргэлжлэх юм байна лээ, 5 жил. Тийм учраас 5 жилийн хугацаанд энэ ачааллыг хийхэд бид нар сургууль барих уу, эсхүл ямар нэгэн тийм дундын хувилбараар одоо шийдэх үү гэдэг энэ хувилбарууд дээр бид нар их зөв хөрөнгө оруулалтын бодлого.../минут дуусав/

**С.Одонтуяа:** 86 Чимэдсүрэн нэмж хариулъя Сангийн яам.

**Ч.Чимидсүрэн:** Саяын асуусан төсөлтэй холбоотой цахилгаан дэд бүтцийн асуудал нь өчигдөр уржигдар манай дээр бас танай төлөөлөгч нар ирж уулзсан юм байна. Яг албан ёсоор бол бас ХХААХҮЯ-наас болбол хүсэлт нь ирээгүй байгаа юм байна. Тэр нь ирсэн тохиолдолд бид Үндэсний аудитын газар луу илгээгээд, Үндэсний аудит дээр болбол баталгаажуулалт хийгдсэн үед энэ хэлэлцүүлгийн үед шийдвэрлэгдэх боломжтой.

**С.Одонтуяа:** Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ингээд улсын төсөв орж ирж байна. 25 их наяд төгрөгийн орлоготой, 27 их наяд төгрөгийн зарлагатай. Ер нь болбол одоо Монгол Улсын хэмжээнд хамгийн түүхэнд хамгийн их төсөв орж ирж байгаа юм байна. Энэ болбол буруу биш л дээ. Энэ болбол цаанаа болбол Монгол Улсын эдийн засаг бас тодорхой хэмжээнд тэлж байна л гэсэн үг л дээ. Тэгэхээр инфляцаа яах юм бэ гэдэг нэг асуудлыг л Сангийн сайдаас асууя. Бид нар саяхан орлого 1,8 их наядар нэмэгдээд, энэнийхээ хүрээнд цалин, тэтгэмжээ нэмэгдүүлсэн, тэтгэвэр тэтгэмжээ нэмэгдүүлсэн. Ингээд зөрөөд инфляц маань дахиад өсөөд явчхаж. Юмны үнэ өсөөд байна шүү дээ. Тэгэхээр 1 дүгээрт юмны үнэ өсөлтөд хамгийн их нөлөөлөөд байгаа мах, гурилынхаа үнийг ер нь яаж

барих юм бэ цаашидаа? Одоо ингээд иргэдээр явж, иргэдтэй уулзаад явж байхад болбол ерөөсөө юмны өсөлтийг яаж барих вэ гэдэг асуудлыг хамгийн түүрүүнд тавьж байгаа шүү дээ. Тэгэхээр инфляцаа 1 дүгээрт болбол яаж барих вэ хэдүүлээ?

2 дугаарт инфляцын чинь хамгийн гол асуудал болбол ерөөсөө импорттоо бид нар орлуулах дотоодын үйлдвэрлэлээ тэлэх асуудал шүү дээ. Тэгээд нөгөө үйлдвэрлэлээ тэлнэ гэхээр үйлдвэрлэл үйлчилгээ би бол одоо энэ Сангийн сайд нараас жил болгон л асуугаад байдаг. Ер нь ААН-үүдээ хэрхэн дэмжих юм бэ, үйлдвэрлэлээ хэрхэн одоо боломж бололцоогоор нь дэмжиж явуулах юм бэ? Та бүхний хувьд болбол одоо хувийн хэвшил болбол хувийн хэвшилээрээ явна гэсэн ийм арга, юуг л бариад байх шиг байгаа юм. Тэгэхээр тодорхой хэмжээний дэмжлэг байж бид нар энэ үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, хүрээг нь тэлэх ёстой болж байгаа. Наад зах нь гэхэд одоо нэг асуулт байж байна. Нөгөө бид нар 10 сая малын арьс шир боловсруулах ёстой үйлдвэр маань хаах нь явж байна вэ, хэдий хэмжээнд явж байна вэ, энэ дээр ямар хэмжээний хөрөнгө оруулалт орж байгаа вэ гэсэн нэг асуулт байна.

2 дугаарт энэ төсвийнхөө хяналтыг бид нар сайжруулах хэрэгтэй. Жил болгон бид нар аудитын дүгнэлтүүд орж ирж байгаа. Зүгээр уншаад л уншаад л өнгөрчхөөд байгаа шүү дээ. Тэгээд энэний ар дээр ЗГ ер нь хяналт дээрээ хэр дүгнэлт хийж явж байгаа вэ? Сая гэхэд чинь одоо ногоон автобустай холбоотой асуудлууд гарч ирж байна. Энэ худалдан авалттай холбоотой асуудлууд, маш олон чанаргүй асуудал одоо бүтээн байгуулалтууд хийгдээд, энэ жил одоо хүлээж аваад л авлаа, хойтон жил нь дахиад нөгөө бороо ус дээрээс нь бороод ч байдаг юм уу эхнээсээ авхуулаад дахиад засвар 2 жилийн дотор дахиад засвар хэрэгцээтэй болоод ингээд явчхаад байна шүү дээ. Тийм болохоор энэ төсвийнхөө зарлага дээр хяналт тавих асуудал дээр ер

нь ямаршуу бодлого хэдүүлээ барих юм бэ? Энийгээ бас нэг тодруулж өгөөч гэж.

Одоо сая Ерөнхий сайд бүх аймгуудаар явж байгаад төсвөө баталж гаргалаа. Төсөв маань ер нь болбол бас хот хөдөөгийн сэргэлт гэдэг дээр орж ирж байгаад маш их таатай хүлээж авч байгаа шүү. Тийм болохоор ер нь энэ хөдөөгийн хөгжлийг нэлээд дэмжих, хотод хот хөдөөгийнхөө сэргэлтийг гэсэн энэ бодлого дээрээ нэлээн ямар бодлого авч явах ёстой юм гэдэг юмыг жоохон тодруулж өгмөөр байна. Үүнийхээ хүрээнд энэ малын арьс ширийг, арьс шир, түүхий эд уначхаад байгаа шүү дээ. Арьс шир, түүхий эдээ ер нь экспортод гаргах боломж бололцоо маань хэр байгаад байгаа юм бэ? Энэний хамгийн ганц түлхүүр нь болбол ерөөсөө малын өвчин. Бид нар малын өвчинтэйгөө тэмцэж чадахгүй байгаа болохоор өвчтэй малын мах гарахгүй байгаад байгаа, хаалттай байгаа, өвчтэй малын арьс шир, түүхий эд боловсруулагдахгүй байгаа, гадагшаа экспортод гарахгүй байгаад байгаа шүү дээ. Тийм болохоор ерөөсөө малынхаа өвчинтэй хэр тэмцэх юм бэ? Бид нар Хөдөө аж ахуйн байнгын хороон дээр миний бие ахлаад, ажлын хэсэг гарч байгаад тодорхой хэмжээний одоо юу төсөв зохион байгуулаад, төсөв тодорхойлоод нийт Монгол Улсын 70 сая малыг эрүүлжүүлэхэд ямар хэмжээний төсөв гарах юм бэ гэхээр жилдээ болбол 70 орчим тэрбум төгрөгийн төсөв гарч байж бид нар бол малаа эрүүлжүүлье. Өөрөөр хэлбэл одоо жилдээ 2 удаа вакцинжуулах арга хэмжээг болбол зохион байгуулъя гэсэн. Энэ мөнгө маань энэ улсын төсөв дээр суусан уу гэдэг ийм асуулт байна. Тэгээд тодруулаад ахиад асууна.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хэрвээ төсвийн тоог яриад рекорд гэх юм болбол жил болгон рекорд тогтоогоод байгаа шүү дээ.

Хойтон ч тогтооно, хойтонгийн дараа жил ч тогтооно. Өмнө өнгөрсөн жилүүдэд жил болгон өмнөхөөсөө өсөж ирсэн. ДНБ маань тэлж байна. ДНБ тэлэх нөлөөллийг төсөв өөрөө ч хийж байгаа. Өөрөөр хэлбэл энэ чинь хөгжлийн төсөв гэсэн үг. Гэхдээ бид эрсдэлээ 1/3 гэдэг дээр л сайн барих ёстой. Энийгээ барьж явж байгаа, одоо 35, сүүлийн жилүүдэд 35, 36, 34 энэ хувь дээр бол маш сайн эрсдэлээ бол ингээд хянаад контролдож явж байгаа гэдгийг хэлье.

Инфляцын хувьд энэ үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах чадварын асуудал болбол Төв банкны асуудал. ЗГ яаж оролцдог вэ гэвэл зөвхөн нийлүүлэлт талаасаа нийлүүлэлтийн шок үүсгэхгүй байхаар төлбөрийн тэнцэл дээрээ л одоо бид тохиргоонуудаа хийж энийг харна гэсэн үг. Өөрөөр хэлбэл дотоодын үйлдвэрлэл, экспорт, гадаад худалдаа энэ тал дээрээ бид ажиллах ёстой юм байгаа юм. Байнгын одоо дотоодын худалдаагаа юу гадаад худалдаагаа нэмэх дээр байлгах, төлбөрийн тэнцлээ нэмэхтэй байлгах гээд. Ингээд энэ дээр дотоодын үйлдвэрлэлүүдээ бид нар яаж дэмжих вэ? Төр өөрөө чадах үйлдвэрүүдээ л хийнэ. Өөрөөр хэлбэл стратегийн одоо цахилгаан станцууд, мөн ЭТТ гээд, мөн энэ манай Наранцогт дарга очиж ажиллаж байгаа энэ төрийн маань ганц том энэ ААН-ээр дамжуулж хийгдэх стратегийн ийм үйлдвэрлэлүүдээ хийнэ.

Харин хувийн хэвшлийн хувьд тэднийг үйлдвэрлэлээ тэлэх, шинээр үйлдвэрүүд бий болго энийг бид бодлогоор, татвараар, мөн дэд бүтцүүдээрээ л дэмжинэ. Ингээд бид Дорноговь аймагт нефт боловсруулах үндэсний томоохон үйлдвэртэй 3 жилийн дараа болно, 1,5 сая тонн баррель жилдээ боловсруулах ийм том үйлдвэрлэл бий болно. Ингэснээр бид одоо ямар ч байсан нефтийн бүтээгдэхүүнүүд дээрээ хараат бус ийм дотоодын үйлдвэрлэлтэй болно.

Та юуг онцолж асуулаа. Тэгээд арьс шир боловсруулах гээд. Ер нь болбол аймгууд дээр жишиг том ийм үйлдвэрүүд бол хөөрхөн хөөрхөн баригдаад л байгаа юм байна лээ. Баянхонгор, Өвөрхангайд бол жишээ нь аягүй хөөрхөн үйлдвэрийг өөрсдөө шийдчихсэн ингээд явж байгаа. Ингээд санаачилгатай байх юм болбол одоо яг бүсчлээд, бүсчлээд аймгууд өөрсдөө ингээд хийх юм болбол маш их боломжууд байгаа юм байна лээ. Харин Дарханд болбол одоо тэнд байрлалтай арьс ширний энэ цогцолборыг дэд бүтцийг нь улс хийе, тэрэн дээр баригдах үйлдвэрүүд бол гаднын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийнхэн л хийх ийм боломжоор нь бүрдүүлнэ. Ингээд дэд бүтэц дээр нь хойтон бүтэн тавьсан байгаа, 23,8 тэрбум төгрөг бүтэн ХХАА-н сайдын багц дээр орсон байгаа шүү. ХААЯ-наас тэр одоо сайхан хийж байгаа ажлуудаа нэг сайхан яриад, тайлбарлаадааач. Тэр эрүүлжүүлэх, вакцинаа нэмсэн эд нар гээд. Тийм, вакцинаа нэмчихсэн байгаа шүү. Зардлаа.

**С.Одонтуяа:** Нэмж хэн хариулах вэ, тодруулж? 2 дугаар микрофон дээр ХААЯ, Хүнс, хөдөө аж ахуйн яам. Нэрээ, албан тушаалтайгаа хэлээд протоколд тэмдэглүүлнэ.

**Ц.Болорчулуун:** ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Гишүүний асуултад нэмж хариулъя. Малын гаралтай түүхий эдийг, арьс ширийг боловсруулах чиглэлд Дарханы арьс ширний үйлдвэр, цогцолбор үйлдвэрийг барихаар төсөвлөж байгаа. Энэ дээр болбол цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийн нийт төсөвт өртөг нь бол 49 тэрбум байгаа. Тэгээд 2024 оны төсөв дээр бол 11,9 тэрбум төгрөгийн төсвийг бол тавиад явж байгаа. Ховдын үйлдвэр технологийн парк нийт төсөвт өртөг 35,9 тэрбум, үүнээс 11,3 тэрбум төгрөгийн төсвийг бол энэ ирэх жилийн төсөв дээр төсөвлөөд явж байгаа.

Өнгөрсөн жилийн түвшинд Монгол малыг эрүүлжүүлэх чиглэлд мал

эмнэлгийн зардалд нийтдээ 59,5 тэрбум төгрөгийн зардалд тусгасан. Үүгээр болбол бид нар дээрээс нь одоо хүмүүнлэгийн тусламж төслийн төслөөс бас 6,5 тэрбумаар шүлхий өвчний вакциныг авч, нийт үхэр сүргээ 2 удаа буюу хавар, намар дархлаажуулалт хийсэн. Ингээд шүлхий өвчин бол одоогоор бол тайван байгаа. Бусад гоц халдвартай өвчнийхөө вакцинжуулалтыг бол цаг тухайд нь бол авч хэрэгжүүлсэн. Энэний үр дүнд бол өвчний одоо ерөнхийдөө бүх аймгуудад тархаад байсан өвчин бол ингээд хумигдах чиглэлдээ бол ажиллаж байгаа.

Энэ жилийн төсөв дээр болбол мал эмнэлгийн зардалд нийтдээ 69 тэрбум төгрөгийн төсвийг тусгаад явж байгаа. Энэ дээр болбол малын үйлчилгээний хөлс дээр тодорхой зардлууд нэмэгдсэн. Мөн малын вакцин дээр 6,5 тэрбум төгрөгийн вакцины зардал нэмэгдэж байгаа нь өнгөрсөн жил бид нар төслийн шугамаар авсан вакциныгаа энэ жил нөхөж авч байгаа хэлбэрээр ингээд төсөв нэмэгдэж харагдаж байгаа. Одоо бол шүлхий өвчин дээр болбол шүлхийн вакцин дээр одоо 3 сая тунгийн нөөцтэй байгаа. Ирэх жил бид нар 9 сая тун вакцин авахаар ингээд төлөвлөөд ажиллаж байгаа.

**С.Одонтуяа:** Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэр инфляцтай холбоотой асуудал та бид хоёр санал нэг байгаа юм байна. Ер нь болбол үйлдвэрлэлээ бид нар тэлж байж л энэ инфляцаасаа сууриараа бид нар гарах ёстой шүү дээ. Тийм болохоор үйлдвэрлэл тал дээр болж өгвөл дэмжлэг өгөөд цаашиа явах хэрэгтэй байна.

Энэ авто замын талаар нэг лавлах хэрэгтэй байна. Сая Ерөнхий сайд очоод Булган аймагт очихдоо Мянганы замын босоо тэнхлэгийн Гурванбулаг, Булган, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 68 км замыг ер нь болбол дуусгая гээд амласан юм. Тэгээд эндээс 10 км зам л



улсын төсөв дээр суучхаад байх юм. Энийг одоо Ерөнхий сайдын амласны дагуу ер нь нэмэгдүүлэх ийм боломж бололцоо юу байна вэ гэдгийг нэг хэлж өгөөч. 2 дугаарт энэ төрийн албан хаагчдын цалинг нь ер нь яах ёстой вэ? Тэр дотроо бол орон нутгийн нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалинг наад зах нь бид нар нэг 2 сая төгрөгтэй болгож байж бид нар тэнд тогтвортой ажиллах ийм боломж бололцоог хангах ёстой болж байна. Тэнд чинь одоо нэг 2-оос 3 орон тоо.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Бат-Эрдэнэ гишүүнээ бид чинь 21 аймагтай, 21 аймгийг төлөөлж ирж байгаа 76 гишүүн байна. Тэгээд яах вэ бид ингээд 2 жилийн дотор 21 аймгаараа бүтэн тойрлоо л доо Ерөнхий сайдын баг. Тэнд ямар ч байсан бид нар бэлтгэл ажил хангагдсан төсөл, хөтөлбөрүүдийнхээ хэмжээнд ард иргэдийн саналыг авч бүрэн тусгасан, бүрэн тусгасан байгаа. Ингээд нэг замыг нэг төслийг хэрвээ бүтнээр нь ингээд суулгаад байх юм болбол бид энэ 21 аймагтаа энэ 6 мянган хүний саналыг яаж ч багтааж чадахгүй шүү дээ. Та минь энэ дээр бас нэг нийтэч байж хараарай. Энэ чинь олон аймаг, олон ард түмний төлөөлөл байна. Ерөнхий сайдыгаа аваачиж байгаад хамаагүй энэ бодит байдлаас хэт их давсан ийм юм бас хэдүүлээ амлуулж болохгүй. Тийм учраас энэ байгаа тавьсан төсвөө хэдүүлээ хойтон.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Жавхлан сайд нэмж хариулъя. Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Сая 2023 оны 7 дугаар сарын 1-нээс дунджаар төрийн албан хаагчдын цалинг 40 хувь нэмсэн. 2024 онд бид бас төрийн албан хаагчдын цалинг инфляцтай уялдуулж бид нар 10 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон байж байгаа. Дундаж цалин

улсын 2023 оны 2 дугаар улирлын байдлаар дундаж цалин 1,9 сая, төрийн албан хаагчдын цалин 1,5, хувийн хэвшлийнх 2 сая орчим байсан бол сая төрийн албан хаагчдын цалинг 7 сарын 1-нээс нэмэгдүүлснээр төрийн албан хаагчдын дундаж цалин 1,9 сая улсын дундаж руу хүрч очсон. Бид нар 24 оны 1 сарын 1-нээс, 24 оны энэ төсөв дээр 23, төрийн албан хаагчдын цалинг төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалинг 20 хувиар, төрийн бусад албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон. Үүнд 532,4 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Хөдөөгийн сумд ажиллаж байгаа 51 мянга, 51,8 мянган төрийн албан хаагчдын үндсэн цалинг 40 хувиар, аймгийн төвийн сум, нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт ажиллаж байгаа 50.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Дуустал хариулчих Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** Аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт ажиллаж байгаа 53,4 мянган төрийн албан хаагчдын цалинг сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус нэмж тооцохоор олгосон. Ингэснээр нийт 105,2 мянган төрийн албан хаагчдад бол орон нутгийн нэмэгдлүүд 20-оос 40 хувиар олгогдоно гэсэн үг. Үүнд нийтдээ 300,8 тэрбум төгрөг олгохоор болж байгаа юм. Мөн 21 аймаг Улаанбаатар хотын 3 дүүрэгт ажиллаж байгаа, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны 3,9 мянган албан хаагчдад 5 жил тутам 6 сарын нэмэгдлийг олгохоор бас төсөвт тооцсон байгаа. Үүний үр дүнд төрийн мэргэжлийн үйлчилгээ буюу багш, эмч гээд эдгээр албан хаагчдын цалингийн доод хэмжээ 1,1 сая, сумд сая 540 мянган төгрөг болж байгаа юм. Аймгийн төвийн сум болон алслагдсан 3 дүүрэгт сая 320 мянган төгрөг энэ бол доод хэмжээ болж орж ирж байгаа юм. Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ 900 мянган төгрөг болж нэмэгдэж байгаа. Сумд бол сая 260 мянган төгрөг,

аймгийн төвийн сум, алс алслагдсан 3 дүүрэгт сая 80 мянган төгрөг болж нэмэгдэж байгаа.

**С.Одонтуяа:** Энхбаярын Батиугар гишүүн асуултаа асууя.

**Э.Батиугар:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн онд бид нар 23 оны төсвийг баталж байхдаа болбол боомтын сэргэлтийг онцолж байсан. Тэгээд тухайн үед болбол 50 сая тонн нүүрс экспортолно гэсэн тийм зорилго тавьсан. Үүндээ бид нар болбол оны өмнө хүрчихлээ. Тэгээд энэ юу харуулж байна гэхээр боомтын сэргэлт маш амжилттай явж үр дүнд нь эдийн засаг валютын хямралд орох тийм эрсдэлээс гарсан. Төлбөрийн тэнцэл болон худалдааны тэнцэл болбол эерэг гарсан. Тэгэхээр ирэх жилд болбол энэ боомтын сэргэлт бол үргэлжлүүлж явах уу? Тэгээд ер нь Монгол Улс өнөөдрийн байдлаар болбол нийт Хятад улс руу урд хөрштэй худалдаа хийх тийм боомтын багтаамж хэдэн сая тонн вэ 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт болбол энэ төмөр замын холболтуудаа хэзээ хийх төлөвлөгөөтэй байгаа вэ урд хөрштэй. Энэ төсөвт болбол гадаадын худалдааны цахим цонх байгуулна гэж бичсэн байна лээ. Энэ нь яг ямар зарчмаар, яаж гадаад худалдааны хүнд суртлыг арилгах вэ?

ТӨК-удын ноогдол ашиг 595 нь тэрбумыг улсын төсөвт авна гэж бичсэн байна. Энэ нь бодитой тоо юу? Мөн энэ 23 ондоо бид нар хэдэн сая, хэдэн төгрөг төрийн өмчийн компаниудаас ноогдол ашиг ашигийн журмаар авсан бэ? Дээр нь энэ хүрээнд асуухад Эрдэнэс таван толгойн хуримтлагдсан ашиг одоогийн байдлаар хэдэн төгрөг баланст нь байгаа вэ? Ирээдүйн өв санд хэдэн төгрөг, хэдэн төгрөгийг оруулахаар тусгагдсан байгаа вэ? Тэгээд нэг Ирээдүйн өв сангийн ер нь хөрөнгийн менежментийг нь ямар зарчмаар явдаг юм, зүгээр дансанд байлгадаг юм уу аль эсвэл тодорхой хэмжээний өгөөж авч хөрөнгө оруулалт

хийх үү, хүү авах уу гэх мэтчилэн зүйлүүд асууя.

Юу байгаа юм, Польш улсын эдийн засаг болбол ковидын дараа болон өмнөх үед бол маш эрчимтэй хөгжиж өссөн. Энэ Европын холбоондоо болбол хамгийн нэг зөв хөгжсөн жишиг улс орон болж тогтоогдсон. Тэгээд үндсэн шалтгаан нь болбол англиар нь хэлбэл Polishdeal гэж ярьдаг. Энэ нь болбол Польшийн гэрээ гэж ярьсан. Энүүгээрээ бол гадаад улсад амьдарч байгаа Польш иргэдээ Польш улсдаа авч ирвэл тодорхой хэмжээний бизнес эрхлэгчдэд нь хөнгөлөлтүүд өгдөг. Энэ утгаараа эдийн засгаа бол маш их хэмжээний Польш иргэдийнхээ хөрөнгө оруулалтаа гаднаас татсан, мөн боловсролтой, мэдлэгтэй, чадвартай иргэдээ эдийн засагтаа шингээсэн. Энэ утгаараа бас Монгол Улсад улсын байдлаар болбол албан бус тоогоор 200 мянган иргэд гадаад улсад амьдарч оршиж байгаа, хөдөлмөр эрхэлж байгаагаас энэ иргэд маань тодорхой 4 жил ч юм уу ажилласныхаа дараа Монгол Улсдаа эргэж ирвэл эдийн засгийн ямар нэгэн дэмжлэг өгөх тийм программ гэхээсээ илүү тийм хөтөлбөр хэрэгжүүлж болох уу? Энэ чинь бол маш их хэмжээний залуучууд ялангуяа залуучууд гадаад улсад хөдөлмөр эрхэлж, дээрээс нь нэмээд их дээд сургуульд сурч мэдлэг боловсролтой болсон. Мөн эдийн засагчдаа их хэмжээний дэм өгөх тийм бололцоо энэ хараад байгаа юм.

Мэдээж жил болгон махны үнэ болбол байнга өсдөг. Энэ талаараа болбол ерөнхийдөө миний яриад байдаг 70 сая малтай байж яагаад үнэ нь байнга өсөөд байдаг юм бэ? Нийлүүлэлтийн гаралтай ямар нэгэн доголдол байна. Үүн дээр ЗГ-ын зүгээс тодорхой хэмжээнд шинэчлэл хийсэн үү ирэх онд? Ахиад л өвөл болохоор, хавар болохоор үнэ өсөх үү? Нөөцийн мах хэдийг бүрдүүлж байгаа вэ? Баярлалаа.

**С.Одонтуяа:** Хариултаа авъя Жавхлан сайд. Батиугар гишүүний

асуултад хариулъя. Махнаас эхэлье. Би түрүүн Батсуурь гишүүний асуултад хариулахдаа бас энэ талаар хэлсэн. Батсуурь гишүүн бол яг таны эсрэг ярьж байна тийм ээ, мах үнэтэй байх ёстой, Улаанбаатарчууд үнэтэй мах идэх ёстой шүү, зах зээлийнхээ үнээр энийг нь чөлөөл гээд. Та бол нийслэлийн иргэд хямдхан мах идэх ёстой гээд. Ер нь бол энэ зах зээлийнхээ зарчим дээр л суурилж явах нь л зөв юм байгаа юм. Бид олон жил энийг бас ингэж тогтвортой барих гэж ийм огцом үнийн шок үүсгэхгүй байхаар зохицуулалт хийж ирсэн. Энийг цаашидаа бол ЗГ аль болох оролцоогоо бага, шат дараатай багасгаад, хэрвээ нийслэлчүүд хямдхан мах идэх ёстой болбол энэ дэд бүтэц логистикийг нийслэл өөрсдөө хариуцмаар байгаа юм. Тийм бага багаар энэ рүүгээ бол шилжих ёстой л гэсэн ийм ЗГ-ын байр суурь хэлмээр байна. Тэгээд ирэх жилийн нөөц, ямар төлөвлөгөө байгаа юм тэрийг ХААЯ-наас тоонуудаа хэлнэ биз.

Боомтын нэвтрэн өнгөрүүлэх чадварууд бол маш сайн нэмэгдэж байгаа. Тийм ч учраас энэ жил бид нүүрсээ ингээд 60 сая тоннд хүргэж чадаж байна. Олборлож чадаж байна, тээвэрлэж чадаж байна. Хилээр нэвтрэн өнгөрүүлэх чадвар эрс сайжирсны үр дүнд ийм үр дүн гарч байгаа юм. Тухайлбал манай экспорт импортын 2 гол боомт байна. Замын-Үүд, Алтанбулаг. Замын-Үүд боомт дээр төсөл хэрэгжээд амжилттай дууссан. Ингээд Замын-Үүд боомтын нэвтрэн өнгөрүүлэх чадвар зорчигчдын хувьд бол 3 дахин, ачаа тээврийн хувьд болбол мөн 3-аас 4 дахин нэмэгдэх ийм бүрэн боломжтой болсон. Энэ бол маш сайн мэдээ. Алтанбулаг дээр АХБ-аар хэрэгжиж байгаа RIBS төслийн хүрээнд мөн энэ жил дуусах ёстой, ирэх жил нэг жоохон ажил үлдэнэ. Ингэвэл мөн л нэвтрэн өнгөрүүлэх чадвар нь зорчигч дээр ч тэр, ачаа тээвэр дээр ч тэр 3-аас 4 дахин нэмэгдэх ийм бүрэн боломжтой болно. Энэ 2 боомтоор зогсохгүй Бичигт боомт мөн Гашуун сухайт дээр ч гэсэн төмөр замаа холбох энэ төслүүд сая 7

сард Улсын Их Хурал дээр бас чиглэл гарч ингэж, ЗГ-т үүрэг боломжуудыг нь нээж өгсөн. Энэ дагуу бүтээн байгуулалтын ажил хийгдээд, 2 талаас ирсэн байгаа төмөр зам хилээ, төсөл, 2 жил, 2 жил байх аа Халтар сайдаа, 2 жил тийм ээ, 2 жил хил холболт нь хийгдээд ингээд замууд холбогдоно. Мөн дараа нь Ханги хүлээгдэж байна. Ингээд боомтын сэргэлтүүд явна. Ирээдүй, ЭТТ-н ашиг, Ирээдүй өв сангийн талаар тоонуудыг Санжаадорж дарга хэлчих үү?

Тэр гадаадад байгаа иргэд гэж байгаа юм. Би арай өөр бодолтой байдаг юм шүү. Гадаадад байгаа иргэдийн хувьд Монгол маань бид нарыг тосож аваад, бид нарыг урьж аваачаад ямар хөнгөлөлт чөлөөлөлт, ямар тусламж үзүүлэх болов гэхээсээ илүү тэнд сурч боловсорсон залуучууд иргэд маань Монголдоо юу хийх вэ гэдэг ийм үзэл бодолтой Монголдоо ирж ажиллаж, хөдөлмөрлөж, Монгол Улсынхаа хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулж, болохгүйг нь засаж, болж байгааг нь дэмжиж ингэж хандлагаа өөрчилбөл их зөв юм байгаа юм л гэж би боддог юм шүү. Тийм.

**С.Одонтуяа:** 82 Ганбат.

**Ж.Ганбат:** Батиугар гишүүний асуултад хариулъя. ЭТТ компани 2022 онд 1,3 их наяд төгрөгийн ашигтай ажилласан. Энэ оны 3 дугаар улирлын байдлаар 2,7 их наяд төгрөгийн ашигтай бол ажилласан байгаа. Ирээдүй өв сангийн үлдэгдэл 22 оны жилийн эцсээр 2,7 их наяд төгрөг байгаа. 2023 онд бид төрийн өмчийн компаниудаас 550 тэрбум төгрөгийн ноогдол ашгийн орлогыг төвлөрүүлэх ийм төсөв батлагдсан байгаа. 24 оны төсвийн төсөлд бид 1,3 их наяд.../үг тасрав/

**С.Одонтуяа:** Ганбат дарга микрофондоо тэгшихэн ярих уу? Сонсогдохгүй байна.

**Ж.Ганбат:** Ирээдүй өв санд 2022 онд 2,7 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй

байсан. 23 онд бид нар төрийн өмчийн компаниудаас ноогдол ашгаар 550 тэрбум төгрөгийн ноогдол ашигийн орлогыг төвлөрүүлнэ гэж тооцсон. 2024 онд оны төсвийн төсөлд 1,3 их наяд төгрөгийн орлогыг төвлөрүүлнэ гэж ингэж тооцоолсон. Эрдэнэс таван.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Гүйцээгээд хариулчих уу? Ганбат дарга.

**Ж.Ганбат:** ЭТТ компани 2022 онд 1,3 их наяд төгрөгийн ашигтай ажилласан 2022 оны жилийн эцсээр. 23 оны 3 дугаар улирлын байдлаар 2,7 их наяд төгрөгийн ашигтай ажилласан.

**С.Одонтуяа:** Батиугар гишүүн тодруулъя.

**Э.Батиугар:** Нөгөө гадаад худалдааны цахим цонх яг ямар байдлаар ажиллах юм бэ? Энэний хүнд суртлыг яаж бууруулах вэ? Мөн ЭТТ-н хуримталчихсан, хуримтлагдсан нийт ашиг нь хэд байгаа юм бэ? Яг баланс дээр нь байгаа. Энэ 2-ыг тодруулъя.

**С.Одонтуяа:** 81 Түвдэндорж дэд сайд.

**Г.Түвдэндорж:** Батиугар гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хөгжлийн яаман дээр гадаад худалдааны нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж байгаа. Үүнтэй холбоотойгоор гадаад худалдааны нэг цонх нэгдсэн нэг цонхны үйлчилгээний бодлогын цахим систем, цахим системийг хөгжүүлээд ажиллаж байгаа. Үүн дээр болбол Хятад, БНХАУ-ын гаалийн системтэй нягт уялдаж, Монголын гаалийн систем ОХУ-тай бас яг энэ 2 хөрш улстайгаа гаалийн системүүд болбол нэг уялдахаар, эргээд нэг цонхны үйлчилгээ, нэг цонхны систем үйлчилгээг болбол хэрэгжүүлээд явж байгаа. БНХАУ-ын хувьд болбол манай экспортын худалдааны 82 хувийг болбол

эээлдэг маш чухал стратегийн түнш.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуултаа асууна. Тэгэхээр 2024 оны төсөв болбол өмнөх жилүүдтэй харьцуулахад бас онцлогтой байгаа. Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгууль мөн Парисын олимп гээд төсвийн зардал яах аргагүй нэмэгдэж байгаа. Тийм учраас бид нар бол энэ төсвийн ерөнхий төслийг бол ерөнхийд нь бол асуудалтай байгааг ойлгож байна. Тэгэхдээ нэг бас хэд хэдэн анхаарах зүйл байна. Тухайлбал энэ аудитын дүгнэлт дээр Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтуудад, тэр дотроо энэ тэгш бус байдлыг арилгах зорилтууд маань хэдэн байр ухрах нь. 2030 он гэхэд ер нь сүүлийн 5 жилд 14 байр ухарсан байгаа. Тийм учраас энэ төсвийн гол зарцуулалт маань орлогын ялгааг багасгах, тэгш бус байдлыг багасгах энэ чиглэлд анхаарах нь зүйтэй гэсэн ийм зөвлөмж өгчихсөн байгаа. Энийг болбол гишүүний хувьд үнэхээр дэмжиж байна.

Тэгээд 1 ийм асуулт байна. Энэ төслийн маань хамгийн нэг гол том зорилт бол энэ хот хөдөөгийн, хөдөөгийн сэргэлтийг дэмжих гээд энэ том зорилт байгаа. Энэ үнэхээр чухал зорилт. Тэгэхдээ ингээд яг төсвийн гол заалтуудыг салбаруудын хуваарилалтыг харахаар ерөнхийдөө нийслэл Улаанбаатарын төсөв болбол харьцангуй бага байна уу гэж харагдаад байгаа. Бид нар ингээд манай нийслэлийн гишүүд ингээд төсөв дээр ажиллаад ингээд харахад бол манай нийслэлийн хэмжээнд бол ерөнхийдөө хотыг тойрсон дэд төвүүдийг холбосон олон түвшний огтлол бүхий ийм авто зам гэдэг хамгийн том дэд бүтцийн төсөл байх шиг байгаа. Тэгээд ногоон байгууламжийн төслүүд гээд ерөнхийдөө бол яг манай нийслэлийн хэмжээнд дорвитой томоохон хөрөнгө оруулалт ер нь төдийлөн харагдахгүй байна.

Харин хөдөөгийн сэргэлтийг дэмжих, хөдөөд орон сууц болон худалдан авах, бизнес эрхлэх гээд нэлээд олон салбар дээр болбол хөдөөд чиглэсэн хөрөнгө оруулалтууд санаачилгууд бол байна. Тэр бол сайшаалтай. Тэгэхдээ яг нийслэлийн хувьд түрүүн манай Сангийн яамны нэг албаны хүн хэлсэн байна, 71 төсөл шинээр суусан байгаа гэж. Энийг бас тодруулах шаардлагатай байна. Тэгэхээр нийслэлийн хөрөнгө оруулалтад ер нь тааруу байна шүү гэж бол нийслэлийн гишүүний хувьд бол үзээд байна.

2 дахь асуулт нь ер нь Монгол Улсад орлого олж байгаа хүн болгон татвар төлөх үүрэгтэй. Татвар болбол улсын төсвийн улсын хөгжлийн гол эдийн засгийн эх үүсвэр байдаг. Тийм учраас энэ 24 оны төсөл дээр энэ татварын бодлогыг шинэчлэх, татвар төлөлтөд хяналт тавих, татвар төлдөггүй тодорхой бүлэг ажил мэргэжлийн онцлогууд байгаа. Жишээлбэл нөгөө хувиараа халтуур хийдэг барилгын бригад цехүүд гэдэг юм уу эсвэл таксид явдаг иргэд гэх мэтээр. Дээрээс нь бас нэмж анхаарах зүйл нь энэ онлайн худалдаа асар эрчимжиж байгаа. Онлайнар бараа бүтээгдэхүүн захиалах гадаад дотоодын болон хот хөдөөгийн хооронд гэх мэтээр. Үүнийг дагаад онлайнар явагдаж байгаа мөнгөний эргэлт ч нэмэгдэж байна. Тэр хэрээр бас онлайнд цахим залилангийн гэмт хэргүүд их байна. Онлайн захиалгатай холбоотой.

Тэгэхээр ер нь энэ манай татварын албанаас энэ онлайн худалдаанд бизнес эрхэлж байгаа хүмүүсийн татварын байдалд анализ хийсэн судалгаа дүгнэлтүүд хийх үү? Ер нь энэ татвар төлдөггүй хуучин байж ирсэн бүлгүүд болон шинээр үүсэж байгаа энэ онлайн худалдаа гэх мэт энэ тал дээр татвар төлүүлэлтийн, татварын баазыг өргөжүүлэх ямар арга хэмжээ авах вэ гэдгийг бол онцлон асуух шаардлагатай байна.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Аймаг хот гэж төсвийн хөрөнгө оруулалтыг ингээд талцаж харьцуулж ярих юм болбол Улаанбаатар нийслэл маань хэт том харагдаад бүүр төсвөө тануулчхаж магадгүй шүү. Тэгэхээр энэ төсвийг их бид зөв харьцуулж ярих хэрэгтэй юм байгаа юм. Хэрвээ аймаг аймгаар нь ярих юм болбол зайлуул нэг аймагт нэг 50-аас 100 тэрбум төгрөг л байдаг юм шүү дээ хөрөнгө оруулалт нь нь. Нийслэл дангаараа энэ чинь 3 их наяд шүү. Энийг бага гэж голж болохгүй. Энэ жилийн, ирэх жилийн хөрөнгө оруулалтын 27 хувь нь шүү, 27 хувь нь нийслэл Улаанбаатарт, нийслэл Улаанбаатарт, цаад талын 60 хувь нь 21 аймагт хуваагдаж тавьж байгаа, тавигдаж байгаа гээд л та бодоод үзээрэй. Яах вэ, ингэж ярьдаг юм хүмүүс, ингэж асуугаад байдаг юм. Гэтэл энэ чинь хүн амаа дагадаггүй юм уу гээд 1,5 сая хүн тал нь энд байна шүү дээ гээд. Энэ хөрөнгө оруулалтыг чинь хар аа яг хүн амынхаа хүн ам гэлтгүй ер нь ингээд бодлогоор нь эрэмбэлж тавих хөрөнгө оруулалтууд гэж байна. Мөн жигд хүртээмжтэй тавих хөрөнгө оруулалтууд гэж энэ 2 янз байна.

Жишээ нь боловсролын салбар байна. Боловсролын салбар бол яг хүнээ дагасан ийм хөрөнгө оруулалтууд хийгддэг хамран сурагдалт гээд. Тэр болбол нийслэл Улаанбаатар хөдөө гэж бид нар ялгаж болохгүй. Хаана л иргэд байна тэнд сургууль, соёл, нийгмийн үйлчилгээ очиж байх ёстой. Тэгвэл зам, эрчим хүч байна. Алслагдсан аймгуудад цөөхөн хүн амтай юм байна гээд тэр лүү нарийхан зам тавьж болохгүй. Тийшээ дэд бүтэц, тэнд хүн амьдрах сайхан орчин, бизнес хийх таатай нөхцөлүүдийг нь бүрдүүлэх энэ бүх дэд бүтцээр нь хангаж өгөх ёстой. Тийшээгээ хөрөнгө оруулалтууд бас ингээд тавигдана. Тэгэхээр нийслэлд тавигдаж байгаа энэ хөрөнгө оруулалтыг голж болохгүй шүү.

Төсвийн хөрөнгө оруулалтаар тавигдах мөнгө байна. Улаанбаатар нийслэлийн өөрийнх нь төсөв жил ирэх тусам асар өндөр тэлж байгаа шүү. Ирэх жил 2 их наяд гараад явах нь. Бид нар төсвийнхөө маш том боломжуудыг сүүлийн жилүүдэд нийслэл Улаанбаатар дээр тавьсан. Эхнээсээ үр дүн нь яаж харагдаж байгаа билээ. 500 тэрбум төгрөгийн бид нар бонд гаргах эрхийг нь өгч байгаа. Үүгээр бүтээн байгуулалтуудаа хийх хэрэгтэй. Томоохон дэд бүтэц, зам, метро ч яриад эхэлсэн байгаа. Яагаад болохгүй гэж. Гэхдээ энэ дээр маш зөв сайн ТЭЗҮ дээрээ суух хэрэгтэй. Тэгэхээр нийслэлд хийгдэж байгаа энэ хөрөнгө оруулалтуудыг огт голохгүй шүү.

Тийм учраас гүйцэтгэл сайтай, чанар үр дүнтэй л байх хэрэгтэй гэж би ингэж бодож байна. Тэр ялангуяа сургууль, цэцэрлэг, нийгмийн чиглэлийн хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын тоонуудыг нь Чимидсүрэн дарга дурдаадах даа. Татвар гэж байна. Татварын бодлогын хувьд бид 2019 онд Татварын багц хууль дээрээ нэлээдгүй том өөрчлөлтүүдийг хийсэн. Энэ хуулийнхаа орчинд бид нар ядаж 10 жил явах тогтвортой явах хэрэгтэй, үр дүнг нь үзэх хэрэгтэй. Жил болгон манай улсын ДНБ тэлээд байна, төсөв тэлээд байна, орлого нэмэгдээд байна гэдэг чинь ер нь энэ татварын 19 онд хийгдсэн багц хуулийн өөрчлөлт ер нь нэг сайн үр дүнгээ өгөөд байна гэж бид нар хараад байгаа, өгч байгаа, сайн үр дүнгээ өгч байгаа. Гагцхүү энийг цаашаагаа жигд хүртээмжтэй, ойлгомжтой, ил тод болгох, хүний оролцоог багасгах, цахимжуулах гээд ийм техник ажлуудыг бол бид нэлээн амбицтай ингэж урагшлуулж байгаа.

НӨАТ дээр жишээ нь энэ далд эдийн засгийг ил болгох бид нар гол зорилгууд бол маш амбицтай хийгдэж байгаа юм. Ирэх жил татварын орлого 22 хувиар нэмэгдэж байгаа болбол энэ дотор НӨАТ-ын орлого 33 хувиар нэмэгдэж

байгаа. Энэ маань тэр хэмжээгээр НӨАТ-ын хамрагдалт тэлж байна гэсэн үг. Тэр хэмжээгээр далд эдийн засаг маань илүү их бүртгэлжиж байна гэсэн үг. Тэр хэмжээгээр хүний оролцоо багасаж, цахимжиж байна гэсэн үг юм байгаа юм. Тэгэхээр энэ татварын орчноо бид нэг их айхтар хөндчихгүйхэн шиг 10 жил тогтвортой явъя гэсэн ийм бодлогоор болбол явж байгаа. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нарыг илүү татварын орчинд оруулах, татвар тайлагнадаг.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Дамбын, Жавхлан сайд нэмээд хариулчих.

**Б.Жавхлан:** Тэр Мөнхцэцэг гишүүн хувиараа хөдөлмөр эрхэлдэг улсуудыг татварын орчинд оруулах гээд маш зөв сэдэв хөндсөн учраас энийг би заавал хариулах ёстой. Ирэх жилийн татвар дээр бид нар энэ жижиг бизнес эрхлэгч, хувиараа эрхлэгч нарыг татварын тайлангаа хялбаршуулдаг болгож байгаа шүү. Энэ маш том өөрчлөлт гарна. Өмнө нь бол одоо юу гэдэг юм өөрөө орлогоо тооцоолоод, тэрнийхээ 10 хувийг нь ингээд тайлагнаад төлдөг байсан болбол зөвхөн өөрөө орлогоо и баримтаар тайлагнаад, тэгээд 1 хувиа л төлчих, тэнд тайлан гаргах ямар ч шаардлага байхгүй ингэж хялбаршуулж байгаа. Тийм, тэгэхээр энэ болбол нэлээн том ийм бас суурь тэлэх, хувиараа жижиг бизнес эрхлэгч нарыг татварын орчинд зөв тайлагнадаг, тэр айхтар хүнд суртлаас, том тэр ажил механик ажлуудаас зугтаадаг эд нарыг нь бол хялбаршуулж өгч байгаа шүү тийм. Энэ дотор болбол томоохон тийм эрсдэлтэй хэсэг гэх юм бол мэдээж энэ захууд дээр хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа улсууд, мөн урлагийнхан байна. Урлагийнхан байна, өмгөөлөгч нар байна, лангуун дээр худалдаа эрхэлдэг улсууд байна. Энэ хүмүүсийг далд эдийн засаг гээд нэрлээд байж болохгүй. Харин зүгээр тайлангаа тавьдаг хялбаршуулж өгөх нь л бид нар цахимжуулж өгөх илүү ил тод

ойлгомжтой болгох асуудлыг нь л бид хийж өгөх ёстой юм байгаа юм.

**С.Одонтуяа:** Хэн Чимидцэрэн дарга нэмж хариулах уу? 86.

**Ч.Чимидцэрэн:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд болбол Улаанбаатар хотод 251 төсөл хэрэгжинэ. Түүний төсөвт өртөг нь бол 2,1 их наяд, санхүүжих дүн нь 713 байгаа. Эдгээрийг төслүүдийг тоймлож авч үзэх юм болбол сургууль болбол нийслэлд 39, цэцэрлэг 41, 41 төсөл, эмнэлэг 17, инженерийн байгууламж болбол 12, зам гүүрний байгууламж бол 6 төсөл гэх мэтчилэн нийт болбол 713 тэрбумын санхүүжилт бүхий төслүүд хэрэгжих нь.

**С.Одонтуяа:** Дамбын Батлут гишүүн асуултаа асууна.

**Д.Батлут:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн тухай хууль төсвийн дагаж хамт өргөн мэдүүлсэн хуулиудаас асуултууд байна. Уул уурхайн биржийн хуулийг бид бүхэн батлаад төдийлөн удаагүй байна. Энэ хуулийн үйлчлэлээр Монгол Улсын эдийн засагт томоохон өөрчлөлтүүд бий болсон, Монгол Улсад нэлээн төсөвт нэлээн нэмэх оноо авчирсан ийм хууль болсон гэж харж байгаа юм. Анх удаа төсөв давж биелсэн, түүгээрээ бид нар цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой асуудлуудыг ч гэсэн нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг аваад ажиллаж байгаа. Тэгээд энэ 24 оны улсын төсвийн хуулийн хамт өргөн мэдүүлсэн хууль дотор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд орж ирж л дээ. Тэгээд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг буюу төрийн өмчийн хуулийн этгээдийн борлуулах уул уурхайн бүтээгдэхүүнийг заавал биржээр арилжих зохион байгуулалтад хөндөгдсөн байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын 68 дугаар тогтоолд тусгайлан дурдсан худалдан авагчтай урт хугацаанд нүүрс худалдах, худалдан авах харилцааг Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржийн хуулиар зохицуулах боломжгүй нөхцөл байдал үүсээд байна гээд ингээд оруулчихсан байгаа юм. Уул нь биржийн хуулиар явж байгаа нь ингээд зах зээлийнхээ зарчмаар явж байгаа. Тэгээд энийг уншингуут зах зээлийн зарчмаараа биш, илүү хямд төсөр үнээр нүүрс нийлүүлэх гээд байгаа гэж уншигдаад байна. Тэгэхээр бид нарын нөгөө нэг хууль баталж гаргаад хэрэгжүүлэх гээд байгаа нь өөрөө утга санаа нь алдагдаад явж байна. Энэ хуулийн үйлчлэл, хүчин чадал нь ч гэсэн буураад явж байх жишээтэй. Тэгээд энэ дээр нэг хариулт авмаар байгаа юм. Яагаад ийм зүйлийг оруулж ирж байгаа юм бол гэж. Тэгээд энэ төрийн бодлого ч өөрөө тогтворгүй байх жишээтэй. Алсдаа нэг нүүрс 2 гэдэг хэрэг гарч ирээд бөөн асуудал үүсэх вий дээ нөхдөө. Энэ дээр надад нэг хариулт өгөөч.

2 дугаарт нь эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалтай холбоотой асуудал байгаа. Бид бүхэн бас өнгөрсөн хаврын чуулганаар төрөөс олгох урамшууллаас ЭМД, НДШ-ийг суутган тооцох тухай хуулийн төслийг бүүр баталсан. Энэ хуулийн хэрэгжилт яваад эхэлчихсэн гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ ЭМД, энэ нийгмийн даатгал дээр үүнтэй холбоотой зохицуулалт төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлууд хэрхэн суусан юм бэ? Би яг ингээд харангуут ерөөсөө энэ тухай хөндөгдсөн зүйл алга байна. Энэ тал дээр надад нэг хариулт өгөөч гэж.

3 дугаарт нь эрүүл мэндийн салбар дундаа эрүүл мэндийн салбар нь өөрөө гүйцэтгэлийн санхүүжилтэд ороод төдийлөн удаагүй байна. Эндээс бас ухарч болохгүй гэдэгтэй санал нийлдэг хүний нэг нь би өөрөө. Тэгэхдээ өнөөдөр яг ЭМД-ын ерөнхий газраас санхүүжүүлж байгаа зарчим нь өөрөө тун буруу зарчмаар яваад байгаа. Нэг ёсондоо хийж чадах, хийж

чадаж байгаа үйлчилгээг үзүүлэе гэхээр гэрээ байгуулагдахгүй, танайх хийлгэхгүй гэж Улаанбаатар хот руу төвлөрөл, төвлөрсөн төв эмнэлэг рүүгээ гэрээ контрактууд хийдэг гээд орон нутагт маш их тийм хэл амнууд байгаад байгаа юм. Тэгээд энэ зүйл нь өөрөө энэ төсвийн хүрэлцэхгүй байдлаас шалтгаалж бий болоод байгаа юм болов уу гэдэг зүгээр хардлага байна л даа. Тэгвэл өнөөдрийн энэ төлөвлөснөөрөө өнгөрсөн, энэ онд бид нар 1,6 их наядыг ЭМД-ын санд төлөвлөж байсан бол ирэх онд 2 их наяд давчихсан байна. Энэ төлөвлөлтөөрөө бид нар ирээдүйд ирэх онд энэ гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн дүүрэн хангаж явах боломж бололцоо байгаа гэж харж байгаа юу? Ингээж энэ асуудлыг бид нар шийдэж чадахгүй бол яг үндсэндээ бас гүйцэтгэлийн санхүүжилтэд орно, орно гэж яриад байдаг орон нутагт энэ маань бүрэн дүүрэн хэрэгжиж чадахгүй байгаад байгаа шүү. Үүнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар тун их буруу менежментээр ажиллаж байгаа гэдэг нь харагдаад байгаа юм. Тэгээд энэ тал дээр хариулт авъя.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Чинзориг сайд байна уу? Эрүүл Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас хүн байна уу? Микрофон хэд вэ? 84 Санжаадорж дарга хариулъя.

**М.Санжаадорж:** ЭМД, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Батлут гишүүний асуултад хариулъя. Малчдын төсвөөс авч байгаа урамууллаас нийгмийн даатгал болон ЭМД-ын шимтгэлд тооцох болбол хууль бол ирэх жилээс бол хэрэгжиж эхлэхээр байгаа. Үүнтэй холбоотойгоор бол ЭМД-ын сан дээр бол 2 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын санд бол 5,9 тэрбум төгрөг, нийт 7,9 тэрбум төгрөг болбол төвлөрүүлнэ гэж болбол тооцоо хийсэн байгаа.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Саяын Санжаадорж манай Санжаадоржийн хариулт дээр зүгээр нэмээд хэлэхэд Батлут гишүүнээ санхүүжилтийн буруу бол энэ тэр байхгүй, тогтолцооны буруу бол байхгүй байгаа юм шиг байгаа юм. Зүгээр манай эрүүл мэндийн салбарын маань эрүүл мэндийн үйлчилгээний энэ байршил, хүртээмжтэй л холбоотой асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр бид нөгөө бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөө гэдэг маань бас энэтэй их холбоотой шүү дээ. Бид ба поликлиник клиникийн түвшний үйлчилгээг сум болгонд хийж чадахгүй. Тэгвэл ядаж бүсчлээд аймаг болгонд хийж чаддаггүй юм болбол нөгөө бүсчилсэн хөгжлийн төвүүд дээрээ клиник поликлиник эмчилгээнүүдийгээ тэнд нь нэг сайн барьж байгуулаад, ингээд төлөвлөгөөнийхөө дагуу ойрын хугацаанд бүтээн байгуулалтаа хийж чадваас нөгөө Улаанбаатар луу ирэх төвлөрлүүд чинь тэндээ саарах юм байгаа юм. Тэгээд яг энүүгээрээ үйлчилгээгээ үзүүлээд, санхүүжилтүүд бол яг тэр хэмжээгээр задраад явна л гэсэн үг. Нэгэнт өнөөдрийг хүртэл бид нар ингээд 100 жилийн хугацаанд поликлиникууд нь ер нь ингээд Улаанбаатартаа төвлөрчихжээ. Тэгэхээр чинь эрүүл мэндийн.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Жавхлан сайд та ерөөсөө товч, тодорхой хариулчих. Энэ хүмүүсийг дахиад 5 цаг гээд, та нэмэлт Жавхлан сайд маш товчхон, тодорхой хариулчих. Дараа нь Чинзориг сайд.

**Б.Жавхлан:** Үгүй ээ тэгэхдээ Одонтуяа дарга энэ жилдээ бид нар ганц удаа ярьдаг төсөв дээр гишүүд асууж байгаа юман дээр би бас бүрэн мэдээлэл өгчихмөөр байна. Товчлоод товчлоод болохгүй байна уучлаарай. Харин тэр юутай хилтэй холбоотой, биржтэй холбоотой худалдаа бол ийм шүү Батлут гишүүнээ. Бид биржийнхээ тогтолцооноос хэзээ ч ухарч болохгүй.



Энэ дээрээ болбол тууштай байна. Цаашидаа үр дүн ч гарч байна, Уул уурхайн яам маш сайн хамтарч бидэнтэй ажиллаж байгаа. Энд орж ирсэн тогтоол болбол энэ оны 7 сарын 7-ны 68 дугаар Улсын Их Хурлын тогтоолтой холбоотой тэрний үргэлжлэл шүү. Тэрэн дотор юу гэж байгаа вэ гэхээр Хятад улсын хил доторх Ганц мод боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшиж төрийн өмчит компани болон ЭТТ ХК-ийн хооронд үе шаттайгаар жил бүр 20 сая тонноос доошгүй хэмжээний нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацааны худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрөх гээд Улсын Их Хурлын тогтоолоор ЗГ-т үүрэг өгчихсөн байгаа. Ингэж урт хугацааны худалдан авах гэрээг бид нар чинь биржийн худалдаагаар явуулж болохгүй байгаад байгаа юм. Энэ нэг техникийн шинжтэй юм болчоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хил худалдаа 20 сая тонноос дээш гэж байгаа энэ стратегийн энэ худалдаа маань нөгөө бүтээн байгуулалттай холбоотой шүү дээ. Тэгэхээр энийг бүүр яг нэр заагаад зөвхөн энэ бүтээн байгуулалттай холбоотой энэ нүүрсний худалдааг биржээс гадуур, зах зээлийн нөхцөлөөр ингэж худалдаалж худалдаалъя гэсэн ийм л зохицуулалт юм байгаа юм шүү.

**С.Одонтуяа:** Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** Би Батлут гишүүний асуултад товчхон хариулъя. Ер нь болбол эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанар үр дүнд суурилсан гүйцэтгэл санхүүжилтийн аргаар санхүүжүүлдэг аргад шилжээд бид нар 3 жилийн хугацаа бол боллоо. Гэхдээ би болбол салбарынхандаа та бүхэн энэ 3 жил болсон их бас үр дүнтэй болж байна гэж бас хэлэх бол арай эрт байна шүү л гээд байгаа юм. Яагаад вэ гэхээр бид нар чинь 3 жил ковидын нөхцөл байдалтай байсан. Гүйцэтгэлийн даатгалын сангаас

санхүүжилт авахаас гадна ковидын санхүүжилт гэж асар их хэмжээний санхүүжилт авч байсан. Одоо яг 23 онтойгоо энэ гүйцэтгэлийн санхүүжилт нь бодит амьдрал дээр яг жинхэнэ утгаараа хэрэгжих боломж нь байна уу үгүй юу гэдгийг харах, үнэнтэйгээ нүүр туулах он чинь 23 он шүү гэж хэлээд, 24 он шүү гэж хэлээд байгаа юм.

Яах вэ одоогоор бид нар засах хэд хэдэн юм бол байна Батлут гишүүнээ. Ядаж аймгийн нэгдсэн эмнэлэг БОЭТ төрөлжсөн эмнэлгүүдийг бүгдийг нь нэг адилхан нэг шатлалтай болгоод лавлагаа шатлалын эмнэлэг болгох.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Чинзориг сайд дуустал хариулъя.

**С.Чинзориг:** Энэ нэгдсэн эмнэлгүүд БОЭТ төрөлжсөн эмнэлгүүдийг чинь лавлагаа шатын эмнэлэг болгочихоор асар их тусламж үйлчилгээний давхцал бий болж байгаа асуудлууд байгаа. Орон нутгийн эмнэлгүүд эрүүл мэндийн байгууллагуудын хийж чаддаг тусламж үйлчилгээг төрөлжсөн эмнэлгүүд нь хийдэг ийм асар их давхцал бол байна. Энэтэй холбоотойгоор бид нар санхүүжилтийнхээ аргад өөрчлөлт хийгээд, тарифт нь өөрчлөлт хийгээд, яг орон нутгийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүд хийж чаддаг эмчилгээ энэ тусламж үйлчилгээг орон нутаг хийдэг байх, ахисан түвшний эрсдэлтэй ийм түвшний үйлчилгээг нь төрөлжсөн эмнэлгүүд хийдэг байхаар тарифт нэлээн өөрчлөлтүүд оруулж өгсөн.

2 дахь асуудлууд нь ирэх жилээс бид нар энэ бүсийн коэффициент гэдэг бас цоо шинэ коэффициент бол гаргаж оруулж бий болгоно. Энэ нь ингэснээрээ төвөөсөө алслагдсан, хүн ам багатай сумын эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжих хэвийн үйл ажиллагаа явуулах ийм бас зохицуулалтыг хийж өгөхгүй

болбол бас болохгүй байгаа асуудлууд байгаа. Энэ салбарын онцлогийг харин Сангийн яамныхан маань маш сайн ойлгож, 110 орчим тэрбум төгрөг ЭМД-ын сан дээр болбол нэмэлт зарлага дээр тусгаж өгч байгаа. Үүгээрээ бид нар бүсийн коэффициент гаргаж, алслагдсан, хүн ам цөөтэй сумдын эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүжилтийг хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөл боломжийг нь хангаж өгөх ийм асуудлууд бол хийнэ. Ер нь болбол энэ тарифын өөрчлөлтийг бол тодорхой хугацаанд бас нэлээн шинэчилж байх, өртгийг нь дахиж тооцож байх, тарифыг нь шинэчилж байх тохируулгыг зайлиггүй бас ойр ойрхон хийж байх зайлиггүй шаардлагууд бол байгаа юм билээ гэж бол үзэж байгаа.

Тэр 2023 оны 8 сарын 1-нээс хэрэгжиж эхэлж байгаа энэ 8 дугаар тогтоолоор болбол яг аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум өрхийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг явуулах ийм нөхцөл боломжийг нь нэлээн бас дэмжсэн ийм өөрчлөлт бол хийж байгаа. Тийм учраас нэлээн жсаахан ахиц өөрчлөлтүүд бол гарах болов уу гэж бол бодож байна. Цаашид нэлээн бас тийм бас боловсронгуй болгох, илүү бас сайжруулах юмнууд бол нэлээн бас байгаа гэдгийг бас хэлье.

**С.Одонтуяа:** Батлут гишүүн тодруулъя 1 минут.

**Д.Батлут:** Энэ Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг чинь ингээд уншаад байхаар дандаа ухралт гарчихсан юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Ерөөсөө шууд тэгж ойлгож байгаа. Зах зээлийн үнээр биш хямд үнээр нийлүүлэх гээд байна гээд. Би түрүүн хэлсэн нэг хэсэг хугацааны дараа нүүрс 2 гээд хэрэг үүсчихсэн байх вий дээ нөхдөө. Үүнээс чинь болоод. Бид нар ухралт хийж байна шүү дээ яг үнэндээ. Хууль батлан гаргахын хэрэг юу байгаа юм бэ, тогтоолоор шийдээд байх юм бол. Тэгвэл

хууль энэ тогтоол хоёрын чинь үйлчлэх хүчин чадал ер нь аль нь илүү байх юм. Энэ дээр бүгдээрээ бодох ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ тогтоолоо эргэж харах ёстой байх. Харин зүгээр энэ Биржийн тухай хууль гэдэг зүйлээ эргэж хармаар байгаа юм, юу б8 дугаар тогтоол гэдэг зүйлээ эргэж хармаар байгаа юм. Яг энд одоогийн байгаагаараа бол хямд үнээр нийлүүлэхээр зохицуулалт хийгдэж харагдаж байна шүү. Магадгүй энэ чинь нүүрсний гэх тодотголтой ахиад нэг хэрэг үүссэн, үүсэх вий. Энийгээ бас манайхан анхаараарай гэдгийг хэлье. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Зочид танилцуулаадахъя эхлээд. Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэлийн урилгаар Увс аймгийн оюутан залуучуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Сайд Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

**Ж.Ганбаатар:** Нэгхэн минут хариулаадахъя. Батлут гишүүний болгоомжлол зөв байгаа юм. Тийм ч учраас яг ингэж ойлгогдож байгаа гэж үзэж байгаа учраас Тогтохсүрэн гишүүний ахалж байгаа ажлын хэсэг дээр маргааш энэ дагах хууль чинь маргааш орж ирэх юм. Тэгэхээр энэ дээр засаж байгаа. Тэр буруу ойлгогдоод байгаа зүйлүүдийг нь засаж байгаа. Тийм ч учраас хэрвээ ийм нэг хаалга нээгээд, энэ хаалгаар нь энийг тогтоол гаргаад л яг таны хэлж байгаагаар биржийн биш аргаар нүүрс гараад байх вий гэдэг дээр Уул уурхайн яам энэ болгоомжлолыг бас маш сайн өгч, юу шат шатад нь өгч байсан. Гэхдээ ингээд төсөв дагаад ороод ирэхээр бид бас засуулах гэж байна. Тэгээд маргааш бол Тогтохсүрэн дарга өнөөдөр нөгөө маргааш оруулахдаа засаад оруулчих байх гэж бодож байгаа. Ажлын хэсэг дээр. Та бас ажлын хэсэг дээр саналаа хэлээрэй. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Норовын Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

**Н.Алтанхуяг:** Надад яг 5 асуулт байгаа шүү. Яг тойрохгүйгээр, бултахгүйгээр, худал хэлэхгүйгээр тоонуудыг нь надад хэлж өгөөрэй. 1 дүгээр асуулт. Гадаад өр, дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувь болчихоод байгаа юм бэ? Тэр Жавхлан сайдын ярьж байгаагаар бол 40 хэдэн хувьтай л байгаа гээд байх юм. Энэ НҮБ-ын хүний юу, Хөгжлийн хөтөлбөрийн илтгэл дотор 23 оны байдлаар ДНБ-д эзлэх гадаад өрийн хэмжээ бол 76,2 хувь гэж байгаа. Тэгээд энэ Их Хурлын гишүүдэд үнэн тоо тарааж болохгүй юм байх даа. Эсвэл та тэр 15 оны хуультай холбоотой та нар нэг хэсэг өрөө хасчихаад байх шиг байна. Энэ дээр би тодорхой юм асууж байгаа шүү.

2 дугаарт нь нэг хүнд оногдох гадаад өр хэд вэ? 16 оны сонгуулиар энэ АН-ынхан өр тавьсаар байгаад нэг хүн 15 сая төгрөгийн өртэй болгочихсон гэсэн. Одоо тэр чинь хэрвээ үнэн юм бол миний багцаагаар тооцоход 35 сая төгрөгийн өртэй болчихоод байх шиг байх юм. Тоо хэлнэ шүү, битгий худлаа тайлбар хэлээд байгаарай.

3 дугаарт нь доллар луу шилжүүлсэн дундаж цалин өнөөдөр хэд юм бэ? Одоо 10 хэдэн онтой харьцуулах юм бэ дээ, өнөөдөр чинь арван, 23 гэдэг чинь 13 онтой харьцуулахад 13 онд доллароор шилжүүлсэн дундаж цалин хэд байсан юм, өнөөдөр хэд болчихоод байгаа юм бэ? Өглөөнөөс хойш ингээд суугаад та нарын тараасан материалыг уншихаар албан тасалгааны цонхоор амьдрал үнэхээр сайхан харагдахаар юм яриад байна. Үгүй ээ амьдрал дээр чинь юмны үнэ өсөөд, хүмүүсийн цалин худалдаж авах юмаа худалдаж авч чадахаа больчихсон байгаа шүү дээ. Сүүлийн 3 жилд чинь 21 онд 14 их наяд байсан төсвийн зарлага чинь 3 жилд яг тэр хэмжээгээр өссөн, одоо 27 болж байна шүү дээ. Тэгээд яаж та нар ийм зарлагаа

ихэсгэчихээд, яаж энэ хүмүүсийн цалин хөлсийг нэмээд, яаж тэр долларын ханшийн уналтыг гүйцье гэж байгаа юм бэ? Би ерөөсөө ойлгохгүй байна. Энэ дээр тоо хэлээд өг, хэд вэ? Тоо нь шүү.

4 дэх асуулт нь энэ хэн Ганбат дарга энэ тэр ороод ирчхэж, сайд нь ч хэлэх байх. 50 сая тонн нүүрс гаргачихлаа гээд онгиоод байна. 50 сая тонн нүүрснээсээ яг хэдэн төгрөг олсон юм, хэдэн мөнгө олж ирсэн юм бэ? Хэдэн мөнгөөр орж ирсэн юм, хэд нь оффтейк гэрээгээр явсан юм, хэд нь оффтейк бартераар явсан юм бэ? Тодорхой хэл. 12 онд намайг ажил авахад Хятадын компанитай хийсэн гэрээгээрээ 350 сая долларыг нь аваад идээд уугаад хаячихаад, тэгээд оффтейк гэрээ хаяад явсан шүү дээ. Одоо тэр нүүрсний хулгай гэдэг чинь би ийм л юм хараад байгаа шүү. Тэр нүүрснийхээ сонсголыг хий л дээ та нар.

5 дугаарт нь хүүш миний бүүр толгойд байхгүй тоо яриад, би нэг хүнтэй жаахан маргаж байгаад хаячихлаа. Та нар мэдэж байгаа хүмүүс хэл. 400 гаруй сая тонн нүүрс зарчихсан гээд байх юм, оффтейк янз бүрийн хэлбэрээр. Ганбаатар сайд ажлаа хариуцаж байгаа юм бол яс хэлнэ шүү. Та нар энэ нэг ийм жонхуу, 60 хэдүүлээ сууж байж нэг хэдүүлээ суучихсан, тэгээд нэг өөх ч биш булчирхай ч биш юм ингээд яриад суугаад байх юм. Энэ дээр тодорхой тоонууд надад хэлээд өг. Эхлээд тоогоо тохирч байгаад цаашаагаа яах вэ ийх вэ гэдгээ ярья. Энд ярьж байгаа тоо ард түмний амьдрал хоёрын хооронд тэнгэр газар шиг зөрөө байна. 7 буудлын Должин эмээгийн гэрийн хаалгаар орохгүй юм бол давахгүй юм болбол ямар элэнцгийн юм чинь тоо хэрэгтэй юм бэ? Тэгээд ингээд энэ нэг хэлэлцүүлгээ нэг жаахан идэвхтэй явуулаад өг, баярлалаа.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Жавхлан сайд, дараа нь Ганбаатар сайд.

**Б.Жавхлан:** Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Тодорхой тоо хэлнэ

үү, хэлэлгүй яах вэ. Тэр таны саяын хэлдэг тэр НҮБ-ын тайланд орсон тоог тэрийгээ яаж бүрдүүлж тооцсон юм тэрийг НҮБ-аас л асууя хэдүүлээ. Би тантай бүүр цуг асууя хоёулаа, ямар тоо, хаанаас гаргаад ирчихсэн юм.

2015 онд батлагдсан ЗГ-ын гадаад өрөнд юу юуг оруулж тооцох вэ гээд. Тэр ангиллаараа болбол ирэх жил ЗГ-ын өр ДНБ-ий 42 хувь, энэ жилийн гүйцэтгэлээр бол 45 орчим хувь гарах байх. Тэгэхээр та юуг нэмэх гээд байна вэ? Би бодвол тэр НҮБ-ынхан энэ Монголбанкны өр, аягүй болбол энэ юуг орчихсон оруулчихсан явж байж магадгүй ОТ-н өрийг, Хөгжлийн банкны өрийг эд нар гээд оруулчихсан явж байгаа байх. Тийм. Тэгэхээрээ таны үед батлагдсан тэр хуулиараа л бид нар тооцож ингэж явж байгаа шүү Алтанхуяг гишүүнээ. Ийм байгаа. Өөр юу гэлээ? 1 хүнд ноогдуулж тэгж тооцох болбол тийм үзүүлэлт ер нь байдаггүй шүү дээ. Яах вэ, одоо хувааж механикаар хувааж тооцож харах юм болбол 9 орчим сая төгрөг гарах байх ингээд тооцохоор. Тэрнээс биш бид нар дотоод энэ ЗГ-ын өрийг ялангуяа ДНБ-д харьцуулж энэ тооцдог эрсдэл даах чадварынхаа энэ үзүүлэлтийг л чанд нарийн барих хэрэгтэй, 78 хувьд хүрч байсан шүү дээ. Та санаж байгаа байх тийм ээ хаана, аль л ЗГ-ын үед хүрч байлаа. Энийг ямар ч байсан 42 хувь хүртэл амжилттай бууруулсан.

Энэ гарч байгаа орон зайных нь хэмжээгээр нь тэр хэрээр нь бид нар өр нэмээгүй. Шинэ арилжааны бонд гаргаагүй, сүүлийн жилүүдэд энэ төсвийн алдагдлаар бол өр нэмэгдэж байгаа. Үнэхээр үүгээр бид энэ ковидын хүнд үеийг давж гарлаа. Яах аргагүй тэр бол үнэн. Гэхдээ үр дүнд нь өнөөдөр бид нар эдийн засгийн өсөлтийг бий болгож чадлаа. Энэ л хамгийн чухал юм байгаа юм. Та 7 буудлын Должин эмээ гэж байна. Энэ боломж энэ төсвийн орлогууд харин нэмэгдсэний үр дүнд хэдүүлээ сая 7 сард тодотгол хийлээ шүү дээ. Хамгийн эхний боломжоороо 33 жилийн түүхэнд анх

удаа давсан орлогоороо бид тодотгол хийгээд, тэрүүгээрээ цалин, тэтгэвэр тэтгэмжийг айл руу орууллаа. Төсвийн бодлогын хамгийн гол үр дүн, нөлөө бол энэ шүү дээ. 4,9 их наяд дээр ирэх жилийн төсвийн зарлага нэмэгдэж байгаа юм. Үүний чинь 70 хувь нь цалин тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдэл байгаа. 20 хувь нь хуулиар энийг нэм гээд бүүр заачихсан. Ялангуяа Нийгмийн даатгалын багц хууль байна. Эндээс 485 тэрбум төгрөг орж ирж байгаа юм. Ийм юм байгаа юм. Би танд тоонуудаа хэлээд байгаа юм. Үгүй ээ та тооноос зугтааж болохгүй шүү, тоо хэл гэгчхээд, тоо хэлэхээр тооноос зугтаагаад байх юм.

Цалингийн хэмжээ, одоо цалин дээр би дутуу ярьчихвал Булгантуяа сайд нэмээд хариулаарай. Бид сая энэ нэмэгдлээр 30-аас 40 хувиар нэмсэн байгаа суурь цалингаа. Суурь цалингаа нэмсэн ирэх жил дахиад 10 хувиар нэмэгдэж байгаа. Мөн орон нутгийн ялангуяа нэмэгдлүүд маш сайн өсөж байгаа шүү 20 хувь, 40 хувиар сумд бүр нэмэгдэлтэй. Нэмэгдсэн суурь дээрээ энэ 40 хувийг авчихаар ер нь дундаж цалин 500-аас 700 доллар луу, та заавал доллароор хэлүүлэх гээд байх юм. Доллароор ингэж өсөж очиж байгаа. Тийм. Тооноос хэдүүлээ зугтаахгүй шүү. Тоог цаг хугацаатай нь яривал зугтааж ерөөсөө болохгүй.

**С.Одонтуяа:** Ганбаатар сайд нэмж хариулъя.

**С.Ганбаатар:** Баярлалаа. Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. УУЯ ийм нүүрсийг тэгж зар, тэрийг урт хугацааны гэрээ байгуул, энийг ингэ гэдэг тийм юм ерөөсөө би хийдэггүй. Хэний үед хийж байсан юм мэдэхгүй байна. Ийм юм бол байхгүй. Бид бол сайд болсноосоо хойш юу байна вэ гэхээр нүүрсийг биржээр зарахыг л шаардаж байгаа юм ТӨК-удаас. ТӨК-уд намайг сайд болсноос хойш Биржийн тухай хуульд багтсанаас хойш нэг ч урт хугацааны гэрээ хийгээгүй гэж надад хэлж байгаа. Тэгэхдээ би тэр

компаниудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцоод, тэр гэрээгээ аваад ир, энэ гэрээгээ аваад ир гэдэггүй юм. Энийг чинь өөр энэ чинь тэртээ тэргүй бүрэн эрхт төлөөлөгч тавигдчихсан ажиллаж байгаа шүү дээ. ЭТТ компанийг хэлж байгаа юм. Өнөөдөр 50 сая тонн нүүрс зарлаа, 52 сая тонн хүрч байна 52 сая. Оны эцэст 60 гараад явчих болов уу гэсэн хүлээлттэй бол байна.

**С.Одонтуяа:** Дуусгаж хариулъя, нэмэлтүүд нь дандаа нэг минутаар явж байгаа шүү.

**Ж.Ганбаатар:** Хариулчихъя. Уучлаарай, тэгэхээр тэр 400 сая тонн гэж юу ярьж байгааг би бол ойлгохгүй байна. Хэзээний хугацааны ямар тоо юм бол ойлгохгүй байна. Манайх бол сая 23 оны 36 сая тонн гээд төсөв яагаад, тодотголоороо 50 болж өссөн юм шүү дээ. Тэгээд өнөөдөр 9 сарын байдлаар 50 сая тонн, 52 сая тонн болчихсон явж байна. Тэгээд энэ хэн Ганбат дарга урт хугацааны гэрээ хэнд байгаа юм, хэд байгаа юм, ямар нэгэн байдлаар 4 гэрээ л байгаа. Надад мэдэгдэж байгаагаар бол. Ахиж бол намайг сайд болсноос хойш урт хугацааны гэрээ огт хийгээгүй. Өнөөдөр энэ сая Батлут гишүүний асуусан байгаа тэр төмөр замын холболттой асуудал бол ЗГ-ын тогтоолтой өөр зүйл яригдаж байгааг та сайн анзаарч байгаа байх. Товчхон хариулахад ийм байна.

**С.Одонтуяа:** Ганбат дарга Сангийн яамны ТНБД 82.

**Ж.Ганбат:** Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Ямар нэгэн оффтейк гэрээ яах вэ өнгөрсөн 2022 оны 10 сарын 26 дээр ЭТТ компани дээр онцгой дэглэм тогтоогоод, тэрнээс хойшоо бол ямар нэгэн урт хугацаатай бол оффтейк гэрээ болон урьдчилж ямар нэгэн байдлаар орлого болоод өр төлбөр бол гаднаас бол аваагүй. Яг одоо би энэ онцгой дэглэм тогтоосноос хойших өнөөдрийн энэ оны онцгой дэглэм өнгөрсөн 22 оны 10 сарын 26-наас 23 оны 9 сарын 31-нийг дуусах

хүртэлх хугацаанд 2,9 тэрбум ам.долларын үнэлгээтэй, 29,5 сая тонн нүүрс борлуулсан. Ингээд яг дансандаа нийт борлуулалтын орлого нь бол 2,9 тэрбум доллароос яг дансанд нь бол бид 1,9 тэрбум ам.долларыг бол яг дансандаа бол хүлээж авсан бэлнээр. 468 сая ам.долларыг бол өмнө байгуулчихсан байсан оффтейк гэрээний төлбөрт бол суутган тооцуулсан.

**С.Одонтуяа:** Та тодруулж асуух юм уу? Гүйцээгээд хариулчих Ганбат дарга.

**Ж.Ганбат:** Тийм зөвхөн ЭТТ компанийн хувьд бол би энэ тоон мэдээллийг хэлж байгаа. Үүнээс яг дансанд орж ирсэн 1,9 тэрбум ам.доллароос биржээр бид нар 726,9 сая ам.долларыг нь бол олсон, бусад 1,2 тэрбум доллар нь бол нөгөө өмнө байгуулагдчихсан гэрээний дагуу 4 тонн дээр бол ингэж байсан. 1,9 тэрбум ам.доллароосоо бид Монголбанкинд бол 1,5 тэрбум ам.долларыг нь бол бид бол Монголбанкинд тушаасан байгаа. Урьдчилж олсон орлого гээд 21-ээс 22 он 18 оноос хойшоо ер нь урьдчилж авсан орлого гээд байгаа, энэ дээр нэг яг онцгой дэглэм тогтоох үед 603 сая долларыг энэ урьдчилж олсон орлогыг бол энэ оны 9 сард бол Чалког хамгийн сүүлд төлөөд бол дуусчихсан. Одоо 9 сараас хойшоо бол бид нийт борлуулж байгаа нүүрсний төлбөрийг бол 100 хувь бол дансандаа хүлээж авч, ямар нэгэн урьдчилж олсон орлогын төлбөртөө суутгахгүйгээр ингэж явж байгаа.

**С.Одонтуяа:** Дараагийн хүн Одонгийн Цогтгэрэл гишүүн, та тодруулах юм уу? Тодруулга 1 минут Алтанхуяг гишүүн.

**Н.Алтанхуяг:** Хөөш энэ АН-ын бүлгийнхэн сонсож бай, би тодруулаад ч эд нар хариулахгүй. Та нар анхаарал тавьж байгаад жаахан нэмээд асуу л даа. Ингээд худлаа тоогоор тоглосоор байгаад л жонглёрдсоор байгаад л тэгээд

л гардаг байхгүй юу. Тэр цалин хэд вэ гээд хэлчхэж, хэлээгүй шүү дээ. Доллароор илэрхийлсэн цалин хэд вэ? 13 оны үед 400 гаруй доллар байсан юм. Одоо тэгээд л тэр хавьд л байх шиг байгаа юм. Та ингээд бултдаг байхгүй юу. Би бүүр анхнаасаа сануулж хэлсэн. Яагаад сонгууль болохоор нэг хүн 15 сая төгрөгийн өртэй гэж улс орон даяар зарлаж баахан явчхаад өнөөдөр яагаад тэр тоог хувааж болдоггүй юм бэ? Хуваагаарай 33 сая төгрөгийн өртэй шүү. 33 сая төгрөгийн өртэй. 15 онд Сайханбилэг танайхтай хамтарч Манан-гийн ЗГ байгуулаад, 15 онд зарим зарим төрлийн баталгаа зээлийг энэ оруулж тооцохоо больчихсон хууль гаргачихсан байхгүй юу.

**С.Одонтуяа:** Тодруулгад нэмж хариулъя Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Хэн Булгантуяа сайд цалинтай холбоотой юм нь тодорхой дүн хэлээд хариулчхаарай. Үгүй ээ Алтанхуяг сайдаа та ч гэсэн ингээд толгой эргүүлээд байх юм АН-ын ямар үед нь танд падлийтай, ямар үе нь танд падлийгүй байдаг юм бэ? Тэр календариа бас нэг тодорхой гаргаж хэлж өгөөрэй. Энэ тэр үед баталсан энэ ЗГ-ын өрийг ингээж ингээж тооцно, ингээж ингээж юм оруулна, энийг оруулахгүй гэдэг тэр зарчим чинь л одоо явж байгаа. Таны тэр 33 сая гэж байгаа чинь бодвол Монгол Улсын өрийг яриад байх шиг байна тийм үү? ААН-үүд хувийн компаниудын бүх өрийг нэмээд л тавиад яриад байх шиг байна. Би бол ЗГ-ынхаа өрийг, мэдэж байгаа өрөө л танд би хэлж хэлээд байна. Тийм учраас тийм тэр тоо бол ийм ялгаатай тоо шүү. Тийм. Тэр цалинг Булгантуяа сайд хэлчихнэ.

**С.Одонтуяа:** Булгантуяа сайд доллар луу шилжүүлснээр хариулна шүү гээд байна.

**Х.Булгантуяа:** Алтанхуяг гишүүний хэлж байгаа үнэн. 2012 таньг Ерөнхий сайд байх хавьцаа бол 400 орчим доллар байсан байна дундаж цалин. Сая 2023 оны 7 дугаар сарын 1-нээс төрийн

албан хаагчдын цалинг 40 хувь нэмсэн. Тэр нэмэхээс өмнө 3 дугаар улирлын тоо статистикаас арай гараагүй байна. Одоо үүнийг тооцоод аваад үзэхэд дундаж тайлан сая 900 орчим гээд тэгэхэд 550 хавьцаа байна. Сая 7 сарын 1-нээс нэмэгдээд ер нь бол төрийн албан хаагчдыгаа нэмэхэд хувийн хэвшил ч гэсэн тодорхой хэмжээгээр нэмэгддэг. Тэгэхээр энэ 600 орчим доллар байна уу болж нэмэгдсэн болов уу гэдэг ийм төлөвтэй байна. Тэгэхээр 200 орчим долларын нэмэгдэл орж ирж байна гэж үзэж байна.

**С.Одонтуяа:** Алтанхуяг гишүүн тодруулъя, угаасаа дэгээрээ зөвшөөрч байгаа. Гишүүн 4 минутаас илүүгүй асууна. Нэмэлт асуулт асуух хугацаа нэг минут, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл нэг минутаас илүү хугацаанд нэмэлт асууж тайлбар авч болно гэсэн.

**Н.Алтанхуяг:** Надад өгчих тийм. Хариулъя, хариулдаг л даа, тэгээд худлаа л хариулж болохгүй. Чи худлаа ярьдаг байхгүй юу. Тэгэхээр 16 оны сонгуулиар Монголын ард түмэн мэдэж байгаа. АН-ын тавьсан өр нь нэг хүнд хуваахаар 15 сая төгрөг болдог юм гэж донгосож донгосож баахан хүнийг хуураа биз дээ. Тэгээд одоо тэрүүгээр чинь чи ингээд улайм цайм ингээд худлаа яриад байдаг байхгүй юу. Засгийн өрийг Монголын гадаад нийт өр гэж би 2 өөр өр ярьж байгаа шүү дээ. Та нар бодвол тэр 15 саяыгаа нийт өрөө хувааж гаргасан юм шиг байгаа юм. Өнөөдөр нийт өрөө хуваахаар чинь 33 сая гарна. Тэгээд хаана байгаа юм бэ нөгөө өр төлөөд байсан чинь, өр бол төлсөн, яаж төлсөн юм дандаа зээл авч төлсөн байхгүй юу. Ингээд ард түмэнд ерөөсөө үнэн хэлэхгүй, алхам бүрдээ худал хэлнэ. Үгүй ээ тэгээд төлөөд байсан болбол тэр 15 сая төгрөг чинь ингээд багасдаг юм байгаа биз дээ. 33 болчихсон байхгүй юу. Үгүй ээ ийм юмаа энэ Их Хурал дээрээ ард түмнээсээ нуулгүй ингээд яримаар байна. Та нар сайд царайлчхаад.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя, 1 минут.

**Б.Жавхлан:** Би нэмж хариулъя. Дараа нь Алтанхуяг гишүүн дахиад нэг минут авах байх. Би тэрний дараа дахиад нэг авна шүү. Өрийн асуудлыг сайн ярих юм бол Алтанхуяг гишүүнээ нэлээн удаан ярьж болно. Та бүхний тавьсан Чингис бондын өрийг бид нар арайхийж төлж дууслаа. Та баярлах хэрэгтэй шүү дээ. Тэр Чингис бонд чинь хаана явж байгаа билээ одоо бүгд Хөгжлийн банкин дээр оччихсон, чанаргүй зээл болчихсон байгаа шүү. Харин өмнөөс нь Монголын ард түмний энэ төлсөн татвараар наадах чинь төлж дуусаж байгаа юм. Үгүй ээ таны асуусан асуултад асууж байна шүү дээ, хариулж байна шүү. Та өөрөө яг энийг ийм хариулт нэхсэн учраас. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын ЗГ-ын үед нийтдээ 12 их наяд төгрөгийн бид нар төрийн өрийн зохицуулалт хийсэн. Үүнээс 4,8 нь бол дахин санхүүжилт таны хэлж байгаа. 6 их наяд нь 2 их наяд нь хүү, 4 их наяд нь үндсэн өр төлбөр төлөгдсөн байгаа. Тийм учраас ирэх жил, энэ жил ДНБ.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Минут дууссан шүү. Хамгийн дээд хэмжээнүүдээ өгсөн. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууна.

**О.Цогтгэрэл:** Би, байж байгаарай, минутаа нэмээд өгөөрэй. Сая Ерөнхий сайд төсвийн тухай танилцуулга хийсэн. Төсвийн тухай танилцуулга дээр 2 санаа хэлнэ лээ. Төсөв, төсвийн орлого нэмэгдсэн тул төсөв тэлж байгаа. Нөгөө талд нь авлигатай хэрхэн тэмцэж байгаа тухайгаа. Тэгэхээр энэтэй нь холбож уг нь би өөрөөс нь асуух гэж бодсон юм. Тэгээд одоо нэгэнт байхгүй ч гэсэн энэ асуултыг санал хэлбэрээр бас ингээд хүргүүлбэ. Гол хэлэх гэж байгаа санаа, гол хэлэх гэж байгаа санаа Ерөнхий сайдын энэ авлигатай хийх гэж байгаа тэмцэл, авлигатай хийж байгаа тэмцлийн тэр бодлогын үзүүр нь яг энэ төсөв дээр суух

ёстой байсан юм л гэж би хэлэх гээд байгаа юм. Үнэхээр бодитойгоор төсөвт авлигатай тэмцэж байгаа болбол.

Яагаад гэхээр би 3 тоо л хэлье. Энэ төсөвт төсвийн ДНБ-д эзэлж байгаа хэмжээ түүхэн дээд хэмжээнд хүрчихлээ, 37 хувьд хүрчихлээ. Дахиад энэ төсвийн танилцуулга дээр байгаа нэг тоо, төсвийн ачаалал гэдэг энэ нэг баримт байна. 2016 онд Монгол Улсын энэ эдийн засаг төсвийн ачаалал 20 хувь байсан болбол одоо 32 хувь болох нь. Ард иргэдээс татвараар татварын ачаалал, татвараар цуглуулж авч байгаа ачаалал, татварын эдийн засагт үзүүлж байгаа нөлөөлөл 50 хувь нэмэгдчихсэн байна. Дараагийн нэг тоо нь 2012 онтой харьцуулахад төрийн албан хаагчдын тоо 160 мянгаас 225 болчихлоо. Тэгэхээр энэ төсөв дээр үнэхээр авлигатай тэмцэж байгаа болбол энэ төрийн эзэлж байгаа эдийн засагт тоо хэмжээ чинь ингээж үнэмлэхүй тоонд хүрээд л, төрийн албан хаагчийн тоо үнэмлэхүй дээд хэмжээнд хүрээд л, татварын ачаалал нь 50 хувь нэмэгдээд, үнэхээр авлигатай л тэмцье гэвэл энэ төрөөр шийддэг, дарга нарын гарын үсгээр шийддэг, элдэв янзын хаалттай, хаалтгүй тендерээр шийддэг, шууд нууц гэрээгээр хийгддэг энэ бүх зүйл чинь багасаж байж энэ авлига чинь буурдаггүй юм уу. Энэ мөнгө чинь ингээд энэ авлигыг хэрвээ тэр хорт ургамал гэвэл авлигынхаа хөрсийг тэжээгээд байдаг, төр нь томроод байдаг, төсөв нь томроод байдаг, төрийн албан хаагч нь ихдээд байдаг, татвар нь нэмэгдээд байдаг, ингэжхээд энэ талд нь авлигатай тэмцэнэ гээд байгаа чинь яг ямар бодлого юм бэ? Энэ зүгээр жүжиг юм биш үү?

Үнэхээр та Ерөнхий сайд бодитойгоор авлигатай тэмцэнэ гэж байгаа болбол энэ олон төрийн албан хаагч, энэ татварын ачаалал, эдийн засагт эзэлж байгаа төрийнхөө төсвийнхөө хэмжээг бууруулахгүйгээр энэ бүх авлигын тэмцэл гэдэг чинь зүгээр л жүжиг болж, энэ цаасан дээр бодлого дээр чинь жүжиг болж орж ирээд байна

шүү дээ. Үнэхээр л авлигатай тэмцье гэж байгаа болбол, авлигатай тэмцье гэж байгаа болбол энд дарга нараар шийддэг, элдэв янзын хаалттай, хаалтгүй тендерээр зарладаг, тэр энэ бүхний чинь л үр дүнд тэр ногоон автобус, энэ бүхний үр дүнд тэр нүүрсний тендер хулгай, энэ бүхний үр дүнд тэр төрийн өмчит олон том том хяналтгүй компаниудын санхүүгийн асуудлууд энэний цаана л гарч ирж байгаа шүү дээ.

Тэгэхээр Ерөнхий сайдаас асуух гэж байсан асуулт болбол та авлигатай жинхэнээсээ тэмцээд байгаа юм уу? Нөгөө дүр эсгэсэн, дүр эсгэсэн ардчилал гэдэг шиг дүр эсгэж тэмцээд байгаа юм уу? Энэ бодлогын тэр үзүүр чинь энэ төсөв дээр уг нь суусан болбол бодитойгоороо Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнийн Засгийн газар, Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд бодитойгоороо авлигатай тэмцэж байгаа юм байна гэдэг энэ бодлого харагдах байлаа. Энэ дээрээ хариулт өгөөч гэж л асуух байсан юм. Тэгэхээр нэгэнт өөрөө байхгүй болохоор хариулт хэн нэгнээс хариулт хэрэггүй. Энийг санал гэж ингээд үзээд яваарай. Өөрөөс нь асууя.

**С.Одонтуяа:** Санал гэнэ, өөрөөс нь асууя гэнэ. Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Та их л хол төөрч явна даа. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын ЗГ энэ далд том эдийн засагтай тэмцээд, энэ авлигатай тэмцээд, уул уурхайн энэ том мафиудтай тэмцээд төсвийн орлогоо 4,9 их наядаар 2 жил дамнаад нэмчхээд байгаа юм шүү. Энэ боломжууд өмнө нь ч байсан, өмнө нь ч байсан. Энийг бид нар төсөв рүү татаж оруулж ирж чадсан юм. Авлигатай тэмцсэн, энэ далд эдийн засагтай тэмцсэн, энэ далд эдийн засгийг цааш нь далд авах явж хадгалах гэсэн тэр том хүчтэй тэмцэсний үр дүнд энэ боломжууд гарч ирсэн юм. Энэ боломжийг хамгийн эхний боломжоор нь тэтгэвэр тэтгэмж, цалингаар төсвийн

бодлогоор дамжуулж айл өрхөд оруулсан юм. Та энд хорсоогүй байх гэж би найдаж байна. Ийм үр дүнгүүд гарч байгаа юм шүү. Энэ нь өөрөө төсөв дээр ингээж орж ирж байгаа юм. Цаашидаа ч орно, цаашидаа ч нэмэгдэнэ, цаашидаа ч энэ далд эдийн засгийг ил болгож төсөв дээр оруулж ирнэ. Орлого болгоно, цалин, тэтгэвэр тэтгэмжээр бид зардлаа нэмнэ, айл өрхөд оруулна. Тэр боломж нь энэ юм байгаа юм.

Бид нар нэг ч төгрөгийн, нэг ч хувийн татвар оролд, энэ суурь татварууд дээр бол нэмээгүй шүү. Зөвхөн ХХОАТ өсөн нэмэгдэж байгаа, өндөр орлоготой хэсэг дээр л маш бага хэмжээгээр ингэж нэмэгдсэн байгаа. Энэ төсвийн орлого нэмэгдэж байгаа чинь харин яг таны хэлж байснаас эсрэгээрээ авлигатай тэмцэж, энэ далд эдийн засгийг ил болгосноор татвар төлөлтийн суурь нь нэмэгдсэн байхгүй юу ил тод болоод. Тэр суурь нь нэмэгдээд орлого нэмэгдсэн юм байгаа юм. Энийг та бизнесмен хүн их амархан ойлгож байгаа байх гэж ингэж бодож байна.

Төсөв та рекорд, рекорд гэж л хэлэх юм. Та ДНБ рекорд тогтоогоод амжилттай тэлээд байгааг яагаад дурдахгүй байна вэ? Тэрний чинь 1/3 дээр нь төсөв байсаар л ирсэн, арваад жил явж ирсэн, АН барьж байхад бас л тийм харьцаатай байсан. Тэр харьцаагаа одоо барьсаар л байгаа. 74 их наяд ДНБ болж байна. Үүний 1/3 дээр 35, 36 хувь дээр төсөв маань явж байгаа. Хүн ам өсөж байна. Хүн ам өсөхийн хэрээр төрийн үйлчилгээ бас тэлдэг, тэлдэг. Төрийн үйлчилгээ тэлэхийн хэрээр төрийн албан хаагч нар дээр ачааллууд нэмэгдэж ирж байгаа. Харин энэ дээр бид цаашидаа төрийн албаны тоог илүү цомхон болгох, илүү цахимжуулах энэ бодлогыг бол цаашидаа үргэлжлүүлнэ. Аль болох хувийн хэвшилээр төр хувийн хэвшлийн түншиллээр ч юм уу, энэ боломж бизнесүүдийг нь тийш нь гаргаж өгөөд, хувийн хэвшилээр нь хийлгүүлэх энэ бодлогыг цаашид тогтвортой



үргэлжлүүлнэ гэж ингэж бодож байгаа. Энэний дагуу ч төсөв явж байгаа.

**С.Одонтуяа:** Цогтгэрэл гишүүн тодруулга 1 минут. Цогтгэрэл гишүүн тодруулга 1 минут.

**О.Цогтгэрэл:** Жавхлан сайд тэр тооны өсөлтийн тухай яриад байна. Би тэр хувь процентын өсөлтийн тухай яриад, яриад байна л даа. 2016 онд төсвийн ДНБ-д эзэлж байгаа хэмжээ 20 хэдэн хувь руу орчихсон байсан, 20 хэдэн хувь руу та тэрийг санаж байгаа байх. Өнөөдөр 37 хувь тэгээд их бага тоо биш. Энэ төрөөр шийддэг мөнгө Монголын эдийн засгийн чинь 20 хэдэн хувь байсан нь 37 хувь болчихлоо. Би энэ рекордыг хэлсэн юм, энэ мөнгөн дүн энэ дээр яриагүй. Одоо тэр 27 их наядыг чинь бас яриагүй. Тэгэхээр энэ бүгдийн чинь цаана л энэ Монгол нутаг дээр явж байгаа энэ бүх мөнгөний эргэлтийн чинь дийлэнхийг нь 50 хувийг нь бараг дарга нар шийддэг улам л болоод байдаг, улам томроод байдаг, хувь процент нь нэмэгдээд байдаг. Тэгээд энэ талд нь авлигатай тэмцэнэ гэдэг чинь угаасаа л авлига гарна биз дээ энд, угаасаа л авлига гарна шүү дээ энд. Энд ер нь гайхах зүйл байхгүй шүү дээ. Ингэхээд тэгэхэд Монгол Улсыг бүгдийг нь шоронжуулах л гээгүй юм бол ингэхээд л нэг.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Нэмж хариулах юм уу, болчихсон юм уу? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүн хаана ямар тоо харсан юм бэ дээ. Би энд яг тоогоо хараад л сууж байна. 2000 тийм 2007 оноос эхлээд л 35, 36, 37 дээр тогтвортой ингэж явж ирсэн байгаа. Тэгээд энэ харьцаагаа л бид барьж байгаа. Ер нь бол төсвийн энэ тоотой маргалдаж байхаар бид ДНБ маань нэг хүнд ноогдох үндэсний орлого маань ер нь яаж тэлж байгаа вэ гэдгийг хэдүүлээ их сайн хардаг байх хэрэгтэй шүү. 1990 онд 300 доллар байсан ДНБ нэг хүнд ноогдох үндэсний орлого ирэх жил 6000 долларт хүрнэ. 22 онд 5000 доллар хүрсэн юм, 23

онд 5400 болно, 24 онд 6000 доллар хүрнэ. Бид 2030 он хүртэл буюу энэ дунд хугацааны шинэ сэргэлтийн бодлогын үр дүнд нэг хүнд ногдох үндэсний орлогыг 10 мянган доллар хүрнэ гэж ийм зорилт тавиад ингээд ажиллаад явж байгаа юм. Хэдүүлээ энэ тоон дээрээ ярьж, энэ үр дүн гарч байна уу, энэ.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Наянтайн Ганибал гишүүн асуултаа асууна.

**Н.Ганибал:** Яах вэ ер нь тэгээд сайхан тоонууд оруулж ирсэн байна. Төсвийн маш олон өөдрөг төсөөллүүд энэ дотор явж л байна л даа. Мэдээж нүүрсний хэмжээ 60 сая тонн, зэс 1 аравны сая тонн гээд. Энэ олон сайхан өөдрөг төсөөллүүд маань бид нар энэ эрсдэлээ хэрвээ ямар нэгэн байдлаар энэ тасалдвал бид нар эрсдэлийг яаж даван туулах вэ? Бид нар нэг төсвийн тодотгол гээд нэг ганцхан даван туулдаг аргатай. Тэрнээс өөр ер нь аргачлал байна уу? Энэ дээр та бүхэн ер нь ямар төсөөлөлтэй байдаг юм бэ?

Ер нь сонгуулийн өмнөх жилийн төсөв болгон сонгуулийн дараа Их Хурал шинээр бүрэлдээд хамгийн түрүүнд хийдэг нэг ажил бол төсвийн тодотгол байдаг. Энэ бол бүүр 20 онд ч тэгсэн, түүний 16 онд ч тэгсэн. Тэгэхээр энэ асуудлуудыг бид нар ер нь даван туулах ямар боломж байна вэ? Өнөөдөр бид нар эргээд энэ алдаагаа давтах гээд байгаа юм биш үү дээ гэсэн ийм санаа зоволт байна. Энэ дээр та нар бас яаж төсөөлж, яаж харж байгаа бол гэдэг асуулт байна. Түрүүн бас яриад л байна л даа, зүгээр уг нь асуухгүй байя гэж бодсон. Би бас энэ эргэлзээд байгаа байхгүй юу энэ нэг тоон дээр. Өрийн тухай асуудал байгаа юм л даа. 2020 онд болохоороо Монгол Улсын нийт ЗГ-ын нийт өр бол 25 их наяд байсан гээд тоо байдаг. Тэгээд 24 онд болохоор 35 их наядын өртэй гээд эргээд нэг тоо, та бүхний өргөн барьсан төсөв дээр л байгаа тоо л доо. Энэ 10 их наяд гэдэг нэмэгдсэн энэ өрийн тоо хэмжээг яаж тайлбарлаад байна вэ гээд.

Уг нь сая Ерөнхий сайд мэдээлэлдээ Чингис бонд, хурал юу ямар ямар бонд гэнэ үү, сайхан нэр хэлж байгаад нөгөө олон сайхан нэртэй бондуудыг бол бид нар ингээд өрийг нь дарчхаж байгаа гээд байгаа юм. Цаана нь бид нар ямар нэгэн нэргүй бас ийм өрийн бас тоо хэмжээнүүд нэмэгдээд байна уу л гэсэн асуудлыг сая Алтанхуяг гишүүн тодруулж асуугаад байх шиг байна л даа. Энэ 2 дээр би нэг юу хариулт авчихъя.

Дээрээс нь нэг ийм асуудал байна. Энэ орон нутгийн төсөв дээр улсын төсөв дээр тавигдаад орон нутагт хийгдэж байгаа ажлуудын одоо хийгдэж амжихгүй байгаа, өнөөдрийг хүртэл хийгдээгүй манай Сүхбаатар аймаг дээр гэхэд Эрдэнэцагаан сум дээр 2 барилга байдаг юм. Баяндэлгэр дээр бас 1 барилга байдаг байхгүй юу сум дээр. Тэгээд энэ сумуудыг харахаар дандаа нөгөө 19 онд төсөв дээр тавигдаад, тэгээд яамнууд нь тендерээ зарлаад, тухайн яамнууд нь тендерээ зарлангуут нэг цүнхтэй компани шууд хэлчихье дээ эзэн нь одоо хүртэл олдохгүй тийм компани өнөөдөр тэр ажлыг хийгээд яваад тэр ажлууд эзэн нь олдохгүй байсаар байгаад 4 жил болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлыг хэдүүлээ нэг алдааг эргэж давтахгүй байхын тулд, ер нь хийгдэх ажлын хяналтыг хэн тавьдаг вэ гэхээр орон нутагт байгаа барилгын хяналтын газрууд. Яг орон нутаг тэрийг тендерээ зарлаад, хяналтаа тавиад ажил хийхдээ бол яг тухайн орон нутаг илүү сайн хэрэгжүүлдэг. Яамнууд болохоороо тендерээ зарлаад, тэгээд хаячихна. Тэгээд ингээд энэ асуудлыг та бүхэн бас яг энэ жилийн төсвийн асуудал дээр бас тодотгож авч хэлэлцээд, тухайн орон нутагт нь төсвийг нь шилжүүлээд, түүнийх нь хяналтыг нь тавиулаад ингээд явбал бас манай бидний энэ батлах төсөв маань илүү үр дүнтэй болох байна гэсэн энэ саналыг бас хэлж байна. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт дээр яах вэ санаа зовж байна. Бас бидэнд гадаад эрсдэл байгаа байгаа. Ер нь яах вэ бид дотоод эрсдэлээ болбол нэг ингээд зохицуулаад ингээд нэг ямар ч байсан ноцолдоод ард нь гараад яваад байна. Тийм ээ. Орлого бодитой орлого нэмэгдээд байна гэдэг чинь энэний л үр дүн шүү дээ. Харин гадаад шокийг бол бид нар үнэхээр бас зохицуулж дийлэхгүй юмнууд олон байна. Энэ ковидыг бид яаж дийлэх вэ, энэ дайн тулааныг бид яаж энийг зохицуулалт хийх вэ дээ тийм ээ. Зүгээр гадаад шок нөлөөлөх зүйлийг бол би хэлж мэдэхгүй байна, үнэхээр эрсдэл бол байгаа.

Харин энэ 74 их наяд гэдэг болбол нэлээн бодитой тоо шүү. Түрүүн Цогтгэрэл гишүүн асууж байсан. Тэр жишээ нь бид нар зэс дээр 8 сая 400 энэ жилийнхээ тоон дээр л байгаа, гаргалт биет хэмжээ нь. Үнээ болбол 7386 гэдэг энэ бид нар тэнцвэржүүлсэн үнээр авч орлогоо тооцдог юм шүү. Аль багаар нь зах зээлийн үнэ, тэнцвэржүүлсэн үнээр. Ингээд зэс дээр бол энэ жилийн гаргасан хэмжээгээрээ л гаргая. Үнээ болбол 7386 гээд тэнцвэржүүлсэн бага үнээр нь тооцсон өсөлт. Нүүрс дээр 140, тэнцвэржүүлсэн үнэ бүүр 180 шүү. Тэгээд аль багаар нь 140-өөр нь. 60 сая тонн гэж байгаа нүүрс маань энэ жилийнхээ гаргасан нүүрсийг л хойтон гаргая гэж байгаа. Хятадын коксжих нүүрсний хэрэгцээ 570 орчим. Үүнээсээ 81-ийг нь гаднаас импортоор авъя гэж байгаа юм байна лээ ирэх жил. Тэрнийх нь 55 орчмыг нь бид нар гаргаад нийлүүлье л гэж байгаа. Тэгээд Хятадууд хэлж байгаа шүү дээ. Та нар аваад л ир, аваад ирж чадсан хэмжээгээр чинь бид нар авъя гэж байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ жил 60 сая тонныг гаргаж байна гэдэг нь нөгөө биет хэмжээгээрээ манай тээвэр логистик, хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадвар, хилийн боомтын сэргэлтийн үр дүнд гаргаж

чаддаг болчихлоо. Тэгвэл бид нар эндээс ухарч болохгүй. Ард түмний өмнө нэмж ухралт хийж ийм амлалт өгч болохгүй. Тэгэхээр бид нар одоо ядаж энэ жилийнхээ хэмжээнд хойтон гаргачих юм болбол энэ эдийн засгийн өсөлт маань хангагдана гэсэн үг юм байгаа юм.

Өрөн дээр та бол тоочин хүн энийг ойлгох байх. ДНБ маань өсөлт маань ингээд өсөөд байгаа юм. Тэр хэмжээгээр бид нар өрөө тэрийг гүйцээж тэгж эрсдэл авч өсгөхгүй байгаа л. Абсолют дүн, номинал дүнгээр бол өр өсөж байгаа нь болбол үнэн. Энэ жил 32 их наяд, хойтон 35, 3-аар 3 их наядаар нэмэгдэнэ. Тэрнийх нь 2,1 их наяд нь энэ жилийн өр биш ээ, энэ жилийн уучлаарай, хойтон жилийн алдагдлаар нэмэгдэнэ. Дээрээс нь бид нар Улаанбаатар хотын бондын 500 тэрбум төсөв дээр орж ирнэ. ЗГ-ын өр болж бичигдэнэ. Мөн Дорнодын цахилгаан станц дээр бид нар энэ 50-аас 70 сая долларын ЗГ-ын баталгаа гаргаж таарах байх. Тэрүүгээр өр ингээд нэмэгдэнэ. Ингээд ирэх жилийнх болбол 3 их наядын өр нь бол ингээж нэмэгдэх юм байгаа юм шүү. Энэ маань нөгөө ДНБ-ийхээ өсөлтийнхөө маш бага хувьд харьцаатай байгаа учраас нийт өрийн хэмжээ маань ДНБ-дээ багасаад яваад байгаа гэсэн үг. Тийм. Нөгөө юу тэрийг манай Чимидсүрэн дарга хариулчих. Тодорхой төслүүд асуусан.

**С.Одонтуяа:** 86 Чимидсүрэн дарга.

**Ч.Чимидсүрэн:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Санхүү, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимэдсүрэн. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 2 дугаар сургуулийг та ярьж байна. Энэ удааширалтай төсөл байгаа, 640 суудалтай сургуулийн барилга байгаа, 19 онд эхэлсэн, 39,4 хувийн бол гүйцэтгэлтэй. 19-өөс 22 он хүртэл бол 3,3 тэрбумын санхүүжилтийг болбол авсан байгаа. Энэ төслийг болбол сая энэ 24 онд 3,8 тэрбумаар төсөвт өртгийн

нэмэгдлийг бол Үндэсний аудит баталгаажуулсан. Тэгэхээр төсөвт өртөг нь болбол 8,4 болоод, энэ онд 3,1 тэрбум болбол сууж энэ ажил болбол цааши үргэлжилнэ. Нөгөө төслийн хувьд болбол цэцэрлэгийн барилга байгаа, 200 ортой, мөн 18 онд эхэлсэн. Энэ төслийг бол энэ онд дуусгахаар санхүүжилтийг нь болбол бүрэн тавьсан байгаа.

**С.Одонтуяа:** Наянтайн Ганибал гишүүн тодруулъя 1 минут.

**Н.Ганибал:** Яах вэ тэр Эрдэнэцагааны цэцэрлэг бол энэ төсвөөрөө баригдаж дуусна гэж байхгүй шүү дээ тийм үү? Энэ бол 18 оны төсвөөр, тэгээд дөнгөж суурь нь тавигдсан байдалтай ингээд байгаа. Тэрэн дээр бол бас эргээд магадлал хийгдээд, Боловсролын яамныхан маань энэ дээр бас ажиллах байх гэж найдаж байна. Би нэг юм бас нэг хэлэх гээд байна. Энэ аудитын энэ дүгнэлт бол бас сайн болсон байна. Энэний зөвлөмжүүд хэр явдаг юм бол? Нэн ялангуяа бас тэр Монголбанкны тэр мөнгөний бодлогын асуудлууд 3 одоо ингээд төсөв 3 ингээд нэг уялдаад, тэгээд нэг бодлого нь ингээд зөв болчих юм бол бас бие биеийнхээ зөвлөмжийг сонсдог, бие биеийнхээ тэр гаргаж байгаа тоон мэдээллүүдээ нэгтгээд ингээд явах юм бол бас Монгол Улсын төсөв бас цаашаа явах, зөв болох ийм голдирол харагдаад байгаа юм. Тэгээд энэ дээр та бүхэн маань тэр мөнгөний бодлоготойгоо хэр уялдаж байна вэ? Монголбанк бол би түрүүн хэлсэн л дээ. Нийт ДНБ-ий өсөлт бол 6 хувь гэсэн, ЗГ болохоороо 7 хувь гээд ингээд тоонууд чинь ингээд зөрөөд байгаа.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Аудитын дүгнэлт бол бид нарын хувьд болбол ёстой тангад ном, бидний сурах бичиг шүү. Яг энийгээ л дагаж ажил хичээж ажилладаг. Тэгээд ер нь жил ирэх тусам үүний үр дүн ч

төсөв дээр гарч ирж байна. Манай төсвийн ерөнхийлөн захирагч нарын сахилга бат ч үүний үр дүнд сайжирч байгаа гэж хэлье. Төсөв маань сайжраад байгаагийн нэг гол нууц нь бас энэ шүү. Тийм аудитынхандаа их талархалтай хандаж байгаа.

2 дахь нь юу гэлээ? Тийм. Төсөв, мөнгөний бодлого бол маш сайн уялдаж байгаа Ганибал гишүүнээ. Би маш тийм сонгодог жишээ хэлье. 22 оны төсвийн алдагдал хуулийн хуульд заасан дүнгээсээ 1 их наядаар сайжирч гарсан гүйцэтгэл. Тэр нь мөнгөний хатуу бодлого, төсвийн хэмнэлтийн бодлоготой уялдаж байна гэсэн үг энэ 2. Өөрөөр хэлбэл тэр хэмжээгээр бид нар цалин, тэтгэвэр, бусад халамжийн ч юм уу эсвэл хөрөнгө оруулалтын ч юм уу ийм урсгал зардлаа нэмж болохоор байсан. Мөнгөний бодлоготойгоо уялдуулж төсвөө хумьсан гэсэн үг.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд нэмж хариулна 1 минут.

**Б.Жавхлан:** Ирэх жилийн жишээ нь төсөв дээр 4,9 их наядын энэ нэмэлтийн 3,1 их наяд нь цалин, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой. Ирэх жил бүүр бидэнд хуулиар үүрэг өгчихсөн байгаа. Тэтгэврийг та нар инфляцтай уялдуулж нэм гээд. Энийг бид нар мөнгөний бодлоготойгоо уялдуулж байгаад 1 сарын 1 гэхээр сая 7 сарын нэмэгдэлтэйгээ арай ойртоод байгаа учраас бас болохгүй. Тийм учраас яг Монголбанкныхны хэлж байгаагаар инфляц яг зорилтот түвшиндээ буюу 8 хувьд хүрэх тэр үед 4 сарын 1-нээс тэр цалингийн 10 хувийн нэмэгдлийг оруулж байх жишээтэй. Тийм учраас Мөнгөний бодлоготойгоо аль болох бид нар ингэж уялдуулж төсвөө хийсэн байгаа. Тийм.

**С.Одонтуяа:** Хавдисламын Баделхан гишүүн асуултаа асууна.

**Х.Баделхан:** Баярлалаа. ЗГ-аас зохион байгуулсан шинэ сэргэлтийн

бодлогын ажлын хүрээнд манай экспортын орлого нэмэгдээд, төсөв давж биелэгдэж байгаа. Энэ бол бодит ажлын үр дүн мөн. ДНБ 3 дахин өсөж, 2 дахин өсөж байгаа юм байна. 2 дахин өсөөд, 77 их наяд төгрөг гэдэг бол энэ болбол маш том амжилт. Нэг хүнд ноогдож байгаа ДНБ нь одоо энэ жилдээ 5 мянган доллар хүрээд, ирэх жилдээ 6 мянган доллар хүрнэ гэдэг болбол маш том амжилт. Энэ дээр нэмээд бид нар Монголбанкны гадаад валютын нөөц яг өнөөдрийн байдлаар 4 тэрбум ам.доллар хүрсэн. Энэ болбол ЗГ-аас зохион байгуулсан бодит ажлын үр дүн гээд ингээд үзэж байгаа. Ийм боломж нь жил болгон бидэнд ирэхгүй л дээ.

Тэгээд миний хэлэх гэж байгаа юм болбол яах вэ төсвийн бодлогоо дэмжиж байгаа. Ирэх жил болбол бид нар энэ жил энэ төсвийн орлогын өсөлтийг болбол үр шимийг бол иргэд хүртэж байгаа. Энэ жил бид нар цалин тэтгэвэр тэтгэмжээ нэмсэн. Ирэх жил 4 сарын 1-нээс бол бас нэгнээс бас нэмнэ гэж төсвийн төсөл оруулж ирж байгаа. Энэ болбол бодит үр дүн мөн. Гэхдээ бид нар үргэлж экспортоороо бид нар үргэлж ийм орлого олох боломж байхгүй шүү дээ. Бид нар үйлдвэрлэлээ хөгжүүлмээр байна ер нь цаашидаа. Аж үйлдвэрээ хөгжүүлмээр байна. Өнөөдөр экспортын нийт экспортын 3 хувь нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн гэдэг болбол туйлын хангалтгүй тоо байна. Бид нар 1980-аад оны үед болбол Аж үйлдвэр хөдөө аж ахуйн орон болсон гэж зарлаж байсан шүү дээ. МАА-н гаралтай түүхий эдийг бүгдийг нь бид дотооддоо үйлдвэрлэдэг байсан. Тэр нэхий, савхи, ноос ноолуур бүгдийг нь бид нар өөрсдөө үйлдвэрлэдэг байсан шүү дээ.

Тухайлбал манай аймагт болбол мянган ажилчинтай ноос угаах үйлдвэр байсан. Баруун 5 аймгийн ноосны малын ноосыг аваад угаагаад экспортод гаргадаг. Тэгээд цэмбэний үйлдвэр барьж байгаад, яг ашиглалтад орох даваан дээрээ энэ зах зээлийн давлагаанд ороод хувьчлаад, тэгээд алга болгосон. Тийм

учраас бид нар цаашидаа аж үйлдвэрийг болбол анхаармаар байна. Энэ тал дээр ер нь төр ямар бодлого баримталж барина ер нь? Бид нар сая энэ Ховдын Булганаар дамжаад Хятад орсон. Тэгсэн чинь Хөшөөтийн нүүрсийг аваачаад хил давуулаад угаагаад тэнд олон хүн ажлын байртай болсон, тэгээд цаашаага гаргаж байна. Наад зах нь бид өөрсдөө яагаад угааж гаргаж болдоггүй юм бэ? Ер нь аж үйлдвэрээ, үйлдвэрээ сэргээж сэргэх талаар ер нь ямар бодлого баримталж байгаа юм бэ? Төсвийн бодлого дээр энд тодорхой туссан юм байна уу гэж 1 дүгээрт асуух юм байна.

2 дугаарт хэлэх юм болбол манай аймгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой энэ нисэх буудлын өргөтгөл гэсэн нэг барилга байсан юм. Сүүлийн 2 жил бид нар гишүүдийн саналаар төсөвт оруулаад компани нь тодроогүй, ирэх жилийн төсвөөс хасагдсан байна лээ. Энэ яагаад хасагддаг юм бэ? 2 жилийн дотор Зам, тээвэр яам төсөв нөгөө сонгон шалгаруулж чадаагүй. Тийм учраас энийг бид нар бүх юмаа хийсэн, газрыг нь бэлдсэн байгаа, дахиад хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулаад энэ ажлыг бас хийж өгөөч гэсэн ийм хүсэлт байна. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Баделхан гишүүнийхээ асуултад хариулъя. Та нөгөө шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд аж үйлдвэрийн сэргэлтийн талаар тодруулаа. Тэгэхээр энэ шинэ сэргэлтийн бодлогын энэ 6 зүйл маань хоорондоо маш уялдаа холбоотой. Ялангуяа аж үйлдвэрийн сэргэлт болбол эрчим хүчний сэргэлтгүйгээр гэж бодохын ч хэрэггүй. Аж үйлдвэрийн сэргэлт маань боомтын сэргэлтгүйгээр бас явахгүй. Тийм учраас аль нэгийг нь бид нар зөвхөн сугалж гаргаж ирж явуулахгүйгээр бүгдийг нь зэрэг амжилттай явуулж байж үр дүн гарах ёстой юм байгаа юм. Тэгэхээр өнөөдөр

яах вэ хүрсэн аж үйлдвэрийн энэ өнөөдрийн байдал маань бид бидэнд гологдож байгаа юм. Цаашаагаа илүү их илүү л нэмэх ёстой л гэсэн ийм бидний амбиц байгаа юм. Тэгэхээр бид аж үйлдвэрийн салбарт болбол улс өөрөө хөрөнгө оруулалт хийгээд, ингээд тэлээд байх биш, хувийн хэвшил гадаадын хөрөнгө оруулалт энд хийх боломжуудыг нь бүрдүүлж өгөх ёстой.

Ялангуяа бид нар бодлогын хүрээнд, татварын бодлогын хүрээнд гэхэд. Татварын бодлогын хүрээнд юу байгаа вэ гэхээр энэ жил 23 онд шүү, одоо энэ төсвийн гүйцэтгэлийн жилд бид ХАА-н салбарт боловсруулах чиглэлийн үйлдвэрүүдийг технологийг нь дагасан технологи дагасан тоног төхөөрөмжүүд импортоор орж ирвэл импортын татварыг нь тэглэсэн байгаа. НӨАТ-ыг нь хойшлуулж өгсөн байгаа. Тэгвэл ирэх жил уул уурхайн салбар, уул уурхайн салбар дээр бид боловсруулалтынхаа түвшнийг ахиулахгүй болбол 10 жилийн дараа магадгүй бид экспорт маань багасах ийм эрсдэлтэй байгаа. Тийм учраас бид ялангуяа нүүрс дээр болбол тултал экспортлох хэрэгтэй, үйлдвэрлэх хэрэгтэй, боловсруулалтаа ахиулах хэрэгтэй. Хүдэр дээр бид нар тултал боловсруулалтаа хийх хэрэгтэй. Зэс дээр ч тэр. Ингээд одоо бид уул уурхайн бүтээгдэхүүн боловсруулах аж үйлдвэрийн салбар дээр технологийн тоног төхөөрөмж оруулж ирж байгаа тохиолдолд ирэх жилээс импортын татварыг нь тэглэж байгаа шүү. Бүүр тэглэж байгаа. НӨАТ-ыг нь 4 жил хойшлуулах боломжийг нь бид нар нээж өгч байгаа.

Энэ жил бид нар Аж үйлдвэр паркийн тухай хууль гээд маш ийм сайн хуультай болсон байна. Сайн гэдэг нь байна, маш их эрэлттэй байна. Одоо ингээд л ерөөсөө хууль эхэлсэн, энэ жил бид нар 3 ч аж үйлдвэрийн паркийн зөвшөөрөл гарсан байгаа, өмнийн Дорноговь, Өмнөговьд. Цаашидаа ч гарахаар хүлээгдэж байна. Ингээд бид

нар цаашаагаа эрчим хүчнийхээ сэргэлтээ амжилттай хийгээд, энэ өсөн нэмэгдэж байгаа энэ дотор нь аж үйлдвэр ч орчихсон явж байгаа. Энэ эрэлт хэрэгцээгээ хангах энэ шинэ эх үүсвэрүүдээ барьж байгуулах, ялангуяа сэргээгдэх эрчим хүч дээр. Ингэж чадваас аж үйлдвэрийн салбар маань болбол бодитой сэргэлт гарна гэж ингэж харж байгаа. Тэгээд Баян-Өлгий аймаг дээр тодорхой төслүүд ярилаа. Чимидсүрэн дарга нэмээд хариулаарай.

**С.Одонтуяа:** Чимидсүрэн дарга 86 дугаар микрофон.

**Ч.Чимидсүрэн:** Баделхан гишүүний асуултад хариулъя. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын энэ Өлгий нисэх буудлын өргөтгөлийн барилга бол 22 онд болбол тавигдсан. Ер нь бол нийт төсөвт өртөг нь бол 4,5. Тэгээд 2 жил дараалан энэ төслийн гэрээ байгуулаагүй, ажил нь явагдаагүй учраас 24 оны төсөлд болбол суугаагүй байгаа.

**С.Одонтуяа:** Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асууна.

**Г.Ганболд:** 2024 оны төсвийн орлого нэмэгдээд төсөвт тэлсэн нь авлигатай тэмцсэний үр дүн гэж хэлсэн Ерөнхий сайдын хэлсэнтэй бол би 100 хувь санал нэг байгаа. Тэр дундаа энэ нүүрсний хулгайтай тэмцсэний шууд үр дүн. Сая сайд нарын хэлж байгаагаар бол энэ оны төгсгөл гэхэд 62 орчим сая тонн нүүрс гарна гэж байна. Өнгөрсөн жилүүдээс бараг 2 дахин их. Тэгэхдээ би энэ жил, бид нар энэ жил шинээр уурхай нээгээгүй, шинээр боомт нээгээгүй, өмнө нь гацаатай байсан нөгөө хэдэн боомтоороо л нүүрсээ гаргаж байгаа шүү дээ. Өмнө нь яадаг байсан С зөвшөөрлөөр баахан дарамталдаг эсвэл баахан гацаа үүсгэж байгаад нүүрсний тээврийнхээ үнийг нэмдэг эсвэл зарим боомтуудаар хулгайн нүүрс гардаг байсныг л зогсоосны үр дүн шүү дээ. Тийм учраас бол энэ төсөв бол би цаашидаа ч гэсэн илүү тэлэх юм байна гэж ингэж харж байгаа.

Тэгэхээр төсвийн гол зардлууд орон нутаг руу бол яах вэ Ерөнхий сайд сая очиж орон нутгуудын өмнө тулгамдаж байгаа асуудлыг бол бараг бүрэн шийдсэн. Тэрэн дээр бол ярих юм алга. Гол нь санаа зовж байгаа зүйл бол нийслэл Улаанбаатар хот дээр л жаахан санаа зовж байгаа юм. Өнгөрсөн жилүүдийн нийслэл рүү тавьсан хөрөнгө оруулалтууд үр дүнгүй болж байна. Энэ бол бараг автобусгүй шахуу өвөлжих юм шиг байна. Нийслэлийн шинэ удирдлагууд ирэх оны төсөв дээр нэлээн олон юм оруулж ирж байна. Зам, тээврийн хотын 1 дүгээр орлогч нь болбол бараг энэ өвөл давс цацахгүй, өвлийн зам тавина гээд л яриад байна тийм ээ. Өвлийн зам гэж ямар юм байгаа юм бэ, энийг нэг Зам, тээврийн сайд нэг хариулаад өгөөч.

Тэгээд нийслэл дээр энэ түгжрэл дээр ерөөсөө бид нар энэ уулзваруудынхаа нэвтрэх чадварыг ерөөсөө 1 ч ахиц дэвшил гаргаж энэ огтлолцохгүй уулзвар хийж чадсангүй. Мөнгө төгрөг тавиад ч үр дүн алга. Тэгэхээр ядаж нэг ирэх оны төсөв дээр энэ нэг хиймэл оюун ухаанаар нэг хэдэн уулзваруудаа нэг удирдаад өгөх арга байна уу. Хиймэл оюун ухаанаар. Энэ нийслэлийн чинь уулзварууд дээр эсвэл нөгөө Замын хөдөлгөөний удирдлагын төв дээр хүн байдаг, эсвэл нэг хэдэн замын цагдаа нар гараад л тэгээд л нэг урсгалуудыг нь явуулаад л, заримыг нь гацаагаад л зогсоочхож байгаа байхгүй юу. Үгүй ээ хиймэл оюун ухаан удирдах юм бол ядаж энэ чинь хүний оролцоогүй болоод ирэхээр би түгжрэлийг болбол эрс багасна гэж хараад байгаа шүү дээ.

Өглөөд нь хот руу орж байгаа чиглэл дээрээ гэрлэн дохионууд нь арай түлхүү асдаг, орой гарах хөдөлгөөн дээрээ арай түлхүү асахгүй болбол ингээд нэг хугацааны тохируулгатай, өглөө ч байсан, орой ч байсан нэг цаг хугацаанд ингээд л асаж унтраад байхаар чинь энэ түгжрэл чинь шийдэгдэхгүй байна шүү дээ. Энэ дээр ядаж 5, 3 төгрөг тавиад, энэ түгжрэлийнхээ асуудал дээр

томоохон ахиц дэвшил гаргах боломж байна уу? Энэ дээр одоо нэг энэ нийслэлийн энэ түгжрэлийн асуудал хариуцсан хүмүүс, энэ ЗТЯ-ныхан энэ дээр туршилт хийсэн зүйл байна уу гэдэг дээр нэг хариулт өгөөдхөөч гэж би асуух гээд байгаа юм.

Булгантуяа сайдаас ирэх онд энэ тэтгэвэр тэтгэмж дээр 800 гаруй тэрбум төгрөг нэмэгдэх нь. Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд болбол сая тэтгэврийн нэмэгдлээр нэг доод тэтгэврийн нэмэгдлүүд 50 мянган төгрөг нэмэгдсэн хүмүүс жаахан гомдолтой байгаа. Ирэх онд тэтгэврийг яг индексжүүлж нэмэх юм уу, эсвэл бүх тэтгэвэр авагчид дээрээ тэнцүү хэмжээгээр энэ тэтгэврийг нэмэх үү гэдэг дээр нэг тодорхой хариулт өгөөдхөөч. Уг нь болж өгөх юм болбол яг тэнцүү хэмжээгээр нэмчих юм болбол доод тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тэтгэвэр нэг жаахан нэмэгдээд явбал арай хүмүүстэй илүү үр дүнтэй юм гэж хэлэх гээд байгаа юм. Тэгээд энэ дээр бас нэг сайд нэг тодорхой хариулт өгөөч гэж хэлье.

Эрчим хүчний сайдаас 2, 3 зүйл асууя. Одоо энэ нэг энэ эрчим хүчний энэ тэр дундаа энэ дулааны үнийн асуудал дээр энэ ЭХЯ Эрчим хүчний зохицуулах зөвлөлд нэг жоохон тодорхой арга хэмжээ авмаар байна. Энэ улсын хэмжээнд байгаа энэ 330 гаруй сумын чинь халаалтын зардлууд нь бүгд тус бүрдээ өөр үнэтэй. Зарим нь болбол маш өндөр үнэтэй, зарим нь үлгэн салган өөрсдийгөө аваад явдаг. Энийг нэг жигдэлж нэг тариф руу оруулж явахгүй болбол аймаг орон нутгийн, сум орон нутгийн тариф болгон өөр байгаа нь бол энэ эрчим хүчний салбарт болбол нэлээн хүндрэл.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? ЭХЯ хариулах уу? Тавинбэх дарга ТНБД хариулна I дүгээр микрофон.

**Н.Тавинбэх:** Цахилгаан, дулааны эрчим хүчний үнийг хараат бусаар бие даан шийдвэрлэдэг Эрчим хүчний зохицуулах хороо бий. Эрчим хүчний зохицуулах хороо эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хүсэлтийг үндэслэж үнийг тогтоож байгаа. Тэгэхээр орон нутагт дулааны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хувьд болбол ялгамжтай үнэ байгаа. Энэ зардалтай холбоотой. Жишээлбэл дулааны эрчим хүчний өртгийн 40-өөс 60 хувийг бүрдүүлдэг нүүрс хаанаас авч байгаа байришилтай, нүүрсний өртөгтэй холбоотойгоор гэх мэтчилнээр бусад нүүрсний үнэд шууд нөлөөлдөг зардлуудыг тооцоод үнийг тогтоож байгаа. Тийм учраас дулааны эрчим хүчний үнэ болбол орон нутгаар, засаг захиргааны нэгж болгон дээр бол ялгамжтай байгаа гэдгийг хэлье. Нэгдсэн байдлаар тогтоох бол боломжгүй тийм учраас. Хүсэлт гаргасан тохиолдол болгонд Эрчим хүчний зохицуулах хороо судлаад үндэстэй гэвэл нэмж байгаа. Бас үнийг нэмэхдээ хэрэглэгчийн хэрэглэгчдээс шалтгаалах хүчин зүйлүүдийг тооцдог гэдгийг би хэлье.

**С.Одонтуяа:** Халтар дарга хариулъя 95 дугаар микрофон.

**Л.Халтар:** Ганболд гишүүний асуултад хариулъя. Энэ өвлийн замын тухай асуудал яригдаж байна. Зүгээр Монгол Улсын хэмжээнд бол өвлийн улиралд зориулсан орсон цас хайлдаг ийм зам барьсан туршилага байхгүй, стандарт одоогоор байхгүй байна. Зүгээр нийслэл хотоос стандартын саналыг боловсруулаад ороод ирвэл ЗТХЯ судлаад тэрийг батлаад бодлогын хэмжээнд явуулахад бол асуудал байхгүй. Энийг хэлье. Тэр хиймэл оюун ухаанаар энэ удирдлагын төв дээр гэдэг юм уу уулзваруудыг удирдах асуудал дээр Нийслэлийн Батзориг дарга ирчихсэн байна хариулчих байх.

**С.Одонтуяа:** Батзориг дарга I дүгээр микрофон дээр хариулъя.

**Ч.Батзориг:** Нийслэл Улаанбаатар хотоос Батзориг. Гишүүний асуултад хариулъя. Ер нь болбол ирэх онд бид нар улсын төсөв гэхээсээ илүү Дэлхийн банкны зээлийн 100 сая долларын төсөл явж байгаа. Энэ төсөл дээр 15 сая доллароор зам тээврийн удирдлагын иж бүрэн системийг шинэчлэх асуудал явж байгаа. Энэ дээр бол нийтдээ 55 уулзварыг мөн скада системээр удирдлагын үндсэн панелүүдийг өөрчлөхөөр орж ирсэн. Энэтэй уялдуулаад нийслэл дээр болбол хөдөлгөөн зохион байгуулалтын мөн 20 тэрбум төгрөг тавигдсан байж байгаа. Тэгээд энэ хоёр 24-өөс 25 оны хооронд хэрэгжих Дэлхийн банкны төсөл байгаа. Уулзварын дахин инженерчлэлийн хувьд бол өнгөрсөн оноос энэ онуудад нийтдээ 7 уулзвар дээр шинэчлэлт хийгдсэн. Нийтдээ 4,5 тэрбум төгрөг энэ дээр зарцуулагдсан байгаа.

**С.Одонтуяа:** Булгантуяа сайд хариулъя. Цалин, тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдэл. Жавхлан сайд 1 минут.

**Б.Жавхлан:** Цалин, тэтгэвэр тэтгэмжийг гишүүд маань энэ ном дээрээс сайн харсан байх. Ирэх жил болбол бид энэ жил, ирэх жил ингээд дамнаад цалин тэтгэвэр тэтгэмжийг бол сүүлийн 3 жил бид дорвитой оролдож нэмж чадаагүй байсан. Энийг реформын шинжтэйгээр маш сайн нэмж, энэ төсвийнхөө энэ нэмэгдлийг бүтэн тийш нь зориулсан байгаа шүү гэдгийг тодруулж хэлмээр байна.

Тухайлбал бид энэ жил сая тодотголоороо нийт төрийн албан хаагч нарынхаа цалинг 30-аас 40 хувиар дунджаар нэмсэн. 30-аас 40 хувиар нэмсэн суурин дээрээ ирэх жил орон нутгийн нэмэгдэл ялангуяа орон нутагт төрийн үйлчилгээг илүү чанартай хүртээмжтэй байлгаж байдаг төрийн албан хаагч нарыгаа албан тушаалаас нь үл хамаарч газар зүйн байрлал нь орон нутагт сумд байгаа л болбол шинэ суурин дээрээсээ шууд 40 хувь сум дээр, аймгийн

төв дээр 20 хувь, нөгөө босоо, хэвтээ ялгалгүйгээр шүү. Дээрээс нь.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Жавхлан сайд дуусгаад хариулчих. Минутдаа тааруулаад л хариулах ёстой шүү уг нь.

**Б.Жавхлан:** Одонтуяа даргад баярлалаа. Нийтлэг ТҮ-гийнхэн болбол 10 хувь биш бүүр 20 хувиар нэмэгдэж байгаа. Ингээд цалин, тэтгэвэр тэтгэмжийг болбол их сайн нэмж байгаа. Тэтгэвэр дээр нэг зүйл байгаа, хуульчлаад өгчихсөн байгаа инфляцтай уялдуулж нэмнэ шүү гээд. Тийм учраас бид нар ямар ч байсан 10 хувиар эх үүсвэрээ ингээд төсөвлөөд аваад орж байгаа, хувилж нэмэх үү нэмэх үү, жигд нэмэх үү гэдэг дээр бол 3Г дараа нь төсөв баталсны дараа бодлогоо гаргана. Ер нь юу гэдэг юм 100, 100 мянгаар ижилхэн жигд нэмчихээр нэг бага дээрээ болбол 15-аас 20 хувь, өндөр дээрээ болбол 10 хувь нэмэгдээд явах байх. Гэхдээ энэ болбол 2 талтай шүү. Энэ их зөв шийдэл биш. Бага дээрээ өндөр хувиар нэмэгдээд явчихаар нөгөө багууд нь ингээд дундаж цалин тэтгэвэр авдаг, өндөр цалин тэтгэвэр авдаг руугаа ингээд урт хугацаандаа бол ингээд л ойртоод л байх юм байгаа юм. Энэ чинь дараагийн зовлонгоо нэмнэ. Нөгөө дундаж авдаг байснууд нь би бага тэтгэвэр лүү шилжээд орчихлоо гээд, ингээд дараа дараагийн ингээд буруу тойрог руу яваад орчихоор ер нь болбол ижилхэн хувилаад нэмэх нь хамгийн зөв, шударга юм байгаа юм.

Ер нь өндөр тэтгэвэр авч байгаа улсууд маань төлж байх үедээ болбол аягүй том ачаалал үүрч байгаа хэсэг нь шүү дээ. Тэрүүгээр чинь аваад төлсөн шимтгэлийг нь аваад тэр үед нь тэтгэврийг нь тавьж байсан ийм л ачаалал үүрч явсан улсууд. Тэд нарыгаа торгоод бага хувиар нэмнэ гэж бас болохгүй. Энэ чинь 2 талтай асуудал. Тийм учраас жигд хувилаад нэмэх талдаа болбол миний дотор бодлого шийдэл бол ийм байгаа шүү тийм.



**С.Одонтуяа:** Гочоогийн Ганболд гишүүн тодруулъя 1 минут.

**Г.Ганболд:** Тавинбэх сайдаа би болбол улсын хэмжээнд бүгдээрэнг нь нэг үнэтэй болгоод өг гэж ерөөсөө хэлээгүй. Бүгдээрэнгийнх нь итгэлцүүрийн дагуу л тэр тарифаа хол ойр нүүрсний үнээсээ шалтгаалаад л бүгдийг нь жигд болгоод өг л гэж хэлсэн юм. Сая Учрал сайд ороод ирсэн учраас энэ жил болбол төсөв дээр нэг сайшаалтай нь өмнө нь энэ Харилцаа холбооны яам байгуулагдаад хөдөөг холбоожуулах тал дээр бол төсөв дээр анх удаа мөнгө тавигдаж байна. Өмнө нь бол Нийтийн үүргийн сангаас нэг хэдэн төгрөг тавигдаад л, цөөн тооны энэ хөдөөг холбоожуулах юм явж байсан юм. Энэ жил 20 тэрбум төгрөг тавигдсан байна. Энэ бол сайн. Цаашидаа ер нь болбол энэ Монгол Улсын бүх баг хөдөөг холбоожуулна гэдэг бол их чухал байна. Тэгээд энэ дээр би танд бас Өвөрхангай аймгийн нэлээн олон сумуудын алслагдсан багуудын хүсэлтүүдийг өгсөн. Энэ дээр сум, сум багаараа байхгүй байгаа учраас яг Өвөрхангайн ямар ямар багууд орсон байна вэ? Энэ дээр бас нэмж оруулаад явах боломж байгаа юу? Ер нь бол цаашидаа та зөвхөн энэ төсвөөс гадна Нийтийн үүргийн сан энэ хоёрыгоо нийлүүлж байж энэ холбоожуулах багийнхаа тоог нэмэх.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Учрал сайд хариулах уу? 1 минут шүү.

**Н.Учрал:** Ганболд гишүүний асуултад хариулъя. Энэ жил улсын төсөв дээр энэ үүрэн холбооны сүлжээ байгуулах төсөв суусан. Тэгэхээр анх удаа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бол Үүргийн сангаар тендер зарлахаар нөгөө ашиглалтын зардлыг нь хариуцах гээд нэлээдгүй олон асуудал үүсэж байсан учраас энэ удаа төр хувийн хэвшлийн түншлэлээр үүрэн холбооны сүлжээг нийт 191 багт 2 жилийн хугацаанд оруулж, Монгол Улсын бүх багийг үүрэн холбоонд оруулах ийм зорилт тавьж

байгаа. Ирэх жил болбол бид нар 100 багийг оруулахаар ингэж төлөвлөж байгаа. Үүний 50 хувийнх нь санхүүжилтийг улсын төсвөөр, 50 хувийг нь хувийн хэвшил, бүх нийтийн үүргийн сангаас урсгал зардлыг нь хариуцна. Нийтдээ Тогтохсүрэн гишүүн, Ганболд гишүүн нараас бас энэ багуудын саналууд болбол ирсэн байгаа. Тэгээд энэ багуудыг болбол энэ сүлжээнд холбох ажлыг зохион байгуулах болно.

**С.Одонтуяа:** Минутдаа яг тааруулж хариуллаа, баярлалаа. Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр 24 оны төсвийн тоонууд дээр бол нэг их маргалдаад хэрэггүй байх л даа уг нь бол. Угаасаа энэ авлигал, шударга бус үйл явдал, далд эдийн засгийг ил болгох чиглэлээр тодорхой арга хэмжээнүүд авсан. Яг энэ хэмжээгээр экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээ ч нэмэгдсэн, борлуулж байсан үнэ ч өссөн, энийг дагаад эдийн засагт өсөлт тэлэлт ч бий болж байгаа. Татварын орлогын бааз суурь нэмэгдсэн, орж ирэх төсвийн орлого нэмэгдэж байгаа, энийг дагаад зардлын асуудал яригдаж байгаа. Тэгэхдээ бид орж ирснийгээ зарцуулахдаа бодох ёстой юмнууд байгаад байгаа юм шиг байгаа юм. Би бол тэгж хараад байдаг юм. Тэгэхээр ирээдүйд бидэнд нэмүү өртөг авчрах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, тэгээд татварын бааз суурийг өргөтгүүлэх өргөтгөх энэ салбараа дэмжих асуудал руугаа тодорхой хөрөнгө юмнуудаа чиглүүлж явах ёстой. Энэ тал дээр 24 оны төсөв дээр ер нь ямархуу юм байна вэ? ХАА-н салбар тал дээр бол би зээлийн хүүгийн зөрөө дээр 120 хэдэн тэрбум төгрөгийн асуудал байна гэж ингэж харагдсан. Гадаад зээл тусламжийн хөрөнгийн ашиглалтын хүрээнд энэ ХАА-н салбарыг дэмжих төсөл хөтөлбөрийн асуудал ер нь ямархуу байна вэ гэдэг нэг ийм зүйл байна. Үүнийг бид ер нь нэлээн онцгой анхаарч

ажиллах ёстой юм гэж ингэж хараад байгаа юм.

Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл төсвийг ер нь болж өгвөл алдагдалгүй л баталмаар байгаа. Алдагдал гардаг юм нь юу байх вэ гэхээр зэрэг хөгжлийг дэмжих дэд бүтэц юм уу, эсхүл тэр нэмүү өртөг бүтээдэг, баялаг бүтээх үйл ажиллагааг дэмжсэн зээл тусламж юуны хөрөнгийн хэлбэрээр л төсөв дээр алдагдал гардаг, тэр хэмжээгээр өрийн асуудал яригддаг байж болно. Тэр нь эргээд тодорхой хугацааны ард дээр нөгөөдхийгөө нөхөж чадах ийм бололцоо боломж нь бүрдэх ёстой юм. Тийм учраас 2,1 тэрбум төгрөгийн алдагдлыг ер нь бууруулах бололцоо боломж ер нь байгаа юу? Үүнийг ер нь юу гэж харцгаагаад байна вэ гэж.

Дараагийн нэг зүйл байна. Бид нарын гол бас нэг анхаарах зүйл бол энэ төрийн өмчийн үр өгөөжийн асуудал. Дам дамаа энэ заяагдмал баялаг дээр тулгуурлачихсан төрийн өмчтэй компаниудаас чинь орж ирэх ноогдол ашиг гэдэг юм уу, дивидентийн орлого ер нь хэр хэмжээний юм байгаад байгаа юм бэ? Цаашид энэ эрх зүйн орчныг нь зөв болгож, өмчийн эзэн бий болж байгаа үр өгөөжийнхөө өөрт ноогдох хэсгээ бүрэн авч чаддаг, тэрүүгээрээ дахин хуваарилалтын зарчмаараа тэр хөрөнгө оруулалтын гэдэг юм уу, хөгжлийн гэдэг юм уу, нийгмийн хамгааллын асуудлуудаа шийдэж явдаг энэ тогтолцоо руу шилжих талаар ер нь манай Сангийн яам ер нь ямар байр суурь, ямар бодол байна вэ гэж нэг ийм зүйлийг асуумаар байна гэж.

Бидэнд хийж чадахгүй яриад байгаа нэг зүйл байгаад байгаа юм. Энэ хүүхдийн мөнгө. Энэ бол уг нь халамж биш, хөгжил хуримтлалын л мөнгө баймаар санагдаад байгаа юм. Тэгээд үүнийг ер нь яаж хийнэ гэсэн бодол төсөөлөл байгаад байна вэ? Үүнийг нэг тодорхой асуучихмаар байгаад байдаг.

10 аймгийн дулааны станц Солонгосын зээлийн хөрөнгөөр баригдаж

байгаа. Энэ удааширах өнгөтэй болох гээд байна. Тэгээд одоо нэг хэсэг ажил явчихсан, тэрэнд тодорхой зээл ороод ирчихсэн. Тэгэхээр үүнд бид нар үйлчилгээний төлбөр төлөх үү төлөхгүй юу? Ороод ирчихсэн энэ зээлд тийм. 10 аймгийн дулааны станцад чинь ажил нь дуусаагүй, хөрөнгө ороод ирчихсэн байдаг. Ороод ирчихсэн мөнгөндөө бид үйлчилгээний төлбөр төлөх юм уу төлөхгүй юм уу? Энэ ер нь ямар байр суурь юу байна вэ? Энэ.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тэр ХАА-н салбарын хөнгөлөлттэй зээл хамрагдалтыг нь нэмэгдүүлье гээд ингэж байна. Энэ бол бас 2 талтай шүү Батжаргал гишүүнээ. Би болбол энэ дээр энэ салбарын асуудал нь ер нь олон жил шийдэгдэхгүй, тэгсэн мөртөө хамгийн их боломж, хамгийн төсвийн дэмжлэг авдаг л ийм л салбар. Бүүр энд нь ингээд дасгачихсан. Цаашидаа бид нар энэ жилээс мөн цаашидаа энийг гүйцэтгэлд суурилуулж, үр дүнд суурилуулж, энэ дэмжлэгүүдийг нь явуулдаг болмоор байгаа юм. Яах вэ бид өмнөх жилүүдийн дэмжлэгүүдийг нь ирэх жил үргэлжлүүлж байгаа. Харин цаашидаа буцалтгүй тусламж өгдөг, татвар төлөгчдийн мөнгөөр зээлийн хөнгөлөлтийн зөрөөг нь төлдөг энэ байдлуудыг аль болох хумих хэрэгтэй. Ялангуяа бид ковидын үед болбол үнэхээр бас яг ингэж явахаас өөр аргагүй байсан. Цаашидаа болбол энийг бид хумих ёстой, хумих ёстой.

Харин тэр дэд бүтцийг нь улсаас шийдэж өгөх, ялангуяа хөдөө орон нутагт мал аж ахуй, газар тариалангийн бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлж өгөх зам харилцаа, тээвэр логистик хийх боломж энэ нефтийн бүтээгдэхүүний үнэ тогтвортой байх, эрчим хүчний хангалтыг нь нэмж өгөх гээд ийм дэд бүтцүүд дээрээ л онцгой анхаарах хэрэгтэй. Ирэх жилийн эрчим

хүчний сэргэлт, ирэх жилийн зам тээврийн энэ бүтээн байгуулалтууд бол бүгд яг энэ рүүгээ чиглэнэ. Энэ бол ХАА-н бүтээгдэхүүний өртгийг нь бууруулах, тогтвортой хөгжих ийм боломжуудыг нь бид дэмжиж өгнө гэж ингэж харж байгаа юм. Төсвийн алдагдлыг бид шат дараатай бууруулна. Энийгээ бид бүүр хуульчилчихсан. Гэхдээ ковидын үед 12 хувь хүрсэн төсвийн алдагдлыг бид нар 2 жилийн дотор, 3 жилийн дотор үнэхээр бид нар тэглэж чадахгүй юм байна. Хойтон нь нэлээн буурч ирнэ 24 онд, 25 оноос эхлээд 2 хувиас доош очих ёстой. Ер нь 25 оноос яг энэ төсвийн сахилга батаа бид барьж явж чадваас ер нь төсвийн алдагдлыг тэг рүү ер нь тун ойртуулна даа 25 онд. Дараагийн Сангийн сайд бол их сайн төсвийн суурь хүлээж авна. Ингээд төсвийн алдагдлаа бууруулах энэ бодлогоо үргэлжлүүлбэл 25 онд тэг рүү тун дөхөж очно.

Төрийн өмчийн ногдол ашиг ирэх жил 597 тэрбум болж өсөж байгаа, шат дараатай өсөж байна. Энийг бид нар ТӨБЗГ-т яриад, энэ төрийн өмчийн үйлдвэрийн газруудад хийгдэж байгаа энэ реформ шинэчлэлийн үр дүнд энийг нэмэгдүүлж байгаа. Гэхдээ дорвитой үр дүн бас гараагүй л байгаа. Цаашаагаа улам бид хяналтаа сайжруулах, үр дүнгүй зардал энэ бүх юмыг онцгой анхаарч ажиллах ёстой байгаа юм. Ногдол ашиг дээр гишүүн юу асуулаа. Энэ чинь Солонгосын Эксим банкнаас санхүүжиж байгаа эхний хэдэн жил нь үндсэн төлбөрөөсөө чөлөөлөгдөж байгаа билээ? Хэн хариулах вэ? Ганбат дарга хариулах уу?

**С.Одонтуяа:** Микрофоны дугаар 86 Чимидсүрэн дарга.

**Ч.Чимидсүрэн:** 10 аймгийн дулааны станцын төслийн үйл ажиллагаа болбол нэлээн эрчимтэй болбол хэрэгжиж байгаа. Ингээд зээлээр болбол зөвхөн үйлдвэрийг нь бол барих юм байгаа юм. Тэгээд энэ онд бид нар энэ цахилгаан хангамжтай холбоотой дэд бүтцийнх нь

асуудалд болбол нийт 42,7 тэрбумыг болбол төсөвт өртөг бүхий 18,1 тэрбумын санхүүжилт бүхий болбол санхүүжилтийг бол тавьсан байгаа. Ингээд дэд бүтцийг болбол ямар ч байсан энэ үйлдвэр ашиглалтад ороход Монгол талын хариуцах, өөрөөр хэлбэл үйлдвэрээс хэрэглэгчид рүү хүрэх зардлыг болбол саатуулахгүйгээр бол шийдэхээр болбол зохицуулалт хийгээд явж байгаа. Нэмэлт болбол үйлчилгээний зардал гарах тухай асуудал одоо яригдаагүй. Яагаад гэвэл ашиглалтад орсон үйлдвэр одоогоор бол байхгүй байгаа.

**С.Одонтуяа:** Батжаргал гишүүн тодруулья.

**Ж.Батжаргал:** Үгүй ээ үгүй Монголын талын оролцоо яриагүй. 10 аймгийн чинь дулааны станцын ажил гайгүй эрчимтэй явмаар болсноо удааширчихлаа. Энэний утга учир нь юу байгаа юм? Зээлийн хөрөнгө нь ороод ирчихлээ. Энэний үйлчилгээнд бид нар төлбөр төлөх юм уу үгүй юм уу гэдэг л юм тодруулаад байна. Энийг шуурхайлмаар байна гэж.

Дараагийн нэг тодруулмаар байгаа зүйл бид энэ хөгжлийг дэмжих дэд бүтцийн хүрээнд томоохон, томоохон бүтээн байгуулалт, зам харгүй тавиад байгаа юм. Тэгээд жилд тавигдаж байгаа хөрөнгүүд бага байгаад байна. Одоо жишээ нь Төв аймгийн энэ баруун хойд талын 3 сумыг холбох авто замын ажил энэ жилд тавигдсан хөрөнгө нь 100, 30 орчим тэрбум төгрөг юм билээ. Тэгээд үнийг нэмэгдүүлэх барих бололцоо боломжийн юм ер нь юу байгаа юм бэ? Энэ замуудыг чинь удах тусам дахиад нэмэгдэл зардал гараад байгаа байхгүй юу. Гүйцээж дуусгахгүй удах тусам. Дараа нь Ерөнхий сайд орон нутагт ажиллах үеэрээ бас тодорхой хөрөнгө оруулалтын ажлууд яригдсан. Тэрэн дотор шинээр тавигдах замын зураг төсвийн асуудал яригдсан юм. Одоо.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** 10 аймагт хийгдэж байгаа дулааны станцууд бол ийм шүү Батжаргал гишүүнээ. Солонгосын Эксим банкнаас зээл аваад санхүүжигдээд явж байгаа. Эхний 10 жилдээ үндсэн төлбөрөөсөө төлөгдөх юм. Тэгэхээр 10 жил нь арай болоогүй байгаа учраас станц нь ашиглалтад орсон ч бай, ороогүй ч бай, баригдаж байгаа ч бай үндсэн төлбөр бол болоогүй. Харин авсан хэмжээндээ бол бид нар хүүгээ төлөөд явах юм байгаа юм. Ийм зохицуулалттай. Харин Монголын талын хүлээх үүрэг бид дэд бүтэц, 2 дугаар хэлхээ, газар доогуурх дэд бүтэц хийгээгүй, бүүр эхлээ ч үгүй аймгууд байгаа. Энийг бол энэ ирэх жил бүгдийг нь, бүгдийг нь их бага хэмжээгээр эхлүүлж байгаа, дуусгахыг нь дуусгана. Тэр замуудын талаар нэмэлт мэдээлэл өгөх үү.

**С.Одонтуяа:** Хэн хариулах юм бэ? 86 Чимидсүрэн дарга Сангийн яам.

**Ч.Чимидсүрэн:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Эхлээд тэр Эдийн засгийн хөгжлийн яам дээр ТЭЗҮ зураг төсөвтэй холбогдуулж болбол 23 онд бол 40 тэрбумыг тавьсан. Энэний хэрэгжилт болбол явж байна. 24 оны төсөвт болбол дахиад 40 тэрбумыг тавьсан байгаа. Энэний задаргаа нь болбол төсөв батлагдсаны дараа гарна. Ингэж хариулъя.

**С.Одонтуяа:** Хариулт дутуу байна уу? Халтар сайд хариулах уу? 95 дэд сайд.

**Л.Халтар:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тэр яах вэ манай яамнаас бол аль болохоор дуусгачих юм сан л гэдэг байдлаар төсөвт өртгийг нь ахиухан тавиад л явуулж байгаа юм. Тэгээд Сангийн яаман дээр маань яг очихоор нөгөө тоолдог хэд нь хязгаартай болохоор тэрэндээ зохицуулагдсан байх гэж бодож байна. 2 дугаарт нь тэр

саяын Сангийн яамныхан бас хариулаа. Зураг төсвийн хувьд бол улсын төсөв батлагдаад гараад ирсний дараа Эдийн засгийн хөгжлийн яам руу яам тэр 40 тэрбум төгрөгийн зургуудыг хуваарилах байх, ЗТХЯ бол саналаа явуулчихсан байж байгаа. Ер нь 2024 онд хийх ТЭЗҮ зураг гэсэн юмнуудыг бол саналуудаа явуулчихсан байгаа шүү. Таны ирсэн санал түүн дотор орсон байна гэж.

**С.Одонтуяа:** Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууна.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Би Халтар сайд, Даваасүрэн сайд 2-оос асуулт асууя. Завхан аймгийн Загастайн даваан замыг тухайн үед нь баригдаж дууссаных нь дараа хэлж байсан. Нэг хучилт дутуу байгаа гэж. Тэгэхээр тухайн үед бол манай Халтар сайд юу зөвлөх компаниар нь дүгнэлтээ гаргуулаад, ингээд компанийн дүгнэлтийг үндэслэнэ гэсэн. Компани нь бол нэг хучилт дутуу байна, модон эдлэлээр ярих юм бол лактаагүй орхисонтой яг адил ингэж үлдээсэн гэсэн. Энэ Загастайн даваан зам 67км авто замыг барихад 20 сая доллар, 20 сая гаруй доллар зарцуулсан байж байгаа. Тэгэхээр энэ бол маш их хөрөнгө, хүч орсон ийм том ажил. Тэгэхээр энэ ажлаа илүү сайн олон жил энэ замаа хэрэглэж, эвдрэлгүй гэмтэлгүй авч явахын тулд заавал нэг хучилт хэрэгтэй гэж ярьсан. Өнгөрсөн 2 жилийн төсөв дээр бол энэ орж ирэх ямар ч боломжгүй байсан. Энэ жил бас мэдээж хэцүү байгаа гэдгийг харж байгаа. Гэхдээ энэ дэд сайдын хувьд салбарын сайдаар ажиллаж байсан хүний хувьд энэ Загастайн даваан замын асуудал дээр та нэг мэдээлэл өгөөч. Ямар боломж гарах вэ?

2 дугаарт нь энэ жилийн төсөвт заавал суух ёстой ажил болбол Идэр сумыг төв замтай холбох 12 км авто замын ажил байгаа. Энэ ТЭЗҮ нь хийгдчихсэн, төсөвт суугдчихсан ажил. Энэ хийгдэнэ биз дээ гэдгийг асууя. Мөн энэ ЗГ-аас хэрэгжүүлж байгаа боомтын

сэргэлтийн хүрээнд Арцсуурь боомтоос Нөмрөг хүртэлх 167 км авто замын ажил энэ жил бас хийгдэх ёстой байгаа. Энэ хөрөнгө төсөв мөнгө нь ямар хэлбэрээр суугдаж хийгдэх гэж байна гэдгийг асууя. Мөн Улиастайгаас Алтай хүртэлх 192 км авто зам байгаа. Энэ бол АХБ-ны зээлийн хүрээнд хийгдэх гэж байгаа ийм зам. Өнгөрсөн хаврын чуулганаар Бямбацогт сайдтай энэ асуултыг асуухад Улиастайгаас 100 км эхэлж ингэж явна гэдэг ийм зүйлийг бол хэлсэн байгаа. Тэгэхээр энэ замын асуудал дээр Халтар дэд сайд тодорхой хариулт өгнө үү?

Даваасүрэн сайдаас нэг асуух асуулт байна. Бид Польшийн ЗГ-тай гэрээтэйгээр цэвэрлэх байгууламжийг барьж байгаа. 5 аймагт цэвэрлэх байгууламж шинээр баригдаж байгаагийн нэг нь бол Завхан аймаг байгаа. Тэгэхээр энэ цэвэрлэх байгууламжийг барих асуудалд 1 сая еврогийн юу хөрөнгө дутаж байгаа гэсэн ийм зүйлийг бол Польшийн тал хэлээд эхэллээ. Тэгээд энэ ажлыг бол ерөөсөө гацааж болохгүй. Энэ дээр ямар шийдэл байна вэ? Энэ асуултад хариулт авъя. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Халтар сайд хариулах уу ЗТХ-ийн дэд сайд Халтар. Даваасүрэн сайд эхлээд хариулах юм байна.

**Ц.Даваасүрэн:** Тэр Завханы цэвэрлэх байгууламжийн асуудал дээр түлхүүр гардах гэрээгээр хийгдсэн байсан юм байна. Тэгээд нөгөө экспертиз магадлан хийсний дараа төсөвт өртөг өссөн гэсэн ийм зүйл ярьж байгаа юм байна лээ. Тэгэхдээ энэ төсөвт өртөг өссөн асуудлыг бас бид нар дахиад ер нь Сангийн яам аудитаар оруулж баталгаажуулах ийм асуудал хийгддэг учраас бид нар өссөн гэснээр нь бол шийдэж өгөхгүй, завал хяналт хийнэ. Тийм учраас энэ асуудлыг бид нар Сангийн яаманд тавина. Сангийн яам тэгээд бас тодорхой аудитын газар гэх юм уу магадлан хийлгэх байх. Ингээд аудит

магадлан хийсний дараа үнэхээр энэ өсөлтийн үнэ нь зөв гэж ингэж үзэх юм болбол бид нар Польшийн ЗГ-т нэмэлт санхүүжилтийн асуудал ярих болчихоод байгаа юм дахиад. Тэр нөгөө Дорнодын 10 саяынх болбол Дорнодын цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нь 2 дахин өсөж байгаа учраас тэрэнд зарцуулахад хүсэлтийг болбол тавьчихсан байгаа. Өнөөдрийг хүртэл болбол яг эцсийн шийд бол Польшийн талаас, Сангийн яамнаас бол гараагүй байгаа. Тэгэхээр энэ чинь нэг төвөгтэй юм учрах нь та өөрөө гишүүн хүн мэдэж байгаа. Хэрвээ нэмэлт зээлийн асуудал ярих юм бол дахиад л нөгөө Их Хурлаар 2 удаа орох, соёрхон батлах энэ тэр гэсэн яг л энэ процедураар явах болно. Ийм л хүндрэлүүд гарч болзошгүй байгаа юм. Хэрвээ энэ зээлийн эх үүсвэрээ нэм гэдэг асуудал үүсэх юм бол.

**С.Одонтуяа:** Халтар сайд 95 дугаар микрофон.

**Л.Халтар:** 3 асуулт асуусан гэж ойлголоо. 1 дүгээрт нь Загастайн давааны зам нэг хучилт дутуу гэж, энэ дутуу биш л дээ улсын комисс авчихсан юм. Улсын комисс зургийн дагуу хэрвээ хийгдээгүй дутуу байвал улсын комисс авахгүй. Ер нь зүгээр зарчмын хувьд нэмэлт хучилт гэвэл тийм байж болно. Насанд, замынхаа насжилт, тэгээд аюулгүй байдал бүх юмаа бодоход бол 5, 10, 20 см зузаан байх тусмаа замын нас уртасна. Тийм учраас энэ цаашидаа өртөг мөнгө нь шийдэгдээд ирвэл болох асуудал. Тэгэхдээ бид нар бол 20 жилийн өмнө барьсан зам дээрээ их засвар хийж чадаагүй л байгаа улсууд шүү дээ. Тийм учраас цаашидаа замыг барилгүй яах вэ. Барихын хэрээр хуучин зам дээрээ их засварын асуудлыг бас төлөвлөж явах ёстой гэж.

Идэр сумын 12 км зам манай яамнаас бол явсан. Тэгээд Сангийн яаман дээр маань очоод бас хасагдчихсан байх шиг байна. Тэгээд Сангийн яамныхан хариулт өгчих байх гэж найдаж байна.

3 дугаар асуулт Арцсуурь Нөмрөг чиглэлийн 159,5 км зам энэ өчигдөр юу ЗГ-ын хурлаар ороод.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Дуусгаад хариулчих уу? 95.

**Л.Халтар:** Арцсуурь Нөмрөг чиглэлийн зам концессын зүйл жагсаалтад ороод өчигдөр ЗГ-ын хуралдаанаар батлагдсан. Ингээд концесс зарлагдана. Улиастай Алтай чиглэлийн зам 2024 онд бас АХБ-ны зээлийн хүрээнд шийдэгдээд явна.

**С.Одонтуяа:** Баярсайхан гишүүн тодруулъя.

**Б.Баярсайхан:** Халтар сайдаа хоёулангийнх нь асуусан, хариулсан энэ бичлэг чинь юу байж л байгаа шүү дээ өнгөрсөн жилийн таны сайдаар ажиллаж байх үед. Тэгэхээр манай Загастайн давааны 67 км зам улсын комисс хүлээж авсан нь үнэн. Гэхдээ Увсын замаас ялгаатай нь манайх нимгэн байгаа. Тэгээд энэ чинь том давааны том зам байгаа. Яг одоо ингээд үлдээх юм бол 10 жилийн л баталгаатай гэдгийг Хятадын зам барьсан компани чинь өөрөө хэлчихсэн. Үнэлгээ дүгнэлт хийсэн, хяналт тавьсан компани ч хэлсэн шүү дээ. Тэгэхээр ингэж өөр өөр хариулт бас өгч болохгүй. Энэ бол цаашаа заавал хучигдахгүй бол энэ хайран хөрөнгө байхгүй болно гэсэн үг.

Тэгэхээр би энэ цэвэрлэх байгууламжийг энэ ковидын үед энэ тендер юм нь зарлагдсан, хэлэлцээр нь хийсэн. Одоо яагаад нэмэлт санхүүжилт хэрэгтэй болчихсон юм бэ? Цэвэрлэх байгууламжийн ажил гацах уу, цаашаа явах уу гэдгийг Жавхлан сайдаас бас асуумаар байна. Завхан аймагт хийгдэж байгаа.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Манай Баярсайхан

гишүүн маань мундаг, мундаг. Тэгээд энэ бүүр төсөл бүрээр аймагтаа хийгдэж байгаа асуудлууд дээр бид нартай ингэж ярьж, ингэж хөөцөлдөж байгаа. Энэ дээр үнэхээр яг ганц ийм төсөл ч биш, нэлээн олон төсөл ялангуяа саяын Батжаргал гишүүний асуудаг тэр 10 станц дээр ч гэсэн яг ийм ажил, яг ийм юм тулгараад байгаа юм. Төсөвт өртөг нь бас яг нэмэгдчихсэн. Тэгээд тэрийгээ экспертээр оруулах ёстой, магадлан хийгдэнэ, дараа нь аудит хийгдэнэ. Тэгээд л баталгаажих юм болбол бид тэгээд л зээлийнхээ дүнг нэмэхээс өөр арга байхгүй. Харин тэр болгон Улсын Их Хурлаар орно шүү. Улсын Их Хурлаар орж ирэхэд Баярсайхан гишүүнээ бидэнтэй цуг байгаад дэмжээд өгөөрэй. Бүгдийг нь соёрхон батлуулна тэр нэмэгдлүүдийг, нэг тийм зовлон байгаа шүү.

**С.Одонтуяа:** Даваасүрэн сайд нэмж хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Энэ Завхан, Говьсүмбэр, Увс, Баян-Өлгий гэсэн ийм 4 аймаг дээр байгаа шүү энэ цэвэрлэх байгууламж. Тэгээд дөрвүүлэн дээр нь үнэ нь түлхүүр гардуулах гэрээтэй мөртөө экспертиз хийсний дараа зураг дээр нь, төсөв дээр нь экспертиз хийсний дараа үнэ нь өсчихсэн. Тэгээд одоо нэмэлт санхүүжилт шаардаад байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ нэмэлт санхүүжилтийн асуудлыг бид нар дахиад аудит хийлгээд л, үнэхээр нотлогдох юм болбол энэ үнэ нь өссөн нь болбол үндэслэлтэй байна гэж үзэх юм болбол нэмэлт зээлийн асуудал ярина. Нэмэлт зээлийн асуудал болбол саяын Жавхлан сайдын хэлээд байгаа шиг яг нөгөө процедурын дагуу Их Хурлаар 2 орох болчихож байгаа юм. Тэгэхээр энэ болбол төслийн хэрэгжилтэд удааширах ийм нөхцөл байсан. Зөвхөн энэ төсөл биш юм байна лээ. Улаанбаатарын цэвэрлэх байгууламж, тэгээд л тэр 10 дулааны станцынх энэ тэр гээд эд нар чинь бүгд нөгөө ковидын үед яагаад, тэгээд үнийн өсөлт гарсны дараа бүгдээрээ ийм болчихоод байгаа юм байна лээ. Ер нь болбол ихэнх хэрэгжиж байгаа төслүүд

бүгдээрээ үнийн өсөлтийн нэмэлт шаардаад ингээд жосоохон хэрэгжилт дээр.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьяа:** Өнөөдөр энэ улсын төсвийн анхны хэлэлцүүлэг болж байна. Тэгэхээр энэ төсвийн тэлэлт энэ тэрийн тухай гишүүд янз бүрийн л байр суурьтай байна. Тэгэхдээ би нэг зарчмын нэг 3-хан асуултыг холбогдох хүмүүсээс нь асууя гэж бодож байна. Улсын төсөв батлагдахаас өмнө нь Монгол Улсын Ерөнхий сайд бүх аймгуудаар явж, хөрөнгө оруулалтын жагсаалтаа эрэмбэлсэн байгаа. Энэ эрэмбэлээд тухайн аймгийн ард иргэдэд ийм зүйлд хөрөнгө оруулалт хийнэ гэдгээ ингээд зарласан. Энэ Ерөнхий сайдын тэр эрэмбэлэгдсэн төсөл хөтөлбөрүүд энэ улсын төсөвт, энэ жилийн төсөвт зайлиггүй суух ёстой гэж ойлгож байгаа. Энэ бодлого хэвээрээ байх уу гэдэг талаар нэг хариулт авмаар байна.

Жил бүрийн төсөв дээр хөнгөлөлттэй зээл гэдэг нэрээр их хэмжээний хөрөнгө төвлөрүүлдэг. Ялангуяа энэ өнөөдөр гурил, газар тариалан, ноос ноолуур, арьс шир, мах махан бүтээгдэхүүнийг үнийн өсөлт, бусад зүйлээс сэргийлнэ гэдэг нэрийн доор их хэмжээний хөрөнгө мөнгө төвлөрүүлдэг. Энэ нь ямар ч үр дүн өгдөггүй. Тэгээд хэдхэн тооны компани хувааж авдаг, ийм авлигын схем бий болж байгаа гэж ойлгож байгаа. Энэ дээр энэ төсвийг Ерөнхийлөн захирагчид, төсөв хөрөнгө төвлөрүүлдэг энэ ЗГ ямар бодлого байна вэ? Энэ дээр нэг хариулт авъя.

Дээр нь одоо энд нэг том ноцтой асуудлууд байгаа гэж би ойлгоод байгаа юм. Аливаа төсөв хөтөлбөрүүд хэрэгжээд, улсын төсөв, татвар төлөгчдийн мөнгөөр зураг төсөвгүй ч юм уу ийм юмыг тавьчхаад л байсан л даа. Одоо сүүлд болбол арай гайгүй болсон.

Энэ жилийн төсөв дээр зураг төсөвгүй юм ерөөсөө оруулахгүй гэж байгаа. Гэтэл өнөөдөр ингээд төсөв нь өсөөд байдаг. Тэрэн дээр ямар асуудал байна вэ гэхээр захиалагч тэр завсар нь болбол тэр Барилгын хөгжлийн төв гээд нэг их хуйвалдааны газар байна. Тэрбум тэрбумаар нь төсвийг нь тавьчихдаг. Тэгээд аудит ингэсэн юм гэдэг хариулт тавьдаг. Энэ дээр ер нь ямар дүгнэлт хийж байна вэ, энэ хэр бодитой гэж үзэж байна вэ та нар? Энэ 3 асуулт дээр хариулт авъя.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Адьяа гишүүний асуултад хариулъя. Одоо бид аудитортаа итгэхгүй бол энэнээс цаашаа хэнд итгэх вэ. БХБЯ-ны дэргэдэх Барилгын хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв тэнд тусгай зөвшөөрөл бүхий төсөвчид байдаг, гэрээт байгууллагууд байдаг юм байна лээ. Үүгээр төсөвт өртгүүд баталгаажиж, магадлан хийгдэж ингэж орж ирж байгаа.

Үнэхээр яг ковидын үеийн энэ нэмэгдлүүдийг бид бас ойлгож аль болох ингэж төсөв тусгаад ингээд явж байгаа. Зөвхөн тэнд юу шүү бараа материалын үнийн нэмэгдэл шүү, цалин гээд бид нар бас авч чадаагүй юмнууд зөндөө байгаа. Одоо энэ гадаа жагсаад байгаа тэр барилгачдын зовлон бол бас тийм юм зүйл байгаа. Гэхдээ бид нар бүгдийг нь бид нар ингээд төсөв бас нэмээд авах ачаалал болбол бас их арай л өндөр байгаад байгаа. Гэхдээ ямар ч байсан аудитлагдаад ирснийгээ бид төсөв өргөн барьтал сүүлийн өдөр 29-ний өдрийн ажлын цаг дуустал бид нар хүлээгээд ирснийг нь бүгдийг нь оруулсан байгаа. Нийтдээ энэ чинь төслийн тоо нь, төслийн тоо нь хэд билээ дүн нь болбол төсөвт өртгийн дүн нь бол 863 тэрбум төгрөгийг ямар ч байсан төсөвт багтаасан байгаа. Ийм л зүйл байна одоо.

Тэгэхдээ ингээд нэг нэлээн ард нь гарчхаж байгаа юм, нэлээн ард нь гарчхаж байгаа юм шүү. Тэгэхээр ирэх жилүүдээс бол энэ хөнгөрөөд явчихна. Нөгөө ковидын нэмэгдэл гэдэг юм болбол ингээд нэлээн шингэрчихнэ. Сая харин амжаагүй үлдсэн тэр 50 төслийн 100-гаад тэрбум төгрөгийн асуудал бол байгаа. Тэгж ирэх юм шиг байна лээ. Тэрийг тэгээд бид Улсын Их Хуралдаа өргөн барьчихсан, одоо Улсын Их Хурал дээр ажлын хэсэг дээр л ярилцах хэрэгтэй байх яах вэ гэдгээ тийм. Аудитдаа бид итгэнэ ээ, итгэнэ.

**С.Одонтуяа:** Хариулт хангалттай юу? Тодруулга Адьшаа гишүүн тодруулъя.

**Ш.Адьяа:** Хөдөө орон нутгаар явахдаа тэр хөрөнгө тухайн аймаг орон нутагт хийх хөрөнгө оруулалтаа эрэмбэлсэн. Тэгээд энд тусгахдаа бүх Ерөнхий сайдын эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүд хэрэгжих үү гэж асуусан. Дээр нь энэ хөнгөлөлттэй зээл хэлбэрээр энэ үнийн өсөлт гэдэг юм уу, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжинэ гэдэг нэрийдлээр их хэмжээний мөнгө төвлөрүүлдэг. Тэр тариа будаа ч гэдэг юм уу, мах, ноос ноолуур, арьс шир гэдэг ингээд энэ төвлөрсөн мөнгө чинь эзэндээ очдоггүй шүү дээ. Энэ энийг таслан зогсоох талаар анхаарч байгаа юу? Тэгээд энд нэг том схем болчихсон байна. Энэ схемээ цаашид үргэлжлүүлэх юм уу, таслан зогсоох бодлого явуулах юм уу? Энэ талаар хариултаа авъя.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс хариулах уу? Тэнд 2 номерын микрофон Болорчулуун дарга.

**Ц.Болорчулуун:** Адьяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өнгөрсөн онд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг зарласан. Үүнтэй холбоотойгоор 6 сарын 17-нд Улсын Их Хурлын 36 тогтоолоор энэ хөдөлгөөнийг

хэрэгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөг баталсан байгаа. Энэ 5 жилийн хугацаанд нийтдээ гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах ийм том зорилт энэ хөтөлбөрийг баталсан. Энийг хэрэгжүүлэхэд нийтдээ 5 жилийн хугацаанд 1,7 их наядын санхүүжилт хэрэгтэй гэсэн ийм тооцоо судалгаа гарсан байгаа. Энэ санхүүжилтээс бол улсын төсвөөс 34 хувийг нь, гадаадын зээл тусламжаас 40 гаруй хувийг нь, ААН-үүдийн хөрөнгө оруулалтаас 22 хувийг, хандиваар бол 8 хувийн төсвийг бүрдүүлнэ гэж тусгасан. Үүнтэй холбоотой хүнс, өнгөрсөн жилийн төсөв дээр 135,5 тэрбум төгрөгийн хүүгийн.../минут дуусах/

**С.Одонтуяа:** Гүйцээгээд хариулчих 2 номер.

**Ц.Болорчулуун:** Арилжааны банкны эх үүсвэрт тулгуурласан ийм хөнгөлөлттэй зээлийг гаргаж явж байгаа. Энэ болбол ингээд мэдээж энэ хүнс хүнсний боловсруулах үйлдвэрүүд, газар тариалангийн салбар, МАА-н үйлдвэрлэлд үйл ажиллагаа явуулж байгаа ААН, иргэдийн бол зээл аваад, зээлээ болбол ингээд яг энэ гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нь бүрдүүлэх чиглэлд бол зарцуулалт нь арилжааны банкнуудын зээл дээр тулгуурлаад явж байгаа. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Адьяа гишүүн тодруулъя.

**Ш.Адьяа:** Тэр Ерөнхийлөгчийн хүнсний хөтөлбөртэй холбож би асуугаагүй. Өнөөдөр энэ мах, мах махан бүтээгдэхүүний үнэ үнийг бууруулна гээд өчнөөн мөнгө тавьдаг зээлийн хэлбэрээр. Дээр нь газар тариалангийн салбарт улаан буудайны дэмжлэг үзүүлнэ гээд мөнгө тавьдаг. Тэгээд энэ үнэ нь яагаад буурахгүй байгаа юм, хэд дахин өсөөд байгаа шүү дээ. Тэгээд л тэр жинхэнэ эздэдээ очдоггүй, хэдхэн тооны том компаниуд энийг хуваагаад авчихдаг.



Тэгээд л ийм том авлигын схем байна шүү. Тэгээд энийгээ тэгээд л 1 Ерөнхийлөгчийн хүнсний хангамж гэдэг ийм юман дээр битгий ийм хутгаж яримааргүй байна. Энэ болбол үнэн шүү дээ. Мах нөөцийн мах гээд гаргадаг, хаана махны үнэ унасан юм бэ? Өнөөдөр тэр хүнсний хангамж, газар тариалан, улаан буудайны татаас гээд өгдөг, хаана тэр гурилын үнэ чинь хэд дахин өсөөд байна шүү дээ. Дээр үед бензин шатахууны татаас өгч л байсан. Ийм юман дээр бас бид нар бол бодлоготой хандмаар байна.

**С.Одонтуяа:** Нэмж хариулах уу? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Адьшаа гишүүний асуулт нэмж хариулъя. Энэ 4 жил болбол төсвийн хувьд энэ төсвөөс санхүүжиж байгаа төслүүдийн хувьд бол үнэхээр бас хүнд 4 жил болж байна. Ковидоос болж цаг хугацааны маш их алдагдалд орж байна. Дээрээс нь төсөвт өртөг нь үлэмж хэмжээгээр нэмэгдэж байна. Энд би танд нэг зүйл хэлэх гэсэн юм. Та энэ бүлгийнхээ тэр хэвлэлийн зөвлөх тэр фэйсбүүк юунууд нь сошиалынх нь юу нь Батука гээд нэг залуу байна лээ. Тэрнээсээ очиж сайн асуугаарай. Тэр нөхөр чинь маш сайн мэддэг юм шиг байна. Баахан кино хийж байгаа юм гэсэн. Сангийн сайдаар ажиллаж байсан, ажиллаж байгаа хүмүүсийн тойргууд руу нь очиж кино хийж, энэ гишүүдийг дараагийн сонгуульд нь унагах гэж зохион байгуулалттай ажил хийж байгаа юм гэсэн. Өчигдрөөс эхлээд миний тухай юм хийчихсэн кино цацаад эхэлнэ лээ. Би Дарханд төрсөн. Дарханаас сонгогдсон гишүүнийхээ хувьд Дарханчууд маань хохирох ёсгүй шүү. Тэнд хийгдэж байгаа энэ төсөл, энэ төсвийн арга хэмжээнүүд бүгд хохирч үлдэж.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ Алтанхуяг гишүүн, дээрээс нь Цогтгэрэл гишүүн бас асуулаа л даа. Тэгээд энэ

төсвийн чинь асуудал хэтэрхий данхайлгаад энэнээсээ болоод асуудал үүсээд байна, төсөв чинь хөгжлийн төсөв болж чадахгүй байна л гэж хэлээд байна шүү дээ. Тэгээд энэ төсвийн хүрээний мэдэгдлээ буюу дунд хугацааны бодлогын баримт бичгээ 2021 онд 3 удаа сольсон, 22 онд 2 удаа сольсон, 23 онд 2 удаа сольсон. Тэгээд ингээд энэ байдлаар дунд хугацааны баримт бичгээ ингээд солиод л, тэгээд л айхтар их нүүрс экспортолно гээд л зардлаа нэмээд л ингээд л яваад байдаг. Тэгээд сая 23 оны 5 сарын 31-ний өдөр төсвийн хүрээний мэдэгдлээ батлахдаа 22,9 их наяд төгрөгийн зардалтай байна гэж байгаад, одоо ингээд л 5 их наядаар нэмэгдүүлээд ороод ирж байгаа байхгүй юу даа. Ингэж болохгүй байхгүй юу. Тэгээд энэ чинь ирээдүй хойч үедээ бид нар хадгалж үлдэх ёстой шүү дээ. Жоохон орлого олж байгаа нь үнэн. Нүүрстэй тэнцээний хулгайтай тэнцээний үр дүнд нүүрсний экспорт нэмэгдэж байгаа. Дээрээс нь нүүрсний нөгөө тооных нь үнэ нь бас нэмэгдэж байгаа. Тийм учраас орлого нэмэгдэж байгаа. Тэгэхдээ энийгээ ирээдүйдээ хамгаалах ёстой, хадгалах ёстой байхгүй юу даа.

Хоёрдугаарх нь тэр НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн тайлан дээр байж байгаа шүү дээ. Та тэрийг нэг шүүхэд өгөөч? Өөрөөр хэлбэл Монгол Улсын ЗГ-ын өр ДНБ-ий 76,2 хувьд би тан руу viber-аар явуулаадахъя хөтөлбөрийг нь, тэнцэж байна гээд. Тэгээд энэ чинь тэгсэн мөртөө та нар яг энэ чинь нөгөө хөгжиж байгаа орнуудын дунджаас 28 хувиар илүү байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө та нар яаж байна гэхээр 48 хувьтай байна гэдэг чинь нөгөө нэг энэ хөгжлийн хөтөлбөрийн тайлан танай ЗГ-ын тайлан 2 чинь яг 28 хувиар зөрөөд байгаа байхгүй юу даа. Тэгээд энийг энэ байгууллагаа шүүхэд өгөөч, манай ЗГ-ыг гүтгэж байна гээд. Энэ чинь ЗГ-ын гаргаж өгсөн тайлангийн үр дүн үндсээр л, дээрээс нь ОУВС болон бусад байгууллагуудаас авсан зээлийг л тооцоолж гаргаж гаргаж байгаа шүү дээ. 2 мянга 2016 он.

Халамжийн асуудал байна 3 дахь асуудал. Халамжийн асуудал. 2016 онд 285 тэрбум төгрөгийн халамж өгч байжээ. Монгол Улс тэр чигээрээ 285 тэрбум. Гэтэл 21 онд 2,1 их наядын халамж өгсөн байна. Энэ 2024 онд 2,4 их наяд төгрөгийн халамж тараах гэж байна шүү дээ. Тэгээд нөгөө 16 оныхоос 10 дахин илүү халамж тараагаад, тэгээд ядуурлаас яагаад гарахгүй байгаа юм бэ? Энэ их халамж хаашаа явчхаад байгаа юм бэ? Тэнд нэг хэд хэдэн баялаг бүтээдэг хүмүүс махаа идэж зулгааж нэг хэдэн төгрөг олж, тэрнийгээ татвар юу татвар хураамжаар өгдөг. Тэрийг нь тэгээд ингээд л сонгуулийн халамж болгоод л тэгээд тэнд нэг зорилтот бүлэг хүмүүстээ өгч байгаад л тэгээд сонгууль явдаг ийм л юм руу ингээд явж байна шүү дээ. Тэгээд ерөөсөө ингээд ядуурал халамж тараагаад ядуурлаас гарч байсан ийм орон ерөөсөө байхгүй. Хөгжиж байсан ийм орон байхгүй.

Ер нь бол энэ 24 оны төсөв дээр ер нь дэлхийн улс олонх улсууд төсвөөрөө дамжуулж тэр хувийн сектороо сайн дэмжсэн тэр орнууд нь илүү сайн хөгжөөд байгаа шүү дээ. Гэтэл энэ төсөв дээр чинь энэ хувийн секторыг дэмжсэн ерөөсөө 1 ширхэг ч юм байхгүй байгаа шүү дээ. Дандаа төсвийн урсгал зардлыг л санхүүжүүлсэн тийм л юмнууд явж байгаа. Данхайсан төсөв бий болгох тэр зүйлүүдийг л хийж байгаа.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Төсөвтэй холбоотой хэсгийг нь би хариулъя, халамжтай холбоотой хэсгийг нь сайд хариулна байх. Төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөгдөж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдлийн тоонуудыг Пүрэвдорж гишүүн бол маш сайн мэдэж байгаа. Яагаад гэвэл Төсвийн хяналтын дэд хорооны дарга учраас. Тэгэхээр тэрэн дотор өөрчилж болохгүй 4 тоо байгаа. Тэр нь өөрөөр хэлбэл Төсвийн тогтвортой байдлын хуулийн

тусгай шаардлага дээр байдаг өрийн хязгаар алдагдлын хэмжээ. Мөн шууд гадна талаас авдаг 2 тоо байна, тэр нь эдийн засгийн өсөлт, ДНБ-ий хүрэх тоо гээд ийм 4 тоо бол гадна талаас автомат орж ирдэг тоо шүү. Ингээд үүн дотор байгаа ДНБ-ий хэмжээ ер нь улирал улиралд тооцооллууд их өөрчлөгдөж байгаа шүү. Сүүлийн 4, 3 жил бид нар ер нь ингэж явлаа. Ковидтой холбоотой, дайнтай холбоотой. Энэ болбол зөвхөн биднээс шалтгаалахгүй байна би хэлээд байгаа юм. Гадаад шок, гадаад нөхцөл байдал өөрчлөгдөөд байгаа учраас энийг дагаад манай дотоодын нийт бүтээгдэхүүний хувь хэмжээ өөрчлөгдөөд байна.

Харин дандаа сайн чиглэл рүүгээ өөрчлөгдөж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөгдсөн тухай бүр энэ хувь хэмжээнүүд дандаа сайжирч гарч ирж байгаа шүү. Энэ үр дүнгээр бид нар тооцооллуудаа эндээ тусгаад явахаас өөр арга байхгүй. Тийм учраас ингэж орж ирж байна. Хойтонгоос болбол эдийн засаг маань ч тогтворжоод ирэх байх. Дээрээс нь Эдийн засгийн хөгжлийн яам төсвийн хүрээний мэдэгдлийг оруулдаг болно. Ингээд ер нь нэлээн бид нар сахилга баттай, аятайхан болоод ирэх болов уу л гэж ингэж горьдож хүлээж байгаа. Энийг манай Төсвийн байнгын хорооныхон их сайн эрх зүйн өөрчлөлтүүдийг хийж чадсан байгаа.

Өрийн хэмжээ дээр Пүрэвдорж гишүүнтэй би санал нийлж байна. Гадна талд болбол нэг ийм өөр, өөр тоонууд яваад байдаг юм. Олон улсын сан валютын сан бас манай ЗГ-ын өрийг ярихдаа бид нараас өөрөөр яриад байдаг юм шүү дээ. Тайланд нь жоохон өөрөөр ордог юм. Тэд өөрсдийнхөө аргачлалаар бүх зөвхөн манайхыг биши бүх улс орнуудын ЗГ-ын өр нь ер нь бол зөрдөг. Зөрдөг ялангуяа хөгжиж байгаа орнуудынх болбол нэлээн зөрөөтэй гараад байдаг юм. Тэд нар өөрсдийнхөө аргачлалаар нэлээн тийм нэлээн байж болох бүх юмыг л хамж оруулаад ингээд

тооцчихдог учраас бид нарын тооцдоогоос бас нэлээн өндөр гараад байдаг. Тэр болгонтой нь тэгээд шүүхдээд байх нь ч хаашаа юм. Ер нь болбол тэр тоон дээр нь энд байгаа суурин төлөөлөгчдөө бид нар хандаж ярилцана. Тэгээд яах эсэхээ шийдээд танд бас мэдээлэл өгнө. Халамжтай холбоотой хэсгийг нь.

**С.Одонтуяа:** Хэн хариулах юм бэ? Булгантуяа сайд уу?

**Х.Булгантуяа:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Халамжийн маань ихэнх нь хүүхдийн мөнгө байгаад байгаа юм. Хүүхдийн мөнгийг 2010, 20 оноос авхуулаад та мэдэж байгаа 5 дахин нэмэгдүүлсэн. Хүн амын өсөлттэй холбоотойгоор жил болгон хүүхдийн тоо бол нэмэгддэг. Тэгэхээр үүний халамжийн өсөлтийн ерөөсөө хамгийн том юм нь хүүхдийн мөнгө байгаа. Та өөрөө ч гэсэндээ хүүхдийн мөнгийг хасах ёсгүй гэж ярьдаг хүмүүсийн нэг. Ер нь төсвийн нийт урсгал зардлын 2024 онд 21,3 их наяд байгаагаас 60 орчим нь төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбар байгаа. Тэгэхээр эдгээр нэн чухал салбаруудыг бид нар санхүүжүүлэхээс өөр аргагүй гэж бодож байгаа юм. Шинээр нэр төрлийн халамж бол үүсгээгүй. Халамжлалтын харин хамрагдалтын хэмээг бол бууруулсан.

Гэхдээ нэн шаардлагатай зарим халамжуудыг бол нэмсэн. Жишээлбэл нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй хүнд олгодог халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Дуусгаад хариулчих. Үгүй ээ үгүй эхнийх нь 4 минут тэгээд нэмэлт 1.

**Х.Булгантуяа:** 288 мянган төгрөг байсныг 325 мянган төгрөг болгож

нэмэгдүүлсэн. Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж гэж байдаг. Энэ нь бол хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа шаардлагатай хүмүүст олгодог. Ихэнхдээ эцэг нь юм уу эх нь ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй ингээд асардаг. Энэ 84500 төгрөг байсан. Хүүхдээ асарч байгаа бол 123100 төгрөг байсан сард. Үүнийг бид нар 2-оос 3 дахин нэмэгдүүлж 275 мянган төгрөг болгосон. Энэ бол нэн шаардлагатай халамж. Тэгээд нэмэгдсэн гэх юм бол иймэрхүү л өнөөдөр халамжийг бид нар 2023 оны онд нэмэгдсэн. Энэ бол ирэх онд ахиад 10 хувиар нэмэгдээд явж байгаа. Эдгээр энэ гол шаардлагатай энэ халамжуудад бол нийтдээ 144,4 мянган хүн хамрагдаж байгаа. Бусдаараа бол шинэ төрлийн халамж нэмэгдээгүй, харин эсрэгээрээ халамжийн хамрагдалтыг багасгаж, олон төрлийн халамжуудыг өмнө нь манай Ариунзаяа сайдын хувьд энэ тэр бол нэлээдгүй бас цөөлж юу яасан цахимжуулсан ийм арга хэмжээг авсан.

**С.Одонтуяа:** Пүрэвдорж гишүүн тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалт тийм ээ Жавхлан сайдаа 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын юу нийт өртөгтэй байлаа гэхэд энэ жил ирэх жил нэгийг нь тавиад, дараа 2 жил нь 2, 2-ыг дараалуулж тавиад ингээд явж байгаа. Яах вэ зарим нь ингээд 2 жил дотроо хийгдэж байгаа. Жишээ нь 3 тэрбумын өртөгтэй байлаа гэхэд эхний жил тэрбумыг нь тавиад, нөгөөдөх дараагийн жил 2-ыг тавьж байгаа. Ийм замаар ингээд төсөв төсвийн хөрөнгө оруулалт чинь ихдээд байгаа. Тэгэхээр 2024 онд АН гараад яах вэ гэхээр Туркийн жишээ дээр ажиллана. Өөрөөр хэлбэл Ардын нам сан байгуулах дээр сангаасаа өөр Их Хурлын гишүүд аваад өөрсдөө зээл аваад байгаа учраас энэ сан байгуулахгүйгээр ямар зүйлийг хийх вэ гэхээр ерөөсөө баялаг бүтээж байгаа тэр хүмүүст 25 онд ямарваа нэгэн тийм улсын төсвийн хөрөнгө оруулалтыг жалганд

тараахгүйгээр, зөвхөн баялаг бүтээгчдэд зориулж тэдний авсан зээлийн хүүгийн төлбөр бүгдийг нь, өөрөөр хэлбэл хэн нэгэн.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Эхлээд хариултаа авчих тэгээд юу яах юм бол. Хэрэггүй. Пүрэвдорж гишүүн нэг минут.

**Б.Пүрэвдорж:** 2025 онд ямарваа нэгэн шинэ хөрөнгө оруулалт тавихгүйгээр зөвхөн Туркийн жишээгээр өөрөөр хэлбэл аливаа нэгэн бүтээгдэхүүн үйлдвэрлээд тэрнийгээ худалдаанд гаргаад, тэр нь татварын системд бүртгэгдсэн тохиолдолд тэр хүнийг үйлдвэрлэл хийж байна гэж үзээд банкнаас авсан зээлийг нь улсын төсвөөс хааж өгөх ийм зүйлийг Турк хийсний үр дүнд өнөөдөр Европын Хятад гэж нэрлэгдэж байгаа. Европын бүх жижиг үйлдвэрлэл бүтээгдэхүүн ЖДҮ-лэлийн бүтээгдэхүүнийг тийшээ хангаж байна. Ингэж бид нар нөгөө баялаг бүтээж байгаа хүмүүсийг, хүмүүсийг ажилтай болгох, халамжаас хөдөлмөр лүү гэдэг энэ шилжилтийг хийсний үр дүнд Монгол Улс хөгжлийн зам дээр гарна гэж тооцож байгаа. Бусдаар бол жалгын нэг хөрөнгө оруулалт тавиад, тэгээд дээрээс нь дахиж сонгогддог аль эсвэл сонгогчдоо халамжаар халамжилдаг ийм төр бид нарыг Монгол Улсыг улам мөхөөх энэ нөхцөл рүү явуулна гэж.

**С.Одонтуяа:** Хариулт хэрэггүй гэсэн санал байлаа. Дамдины Цогтбаатар гишүүн асуултаа асууна.

**Д.Цогтбаатар:** Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд төсвийн асуудал хэлэлцэж байгаатай холбогдуулан хэдэн зүйл бас асуумаар байна. Тэгэхээр ингээд 2021 оноос эхлээд л өөрийнхөө дүүргийн хүрээнд бол энэ үерийн асуудал байна, үерийн эрсдэл байна гээд би олон удаа Засагт ч хандаж байсан, олон нийтэд хандаж байсан, одоо энд миний ингээд гарт баримтууд байж байна. 21 оны би 6 сард Засагт бүүр албан бичгээр хандаад 16 тэрбум төгрөг энд

тавьж өгөөч, 15-аас 20 дугаар хороонд үерийн далан байгуулах, үерийн инженерийн байгууламжуудыг байгуулах ажлыг зохион байгуулахгүй бол энэ чинь ингээд эрсдэлтэй байгаад байна гэдэг асуудлыг ярьж байсан. Ингээд энэнээс хойш 2 жилийн дараа тэр яг ярьж байсны үер болж байгаа юм. Энд тэр инженерийн байгууламжууд байгуулагдаагүйгээс болоод яг тэр үедээ би бүүр хэд хэдэн удаа Сангийн яаман дээр ч гэсэн Сангийн яамныхантай төсөв хэлэлцэж байхад бүүр сайндаж муудаад л ярьж байсан. Энэ манай иргэдэд үер болчихоор очоод Сангийн яамныхан та нар тайлбарлах юм уу, үгүй бид нар нүүрээ ширлээд л очоод тайлбарлана шүү дээ, юу гэж тайлбарлах юм. Иргэдийн өмч, амины асуудал яригдаж байхад Хэмнэлтийн хууль ярьж ийм юман дээр мөнгө хэмнэдэггүй юм шүү гээд л би үзэж байсан.

Одоо тэгсэн бид нар ахиад л ингээд төсвөө оруулж байтал Хэмнэлтийн хуулиа яриад, энэ том юм чинь ахиад ороогүй төсөвт. Тэгээд дараа жил үер болбол бид юугаа ярьж суух вэ? Энэ дээр тэгсэн бүүр сүүлдээ нэг 90-ээд метрийн нэг 13, 4 дүгээр хороон дээр хийгдэж байгаа ажлын 90-ээд метрийн инженерийн ажлын юу төсөв дутчихаад байж байгаа. Сүүлдээ бүүр аргаа бараад гуйгаад 90-ээд метрийнхийг гуйхад тэрийг хүртэл оруулаагүй. Одоо ингэхээр энэ үер усны аюул болохоор СБД-т энийг чинь яах юм бэ? Энэ яагаад оруулахгүй байгаа юм бэ? Бид нар ер нь нийтдээ 18 ажлын бас санал тавихад 6-г нь л баталж өгсөн байж байгаа юм. Тэгээд энэ дээр би мэдээж манай дүүрэг дээр энэ ингээд л угсармал барилгын нийтийн орон сууцын барилгын эрчим хүч, дулааны алдагдлыг бууруулах энэ ажлууд хасагдчихсан л байж байна. Энэ далан инженерийн байгууламжийн асуудал хасагдсан, гудамж талбайн гэрэлтүүлэг хасагдсан ингээд ийм олон юм хасагдсан байхаар энэ дүүрэг рүү чинь чиглэсэн хөрөнгө оруулалт дээр бид нар яаж гуйж, яаж аж

*ажиллах ёстой юм бэ? Би бол сүүлдээ бүүр учраа олохоо больчихоод байна.*

*2 дахь асуудал энэ манай дүүрэг дээр төвийн дүүрэг байж сургууль, цэцэрлэгийн асуудлаа бид нар бас гүйцээж шийдэх юмнууд байгаад байна. Энх-Амгалан сайд энэ дээр бас хариулж өгөөч. Энэ 31 дүгээр сургууль, 71 дүгээр сургуулиудын асуудал, 12 дугаар хороонд баригдаад дуусаж байгаа 720 хүүхдийн суудалтай энэ сургуулийн барилгын асуудлуудыг санхүүжилтийг шийдэх хэрэгтэй байна. Энэ дээр ямар арга хэмжээнүүд авч байгаа вэ? 31 дээр юу Энх-Амгалан сайдад би баярлаж байгаа. Яг дүүрэг дээр өөрөө очиж ажиллаад бас нэлээн юмнууд урагшлуулсан. Гэхдээ урагшлуулсан гээд үр дүн бас хэрэгтэй байгаа шүү. Энэ дээр бас нэг хариу өгөөч?*

*Миний 2 дахь бас асууя гэж байгаа асуудал бол өчигдөр би энэ шүүхийн байгууллагуудтай очиж танилцлаа. Энэ төсвийг нь 55 тэрбумаар хасчихсан байж байгаа юм. Тэгээд энэ чинь нөгөө яг энэ асуудал дээр бол ХЗБХ-гоор энэ төсвийг нь багцлаад, базаж өгөөд явуулсан байхад энийг бол хасах ёсгүй юм байна лээ хуулиараа. Тийм хуультай юм байна лээ. Яг энэ асуудал дээр бол. Тэгээд энийг ингээд хасчихсан байх юм. Энийг Жавхлан сайдаа нэмж өгч болох уу? Яагаад гэвэл бид нар иргэдийнхээ өмнө шударга ёс ярьж байгаа бол эхлээд тэр шүүхийн ажиллах нөхцөлийг хангаж өгч байж дараа нь тэр шударга ёсны чинь хүсэлт хүсэмж биелэх тэр боломж нь бүрдэнэ шүү. Тэгээд энэ хэдэн асуулт дээр хариулт авмаар байна.*

**С.Одонтуяа:** *Хэн хариулах вэ? Эхний хариулж байгаа хүн 4 минутаар шүү. Энх-Амгалан сайд.*

**Л.Энх-Амгалан:** *Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ зун бас бид нар ерөнхийдөө энэ нийслэлд 3 ээлжид орох эрсдэлтэй сургуулиуд дээр ганцхан СБД гэхгүйгээр нийт 47 сургууль дээр асуудал үүссэн учраас бас нэлээн*

*асуудлуудыг шийдвэрлэе гэж бас Монгол Улсын ЗГ бас бүрэн бүрэлдэхүүнээрээ холбогдох яамдын удирдлагууд нэлээн зунжингаа ажилласан. Ингээд ЗГ луу бид нар 2 удаа энэ 3 ээлжид орох эрсдэлтэй сургууль, удааширалтай байгаа таны хэлж байгаа энэ 31, 71 дүгээр сургууль, Сонгинохайрханы 12 дугаар сургууль, ЧД-ийн 5 дугаар сургууль, БЗД-ийн 26 дугаар хороон дээр байгаа 2 сургууль, 1 цэцэрлэгийн асуудлуудыг бас жаахан Төсвийн хуульд хууль зөрчихгүйгээр зохицуулах ямар бас шийдлүүд байх вэ гэдэг дээр бас нэлээн шийдлүүд гаргаж ажилласны хүчинд бид нар ямар ч байсан 9 сарын 1 биш, 9 сарын 1-нд биш юм гэхэд одоо энэ 12 сардаа багтаагаад энэ 5 ачаалал үүссэн сургуулиуд дээр бас тодорхой шийдлүүд гаргасан.*

*Юун дээр СБД дээр байгаа энэ 71 дүгээр сургууль, 31 дүгээр сургууль 2-ын бас энэ гүйцэтгэгч нарт бид нар их талархах ёстой юм байгаа юм. Муу гүйцэтгэгч нар ч байгаа, сайн гүйцэтгэгч нар ч байгаа. Тэгээд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд магадлангаа хийлгээгүй байж байж тийм ээ, магадлан 1 дүгээрт магадлан хийлгээгүй, 2 дугаарт магадлан нь ямар дүнгээр гарахыг мэдээгүй байж байж бас тодорхой яамтай итгэлцлийн хүрээнд энэ ажлаа дуусгах ийм ажлуудыг хийж, өнөөдөр бас дуусгаж байгаа. 31 дүгээр сургууль дээр болбол та бид 2 бас очсон, 71 дээр очсон. Асуудал болбол нөгөө яг дээшээ өргөтгөл хийж байгаад, нөгөө дээврийнхээ бүх дээврээ онгойлгочихсон байх үед нь нөгөө том үер орж ирээд ингээд 1, 2 дугаар давхрыг давхар авчихсан ийм эрсдэл үүссэн, тооцоогүй эрсдэл үүссэн учраас бол ажлын гүйцэтгэл жаахан удааширч байгаа. Гэхдээ 1, 2 давхраар яг энэ сургуулиудаа нээгээд явж байгаа. Яах вэ дээ тэгээд ер нь эхлээд сургуулиа нээ гэсэн, дараа нь нээж байна, тэгээд давхар давхраар нээгээд ингээд хэсэгчлээд уг нь бол энэ чинь барилгын стандартад байж болохгүй л зүйл юм байна лээ л дээ. Тэгээд амьдрал дээр ийм нөхцөл байдлууд үүсэж байгаа учраас бас бид нар нэлээн олон*

шийдлүүдийг гаргаж, нэг жаахан прагматик маягаар ажиллаж, өнөөдөр бас тодорхой үр дүн гарч байгаа болов уу л гэж харж байгаа шүү дээ Цогтбаатар гишүүнээ нэгд.

2-т энэ далимд би бас ашиглаад хэлэхэд ерөнхийдөө энэ нийслэл дээр 3 ээлжийн сургуульд орох эрсдэлтэй байгаа, улсын хэмжээнд би 67 сургууль гэж харж байгаа юм. Нийслэл дээр 47 сургууль байгаад байгаа юм. Тэгээд 3 ээлжид орсон хамгийн гол эрсдэл юу вэ гэхээр ерөөсөө л яг нөгөө 12 дугаар ангийн хүүхдийг 30-аас 35 мянган хүүхэд төгсөөд, 1 дүгээр ангид 70-аас 75 мянган хүүхэд орж ирж байгаа. Зарим жил 80 мянган хүүхэд орж ирж байна. 30-аас 40 мянган хүүхдийн зөрөө жил бүхэн гарч ирж байгаа учраас энэний энэ ачааллуудыг яаж шийдвэрлэх вэ л гэдэг асуудал байна 1 дүгээрт.

2 дугаар асуудал болбол ер нь энэ Улаанбаатар хотод сургуульгүй том, том хорооллууд барьсан асуудлууд байгаад байгаа юм. Тэгээд анх энэ барилга архитектурын төлөвлөлт, ажил эхлэх зөвшөөрөл авахдаа дандаа сургууль, цэцэрлэгээ төлөвлөчихдөг. Яг улсын комисст өгөхдөө хорооллоор нь хүлээлгэж өгдөггүй байшин байшингаар нь зараад явчихдаг нэг ийм технологи гарчихсан юм байна лээ л дээ. Бүүр технологи болсон юм байна лээ энэ. Энэ технологи хаана нэвтэрч байна вэ гэхээр бүүр Улаанбаатараасаа халиад Эрдэнэтэд хүртэл ингээд ийм технологи нэвтэрснээс Эрдэнэтэд ч хүртэл том сургуульгүй хорооллууд байшин байшингаар нь зараад явчихдаг нэг ийм нөхцөл байдлууд үүсэж байгаа юм. Тийм учраас болбол бид нар энэ олон жил сүүлийн 30 жилийн энэ завхрал, тэр тусмаа хот дээр байгаа энэ завхрал энэ асуудлуудыг бол нэлээн тийм системийн хувьд нь цэвэрлэж байж бид нар энэ асуудал дээр тодорхой шийдэл гарах ёстой юм болов уу гэж харж байгаа юм.

3 дугаар асуудал болбол ерөнхийдөө энэ бид нар энэ улсын төсөв дээр төсвийн хөрөнгө оруулалт батлахдаа газаргүй сургууль, цэцэрлэг батлаад явуулчихдаг, зураг төсөлгүй, зураг төсөвгүй, сургууль, цэцэрлэгийг батлаад явуулчихдаг нэг бид нарт нэг ийм гэм байсан. Энэ танхим дотор л энэ юунууд үйлдэгдсэн шүү дээ ер нь болбол. Бид нар бүгдээрээ буруутай. Өнгөрсөн 10 хэдэн жилийн турш бид нар хөрөнгө оруулалт.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Нэмж хариулах хүн хэн билээ, болчихсон уу? Хэн Жавхлан сайд хариулах юм уу? Үерийн далан дээр төсөв тавьсан уу гэсэн, үерээс хамгаалах чиглэлээр.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Бид чинь системээр хөрөнгө оруулалтуудынхаа саналуудыг авдаг болоод 2 жил болж байгаа юм. Одоо ингээд бид 11 сарын 15-нд төсөв батлагдмагц хойтонгийн төсвийн саналууд ингээд яваад эхэлнэ. Тэгэхээр энэ жилийнх дээр болбол яг Улаанбаатар хотын үерийн далан болон ийм байгууламжуудтай холбоотой системээр Сангийн яаманд нэг ч санал ирээгүй юм шүү. Тэгээд яагаад ирүүлээгүй юм ерөөсөө 1 ч ирүүлээгүй. Энэ юуныхан нийслэлийнхэн ирчихсэн байгаа юм байна тийм ээ, ашигүй ашигүй. Нийслэлийнхэн тэрэн дээрээ саналаа хэлээрэй.

Яах вэ өмнө нь явж ирсэн практикаар болбол энэ үерийн далантай холбоотой, үер устай холбоотой байгууламжууд бол голцуу нийслэлээр өөрсдөө хөрөнгө оруулалтуудаараа шийдэж ирсэн байдаг юм. Тэгээд ирэх жилийнх дээр ямар төлөвлөгөөтэй байгаа гэдгийгээ тийм Сайнзориг дарга хэлээдхээрэй. Ер нь аягүй олон гишүүд нийслэлийн гишүүд асуугаад байна шүү. Мэдээлэлжүүлэх хэрэгтэй, эд нарын асууж байгаа нь ч зөв тийм. Энэигээ далимдуулаад иргэддээ бас мэдээлэл өгчих хэрэгтэй.

**С.Одонтуяа:** Эхлээд 1 дүгээр микрофон хариулчих уу, 1 хариулах гэж байгаа юм уу? Сайнзориг. Өнөө хууль зүйн, одоо нийслэлийн төлөөлөл.

**П.Сайнзориг:** Тийм байна. Цогтбаатар даргын асуултад хариулъя. Би бас өнөөдөр ажил авч байгаа учраас бас танд ерөнхийдөө нарийн задаргаатай мэдээллийг өгч чадахгүй байна. Тойм мэдээллийг бас өгье. Ер нь бол ирэх жилийн төсөвт яг үерийн барилга байгууламжтай холбоотой энийг засаж сайжруулах энэ чиглэлд бол нийслэл дээр 15 орчим тэрбум төгрөгийг бас урьдчилсан байдлаар бол төлөвлөгөөнд тусгаад байгаа. Ирэх 7 хоногоос бас бид нар гаднын мэргэжилтнүүд буюу Голландын мэргэжилтнүүдтэй бас уулзаж, яг энэ нөхцөл байдлуудыг газар дээр нь зөвөөр бас шийдэх инженерийн шийдлүүдийг бас ярилцаж, энэ жилийнх ирэх жил бас энэ чиглэлийн үер усны гамшигаас бас иргэдийг бас сэргийлэх асуудлыг нэлээн тийм шинжлэх ухаанчаар бас шийдэх энэ гарц гаргалгааг хайгаад явж байгаа.

Мөн нийслэлийн хэмжээнд энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд бас нийслэлийн босгох бонд буюу тэндээс 100 орчим тэрбум төгрөгийг бас тусгахаар, зарцуулахаар бас урьдчилсан байдлаар төлөвлөж байгаа. Ер нь зүгээр энэ авто замын.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Дамдины Цогтбаатар гишүүн тодруулъя 1 минут.

**Д.Цогтбаатар:** Энэ ийм шүү Жавхлан сайдаа энийг хар даа. Би одоо энд бүүр ЗГ луу явуулж байсан энэ албан бичиг байж байгаа 21 оны 6 дугаар сарын 7-ны албан бичиг би бүүр тоотой нь 16 тэрбум гээд, одоо энэ харин хот дээр энэ чинь 15 тэрбум гээд яг энэ дөхсөн энэ барьж байгаа тоо яригдаж байна. Тэгэхээр энийг бид нар байнга тавьж байгаа юм. Асуудал нь юу байна гэхээр танай дээр энэ асуудлыг тавиад очихоор

өөдөөс Хэмнэлтийн хууль яриад, миний нөгөө гол яриад байгаа юм чинь ийм асуудал дээр хэмнэлт ярьдаггүй юм гээд л бид нар зүтгээд яваад байгаа. Тэгээд хот дээр тавигдаж байгаа шүү гээд одоо энд хариу орж ирж байна л даа. Хот дээр тавигдаж байгаа. Гэхдээ одоо энэ хариултыг би ингээд тэмдэглээд авлаа шүү. Хот дээр энэ асуудал явагдаж байгаа юм байна. Яагаад гэвэл танай 2-ын хооронд эзгүй ингээд орхигдоод яваад байсан байхгүй юу. Тэгэхээр одоо энэ дээр юу нэгэнт энэ хот аваад хийж байгаа бол энийг би салахгүй хойноос нь хөөцөлдөөд явна шүү дээ. Тэр Голландын мэргэжилтнүүдийн хийсэн юу чинь.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя 1 минут.

**Б.Жавхлан:** Би Цогтбаатар гишүүн, Ганзориг, Сайнзориг даргад хоёуланд нь хариулж байгаа юм шүү. Ер нь орон нутаг энд яг ижилхэн асуултууд гарна. Энэ жил ганихан аймагт үер болоогүй, ганихан нийслэлд үер болоогүй. Бүх гишүүд бас энийг асууж байгаа байх. Энийг анхааралдаа авчхаарай. Юу вэ гэхээр үгүй ээ Цогтбаатар гишүүнээ би таны асуултад хариулаад байгаа юм шүү. Манай 2 дунд орхигдоогүй шүү. Энэ Хэмнэлтийн хууль ерөөсөө огт хамаагүй. Тогтохсүрэн гишүүнээ танай аймагт ч гэсэн үер болсон байгаа. Нэгжийн хуулиар ийм байгаа шүү. Нэгжийн хуулийн 21.1.14 дээр бүүр ингээд заачихсан байгаа. Харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан суваг, тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт орон нутаг өөрөө хийнэ. Төсвийн энэ Нэгдсэн төсвийн хуулиар нэг төгрөг ч ийшээ хийж болохгүй шүү гээд хуульчилчихсан байгаа шүү Цогтбаатар сайдаа. Хуульчилчихсан байгаа. Төсвөөс болохгүй шүү, энийг орон нутаг өөрөө шүү гээд. Тэгэхээр манай 2-ын дунд гэсэн ойлголт байхгүй. Цаашидаа Сайнзориг

даргаа энийг бүгдийг нь 100 хувь энэ Нэгжийн тухай хуулиар нийслэл өөрөө хариуцаж явна шүү.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд шүүхийн асуудлаар.

**Б.Жавхлан:** Бид нар шүүх дээр төсвийн алинаар нь аль хуулиар явах вэ гэвэл бид нар Төсвийн хуулиа л барина Цогтбаатар гишүүнээ. Төсвийн хууль дээр юу гэж заасан байдаг вэ гэхээр бусад тэр дагасан янз бүрийн салбар салбарын хуулийг хуулиас бид ерөөсөө огт хараат бусаар Төсвийн хуулиа бариад л төсвөө төлөвлөх, тэгээд Их Хуралдаа өргөн барина. Их Хурал дээр баталдаг ийм л зарчмаар явна. Аягүй олон салбарын хуулиуд дээр тийм зүйлүүд байдаг юм. Бид нар алийг нь ч барьдаггүй. Зөвхөн Төсвийн хуулиа л барьдаг.

Харин шүүх дээр болбол бид онцгой анхаарах хэрэгтэй. Тэр таны хандлагатай бол би яг 100 хувь санал нийлж байна. Хараат бус бид энэ шүүх засаглалтай болбол эд нарыгаа тохь тухтай ажиллах орчин, цалин мөнгө, хөлс нь хангалттай байхаар өөр зүйлд санаа зовохгүй ийм бие даасан байдлаар ажиллах бүх боломжийг нь бид нар хангах ёстой. Тэрийг болбол 100 хувь санал нийлж байна. Өмнөх түүхээ харах юм бол ер нь арваад жил ялангуяа хөрөнгө оруулалт дээр нь болбол олигтой юм тавиагүй, одоо энэ байшингууд нь маш муудчихсан, очоод үзэхээр үнэхээр хүнд нөхцөлтэй байдаг.

**С.Одонтуяа:** Болчихсон доо. Та тодорхой хариулчихлаа. Цэрэнпунцаг гишүүн асуултаа асууна.

**Ц.Цэрэнпунцаг:** 2, 3-хан товчхон асуулт асуучихъя. 1 дүгээрт энэ аймгуудад баригдаж байгаа дулааны станцууд байгаа шүү дээ. Завхан аймагт Улиастайд баригдаж байгаа. Тэгээд энэ дулааны станц маань төлөвлөсөн цаг хугацаандаа дуусах нь уу? Өнөөдрийн барилгынх нь үйл явц ямар явж байгаа юм

бэ? Янз бүрийн энэ дээр санхүүжилтийн хувьд бол саад бэрхшээл гарч байгаа юм байна уу үгүй юү 1 дүгээрт асуучихъя.

2-т манай Улиастай Завхан аймаг бол бүгд мэдэж байгаа хөгжлөөр хоцрогдож яваа. Ялангуяа барилгажилт бага хийгдсэн, аймгийн төвд Улиастай хотод бол бас энэ хоцрогдож яваа нь сүүлд хөдөлж байгаагийн бас давуу тал байна. Бид нар бол зөв төлөвлөөд ингээд ажиллах юм бол бас энэ иргэдийнхээ ялангуяа гэр хороололд байгаа иргэдийнхээ энэ 07 га газрыг нь бол үнэ цэн оруулах ийм боломж байгаа юм. Энэ бол шугам инженерийн шугам сүлжээ татаж өгөх хэрэгтэй байгаа юм. Бид нар дулааныг яриагүй. Энэ дулааны станц нь бол хүчин чадал багатай. Энэ бол зөвхөн өнөөдөр тэр төв магистралдаа залгагдаад л тэгээд л энэ тодорхой хэмжээний хэсгээ халаагаад л болох юм байна лээ. Ер нь тэр бусад энэ гэр хороолол 2 тал руугаа манай голынхоо 2 тал руу гарчихсан байгаа тэр хороолол гэр хороолол руу бол цэвэр юу бохирын шугам, цэвэр усны шугам татаад өгчихвөл бид нар энэ цахилгаанаар халаадаг үр ашигтай ийм шийдлүүд олон байна. Бид нар бас шинэ юм руу явахгүй бол дандаа энэ байшин барилга барьж энэ яндангуудыг солино хаана гэж энэ Улаанбаатар хот бол сүүлийн 30 жил энэ үлгэр шиг юм хийж яваад одоо бид нар үр дүнг нь хараад байж байна шүү дээ.

Өнөөдөр, одоо жилд хэд энэ ипотекийн зээл гэж энэ инфляцад ямар их нөлөөлдөг, бид нар бүгдээрээ энийг нь төлдөг. Тэгээд жилд 3, 4 мянган айл, одоо 4, 5 мянган айл энэ ипотекеэр байранд ороод тэгээд энэ гэр хорооллуудаас энэ 4, 5 мянга, 10 мянгаараа яндан хаагдсан юм байна уу? Дахиад л тэр хашианд нь нэг айл ирээд л, тэр хашиаг нь байшинг нь нэг айл худалдаж авч суугаад л дахиад л яндангаа утаа гаргаад сууж байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг бид нар энэ алдааг бас Завхан аймагт би давтчихгүй юм сан гээд Тосонцэнгэл сумд өөрийн хөрөнгөөр 18 мегаваттын дулааны цахилгаан станц



барьж байна. Тэгээд эд нарыгаа бид нар энэ Улаанбаатарт гарсан алдааг давтахгүй хийхийн тулд бол энэ төсөв дээр энэ цэвэр ус, бохирын шугам 2-ыг нь татаад гэр хорооллууд руугаа хүргэе. Ингээд энэ төрийн энэ ялангуяа төрөөс энэ төсвөөс хөрөнгө оруулалт хийж байгаа энэ хөрөнгө оруулалтын нэг зорилго бол энэ иргэдийнхээ, бизнесүүдийнхээ бизнесийн орлогыг нь нэмэгдүүлэх, иргэдийнхээ хөрөнгийг үнэ цэнтэй болгох энэ чиглэл рүү хандаж хийгдэх ёстой гэж ойлгож энэ Улиастай дээр бас тодорхой хэмжээний санхүүжилт төсөвт тавьж өгөөч гэж бас нэлээн 2 жилийн өмнөөс бас төлөвлөж, ажиллаж санал гаргасан юм байгаа юм. Тэгээд энэ дээр тавьсан мөнгө хангалтгүй юм шиг харагдаад байх юм. Энэ дээр нэмэх боломж байна уу үгүй юү?

Тэгээд цаашдаа энэ ерөнхий энэ хөрөнгө оруулалт хийгдэж байна. Хөрөнгө оруулалтын яг хэдэн хувьд нь энэ барилга байшин цемент зуурч байгаа юм бэ? Энэний яг хэдэн хувь нь урагшаа импортлоод гараад явчихдаг юм бэ, ямар тооцоо байна вэ? Энийг нэг хэлж өгөөч.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Чимидсүрэн дарга Сангийн яам.

**Ч.Чимидсүрэн:** Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Завхан аймагт баригдаж байгаа дулааны станцын ажил болбол хэвийн явагдаж байгаа. Гэхдээ гүйцэтгэлийн хувь болбол 12 хувьтай байна. Одоогоор болбол ямар нэгэн тийм гүйцэтгэлтэй санхүүжилттэй холбоотой хүндрэлтэй асуудал бол бидэнд тавиагүй байгаа. Ирэх онд болбол цахилгаан хангамжтай холбоотой төсвийг 24 онд болбол улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр болбол тавьсан байгаа.

Завхан аймагт тэр үйлдвэрийн районы цэвэр усны шугам сүлжээний төсөл болбол энэ оноос хэрэгжинэ 3 жилийн хугацаатай. 24 онд болбол төсөвт өртгийг 7,1 тэрбумаар,

санхүүжих дүнг болбол 3 хуваагаад 2,1 тэрбумаар болбол тавьсан байгаа.

**С.Одонтуяа:** Тавинбэх ТНБД хариулъя 1 дүгээр микрофон.

**Н.Тавинбэх:** Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Солонгосын Эксим банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нэр бүхий 10 аймагт 20-оос 30мвт-ын дулааны эх үүсвэр баригдах учиртай. Өнөөдөр 2015 оноос хойш энэ ажил яригдаж байгаа. Тэгээд 2022 оны 7 сард эзэнтэй болсон. Зээлийнхээ тусгайлсан хэлэлцээрээр Солонгосын компани энэ ажлыг гүйцэтгэх ёстой, техникийн хяналтыг бас Солонгосын компани гүйцэтгэх учиртай хоёулаа тодорсон. Хүндрэлүүд байна. Гэхдээ өнөөдрийн байдлаар бол ажил хэвийн явагдаж байна, хэвийн явагдаж байна. Өнөөдрийн байдлаар гүйцэтгэл 42 орчим хувьтай байна. Гол гарч байгаа хүндрэл болбол их удаан хугацаанд үргэлжилсэн учраас үнийн өсөлт гарсан тухай гүйцэтгэгчээс мэдээлэл хийж байгаа. Нэлээн өндөр үнийн өсөлтийг ярьж байгаа. Бид нар үнийн өсөлтийн хэмжээг өнөөдөр эцэслээгүй байна. Мэргэжлийн холбогдох байгууллагууд хяналт хийж байна. Ингээд хяналтын дүнгээр энэ үнийн өсөлтийн хэмжээ бол тодорхой болох байх. Энэ үед холбогдох.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Тавинбэх дарга нэмээд хариулчих, гүйцээгээд хариулчих.

**Н.Тавинбэх:** Үнийн өсөлтийг оруулж ирж шийдвэрлүүлнэ. Энэ дулааны шинэ эх үүсвэртэй холбоотойгоор Монгол Улсын ЗГ 4 үүрэг хүлээж байгаа. Цахилгаан хангамжийг шийдвэрлэх учиртай, ариутгал татуургын системийг шийдвэрлэх учиртай, технологийн болоод ахуйн усны шийдэх учиртай, мэдээлэл технологийн дэд бүтцийг шийдэх учиртай. Энэ жилийн төсвийн хувьд энэ ажил нэлээн хоцорч явсан ч гэсэн ажил нь эхэлсэн 9 аймаг дээр тодорхой хөрөнгүүт тавигдчихсан. 24 оны төсөв дээр. Бэлтгэл

ажил эхлэх бололцоо санхүүгийн хувьд бүрдэж байна гэж ингэж ойлгож болно. Завхан аймгийн хувьд болбол ажил өнөөдрийн байдлаар Сангийн яамтай гүйцэтгэл харьяа зөрж байна, 42 орчим хувьтай явж байгаа гэдгийг хэлье. Гэрээний хугацаа болбол 22 оны 7 сард ажил эхэлсэн, 26,5 сар үргэлжлэх ёстой. Ингээд тооцохоор 24 оны 6 сард ашиглалтад орох учиртай. Хүндрэл гараад зогсчихгүй бол.

**С.Одонтуяа:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуултаа асууна. Годруулах юм уу? Цэрэнпунцаг гишүүн тодруулга 1 минут.

**Ц.Цэрэнпунцаг:** Энэ төсвийн хөрөнгө оруулалтын хэдэн хувь нь барилга руу орж байгаа юм бэ гээд асуусан юм. Яг хэдэн хувь нь барилга болж орж байгаа юм бэ? Тэгээд энэ цаашаа хэдэн хувь нь энэ материал болоод энэ импортыг дэмждэг юм бэ? Энэ дээр нэг тоог хэлж өгөөч гээд. Дээрээс нь энэ ер нь Улиастай дээр цаашидаа Тосонцэнгэл 10 мянган хүн амтай том сум эд нар дээр энэ инженерийн шугам сүлжээг өргөтгөхөд эх үүсвэр төсвөөс тавьж өгөх, нэмж өгөх ийм боломж байна уу үгүй юү гэж асуусан. Энэ 2 дээр хариулт авъя.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Ажлын хэсэг хариулах уу? Ажлын хэсэг хариулчих, юугаа микрофоноо дээшээ өргөөд 86 Сангийн яам Чимидсүрэн дарга.

**Ч.Чимидсүрэн:** Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Хөрөнгө оруулалтын нийт төсвийн 75-аас дээш хувь нь болбол ер нь барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажилд болбол зарцуулагддаг. Өртгийнх нь хувьд аваад үзэх юм болбол түүний 43 хувь нь болбол ер нь барилгын материалын зардал байдаг гэсэн ийм ерөнхий тооцоо байна.

**С.Одонтуяа:** Тогтохсүрэн дарга асуултаа асуух уу? Тогтохсүрэн дарга асуултаа асууна.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Улсын төсвийг хэлэлцэж байна. Тэгэхээр бид нар энэ сүүлийн жилүүдэд Жавхлан сайдын зарлага л их нэмэгдээд байгаа юм. Хамгийн санаа зовоож байгаа юм. Зөвхөн 2024 онд нийт зарлага маань энэ 5 их наяд орчим төгрөгөөр нэмэгдсэн байгаа. Мэдээж цалин, тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдэл бид нарын энэ 24 онд, 23 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөлөөлөл бий. Гэхдээ л нийт зарлага бол ийм хэмжээнд нэмэгдэж байгаа юм. Хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа ч юм байгаа. Цаашидаа болбол манай Сангийн яам энэ зарлагыг ер нь тодорхой түвшинд барих, зарлага дээрээ нэлээд дүн шинжилгээ хийж, зардлыг бууруулах чиглэлээр тодорхой менежментийн арга хэмжээ авахгүй бол бид нар ингээд зарлагаа нэмээд л байвал зарлагадаа тааруулж орлогоо хийгээд байгаа байхгүй юу. Зарлагаа дийлэхгүй болохоороо л тэгээд л нүүрснийхээ хэмжээг нэмээд л эхэлж байгаа ийм л зүйл байгаа юм. Тийм учраас энэ зардлын асуудал дээр бид нар онцгой анхаарч, зардлыг бууруулах менежментийн асуудлыг нэг судалж авч үзэхгүй бол цаашидаа бид зарлагаа дийлэхээ болиод, зарлагадаа тохируулж орлогоо нэмэгддэг нэг ийм чиглэл рүү л явчхаад байгаа юм. Тийм учраас хуримтлалыг бид нар ерөөсөө үүсгэж чадахгүй ингээд ийм байдал руугаа яваад байгаа юм.

Би орон нутагтай холбоотой 3 асуудлыг асууя гэж бодож байна. 1 дүгээрт нь 2024 онд ЗГ орон нутгуудыг орон сууцжуулах чиглэлд онцгой анхаарна гэж байгаа. Энэ хүрээндээ ипотекийн зээлийн санхүүжилтийг одоо бол 18 хувь нь орон нутагт явж байгаа. Энийг 50 хувь болгоно, хот хөдөө 2 бол үндсэндээ 50, 50 хувиар явна гэж байгаа юм. Тэгээд би энэ дээр асуух гээд байгаа гол юм. Яах вэ 50, 50 хувиар явахад 2200 орчим иргэн хөдөө орон нутагт орон сууцын ипотекийн зээлд хамрагдаж байгаа юм. Гэхдээ хамгийн гол нь ипотекийн зээлийн үндсэн том эх үүсвэрийг нэмэгдүүлэхгүйгээр дорвитой өөрчлөлт гарахгүй байгаа юм.

Тэгэхээр энэ цаашидаа энэ ипотекийн зээлийн үндсэн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр Сангийн яам тодорхой бодлого боловсруулж, анхаарч байгаа юм байна уу? Энийг зөвхөн энэ жил ярьж байгаа асуудал биш олон удаа ярьж байгаа юм. Үндсэн ипотекийн зээлийн эх үүсвэрээ нэмэгдүүлэхгүй одоогийн байгаа эргэн төлөлтөөр яваад байвал энэ нэг их тийм том үр дүнд хүрэхгүй юм байгаа юм. Энийг 1 дүгээрт нь би асууя гэж бодож байна.

2 дугаарт нь тэр 8 аймгийн дулааны станцтай холбоотой асуудал л байгаа юм. Энэ дээр бид нар маш их санаа зовж байгаа юм. Энэ 2016 оноос хойш яригдаж байгаа асуудал. Үндсэндээ 8 дахь жилдээ яригдаж байна. Ажлын гүйцэтгэл 42 хувь гэж байна, 42 хувь байхгүй 15 хувьтай л байгаа юм бодит амьдрал дээрээ. Би энэ ногоон автобусны араас орчих вий гэж энд их санаа зовоод байгаа юм энэ ажил дээр. Яагаад гэхээр энэ болбол Солонгосын зээлээр Эксим банкны зээлээр явж байгаа асуудал. Одоо гүйцэтгэгч талаас тавьж байгаа шаардлага чинь 1 дүгээрт бол үнэ нь үнээ нэмнэ гэж шаардлага тавьж байгаа юм. Тэгээд энд нь манай энэ ЭХЯ яг юу гэж ярилцаж байгаа юм бэ? Үнийг нь нэмэх боломжтой гэж үзэж байгаа юм уу, боломжгүй гэж үзэж байгаа юм уу энэ талаар өөрсдөө ТЭЗҮ юм уу, үнэ өсөх шаардлага, шалтгаан нь бодитой байна уу үгүй юү гэдгийг тодорхойлсон уу гэж би 1 дүгээрт асуух гэж байгаа юм. 2 дугаарт нь техник технологи нь ажил нь бол нэлээн их удаан явж байгаа юм, маш удаан явж байгаа юм. Энэ болбол санхүүжилттэй холбоотой зориуд ингэж удаан явуулах ийм зорилго чиглэл байгаа юм.

3 дахь асуудал бол Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэж байгаа энэ тээвэр логистикийн төслийн асуудал байгаа юм. Халтар сайд сая байсан чинь гараад явчхаж уу үгүй юү. Энэ тээвэр логистикийн төсөлтэй холбоотой асуудал яг хэзээ эхлэх гэж байгаа юм бол

гэдэг асуудал байгаа юм. Яах вэ энэ баригдсан замуудаа засварлая гэдэг зөв. Манай Өвөрхангайн хувьд бол Улаанбаатар, Арвайхээр, Арвайхээр, Баянхонгор, Хархорин, Цэцэрлэг гээд замуудын их засварын асуудал байгаа. Энэ ажил яг хэзээ эхлэх гээд байгаа юм бэ? Улсын Их Хурал дээр энэ зээлийн санхүүжилтийн гэрээнүүд нь орж ирээгүй санагдаж байна. Энэ хэзээ орж ирэх гээд байгаа юм бэ, одоо тэр зээлийн санхүүжилт нь орж ирнэ, дараа нь тендер зарлана гэсээр байтал тэгээд жил дуусчих гээд байдаг байхгүй юу. Тийм учраас би энийг ажлын явцад.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Манай Сангийн яамныхны хувьд бол нэг эмзэг асуудлыг та хөндчихлөө шүү. Бодлогын хувьд бид нар маш их хичээж ажиллаж байгаа нэг зүйлийг та яг эсрэгээр нь хэлчихлээ. Юу гэвэл Сангийн яам би ажиллаж байхдаа энэ сүүлийн бид нар 3 жил 3 удаа төсөв оруулж ирэхдээ зарлагадаа тааруулж орлого төсөвлөж орж ирсэн нэг ч төсөв байхгүй шүү. Бид нар эдийн засгийнхаа хөгжлийн, эдийн засгийнхаа тэлэлтийн тэрэнтэй харьцуулсан тэрний боломжит орлогоо төлөвлөөд энэ орлогодоо нийцсэн зардлаа арайхийж багтаадаг. Хэрвээ зардалдаа багтааж, зардлаа бүрэн санхүүжүүлэх орлогоо зохионо гэх юм бол өнөөдрийн энэ 27 тэрбум, 27 их наяд биш шүү. Магадгүй 30, 40 их наяд нь төсөв орж ирэх байсан байх. Тийм учраас боломжит орлогоо маш сайн төлөвлөөд, зардлаа хасаад хасаад, танаад танаад ингэж орж ирж байгаа юм. Байж болох ёстой зардлуудаа багтаана гэх юм болбол хөрөнгө оруулалт 300 тэрбум биш бүүр хэдэн их наядар нэмэгдэх ийм ч шаардлага эрэлт хэрэгцээ байгаа.

Энэ жил нэмэгдэж байгаа урсгал зардлын 4,9 их наядын энийг

тайлбарлахад маш амархан байгаа. Гуравхан л зүйл байгаа. Ерөөсөө цалин, тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдэл 65 хувь нь, хуулиараа шууд автомат нэмэгдүүлэх үүрэг авчихсан одоо бол тухайлбал Нийгмийн даатгалын багц хуулиар нэмэгдэж байгаа маш их зардлууд байгаа. Тэр нь нэмэгдэлтийн 20 хувь нь байгаа. Бусад нь нэг удаагийн шинжтэй ийм зардлууд байна ирэх жил. Хөрөнгө оруулалт бол энэ 4,9 их наядын 6-хан хувь буюу 300 тэрбум л байгаа нэмэгдэж байгаа. Тийм учраас ирэх жилийн нэмэгдэл болбол ийм нэмэгдлүүд байна.

Ипотекийг бол Монголбанкт бид нар ярьж байгаа. Нэмэлт эх үүсвэрийг бол Төв банк бас чанга л байгаа. Яагаад гэхээр нөгөө хуулиараа бас энэ хязгаарлагдалтай байгаа учраас. Гэхдээ ямар ч байсан Монголбанк бол цаашидаа энийг оператор хийгээд явъя гэдэг дээрээ бол ойлголцсон байгаа.

10 аймгийн хувьд болбол ганцхан энэ дулааны станц биш, Дорноговийн нефтийн үйлдвэр байна, Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжууд гээд гадна талын зээлээр хийгдэж байгаа бүх төслүүд дээр үнийн өсөлтүүд яригдаж байгаа. Үнэ өсөлтүүд ингээд магадлан хийгдээд, аудитлагдах юм бол одоо бид гарцаагүй зээлийн дүнг нэмэхээс өөр арга байхгүй. Тэр бүрд харин Их Хурлаар орж ирнэ. Их Хурлаар оруулж ирээд нэг мөр багцлаад ингээд явна.

Тээвэр логистикийн АХБ-аас бид нар хариугаа хүлээж байна. Хариу ирмэгц даруйхан Улсын Их Хурлаар оруулаад соёрхон батлуулчих юм болбол энэ жил багтаагаад худалдан авах ажиллагааг нь эхлээд зарлачих, ингээд ирэх жилийн барилгын сезон эхэлмэгц засваруудаа эхлэх ийм боломжтой болж ирж байгаа юм. Энийг бол харин бид нар ЗТХЯ-тай хамтраад маш түргэн шуурхай ингэж шийдэж явж байгаа юм шүү. Тэр дулааны станц дээр ЭХЯ хариулах шаардлагагүй дээ. Энэ зээлийн үнийн өсөлтийн асуудал манай дээр явж байгаа учраас

аудитлагдаад гараад ирэх юм бол гарцаагүй зээлийн дүнгээ нэмэхээс өөр арга байхгүй. Тийм.

**С.Одонтуяа:** Тодруулга 1 минут Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** ЭХЯ хариулна биз. Гэрээгээрээ 24 оны 6 сард дуусаж байгаа гэж байгаа юм дулааны станц. Одоо 15, 20 хувьтай л байгаа гүйцэтгэл. Тэгээд дээр нь үнэ нэм гэж шаардаад байгаа. Тэгэхээр 6 сард ашиглалтад орно гэдэг бол хаана ч худлаа асуудал байхгүй юу. Тэгээд энэний ажлыг нь хурдавчлах чиглэлд онцгой анхаарах хэрэгтэй байгаа байхгүй юу. Энэ дээр би ЭХЯ-ыг бүүр дахин дахин хэлээд байгаа юм энэ ажлыг нь хурдавчлуулах чиглэл дээр онцгой анхаарал тавьж ажиллахгүй бол болохгүй нь л гэж хэлэх гэж байгаа юм.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Одоо яг сая энэ Тогтохсүрэн даргын хэлдэг өнцөг дээр бол Монгол тал бүгд бид нар нэг байр суурьтай байх хэрэгтэй. Солонгосын ЭСЯ энийг харж байдаг болбол энийг сайн сонсох ёстой юм байгаа юм. Зарим талдаа манайхаас долоон доор байгаа шүү ер нь энэ гүйцэтгэгч компаниуд нь Солонгосын талаас шалгарч ирсэн компаниуд нь. Одоо бас үнийн өсөлт яриад л хийхгүй ингээд суучихдаг. Хамгийн өндөр гүйцэтгэлтэй нь дөнгөж 30 хувь руу бүүр нэг аймаг дээр бүүр эхлээ ч үгүй байж байгаа шүү дээ. Тэгээд хойтон 4 сар, 6 сард эхнээсээ ашиглалтад орох ёстой. Ийм хариуцлагагүй компани. Тэгсэн мөртөө бид нар авч ашиглаж эхэлсэн зээл дээрээ хүү төлөөд эхэлчээж байгаа юм. Тийм учраас бид энэ алдагдлаа ч ярина, хариуцлагаа ч ярина. Үнийн өсөлт бол гарцаагүй, үнэхээр аудитлагдаад ирэх юм болбол зээлийн дүнг нэмэхээс өөр арга байхгүй. Тэгэхээр аль аль тал дээр нь бүгдээрээ задлаад шахаад явъя. Түүний өсөлт байдаг болбол тэрийг нь бушуухан шийдээд ажлыг нь түргэн шуурхай дуусгах тал дээр нь ч бас бодъё.

**С.Одонтуяа:** Буланы Бейсен гишүүн асууна. Байхгүй байна.

**Б.Бейсен:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Энэ 24 оны төсвийн төсөлтэй танилцлаа. Хэчнээн алдагдалтай төсөв гэсэн ч бас нэлээн улс орны хөгжлийг гаргасан сайхан төсөв тавигдсан байна. Харамсалтай нь би энэ багцаараа нэг эрүүл мэнд, боловсрол, ХАА чиглэлээр нэг хэдэн санал оруулсан. Уг нь саналаа 6 сарын 15-нд өгсөн юм. Тэгээд эд нар ороогүй байна. Ялангуяа энэ боловсролын салбар дээр манай аймгийн боловсролын салбарыг мэдээж байгаа 21 дүгээр байранд байдаг. Сурагчдын компьютер, тоног төхөөрөмж, багш нар ерөөсөө хангалтгүй. Энэ талаар бас тавьсан юм. Тэрийг тухайн үед нь би Боловсролын яаманд саналаа хүргүүлсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр гүйцэтгэлийн санхүүжилт орж байгаатай холбоотой сумууд гүйцэтгэлийн тоног төхөөрөмж дутагдалтай учраас гүйцэтгэлийн санхүүжилт авч чадахгүй байгаа. Тэрнээс болоод сумууд дээр шинжилгээ хийгдэхгүй, аймгийн нэгдсэн эмнэлэг яагаад аймаг руугаа яваад ачаалал нэмэгдэж гэж байгаа. Бас Чинзориг сайд саналаа хүргүүлсэн. Энийг үлдчихсэн байна, энийг нэг нэмж оруулж өгөөч гээд хүсэлт тавьж байна. Сангийн сайддаа, энэ ажлын хэсгийн ахлагч нартаа, тэр Сангийн яамны төрийн нарийнд бас хэлсэн, энэ санал юмыг хүлээж авна уу гээд хэлмээр байх юм. Яагаад ороогүй юм бол 1-д.

2 дугаарт Соёлын сайдаас Улаанхус сумын Соёлын төвийн барилгын тухай үед нь барилгын гадна дулааны угсралтын ажлын төсөв тавигдаагүй. Нэмж юу гаргасан байна зураг төсөв нь гарсан, Барилгын хөгжлийн төвийн дүгнэлт гарчихсан байна. Соёлын яамнаас 8 сарын 18-нд нэг очоод, 9 сарын 27-нд нэг очоод ингээд юу хийсэн байна хурал хийгээд тухайн төсвийг нь оруулж

өгөхөөр тохирсон байна. Гэтэл энэ нь ороогүй үлдчихсэн байна. Тэр гадна дулааныг гүйцэтгэсэн компани зээлээр аваад гүйцэтгэсэн. Тийм учраас энэ асуудлыг бас оруулж шийдэж өгнө үү гээд хэлмээр байх юм.

Нөгөө талаар манайхаас гарсан 2 гишүүний маань бүх хөрөнгө оруулалт тавигдсан байна. Минийхийг тавьж өгчихсөн үү гэдгийг хэлмээр байх юм. Энэ өгсөн юун дотор бас зарим юман дээр энэ жил Ховд гол дээр гүүр баригдсан шүү дээ Алтанцөгцийн наагуур. Дахиад гүүрний асуудал тавигдсан байна. Тэрийг эсэргүүцэж байгаа биш, ер нь тэрний төсвөөс хасаад уг нь би 4 тэрбум гэж байхад 3 тэрбум хэдэн 100-г л оруулсан юм. Энийг дотроо гүйлгэж болохоор юм шиг байна Сангийн сайдаа. Энэ тал дээр бас анхаарч өгнө үү гэдгийг хэлмээр байх юм.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Бейсен гишүүнээ нийт Баян-Өлгий аймагт болбол яг улсын төсөв хөрөнгө оруулалтаар болбол боловсролын салбарт 26 төсөл арга хэмжээ буюу сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заалны барилгууд баригдахаар эрх нь Баян-Өлгий аймаг руу шилжиж байгаа юм. Яг сүүлийн 2 жилд бол та намайг бас анзаарч байгаа байх. Энэ боловсролын салбарын Боловсрол, шинжлэх ухааны сайд болоод Баян-Өлгий аймагт бид нар 2 удаа өөрийн биеэр очиж ажилласан. Манай Баян-Өлгий аймгийн нэг зовлон болбол нэг зовлон биш ээ ер нь олон зовлон байгаа юм яг үнэнийг хэлэхэд Бейсен гишүүнээ. Одоо бид нар эрх шилжүүлээд явуулдаг, тэгээд бараг үндсэндээ тендер зарлах гэж 2 жил болж байна шүү дээ танай аймаг дээр тийм ээ. Тэгээд иргэдийн Хурлын Төлөөлөгчид нь хоорондоо тендерээ хувааж авдаг энэ нууц биш шүү дээ Бейсен гишүүнээ. Сүүлийн үед намайг нэг цэцэрлэг дээр 15 жижүүр байсан байна гэдгээрээ их буруутгаж байгаа юм шиг байна лээ. Энэ

үнэн шүү дээ. 1 цэцэрлэг дээр 8 жижүүртэй, тэгээд салбар салбар дээрээ дахиад жижүүрүүд тавьчихсан тийм л юм байна лээ.

Танай дээр манай салбарын 420 гаруй орон тоо илүү байна, 420 гаруй орон тоо. Сүүлдээ цэцэрлэгүүд нь төрийн цэцэрлэгүүд нь салбар цэцэрлэгүүд байгуулаад тийм ээ тэгээд өөрөө хажуу талд нь 2 улсын цэцэрлэг байхад тэндээсээ илүү хүүхдүүдийг нь аваад өрсөлддөг, улсын цэцэрлэгүүд нь хоорондоо хүүхдүүдийнхээ оронд хувьсах зардлаа авч өрсөлддөг энэ нэг ийм асуудал болсон. Боловсролын салбарын үнэлгээ, багийн үнэлгээ, сургууль, цэцэрлэгийн үнэлгээ хийхээр үнэлгээг маш буруу хийдэг. Бүх хүмүүсээ 100 хувь үнэлээд, бүх цэцэрлэгүүдээ 100 хувь үнэлээд явуулчихдаг ийм л аймаг болчихоод байгаа юм. Үнэнтэй нүүр тулж сурах ёстой. Тэгээд ер нь болбол Баян-Өлгий аймаг дээр байгаа энэ халамж, зарцуулж байгаа энэ мөнгөнүүд, улсаас санхүүжүүлж байгаа энэ мөнгийг бид нар их л сайн л үзмээр юм байна гэж би ойлгосон. Энэ дээр бид сүүлийн 2 жил болбол энэ Баян-Өлгий аймгийн боловсролын чанарыг дээшлүүлэх чиглэл рүү бас нэлээн онцгойлон анхаарч, Монгол Улсын гавьяат багш Цолмонбаатараар ахлуулсан бүрэн эрхт төлөөлөгч юм даа. Бид нарын хэлснээр БЭТ тавьж 30 гаруй гавьяатуудыг ийм багтай 2 жил ажиллуулж байна. Тодорхой үр дүн гарч байгаа, сайн сургуулиуд байгаа, сайн цэцэрлэгүүд байгаа.

Тэгээд та өөрөө яах вэ боловсролд бас ээлтэй гишүүний хувьд бол сүүлийн 2 жил тоног төхөөрөмжүүд, компьютерууд, ухаалаг самбаруудыг шийдэх гэж бас нэлээн оролдож байх шиг байна. Гэлээ гэхдээ сургууль, цэцэрлэгүүд дээр бид нар нөхөн хангалтын зардал гэж олгодог болсон Бейсен гишүүнээ. Нэг үеэ бодох юм болбол Улсын Их Хурлын гишүүн дээвэр цонхны засвар, компьютер тоног төхөөрөмжүүдийг ингээд Улсын Их Хурлын гишүүнээсээ гуйгаад, царайчлаад

байх биш өөрөө сургууль, цэцэрлэгүүд өөрөө энэ асуудлуудаа шийддэг ийм боломжуудыг үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо нэвтрүүлээд маш их том үр дүн гарч байгаа шүү дээ Бейсен гишүүн тийм ээ. Тэгэхээр энэ зүйл рүү та бас нэлээн энэ аймгийнхаа боловсролын салбарт байгаа асуудлууд, энэ бугшсан асуудлуудыг бас нэг идээ бээрүүдийг шахахгүй болбол яг бид нар их хүнд асуудлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр энэ зүйл дээр нэлээн санал санаачилгатай гаргах ёстой. Тэгээд таны саналыг бид нар бас дэмжиж, энэ нийт Баян-Өлгийн аймгийн гишүүдийн компьютержилтийн асуудлууд энэ аймгууд юу сургуулиудыг дижитал анги болгох чиглэл рүү бас нэлээн хамтарч ажиллаж байгаа. Тэгээд ямар ч байсан энэ 24 оны улсын төсвийн энэ хэлэлцүүлгийн үеэр таны гаргаж байгаа энэ саналуудыг бас салбарын сайдын хувьд бас нэлээн дэмжиж ажиллана гэдгийг бас би онцолж хэлье гэж бодож байна. Тийм баярлалаа.

**С.Одонтуяа:** Бейсен гишүүн тодруулах уу? 1 минут.

**Б.Бейсен:** Энэ саяын хөрөнгө оруулалтыг бол уг нь би өөрийнхөө багцаар яая гээд санал өгсөн юм байгаа юм 6 сарын 15-нд. Зүгээр тендер шалгаруулалт дээр тийм асуудал байгаа нь үнэн. Ноднингоос 3 сум үлдсэн байгаа бүрэн компьютерын кабинеттай гээд 30, 30 компьютертой сурагчийн ширээ, ухаалаг самбартайгаа тэгээд 3 үйлдэлт канонтойгоо. Энэ асуудлыг тавьсан юм. Тийм учраас энийг шийдүүлэх тал дээр бас анхаарч өгнө үү.

Сангийн сайдад хэлэхэд энэ дотроо гүйлгэх асуудлууд байгаа юм байна ер нь. Тэр талын асуудал дээр бас ажлын хэсэг дээр бас Тогтохсүрэн даргад бас саналаа хэлсэн. Би ганцаараа үлдчихээд байгаа юм байна энэ асуудлыг шийдэж өгч тусална уу гэдгээ хэлмээр байх юм.

**С.Одонтуяа:** Санал байлаа. Энхтайвангийн Бат-Амгалан гишүүн алга байна. Хассуурийн Ганхуяг байхгүй байна. Сүхбаатар гишүүн. Байгаа юм уу? Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууна. Тийм үү? Хүлээж байгаарай. Дэд сайд хариулах уу Батбаяр. Бейсен гишүүний асуултад 1 минут, 91 дүгээр микрофон. Асчихлаа.

**М.Батбаяр:** Бейсен гишүүний асуултад хариулъя. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын 300 хүний суудалтай соёлын төв 2019 оноос баригдаж эхэлсэн. Одоогийн байдлаар барилга угсралтын ажил бүрэн дуусаж дууссан байгаа. Тэгэхээр 19 оноос хойш анх эхлэх үедээ бол гадна шугам сүлжээний зураг төсөв байгаагүй. Ер нь бол энэ барилгын төсвийн бүрэн бүтэн байдлыг хангах, энэ төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх үүднээс бол зайлиггүй гадна шугам сүлжээтэй, төв сүлжээний зураг төсөвтэй, төв нь Барилгын хөгжлийн төвөөр баталгаажсан байж цаашидаа явах ийм чиглэл рүү Соёлын яам ажиллаж байгаа. Тэгээд сая энэ удаад гадна шугам сүлжээний төсөв 9 дүгээр сарын 25-ны өдөр баталгаажиж тус яаманд хүрэлцэн ирсэн. Ингээд үндсэндээ энэ удаад бол төсвөөс хоцорсон байгаа. Тэгээд цаашидаа бол энийг төсвийн хугацаанд нь бүрэн бүтэн байдлыг хангах тал дээр анхаарч ажиллаж байгаа. Тэгээд энэ удаагийн энэ одоо гаднын шугам сүлжээний төсөв.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Болчихсон, Бейсен гишүүнээ? Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууна.

**Х.Ганхуяг:** Хэд хэдэн асуулт байгаа. Тэгээд би бүх асуулт дээрээ хариултаа авчихмаар байна бүрэн дүүрэн. 1 дүгээрт сангуудыг шалгаж байгаа. Тэгээд энэ дээр нэг Ирээдүй их өв сан гээд 2,7 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй ийм сан байдаг. Ямар нэг үр өгөөжгүй, ханшийн алдагдал ингээд зүгээр үнэгүйдээд явж байгаа ийм сан байна.

Тэгээд энэ дээр яагаад өдий хүртэл ямар нэгэн арга хэмжээ авдаггүй юм бэ? Ядаж гадаадын А зэрэглэлтэй валютын бондод байршуулж болоогүй юу эсвэл валютаар хадгалж болоогүй юу гэдэг 1 дүгээр асуулт байна. Яагаад энийг үнэ үнэгүйдүүлээд, үнэ цэнгүйдүүлээд байгаа юм бэ?

2 дугаар асуудал болохоор энэ төсвийг дагасан хуулиуд дээр ААН-ийн ЗГ-ын бондыг авбал ААНОАТ-ыг хөнгөлж өгч байна, ХХОАТ-ыг хөнгөлж өгч байна. Ер нь бол ирэх жил бол ЗГ бол нэлээн идэвхтэй дотоодод бонд гаргана гэж харагдаж байна. Манай хувийн хэвшилд бол ерөөсөө орон зай үлдэхээргүй байхаар байна. Өнөөдөр бол зээлийн хүү чинь бол 20 хувь гарчхаад л явж л байна л даа одоо арилжааны банкнаас энгийн зээл авахад. Тэгээд ер нь бол яг ийм байдлаар явбал ер нь энэ ирэх жил энэ хувийн хэвшилд чинь ямар орон зай байх юм бэ? Ямар хувийн хүүтэйгээр зээл олдох юм бэ? Энэ дээр нэг хариулт авчихмаар байна.

Нийслэлийн төсөвтэй холбоотойгоор хэдэн асуулт асуумаар байна. Нийслэлээс сонгогдсон гишүүд түгжрэлийг шийдэх зорилгоор бид нар чинь бол бас нэлээдгүй хэмжээний төсвийг бол нийслэл хуримтлуулж байгаа. Тэгээд бид нар чинь ингээд тойрог дээрээ гэрэлтүүлгийн асуудал санаачилж болдоггүй, камержуулалтын асуудлыг оруулж болдоггүй, зам тохижилтын асуудлыг оруулж хэлж болдоггүй, зарим байранд дулаалгын асуудлыг оруулж болдоггүй. Тэгсэн мөртөө сая ингээд л хүүхэд хамгаалахтай холбоотой асуудал сэдэв хөндөгдөнгүүт та нар гишүүд та нар юу хийсэн бэ гээд л асуулт орж ирдэг. Тэгээд бид нарт эрхийг нь өгөхгүй, юм хийх гэхээр хийлгэхгүй. Манай тойрог дээр бол 2, 3 байшин байна ингээд дулаалга хийж байгаад яг гол дээр ирээд зогсчихсон, төсөв нь дуусчихсан гээд. Тэгээд бид нарын ойлголтоор бол энэ 23 онд тэр дуусаагүй объектуудыг дуусгаж өгнө гэж ойлгосон. Юу ч хийгдээгүй. Тэгээд дулаалга нь ч байхгүй, гэрэлтүүлэг

нь ч байхгүй, камержуулалт нь байхгүй, зам нь байхгүй, тохижилт нь байхгүй. Тэгээд энэ цаашидаа яг ийм асуудлууд хэрвээ нийслэл хариуцаж явах юм болбол 100 хувь хариуцаж явах юм уу эсвэл бид нар хариуцаж явах юм уу? Энийгээ нэг тийш нь гаргаж өгмөөр байна.

Тэгээд сая энэ үерийн эрсдэлтэй холбоотойгоор Даваасүрэн сайд бараг 4 их наяд төгрөг шаардлагатай гээд сая ярилаа л даа. Тэгээд энэ мөнгө нь хаана байгаа юм, хэн төсөвлөж байгаа юм, нийслэл дээр тавигдах юм уу, улсын төсөвт тавигдах юм уу энийг нэг хариулт авчихмаар байна.

ДНБ-д 6 мянган доллар хүрнэ гэсэн байдлаар сая Сангийн сайд бас мэдээлэл хүргэлээ. Тэгээд иргэдэд чинь энэ орлого чинь ерөөсөө наалдахгүй байна. Уг нь бол ЗГ энэ жил өрхийн орлого руу илүүтэй их анхаарч байгаа гэж ярьсан. Тэгээд энэ НӨАТ-тай холбоотой асуудал дээр уг нь байр сууриа нэгтгэсэн болов уу гэж бодсон чинь ингээд нэгтгээгүй, 2 тал болоод л үзээд байна л даа. Уг нь бол яах вэ НӨАТ-ын буцаалтыг нэмэгдүүлснээр яг өрхийн орлого, хувь хүний орлогод бол эергээр нөлөөлнө. Тэгээд энэ дээр бол нэг талдаа гармаар байна гэдэг нэг асуудал.

Тэгээд түгжрэлийг бууруулах чиглэлээр энэ ирэх жилийн төсөвт ямархуу хэмжээний мөнгө тавигдсан бэ? Ингээд нэг автобус гээд нэг баахан сая асуудал боллоо. Ирэх жил энэ автобусны худалдан авахад хийгдэх үү хийгдэхгүй юу гээд нэг хариулт авчихмаар байна.

Энэ төр хувийн хэвшлийн түншлэлийн энэ хуулийг ерөөсөө дутуу ашигласан байна. Энэ соёлын төв, энэ цэцэрлэг эд нарыг энэ аймаг сумдууддаа энэ хувийн хэвшилдээ боломжийг нь олгоод, урт хугацааны түрээсээр асуудлыг шийдэж болоогүй юу? Тэгээд ингээд бүгдийг нь хөрөнгө оруулалт болгож оруулалт тавиад л, тэгээд энэ төсөв чинь данхайгаад л ингээд л явж байна.

Тэгээд энэ сургуультай холбоотой, манай тойрогтой холбоотой энэ сургуулийн асуудал Алтай хотхон дээр манай Энх-Амгалан сайд бас ажиллаад сургуультай болгож өгсөнд байсанд бас талархаж байна. Тэгээд Материал Импекс гээд манай 25 дугаар хорооны асуудал байгаа.

**С.Одонтуяа:** Эхлээд хариултаа авчих уу? Тэгээд нэмэлт нэг минут. Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Ганхуяг гишүүн 8 асуулт асуусан. Би нэг минутад яагаад ч амжихгүй шүү. Ирээдүйн өв сан 25 оноос тийм боломж гарна. Одоо бол энэ чинь манай Төрийн сан дотор байдаг шүү дээ. Төрийн сан дотроос сугалж гаргаж ирээд А эргэлттэй өөр банканд аваачиж тавьж байршуулах боломжгүй 25 оноос тусдаа ингээд мөнгөтэйгөө цуг тусгаарлагдахаараа тэр үед ийм юу хийж болно. Эх үүсвэр, зохицуулалт үр ашигтай байх талын тэр юмыг тэр үед нь л бодох байх.

ДНБ 6 мянган долларт биш шүү. Нэг хүнд ноогдох үндэсний орлого 6 мянган долларт хүрэх юм. Ингээд бид нар төсвийн орлого нэмэгдэх хэрээр хамгийн эхний боломжуудаа хүн амынхаа өрхийн түвшинд нь орлогыг нь дэмжиж оруулж байгаа. Энэ жилийн 4,9 их наядын чинь ерөөсөө 70 хувь нь дангаараа цалин, тэтгэвэр тэтгэмж буюу шууд өрхийн орлого гар дээрээ очдог ийм орлогыг дэмжиж байгаа гэсэн үг.

НӨАТ маань Ганхуяг гишүүнээ ёстой уучлаарай. Хэдүүлээ одоо улс төр хийнэ хийнэ гэхэд ингээж улс орноороо тоглож ингээж болохгүй би танд энийг аминчлан захъя. Бид орлого олдог механизмаа дэмжих үү эсвэл хэрэглээг нь дэмжих юм уу? Та хэрэглээг нь дэмжье гээд байх шиг байна. Хэрэглээг нь дэмжье гэж байгаа бол ёстой нөгөө инфляц руугаа явна. Энэ яах вэ энэ ингээд онолын асуудал. Гэтэл одоо байгаа хуримтлал



одоо байгаа тогтолцоогоор чинь энэ НӨАТ-ын орлогын чинь ерөөсөө НӨАТ төлөгч нарын 10 хувь нь нийт НӨАТ-ын орлогын 60 хувийг нь бүрдүүлж байгаа юм. Та эргүүлээд ингээд урамшууллыг нь буцаагаад тавьчихъя гэж байна. Тэгвэл буцааж тавих тэр 60 хувь чинь нөгөө л 10 хувь дээрээ очно. Хэрвээ танд энэ төсвийн боломж нь 600 тэрбум төгрөгийн боломж байгаа болбол өөр сувгаар өрх бүрд ордог хүүхдийн мөнгөө тэгвэл нэмье л дээ тэр 600 тэрбумаараа. Тэгж байж наад чинь байгаа онож, яг олон нийтэд жигд очих комбинац болно. Тэгэхгүй ингээд яг өндөр хэрэглээтэй, өндөр орлоготой хэсгээ л буцаагаад тэр лүү нь аваачиж өгөөд ийм ёстой жинхэнэ энэ чинь төсвийн үрэлгэн зардал болно. Би ингээд бусад дутуу юмнуудыг нь бол орхилоо шүү. Энэ хэсгийг нь л ярьчихъя.

Түгжрэл рүү гэж байна. Ер нь нийслэл рүү бид нар сүүлийн жилүүдийн төсвийнхөө ёстой үндсэндээ дээжийг нь хамаг байдгаа л тийш нь боломжуудаа тавьж өгч байгаа шүү. Сайнзориг дарга энэ талаар ярих гээд байх шиг байна. Та нэг нэмээд өгөөрэй. Төр хувийн хэвшлийн түншлэл дээр тантай би 100 хувь санал нийлж байна. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль сая 7 сарын 1-нээс хэрэгжих байсан. Харамсалтай нь нэг хагас жилээр хойшлуулчихсан. 1 сарын 1-нээс ингээд хэрэгжээд эхлэхээр бид дараагийн бидний энэ хөрөнгө оруулалтын ялангуяа маш их ирээдүй боломж бол энэ хуулиар зохицуулагдана. Таны ярьж байгаа тэр цэцэрлэг, сургууль бол бүрэн боломжтой ийм ажлууд байгаа. Амжчихсан уу?

**С.Одонтуяа:** Годруулах уу Ганхуяг гишүүн? 1 минут.

**Х.Ганхуяг:** Энэ орон нутгийн төсөвтэй холбоотойгоор нэмээд хариулчхаарай. Дараагийн асуудал болохоор энэ үдийн хоолтой сургуулийн үдийн хоолтой холбоотой нэг асуулт байгаа. Материалыг нь бэлдэж өгдөг нь ТӨК-уд, худалдан авалт хийдэг нь төр.

Тэгсэн мөртөө энэ дунд нь НӨАТ татвар аваад яваад байгаа. Тэгээд НӨАТ-ын татварыг нь тэглэж болдоггүй юм уу? НӨАТ төлөгч биш шүү дээ. Тэгээд яг нөгөө нэг өртөг нь хүүхдэд очиж байгаа хоолны өртөг чинь л өсөөд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр нэг хариулт авчихмаар байна.

Дараагийн асуулт 2024 он бол олимпын жил. Тэгээд бид нар чинь ингээд тусдаа яам сайдтай болсон. Тэгээд ирэх жил бид нар энэ цагаан тугтай орох гээд байна уу, Монгол улсынхаа тугтай орох гээд байна уу? Тэгээд яагаад үндэсний шигшээ багууд дээр энэ багийн спорт дээр яагаад ер нь санхүүжилт олгодоггүй юм бэ? Яагаад тэр үндэсний шигшээ багийн багийн спортынхонд цалин өгдөггүй юм гэдэг асуулт байна.

Тэгээд энэ дараагийн асуулт болохоор энэ талх гурилан бүтээгдэхүүнтэй холбоотой асуулт байна. Сая өчигдөр ингээд захуудаар явлаа. Талх бол үндсэндээ 43 хувиар өсчихсөн байна үнэ нь. Тэгээд бид нар чинь ингээд.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Эхлээд хариулт хангалтгүй гэж үзвэл нэмээд нэмж өгнө дэгээрээ. Хэн хариулах юм бэ Жавхлан сайд уу?

**Б.Жавхлан:** Улаанбаатар хотын гишүүд маань нийтлэг асуулт тэр орон нутгаар хийгддэг ажлуудыг асуугаад байгаа юм. Маш ойлгомжтой ингээд заачихсан байгаа шүү. Улсын төсвөөс ийм юм хийж болохгүй, ийм юмыг орон нутгаар хийнэ гээд. Тэрэн дотор ялангуяа яг таны асууж байгаа болон түрүүн Цогтбаатар гишүүний ч асуугаад байсан тэр үер устай холбоотой үерийн далан эд нар гээд ийм дэд бүтцийн ийм шугамуудыг болбол нийслэл өөрөө бүрэн хийгээд явах ийм хуулийн үүрэгтэй юм.

Олимп дээр бол ингэж байгаа сайн мэдээтэй байгаа. Одоо бид ийм олимпын олимпизм хариуцсан спортоо хариуцсан

сайдтай болсных Бат-Эрдэнэ сайд маань ажлаа авмагцаа энэ яг юуг, юу билээ золиг, тэр допингийн асуудлыг ярьсан юм. Тэгээд аягүй олон жил нөгөө төлбөр нь төлөгдөөгүй ирчихсэн харин яаж азаар тэр үед Бат-Эрдэнэ сайд надад хэлээд бид 2 тэрийг хараад, тэгээд тэр үед нь нэг юу бараг тэрбум төгрөг байх даа төлчихсэн байхгүй юу. Өнгөрсөн жилийн сүүлээр юм. Хэрвээ тэр төлөөгүй.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Жавхлан сайд гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Бат-Эрдэнэ сайд байхгүй учраас би өмнөөс нь хариулаад байгаа юм шүү. Тэгээд одоо болбол тэр цагаан тэр цагаан юу муу гэж байхгүй. Улс улсынхаа далбаан дор оролгүй яах вэ, тийм бэлэггүй юм гэж юу байх вэ. Тэр багийн спорт дээр хоёулаа яг адилхан. Би бас хоккейн спортынхоо холбоог толгойлсоор л байгаа. Та сагсанд бас их дуртай хүн. Тэгэхдээ энэ дээр ядаж хэдүүлээ энэ багийн спортууд маань олимпод ордог болчихвол татвар төлөгчдийнхөө мөнгийг тэр хүмүүстээ зориулах юм. Үгүй ээ тэгээд л орсноос нь хойш л явуулъя л даа. Юун тэр чинь өмнө нь ороогүй л байсан биз дээ. Тэгэхээр олимпын төрөлд орчихсон спортууд дээр болбол тусгай тийм журам байдаг юм байна лээ. Тэрийгээ дагах биз дээ. Тийм.

**С.Одонтуяа:** Ганхуяг гишүүн тодруулъя 1 минут.

**Х.Ганхуяг:** 3-ыг үржих 3 дээр манай үндэсний шигшээ баг 2016 онд, 2020 онд олимпод орсон шүү эмэгтэй баг. Та ороогүй гэж худлаа ярьж болохгүй шүү. Тэгээд энэ дээр бол онцгой анхаарал тавьж өгөөрэй гэж хүсмээр байна.

Дараагийн бас энэ талхтай холбоотой асуудал байна л даа. 43 хувь өссөн 7 сараас хойш. Тэгсэн мөртөө бид нар татаас өгөөд байдаг. Өнөөдөр дэлхийн улаан буудайны хани 240 доллар байна, манайх бараг 300 гаруй доллар

байгаа байхгүй юу. Тэгээд энэ бүүр ингээд хиймлээр зохиомлоор үнийг нь үнэтэй болгоод байгаа байхгүй юу талхныхаа үнийг, гурилынхаа үнийг. Тэгээд энэ дээр энэ судалгаа хийдэггүй юм уу та нар чинь татаас өгөхдөө ер нь? Энэ дээр хариулт авъя.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Тэр олимпын төрөлд орсон энэ тэрийг би яаж бүгдийг нь мэдэх вэ уучлаарай буруу хэлчихсэн бол амжилт хүсье. Тэгээд олимпын аварга болоорой. Тэр талхыг би бол наадах дээр чинь бол 100 хувь санал нийлж байна шүү. ХАА-н салбар он удаан жил хамгийн их татаас авдаг л, хамгийн их дэмжлэг төсвөөс дэмжлэг авдаг л ийм л салбар. Тэгээд ерөөсөө проблем нь дуусдаггүй, үр дүн гарч байгаа эсэх нь бас шууд мэдрэгддэггүй. Тэгэхээр цаашидаа энэ дэмжлэг, энэ татаасуудыг бол шууд үр дүнтэй нь уяж, үр дүн дээр нь суурилсан байдлаар ингэж санхүүжүүлж явах нь болбол хамгийн зөв, тийм. Тантай санал нийлж байна. ХАА-нхан байвал үр дүн гардаг юм уу үгүй юм уу тэр талаараа нэг мэдээлэл өгөөдхөөч. Болорчулуун дарга байна уу?

**С.Одонтуяа:** ХААЯ хариулчих, Болорчулуун дарга, энэ их татаас өгөөд үр дүн гарч байна уу гэсэн. Танд 2 минут өгчихсөн. Та дараа нь тусдаа очоод яачихгүй юу асуучих.

**Ц.Болорчулуун:** Ганхуяг гишүүний асуултад нэмж хариулъя. Тэгэхээр талхны үнийн өсөлт, гурилын үнийн өсөлт бол ингээд улаан буудайн ингээд өөрийн өртөгтэй холбоотой байгаад байгаа юм. Улаан буудайн үйлдвэрлэлд орж байгаа үндсэн орцууд болох техник тоног төхөөрөмж, үр бордоо, ургамал хамгааллын бодис бүгдээрээ 100 хувь импортын хамааралтай байгаад байгаа юм. Тэгээд дэлхийн зах зээл дээр металлын үнэ сүүлийн жилүүдэд 30-аас 40 хувь өсчихсөн. Тэгээд ОХУ-д бас улаан

буудайн үр үйлдвэр үрийн үнэ бас тодорхой хэмжээнд өсчихсөн, тэгээд шатахуун бас тодорхой хэмжээнд өсөлттэй орж ирж байгаа тэгээд эдгээрээс хамаараад улаан буудайн өөрийн өртөг болбол нэлээд өндөр гараад байгаа. Тэгээд өнгөрсөн жилийн ургацаас бид тооцоо хийж үзэхэд намрын ургац дээр болбол 28-аас 30 хувийн өсөлттэй.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Болорчулуун дарга гүйцээгээд хариулчих 2 номерын микрофон.

**Ц.Болорчулуун:** Бид улаан буудайныхаа үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээгээ яг хангахуйц хэмжээнд л үйлдвэрлэл явуулж байгаа. Тэгээд шаардлагатай тохиолдолд дутагдаж байгаа бага зэргийн буудайг болбол Оросын холбооны улсаас импортлож, дээрээс нь Монголоос бас үйлдвэрлэж байгаа буудайны чанартай холбоотой бас сайжруулагч хэлбэрээр ингэж улаан буудайг оруулж ирж ийм байдлаар бол гурилынхаа үйлдвэрлэлийг явуулж, хангамжаа бүрдүүлж байгаа. Тэгэхээр энэ нь импорттой холбоотой байгаа учраас тодорхой хэмжээнд гурилын өөрийн өртөгт нөлөөлж байгаа. Үүнтэй холбоотой бас үнийн өсөлт тодорхой хэмжээнд гарч байгаа гэдгийг хэлье.

**С.Одонтуяа:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууна.

**М.Оюунчимэг:** Энэ Ганхуяг гишүүний яриад байгаа нэг зүйл бол үнэн юм. Энэ талх 43 хувь, гурилан дээр инфляц 140 хувиар өсчихсөн гээд татаас хамгийн их өгч байгаа, тэгээд энэ нь ийм зөрөөтэй. Одоо энэ нь тэгтэл хөрөнгө оруулалт дээр ийм юм ороод ирж байгаа байхгүй юу. Бас л Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төслийн төсөлд тариалангийн талбайг хашаалуулах арга хэмжээнд л гэхэд 6,5 тэрбум төгрөг төсөвлөөд. Гэтэл 20.1.2 дээр хувийн ААН тариалан эрхэлж байгаа бол хашаагаа өөрсдөө барина гээд хуульд заачихсан

байхад 6,5 тэрбум төсөвлөөд ороод ирчихсэн.

Гэтэл Энх-Амгалан сайд өнөөдөр 67 сургууль, цэцэрлэгийн барилга гацчихсан байна. Түүний нэг нь манай ЧД-ийн 5 дугаар сургууль 97 хувьтай. Өнөөдөр 3, 4 дүгээр ангийн 500 хүүхэд нь Хөдөлмөрийн дээд сургууль дээр аюултай орчинд хаалга байхгүй тэр газар сурч ч чадахгүй Үндсэн хуулиар аюулгүй орчинд сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй ингээд байж байна шүү дээ. Салбарын сайд маань ч очсон. Тэгээд хэн ажил хийх юм, яагаад энэ нь биелдэггүй юм бол? Аудитын газар дээр бас магадлал нь очсон, Сангийн яаман дээр энэ шийдсэн байх ёстой. Уг нь Монгол Улсын Ерөнхий сайд энэ удаагийн төсвийн онцлог нь эрүүл мэнд, боловсролын салбарт онцгой анхаарч энд хөрөнгө оруулалтыг юунаас ч харамлахгүй гэж хэлсэн. Гэтэл ийм байж байна шүү дээ. Одоо хүйтэрлээ, тэр 500 гаруй 3, 4 дүгээр ангийн хүүхдүүд яах вэ Энх-Амгалан сайдаа? Эцэг эхчүүд өдөр болгон биднээс асууж байна 97 хувьтай байгаа 5 дугаар сургуулийн тухайд нэг хариулт авъя гэж бодож байна.

2 дахь зүйл нь би Сайнзориг даргыг бас энэ нийслэлийн 1 дүгээр орлогч болсонд бас их найдвар тавьж, их талархаж хүлээж авч байгаа. Саяын асуугаад байгаа үнэн. 2020 оноос хойш нийслэл Улаанбаатар хотод жишээлбэл ялангуяа гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил тэг зогсолттой байгаа. БХБЯ-нд тусгасан тухайн үеийн мөнгө нь ковидоос болоод гацсан, өөр юманд зарцуулсан. Дараа нь нийслэл дээр очсон, БХБЯ нийслэл 2 дундаа ингэсээр байгаад огт юм яваагүй. Одоо бид 24 оны улсын төсөв ярьж байна. Тэгэхээр сая Сангийн сайдын ярианаас үзэхэд нийслэл дээр л ер нь асуудал очно гээд байх юм. Гэхдээ энэ ганц нийслэл энийг хийж чадах уу? Гэр хорооллын дахин төлөвлөлт явах уу? Дэд төвүүд яах вэ? Жишээлбэл манай ЧД-т гэхэд 16-аас 20 онд бид бараг 8 тэрбум төгрөгийн шугам сүлжээ, 40 тэрбум төгрөгийн шугам сүлжээ

тавьчихсан. Энэ дээрээ байшингаа баримаар байдаг, хүмүүс хүлээлттэй байгаад байдаг. Тэгээд санхүүжилт улсын төсөв ч байдаггүй, нийслэлийн төсөв ч суудаггүй, БХБ-ын сайд төсөв мөнгийг нь шийдэхгүй бол болохгүй байгаад байна гэж яриад байдаг. Тэгэхээр энэ дээр Сангийн сайд маань ч нэг хариулт өгмөөр байна.

Улсын төсөв дээр энэ нийслэл Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдол дээр, ялангуяа гэр хорооллын энэ дахин төлөвлөлт дээр, шугам сүлжээ, дэд бүтэц, хэсэгчилсэн инженерүүдийг татах дээр яаж, ямар бодлого барих юм бэ? Монгол Улсын Ерөнхий сайд очихдоо бол одоо энэ дээр онцгой анхаарна гэсэн. Гэтэл огт шаардлагагүй энэ тэр тариалангийн талбайг хашиалуулах 6,5 тэрбум төгрөг энэ шаардлагагүй хөрөнгө оруулалт асар их байна гээд аудитын энэ дээр гарчихсан байна шүү дээ. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 13 тэрбум төгрөг энэ тэр гээд л. Дахин, дахин ингээд л 3, 4 дахин төсөв нь нэмэгдээд байдаг. Гэтэл хүн амын талаас илүү хувь нь амьдарч байгаа Улаанбаатар хотынхоо хөрсний бохирдол, одоо утаа юу болох вэ, бид яах ёстой юм бэ? Нийслэл Улаанбаатар хотод зөндөө мөнгө өгсөн гээд байдаг. Өнөөдөр бид юу шийдсэн юм, юу ч шийдэгдээгүй байна шүү дээ. Сая тэгээд л автобусны асуудал нь юу болчхов?

Тэгээд энэ бас Үндсэн хуулиар зөрчигдсөн эрх зөрчигдөөд байна шүү дээ олон мянган хүний. Бүх эмнэлэгт хүүхдүүд өнөөдөр оргүй болж эхэлж байна. Яасан нөгөө хөрс, агаарын бохирдлоосоо үүдэлтэй хамрын ханиад нөгөө энэ амьсгалын ханиад асар их болж байна гээд. Одоо хүүхэд хэвтэх газаргүй болж байна шүү дээ. Тэгэхэд бид яг төсөв хэлэлцэж байна, яг энэндээ онцгой анхаармаар байна. Энэ онц шаардлагагүй гэсэн Аудитын газраас өгсөн дүгнэлтэд тусгагдсан энэ хөрөнгө оруулалтуудыг нь болиод, харин энэ шаардлагатай юм руу тусгамаар байна. Тэгэхээр гэр хорооллын

дахин төлөвлөлт, инженер, сургуулийн саяын зүйл дээр тодорхой хариулт эхлээд авахыг хүсэж байна.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Нийслэл 1 дүгээр микрофон Сайнзориг нийслэлийн 1 дүгээр орлогч дарга.

**П.Сайнзориг:** Оюунчимэг гишүүний асуултад хариульа. Мэдээж энэ замын хөдөлгөөний түгжрэл, энэ орчны бохирдол буюу агаарын бохирдол бол бас нийслэл Улаанбаатар хотын иргэдийн тулгамдсан буюу ер нь стресс бухимдлыг төрүүлж байгаа асуудал мөн. Гэхдээ бас үе үеийн ЗГ энэ дээр анхаарч ирсэн боловч энэ удаагийн ЗГ бас нэлээдгүй анхаарал хандуулж бас зөв шийдэл, хөрөнгө оруулалт, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд бол нэлээдгүй ажиллаж байгаа гэдэг зүйлийг бас хэлмээр байна. Тун удахгүй бас ЗГ-таа бид нар бас холбогдох гэр хорооллыг замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуулийн төслийг бас өргөн барьж байгаа. Энэ хүрээндээ бас замын хөдөлгөөний түгжрэл болоод энэ гэр хорооллыг орон сууцжуулах асуудал дээр хууль, эрх зүйн тэр түгжээнүүдийг алга болгож байж цаашидаа бас энэ орж ирж байгаа олон улсын зээл хөтөлбөрүүдийг үр дүнтэй зарцуулах энэ чиглэлдээ бас нэлээн том алхахыг хүсэж байгаа.

Өөрөөр хэлбэл бас өнөөдөр бас Сангийн яамнаас хүртэл дэмжиж бас Нийслэлийн дэргэд бас энэ ногоон орон сууцын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бас их компанийг байгуулах энэ зөвшөөрлийг өгч байгаа. Дээрээс нь бид мэдээж яг бэлэн болчихоод байгаа дэд бүтцийн хувьд Сэлбэ дэд бүтэц болон Баянхошуу дэд бүтэц дээрээ тулгуурлаад ерөнхийдөө хамгийн түрүүнд газар чөлөөлөлтийг хийж, энэ дээр иж бүрнээр нь төлөвлөе гэж байгаа. Цэгэн төлөвлөлт гэж практик дээр ярьдаг юм байна лээ. Жижиг жижгээр төлөвлөх энэ рүү биш цогц байдлаар нь төлөвлөж, тодорхой хэмжээний энд өртөгдөж байгаа 68 мянган иргэдийнхээ

эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг цогц байдлаар шийдэх алхмыг Сэлбэ дэд төвөөсөө эхлээд явъя гэсэн ийм төлөвлөлт гаргаад, ирэх жилээс энэ газар чөлөөлтийг эхлүүлж бас тодорхой хэмжээнд барилгын ажлыг шуурхай эхлүүлэх ийм бодолтойгоор бас холбогдох хуулийн төслүүдийг өргөн барьж байгаа.

Энэ хүрээндээ бас 1800-гаад 50 өрхийн бас асуудал байна. Эргээд энийгээ бас тодорхой хэмжээнд нийгмийн асуудалтайгаа уялдуулж шийднэ. Энд байгаа бас амьжиргааны түвшин доогуур байгаа иргэдийгээ энэ бүтээн байгуулалтад оролцуулах, мэргэшүүлэх, эргээд энэ юу гэдэг юм бүтээн байгуулсан орон сууцдаа амьдарч байх энэ иргэд маань бас санхүүгийн хувьд болон ажлын байрны хувьд тодорхой орлоготой болох юм бол энэ бас төсөл цаашидаа fail-дэхгүй явах гэдэг юм уу, энэ эргэлтийн хөрөнгүүд нь бий болох зэргээр бас үе шаттайгаар энэ алхмуудыг эхлүүлнэ.

Дээрээс нь мэдээж юу гэдэг юм нийгмийн, нийслэл Улаанбаатар хотын яг энэ түгжрэлийг иж бүрнээр шийдэх юм бол энэ 2 дэд бүтцийг цаашиаа үргэлжлүүлэх Дамбадаржаа, эргээд энэ Толгойт ч гэдэг юм уу, Шархад гээд бусад тэр 4 дэд төвүүдийг байгуулах энэ ТЭЗҮ-үүд гарсан. Энийгээ мөн бас үргэлжлүүлээд шуурхай шийдэх асуудлууд байна.

Дээрээс нь нийтийн тээврийн хүртээмжийн асуудал байгаа. Энэ асуудлаа бас олон улсын нээлттэй тендерийг өнөөдөр ингээд зарлаж байна. Тэгээд яг бас тодорхой хэмжээний хугацаа алдсан ийм зүйл байна. Өнөөдрийн байдлаар 20 дизель автобус, өмнөх тендер худалдан авалтаар бол 20 дизель автобус, 50 ширхэг дунд оврын автобус энэ бол богинын рейст явах, эргээд 55 цахилгаан автобус авчихсан энэ үйлчилгээнд гаргаж байгаа. Энэ олон улсын нээлттэй тендерээр бусад олгогдсон энэ санхүүжилтийн хүрээнд том оврын нийтийн тээврийн

автобуснуудаа авахаар бас нийслэлээс холбогдох тендерийг зохион байгуулалтыг хангаж, өнөөдрөөс эхлээд энэ нээлттэй тендер зарлагдаад явж байна.

Тэгээд ер нь зүгээр энэ түгжрэлийн асуудал бас нэлээн суурь асуудал буюу үр дүнтэй тэмцэхээсээ илүү шалтгаан нөхцөлийг л олж зогсоох ёстой юм байна лээ. Ер нь зүгээр сургуулийн жишээ нь төвлөрөл энэ хотын төвдөө бий болчихсон. Эргээд энэ хотын төвүүдийнхээ сургуулийг л өргөтгөөд ч юм уу, энэ давхарлаж нэмээд байх юм бол энэ түгжрэл ерөөсөө шийдэгдэхгүй. Өөрөөр хэлэх юм бол тэр яг сургуулийг аль болохоор нийслэлийн тэр гэр хорооллын тулгамдсан буюу сургууль, цэцэрлэгийн хүртээмж багатай иргэд рүүгээ ойртуулах энэ алхмыг хийхгүй бол буцаад л юу гэдэг юм зөвхөн нийслэл хотын тэр сургууль хүртээмж багатай хэсгээс орж ирэх 91 мянган хүүхдүүд өнөөдөр өглөө болгон хотын төв рүү сургуульд явах, энийгээ дагасан тээврийн түгжрэлийн асуудал үүсэх, магадгүй бусад хүүхдүүд нь гэртээ ороод гэрийн даалгавраа хийж байхад энэ хүүхдүүд сурч боловсрох.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Баярлалаа. Жавхлан сайд нэмж хариулъя 1 минут. Дараа нь Болорчулуун дарга тэр хашиагаа.

**Б.Жавхлан:** Оюунчимэг гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье. Тэр Хүнс, хөдөө аж ахуйн яамны урсгал зардал дээр нь бараа үйлчилгээний бусад зардал гээд байдаг юм шүү. Тэрийг аудит хийж байх үед Аудитын үндэсний аудитын газарт Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан өөрсдөө тайлбар хийхдээ энийг энэ хашиаа гээд тэгж тайлбарласан байна лээ. Тэгээд Үндэсний аудитын газрынхан тийм аудитын дүгнэлт хийсэн байна. Баярлалаа гэж хэлмээр байгаа юм Үндэсний аудитынханд. Аудит хийлгэсэн бид нарт ийм юм хэрэгтэй байдаг байхгүй юу. Дараа хэрвээ түрүүгээрээ хашиа хийж гэж байгаа болбол ингээд аудитын ийм

дүгнэлттэй байгаа болбол гарчхаж байгаа юм чинь Төрийн сан дээрээс зардал гарахгүй, ирвэл бид нар гүйцэтгэл гаргахгүй, Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан энийг сонсоорой. Оюунчимэг гишүүн бас зөв сэдэв хөндчихлөө. Ийм аудитын дүгнэлт орчихсон байна. Тэгээд манайхан тэр үед нь бас Болорчулуун.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Болорчулуун дарга нэмээд хариулъя.

**Ц.Болорчулуун:** Оюунчимэг гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр өнөөдөр Монгол Улс бас энэ газар тариалангийн үйлдвэрлэлд нийт газар нутгийн 0,7 хүрэхгүй газрыг бол ашиглаж байгаа. Тухайлбал 880 орчим мянган га талбай л байна. Сүүлийн жилүүдэд энэ цаг уурын нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор урдаасаа хойшоо цөлжилт маш их явагдаж байгаа. Тариалангийн талбай болбол маш их хумигдаж байгаа. Тэгэхээр бид нар болбол саяхан ингээд 2008 оноос өмнө бол бараг бүх улсаас ингээд гурилаа гуйдаг ийм нөхцөл байдалд байсан. Сүүлийн жилүүдэд бол мэдээж төр засгаас анхаарч тодорхой хэмжээний татаас, урамшуулал, дэмжлэг үзүүлсний үр дүнд ямар ч байсан гурилаа гаднаас гуйхгүй хэмжээнд, төмсөө дотооддоо үйлдвэрлэл 100 хувь үйлдвэрлэдэг хэмжээнд. Энэ жилийн тухайд гэх юм бол бид нар саяхан 3 жилийн өмнө хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээний 40 гаруй хувийг хангадаг байсан бол энэ жилийн тухайд 82 хувийг хангах ийм том бас амжилтыг үзүүлээд байгаа. Тэгэхээр энэ.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Дуустал хариулчих 2 номер.

**Ц.Болорчулуун:** Тэгэхээр энэ төр засгаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд бас үр дүнгээ өгч байгаа. Бид нар бас хүнсний хүнсний ногоо, үр тариа, улаан буудайгаараа дотоодын

хэрэгцээгээ хангахуйц хэмжээнд болчихсон, гаднаас гуйлга гуйхгүй хэмжээнд болж байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд энэ манай салбар дээр нэг хаашаа гэдэг үг орж ирээд байгаа юм. Тэгэхээр энэ хаашаа гэдэг бол өөрөө энэ хаашаа гэдэг үгэндээ гол нь биш. Энэ болбол мэдээж энэ 0,7 хувь хүрэхгүй байгаа тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах асуудал байгаад байгаа юм. Энэ Тариалангийн тухай хуулийн 19.5.2-т тариалангийн хөрсний үржил шимийг хамгаалах, тэгээд ургамал хамгааллын зохистой хэрэглээг бий болгох, ойн зурвас байгуулах гээд ингээд тодорхой заалт ороод өгчихсөн байж байгаа. Энэ нь өөрөө энэ тариалангийн талбай төрийн газар байгаад байгаа. Энийг хамгаалах, хөрсний үржлийн шимийг нь хамгаалж цаашидаа бид нар үе удмаараа дамжсан энэ ургац авч хүнсний ногоо бусад үр тариагаа дотоодын хэрэгцээгээ хангахад, дотоодоос хангахад энэ талбайгаа ингэж хамгаалах нь болбол зайлшгүй байгаад байгаа.

Тийм учраас энэ эрх зүйн орчин нь бүрдчихсэн байгаад байгаа юм. Энэ дээр зөвхөн хаашааны асуудал биш байгаад байгаа. Энд маш өндөр технологитой техникийг технологи нэвтрүүлэхэд, энд хамгаалахгүй бол одоо бид нар ингээд цөлжилт явагдаад байна, дээрээс нь бэлчээрийн МАА газар тариалангийн бүсэд нэлээд зонхилчихсон байгаа учраас бид нар ургацаа авахгүй байх ийм нөхцөл байдал үүсэх гээд байгаа учраас энэ дээр бол хөрсний үржил шимийг хамгаалах энэ арга хэмжээг төр тодорхой хэмжээнд төрийн газар дээрээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэг байдлаар туссан. Энэ дээр болбол зөвхөн нэг хаашаа гэж орсон үгийг болбол хаашааны асуудал биш гэдгийг бас онцгойлж хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

**С.Одонтуяа:** Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Оюунчимэг

гишүүнээ ер нь энэ ганцхан 5 дугаар сургуулийн асуудал биш. Энэ зун бид нар бас нэлээн хэдэн сургууль дээр ажилласан. Тэгээд яах вэ би өчигдөр Байнгын хороон дээр энэ төсөв шантаажилдаг өвсний хурга шиг болсон хэдэн компаниудтай болсон байна гэж би нэг үг хэлсэн юм. Тэгээд энэ ордны гадаа жагсааж байгаа зарим компаниуд бас занаж эхэлж байх шиг байна л даа. Ийм компаниуд байгаа. Тэр тусмаа яг энэ угжны хурга шиг компани бол танай 5 дугаар сургуулийг барьж байгаа компани. Сургуулиа дуусгачхаад 2 жил болж байгаа шүү дээ, дуусчихсан сургууль. Би очиж үзсэн, 97 хувийн гүйцэтгэлтэй, одоо 200-хан сая төгрөгийн нэмэлт засвар хийгээд л будаг түрхээд л тэгээд л ороход бэлэн. Гэсэн чинь энд 3 аравны хэдэн тэрбум төгрөг нэхээд ингээд сууж байгаа юм. Тийм учраас магадлан хийлгэх гэхээр одоо гүйцэтгэгч нь байгаа учраас магадлан хийж болдоггүй юм байна. Тэгэхээр бид нар гэрээг нь цуцалж байгаа. Энэ жил ер нь болбол бид нар 27 компанийн гэрээг цуцалж, хар жагсаалтад оруулах ЗГ, Сангийн яаманд бид нар саналаа хүргүүлчихсэн байж байгаа.

**С.Одонтуяа:** Оюунчимэг гишүүн тодруулъя.

**М.Оюунчимэг:** Энх-Амгалан сайд тэр компани яам хоёрын маргаанаас болоод хариуцлагагүй компани тендерт нь ялуулаад энэнээс болоод хүүхэд хохирч болохгүй. Өнөөдөр тэнд 3, 4 дүгээр ангийн 500 гаруй хүүхэд хар өглөөгүүр бас сая хэлж байна шүү дээ, машин ч байхгүй тэгээд тэр Хөдөлмөрийн дээд сургууль гээд хүйтэн газар өвөлжих гэж байна шүү дээ. Тэгэхэд чинь компани гээд, тэр компаниа та нар учраа ол, одоо цуцлахад дахиад яах вэ тэр 5 дугаар сургуулийн гүйцэтгэл бүүр зогсох нь. Тэгэхээр яах вэ та салбарын сайдын хувьд арга хэмжээ аваач, энэ хүүхдүүдийг битгий хохироогооч. Тэр 2 хувийг нь дуусгаад өгөөч, би энийг бүүр танаас хүсье. Та очихдоо бас амласан. Тэгээд энэ тэр бусад асуудлаа өөрсдөө шийдээрэй, энийг би

таныг шийднэ байх гэж үнэхээр итгэж байна шүү гэдгийг нэгд хэлчихье.

2-т нь Болорчулуун дарга ингээд л нэг сайхан хариулах юм. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн хамаг мөнгийг нь цөлмөөд л авсан том, том компаниуд өнөөдөр манай хашааг барьж орхих гэж байгаад баярлалаа гээд л сая дарга нарыг очиход инээгээд л зогсож байна шүү дээ. Болохгүй шүү дээ. Энэ мөнгө энэ 6,5 тэрбум төгрөг.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Энх-Амгалан сайд хариулна. Оюунчимэг гишүүнээ дэгээрээ 1, 1 минутаар л явна дэг нь тийм.

**Л.Энх-Амгалан:** Оюунчимэг гишүүнээ намайг загнаад яах вэ дээ. Уг нь болбол энэ чинь би Боловсролын сайдын хувьд өнөөдөр Монгол Улсад баригдаж байгаа 380 барилга дээр очиж ажиллаж чадахгүй шүү дээ тийм ээ. Тэгээд энэ зун би наад сургууль дээр чинь 2 удаа очсон юм харин. Би өөрийн биеэр очсон юм. Тэгээд энэ тендерийг чинь манай компани юу манай яам зарлаагүй юм. Одоо бид нар Улаанбаатар хотод эрх шилжүүлээд ингээд ер нь орон нутагт ингээд энэ тендерийн эрх шилжүүлээд энэ тендер зарлаж байгаа компаниуд чинь юу орон нутгууд чинь өөрсдөө хариуцлага хүлээх ёстой шүү дээ. Би түрүүн Баян-Өлгийгийн жишээг ярилаа. Тэгэхээр одоо би өнөөдөр байна шүү дээ тэр 5 дугаар сургуульд сурч байгаа 1-ээс 5 дугаар ангид сурч байгаа тэр хүүхдүүд нэг ч хүүхдийн төлөө юу гэдэг юм сургуулийн гадна үлдээхгүй байхын төлөө бүх л арга хэмжээг авч байна. Өнөөдөр ганцхан шийдэл болбол энэ компанийн гэрээг цуцалж байж, магадлан хийж байж дахиад тэр шаардлагатай байгаа 300 хэдэн сая төгрөгийг нь тусгаж хийж байж ингэж байж эрх зүйн орчин үүсэх юм байна. Одоо бид нар чинь нэг хэсэг нь хуулийн дээр амьдарч, нэг хэсэг нь хуулийн доор амьдарч болохгүй биз дээ. Монгол Улсад хууль дээдлэх л.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Оюунчимэг гишүүн тодрууль 1 минут.

**М.Оюунчимэг:** Энх-Амгалан сайдаа би танаас загнаагүй, зүгээр тэнд үнэхээр хүүхдүүд хохироод байна. Хөдөлмөрийн дээд сургууль гэдэг газар нь өөрөө хар аа манаач ч үгүй, хамгаалагч ч байхгүй, тэнд хулгайч нар хүртэл орчихсон хүүхэд хулгайлбал яах вэ. Тэгээд автобус байхгүй. 5 дугаар сургуулийн асуудлыг та яаралтай шийдээд өг. Та очихдоо 8 сард та очихдоо би энэ асуудалгүй дор нь шийднэ гэсэн сайдын ам үг биелэх ёстой. Гэхдээ та ажлаа хийж байгаа би таныг ойлгож байна. 67 сургууль, цэцэрлэг ийм байдалтай байгаад байгаа. Гэхдээ энэ 5 дугаар сургуулийн 97 хувь нь биелчихсэн байхад тэр хоёрхон хувь, гуравхан хувийнх нь асуудлыг та юуны төлөө шийдвэр гаргах түвшний хүн байгаа билээ энэ асуудлыг нэг шийдээд өгөөрэй гэж би танаас хичээнгүйлэн гуйж байна, сайдаа.

2-т нь тэр Болорчулуун дарга сая хэлээд байна ингэж болохгүй. Ноос ноолуурын урамшуулал дээр 25,5 тэрбум төгрөгийн төсвийг хязгаараас нь хэтрүүлээд бас төсөвлөөд ороод ирсэн. Хашаа, энэ хашаа хийж өгчхөөч дээ та нар. Тэгтэл энд хуулиараа тэр хүмүүс өөрсдөө хашаа.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Санал Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууна.

**Н.Энхболд:** ЗГ-аас нэлээн тийм өөдрөг төсөл орж ирсэн байна. Тэгээд би 2, 3 асуултууд байна. Тодорхой, богинохон хариулчхаарай. Нүүрсний экспорт маань биднээс хамаарахгүй шалтгаанаар 60 саядаа хүрэхгүй болбол яах вэ гэдэг, хувилбар тооцоо юмнууд байна уу? Би дараа нь яагаад энэ асуултуудыг асууж байна гэдгээ бас тайлбарлая. Уул, энэ хүмүүс бас мэдээлэлгүй байдаг юм байна. Төсвийн орлогын хэдэн хувийг уул уурхай бүрдүүлж байна вэ? Бид нар бүгдээрээ мэдсэн л дээ уншаад. Тэн дотроо ОТ, Эрдэнэт, Тавантолгойгоороо тус тусдаа

яг хэдэн хувийг эзэлж байна вэ? Энэ хэдэн асуултад нэг хариулмаар байна.

Ерөнхий сайд Төв аймагт очиж ажилласан, аймгийн удирдлага, иргэдтэй уулзсан, тулгамдсан асуудлуудын эрэмбэ тогтоосон. Төсвийн төсөлд нэлээн сайн орж орсон байна. Төв аймаг, Зуунмод, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудалтай холбогдоод тэнд үүсэж байгаа асуудлуудыг урьдчилаад шийдэх боломжуудын талаар ярьсан. Тэрний дагуу нэлээн сайн хөрөнгө оруулалт ирсэн байна. Тэгэхдээ асуудлууд үлдсэн байна. Би зүгээр Сангийн сайдаас зардлынхаа хэмжээнд нийт дүндээ хэтрүүлэлгүйгээр дотроо нааш цааш нь шилжүүлээд бас нэг тулгамдчихсан байгаа жижгэвтэр асуудлуудыг ингээд шийдчихэж болно гэж ойлгож байгаа. Зөв үү, буруу юу, тийм үү үгүй юү тэрэн дээр товчхон нэг хариулчхаарай.

Яриан дунд гараад ирлээ. Тэр газар тариалангийн асуудал, хашааны асуудал. Нэг асуудлыг ярих гээд нөгөө асуудлыг нь огт хэрэггүй юм шиг ярьж болохгүй. Энэний чинь цаанаа өөрөө хүнсний хөтөлбөр гээд юм байна. Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай асуудал байна. Хэдхэн жилийн өмнө бид нар тариа будаагаа авч чадахгүй, талхны талхгүй болчихоод сууж байсан улс шүү дээ. ЗГ-аас удаа дараа арга хэмжээ авч байж одоогийн үр дүнд хүрч байгаа юм. Тэгэхээр энэ би аудитынхан яагаад тийм дүгнэлт гаргасныг мэдэхгүй байна. Нарийн учрыг нь сая Болорчулуун хэлсэн. Би давтмааргүй байна. Энэ чинь цаанаа зүгээр нэг хашааны асуудал биш, хөрсний хамгаалалтын асуудал, газар тариалангийн хөгжлийн асуудал, олон мянган хүний ажлын байрны асуудал, малчид, тариаланч хоёрын хоорондын зөрчлийн асуудал гээд их олон асуудлуудыг шийдэхэд хэрэглэдэг арга байхгүй юу. Тэгэхээр үүнийг байхгүй болгож болохгүй, талхгүй болно, зөрчил хөдөөд нэмэгдэнэ энийг бид нар бас бодолцох ёстой шүү. Нэг ийм зүйл хэлчихье.



Ер нь төсөв бид нар ганцхан түрийвчтэй л улс шүү дээ. Одоо нэг юм оруулна нөгөөдхийг нь хасна гэвэл тэгвэл алийг нь хасаад 5 дугаар сургууль орох юм, алийг нь хасаад хаашааныхаа мөнгөөр юу хийх юм гэдэг юмнуудаа бид нар эндээ их нэг их улс төржилгүй ярих хэрэгтэй юм байгаа юм. Тийм боломж нь байгаа хуулиар бидэнд тийм болгож байгаа. Эцсийн дүндээ Улсын Их Хурал энийг батална. Гэхдээ бас хуулийн хязгаар бий. Зардлаа хэтрүүлэхгүй байх ёстой, энэ хүрээндээ л хэдүүлээ явъя.

Нэг зүйл байна би бас их уг нь том асуудал юм л даа. Ганцхан түрийвчтэй улс. Сая манай сөрөг хүчнийхэн яриад байна, хойтон ялах юм байна, тэгээд ялчхаад зөвхөн баялаг бүтээгчдийнхээ өрийг нь Турк шиг дараад, хөрөнгө оруулалтуудыг бүгдийг нь зогсоох юм байна. Тэрнийг дагасан дотоодын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт юу болох вэ, ажлын байрнууд хаашаа явах вэ, хаанаас тэрийг нөхөх вэ, тэр хооронд үүсэх нийгмийн асуудлуудыг яаж шийдэх вэ, маш олон асуудал байгаа. Нэг л түрийвчтэй. Манайх бид нар болбол тэр түрийвчээ аль болохоор том болгох юм сан, ы тэгээд эдийн засгаа тэнцвэртэй хөгжүүлэх юм сан, нийгмийн асуудлуудаа, зайлшгүй асуудлуудаа бүгдийг нь биш шүү шийдэж байх ёстой гэдэг ийм л бодлого барьдаг улс төрийн үзэл баримтлалтай хүчин өнөөдөр энд сууж байгаа. Мэдээж намуудын хоорондын үзэл баримтлал, бодлого өөр байна. Энэ ойлгомжтой. Би нэг минутаа үргэлжлүүлье авчихъя даргаа.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Үгүй ээ эхлээд хариултаа аваад дэг нь тийм 13.2-оор. Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Энхболд гишүүний асуултад хариулъя. Нүүрс дээр үнэхээр бас таны хэлж байгаа шиг тийм эрсдэл бид нар тооцох л хэрэгтэй юм байгаа юм. Тийм учраас харин 60 сая тонн гэж нэлээн даруухан тавьчхаад байгаа юм шүү дээ.

Энэ жилийнхээ хэмжээнд л гаргая гээд. Хүрч үзээгүй хэмжээ бол биш. Энэ жилдээ бид нар 60-ыг гаргачихаар байна, 60-аас ч илүү гарчихаар байгаа шүү. Гэхдээ энэ жилийнхээ хэмжээндээ л байа гэж байгаа юм. Яах вэ тооцоод үзэх юм болбол 1 сая тонн нүүрсэн дээр 70 тэрбум, 70 орчим тэрбум төгрөгийн орлого уяж байгаа юм. Өөрөөр хэлбэл 1 сая тонн давбал 70 тэрбум төгрөгийн нэмэлт орлого орлоно. Дутвал тэр хэмжээгээр мөн орлого тасарна гэсэн үг. Гэхдээ орлого тасарсан тохиолдолд бид алдагдлаа барих ёстой. Алдагдлаа нэмэхгүйгээр, алдагдлаа бариад ийм зохицуулалт хийхээс өөр аргагүй болно. Хуулийн дагуу ийм нөхцөл үүснэ гэсэн үг.

Уул уурхайн салбаруудын орлогуудын хувьд ингэдэг юм шүү. Манай Эрдэнэт үйлдвэр маань болбол ер нь оруулсаар л байгаа юм. Хэчнээн ОТ, ОТ л гээд ярьж байгаа боловч уул уурхайн салбараас орж байгаа орлогын 25 хувь нь манай Эрдэнэтээс ордог. 9 хувь нь ОТ-гоос, харин манай ЭТТ нэлээн том байр суурь эзэлдэг болсон 31 орчим хувийг эзэлж байгаа юм ийм мэдээллүүд. Тэр зохицуулалт өгч байна. Та өөрөө товчхон хариул гэсэн болно. Тийм зохицуулалт хийж болно. Өөр мэдээллүүдийг хэн өгөх юм бол.

**С.Одонтуяа:** Энхболд гишүүн тодруулж асууя 1 минут.

**Н.Энхболд:** Тэгээд одоо жишээ нь бүх хөрөнгө оруулалтыг зогсоочоод ямархуу нөхцөл байдлууд үүсэх вэ? Төсвийн хөрөнгийн. Үгүй ээ харин зогсоогоод л яах юм байна л даа. Баялаг бүтээгчдийнхээ өрийг дарахад л бүх мөнгөө зарах юм байна л даа. Сургууль, цэцэрлэгээ барихаа болих уу, эмнэлгээ барихаа болих уу, Оюунчимэг гишүүний сая яриад байгаа асуудлыг шийдэхээ болих уу? Энэ чинь олон асуудал дагуулна шүү дээ. Тэгээд тийм боломж байдаг юм уу? Үгүй ээ тэр би зүгээр нөгөө бүх хөрөнгө оруулалтаа зогсоогоод, тэрүүгээрээ зөвхөн баялаг, хөрөнгө баялаг бүтээгчдээ

дэмжээд өрийг нь дарах ийм бодлого явуулна гэж байна шүү дээ тэгээд. Тэгвэл яах вэ, ямар байдалд орох вэ? Тийм боломж бий юу манайд?

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Тэгвэл би таны асуултыг буруу ойлгосон байна шүү уучлаарай. Би ойлгохдоо төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн батлагдсан төсөв дотроо шилжүүлэлт хийж, зохицуулалт хийх үү гэж байгаа тэр бол болно. Харин таны ярьж байгаа шиг хөрөнгө оруулалтуудыг зогсооно гэдэг чинь байж болохгүй л дээ. Яагаад гэхээр энэ чинь хууль байхгүй юу. Төсөв бол өөрөө хууль болж гардаг, хууль болж гардаг. Хэрвээ төсвийн тодотгол хийж, хөрөнгө оруулалтуудыг нь зогсоогоогүй л болбол энэ одоо хууль болж гарсан төсөл арга хэмжээ бүр явах ёстой. Тийм өөр сонголт байхгүй.

**С.Одонтуяа:** Энхболд гишүүн маань жоохон улс төржих гэж байгаад баахан ороогдчихлоо. Нэмэлт 1 минут.

**Н.Энхболд:** Үгүй ээ, би улс төржих гээгүй. Би зүгээр санаа зовоод л асуусан юм. Бүх хөрөнгө оруулалт зогсчихоор яах юм бол? Дотоодын ААН-үүд яах вэ, сургууль, цэцэрлэг, эмнэлгээ барихгүй байх уу, тэрэнд санаа зовсон юм. Түүнээс би эхлүүлээгүй л дээ. Тэгээд хүмүүс тал талаас нь бодож асуудалд хандах биз дээ. Улс төржүүлээгүй шүү, юмыг яаж мэдэх вэ тийм байдалд хүрвэл яах юм бол доо гэж л асуусан юм. Болдоггүй л юм, болохгүй л юм байна л даа. Болохгүй гэдгийг нь Сангийн яам хэлж л байна.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Даваажсанцангийн Сарангэрэл гишүүн асуултаа асууна.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүдээс тойрогтоо тулгамдаж байгаа асуудлаар үйл

ажиллагаа, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын санал авсан юм. Тэгээд би салбар салбарын сайд нар миний хэлж байгааг анхааралдаа аваад, хасагдсан энэ асуудал дээрээ би хэрхэвч санал нийлэхгүй гэдгээ урьдчилаад хэлчихье. Тухайлбал Хан-Уул дүүргийн 17 дугаар хороо өнөөдөр нэг ч цэцэрлэг байхгүй. Харин Энх-Амгалан сайд маань түрээсийн асуудлыг шийдээд энэ хүүхдүүд нь өнгөрсөн жил бол ингээд цэцэрлэгтээ явцгаасан. Тэгээд энэ 17 дугаар хороо дээр 240 хүүхдийн ортой цэцэрлэг авах асуудал байгаа юм. Худалдан авах ажиллагаа дээр бол ямар нэгэн зургийн асуудал байхгүй шүү дээ. Тийм болохоор энэ Сангийн яамны нөхдүүд миний хэлж байгаа Хан-Уул дүүргийн 17 дугаар хороонд 240 хүүхдийн ортой цэцэрлэг авах тухай асуудал хассаныгаа буцааж оруул.

2-т нь Хан-Уул дүүрэгт мөн фитнес танхим бүхий спорт заал шинээр барихаар санал өгсөн, ижил маягийн зурагтай юм байна. Хэрвээ Сангийн яам ижил маягийн зургийг хүлээн зөвшөөрөхгүй гэж байгаа бол та бүхэн өөрснөө зургаа гаргацгаа, би өөр зураг бол өгч чадахгүй. Энэ бол суух ёстой. Энэ гишүүдээс авсан саналын хүрээнд би саналаа өгсөн.

3 дугаарт Булгантуяа сайд Хан-Уул дүүрэгт эмэгтэй жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төв барихаар санал өгсөн. Хөдөлмөрийн яам дэмжээгүй байна. Энийгээ мөн төсөвт суулгахыг би танаас хүсэж байна. 3 дугаарт мөн Хөдөлмөрийн сайдаас асуух гэж байгаа зүйл эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин урамшуулал ирэх онд хэрхэн яаж нэмэгдэж өөрчлөгдөх юм бэ гэдэг талаар асуугаад байгаа юм. Энэ дээр хариулт өгөөрэй. Бид нар чинь бас нэг эмэгтэй бизнес эрхлэгчдээ дэмжье, хууль гаргая гээд явж байгаа. Энэ төв бол нэн чухал гэж үзэж байгаа учраас ийм санал өгсөн гишүүдээс авсан саналын хүрээнд энэ маань байхгүй байгаа учраас энийг би суулгахыг та бүхнээс шаардаж байна.

Хан-Уул дүүрэгт Сангийн сайдаа, Жавхлан сайд фитнес танхим бүхий спорт заалыг мөн гишүүдээс авсан саналынхаа хүрээнд би ижил маягийн зургийн саналтай өгсөн. Энэ маань ороогүй байна. Тийм учраас Сангийн яамны нөхдүүд гишүүдээс авсан саналын хүрээнд миний өгсөн энэ саналыг буцааж суулгаарай гэж би та бүхэнд хэлье.

Дараагийн асуудал Боловсролын сайдад би Энх-Амгалан сайдаа талархаж байгаа. Үнэхээр ЗГ дээрээ шийдүүлээд, бүх хүүхдүүдийг Улаанбаатар хотод цэцэрлэгт бол хамруулж чадсан. Энэ үнэхээр амжилттай ажил. Өнгөрсөн зунжингаа мөн 9 дүүргийнхээ сургуулиудаар явсан байна лээ, явсан байна лээ. Шат дараатай асуудлыг шийдэж байгаа гэдгийг би ойлгож байгаа. Нэг мөр, нэг амьсгаагаар шийдэх боломжгүй. Тэгээд энэ хүрээндээ бол Хан-Уул дүүрэгт 17, 23, 24 гэсэн 3 хороо улсын 1 ч цэцэрлэггүй, 1 ч сургуульгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ асуудлаа иргэд маань байн байн тавьж байгаа учраас би сайдад энэ хэд хэдэн саналуудаа өгч байгаа. Түрүүн бас бид 2 ярилцсан. Энэ хүрээндээ нэг хороо хорооны асуудлыг яриад орхиё. Тухайлбал Энх-Амгалан сайд 2020 онд шүү дээ, одоо ингээд 23 он болчихлоо. Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо буюу Био комбинат 640 хүүхдийн ортой сургууль эхлүүлсэн, одоо хүртэл дуусдаггүй, энэ их хүндрэлтэй байна. Тэгээд 12 дугаар хороо Био комбинат гэдэг маань Улаанбаатар хотоос 25 км-ийн зайтай, хүүхдүүд нь өвөл Морингийн даваагаар давж өөр газар хичээллэж байгаа. Энэ сургуулийг ашиглалтад оруулах тал дээр та минь нэг анхаарч өгөөч гэдэг нэг ийм хүсэлтийг тавьж байна.

2 дугаарт мөн Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо дээр нийслэлийн төсөвт 10,1 тэрбум төгрөг суулгаад, 640 хүүхдийн сургууль эхлүүлсэн, одоо нам зогсчихсон байгаа. Энэ мөн бас хүндрэлтэй байна. Мөн 18 дугаар хороонд

200 ортой хүүхдийн цэцэрлэг байгуулахад 4,1 тэрбум төгрөгийг улсын төсөвт суулгасан юм. Энэ ажил маань бас дахиад зогсчихлоо. Нэг ийм асуудлууд байгаа учраас би Энх-Амгалан сайдыгаа нэг анхаарч өгөөч гэдэг ийм хүсэлт.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Энэ жил анх удаа Ерөнхий сайдын баг 21 аймгаар тойрч дуусаад, хөрөнгө оруулалтуудыг төсвийн ерөнхийлөн захирагч нараас шаардлага хангаж ирүүлсэн төслүүдийн хүрээнд ард олон нийтээс санал авч эрэмбэлж, ингэж ер нь бүгдэнг нь 100 хувь үндсэндээ тусгасан байгаа. Энэ дотор зураг төсөвгүй ийм зүйлүүдийг зураг төсөв рүү нь, төсөв рүү нь, зураг төсөвтэй нь бүгд төсвийн санхүүжилтүүд нь хийж эхлэгдэхээр ингэж зохицуулалт хийсэн байгаа.

Мөн гишүүд өөр өөрсдийн тойрог дээрээ ийм хөрөнгө оруулалт хийх шаардлагатай, иргэдээс ийм санал ирж байна гээд ингээд санал ирүүлдэг. Аль болох аймгуудаар тойрсон тэрэнтэй нь давхцаж байна уу, давхцахгүй байна уу, зураг төсөвтэй байна уу, нөгөө шаардлагууд хангаж байна уу гээд ингээд ер нь л нэлээн л тусгасан байгаа. Танаас ирүүлсэн би албан бичгийг одоо яг хараад сууж байна. Энэ дотор фитнес гэж байгаа, фитнес нь нөгөө хуулиараа бид энийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх боломжгүй байгаа фитнесийн ийм цэгүүдийг. Энийг бол Нэгжийн хуулиар ийм хязгаарлачихсан ийм байгаа. Тэгэхээр энэ боломжгүй гэсэн үг.

Тэр худалдан авах төсөл энэ их төвөгтэй шүү Сарангэрэл гишүүнээ. Та одоо нэг объект заагаад энийг худалдаж авмаар байна гэсэн байгаа болбол тэрэн дээр одоо үл хөдлөхийн үнэлгээ ядаж байх ёстой, ямар үнэ өртөгтэй юм, зах зээлийн үнэ нь ямар юм энэ дээр судалгаа хийгдсэн ийм зүйлүүд байх ёстой. Ингээд ийм

юмнууд байхгүй юм байна лээ. Тэгэхээр одоо яг энэ шаардлага хангаагүй учраас ингээд хасагдсан байна. Зүгээр одоо ажлын хэсэг дээр хэрэв шаардлага хангасан бол ажлын хэсэг дээрээ энийг бас ярих хэрэгтэй. Тэгээд ийм л би танд хариу өгье. Үгүй ээ ер нь яах вэ тэр нэгдсэн ийм нийтлэг зураг гэж манайхан их ярьдаг. Энэ бас л өмнөх төсөвт өртөг нэмэгддэг, төслүүд он удаан жил үргэлжилдэг дотор нэг бас буруу шалтгаан нь энэ байсан байгаа юм.

Нийтлэг нэг зураг гэхчхдэг юм. Тэгэхээр тэр зургийг тэр зургаар Өмнөговь аймагт барих, Увс аймагт барих, Дорнод аймагт барих, Баян-Өлгий аймагт барих бүгд өөр өөр төсөв гарч ирнэ. Бүүр хааш нь харуулж барьж байгаагаасаа болоод, дэд бүтцээсээ ойрхон байна уу, хол байна уу гэдгээс хамаараад энэ угсралтуудынх нь энэ төсвүүдээсээ болоод бүгд өөр өөр гарч ирдэг. Нэг зураг тавьчихдаг, яах вэ ижилхэн зураг байж болно. Хойтон дахиад төсөвт өртөг нэмэгдэх шаардлагатай болдог. Тийм учраас хэдүүлээ аль болох ийм юмнаас л зайлсхийж, татгалзаж, татгалзаж байж энэ хөрөнгө оруулалтууд маань алдаа мадаггүй ингээд жигд, дараа дараагийнхаа жилүүд дээр хүндрэл учруулахгүйгээр оновчтой төсвийн зардал маань үр дүнтэй ингэж болох чиглэл рүүгээ явж байгаа гэдгийг хэлэх гэсэн юм.

**С.Одонтуяа:** Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** Манайхаас хөрөнгө оруулалтын саналыг бол Сангийн яам руу явуулсан. Чимиддорж дарга тэр яагаад хасагдсан юм тэрүүнийг нь нэг тайлбарлаадхаач. Миний ойлгосноор зураг төсөвгүй гээд л тэгсэн юм шиг байгаа юм. Манай дээрээс явуулсан олон хөрөнгө оруулалтууд иймэрхүү шалтгаанаар ер нь хасагдсан. Үнэнийг хэлэхэд бас энэ Сарангэрэл даргын хэлж байгаатай бас санал нэг байна. Үнэнийг хэлэхэд захын хороодод бол хувийн хэвшил тэнд фитнес заал бариад л, тэндээс

орлого олоод л гэж юм бол байхгүй юм байна лээ. Соёлын төв хэрвээ сумын төв нь бариад, төвд бариад энэ соёлын үйлчилгээг сумд хүргэх ёстой гэж байгаа бол эрүүл мэндийн үйлчилгээгээ нэг төрлийн эрүүл мэндийн үйлчилгээ шүү дээ. Тэгээд бид нар энэний төлөө бүхэл бүтэн салбарын сайдтай боллоо. Хөрөнгө оруулалт төсөв тавьж байна. Тэгэхээр дандаа өвдсөн хойно нь төсөв зардаг биш. Уг нь бол эрүүл мэндийн наад захын энэ үйлчилгээг авах, тэр тусмаа захын хороодод бол ийм барилга байгууламжийг дэмжмээр байгаа юм.

Эрүүл мэндийн салбарын хувьд бол бид нар цалин одоо бол ТҮМ 1 сая төгрөг байгааг 2024 оноос авхуулаад бүгдээрээ 10 хувиар нэмэгдэнэ. Дээрээс нь нэмээд гүйцэтгэлийн санхүүжилт.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Гүйцээгээд хариулъя Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** Энэ нөгөө 7 сарын 1-нээс ингэж нэмэгдээд, одоо ахиад 24 оны, 24 оны 4 сарын 1-нээс ахиад 10 хувь нэмэгдэж орж ирнэ. Мөн үүний дээр ЭМД-ын сангаас гүйцэтгэлийн санхүүжилтийг нэмж авах бас боломжтой байгаа. Мөн бүүр салбар болгон дээр үндсэн цалингаас гадна бусад нэмэгдлүүд бас тооцогдож орж ирдэг Төсвийн тухай хуулиараа. Аймагт бол аймгийн төвийн сум, захын 3 дүүрэг, суман дээр ажиллаж байгаа гээд 40 хувийн нэмэгдэл, 20 хувийн нэмэгдэл гээд бусад нэмэгдлүүд бас тооцогдож орж ирнэ.

**С.Одонтуяа:** Болсон уу? Энх-Амгалан сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Сарангэрэл гишүүнээ Хан-Уул дүүрэг бол их хүнд дүүрэг болж байгаа юм байна лээ дээ. Яг үндсэндээ болбол нөгөө бетонон ширэнгэ гэж бид нар сүүлд хүлээн зөвшөөрөх шиг боллоо. Бараг хэллэг болж байх шиг байна. Тэгээд бетонон ширэнгэ барьсан

энэ хороолол барьсан компаниудын золиос нь л энэ Хан-Уулд амьдарч байгаа иргэдийн үр хүүхдүүд, тэд нарын ирээдүйн хувь заяа юм байна л гэж би бодож ойлгож байгаа. Тэгээд цаашидаа болбол газаргүй болчихсон юм байна лээ. Ямар ч улсын сургууль, цэцэрлэг барих газаргүй болчихсон. Тэгээд сая таны хэлж байгаа энэ 17 дугаар хороо, 23 дугаар хороо, 24 дүгээр хороо болбол газар нь байхгүй. Хэчнээн хөрөнгө оруулалт тавьсан ч гэсэн газар нь байхгүй болж байгаа учраас нэг шийдэл болбол одоо сургуулийн бус зориулалтаар барьсан барилгуудыг авч сургууль болж зохион байгуулахаас л өөр сонголт байхгүй байна гэж харж байгаа юм.

Та бас өөрөө хөрөнгө оруулалтыг тавьж 2 том хөрөнгө оруулалтын цэцэрлэг, сургуулийн асуудлыг шийдсэн. Эргээд яг энэ 18 дугаар хороо дээр баригдаж байгаа тэр нөгөө 640 хүүхдийн сургууль бол яг л өнөөдрийг хүртэл газрын маргаанаас болоод л ингээд 2 ажил нь.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Энх-Амгалан сайд гүйцээж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Тэгээд энэ газрын маргаантай 2 айл дээр газар олголт хийчихсэн учраас ингээд мөнгө нь байгаад байдаг, ажил нь эхэлдэггүй нэг ийм зовлон болчихсон. Тэгээд цаашидаа бол бид нар энэ нийслэл дээр энэ сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалтуудыг тавих юм бол давхар газар чөлөөлөлтийн зардлуудыг нь улсын төсөв дээр тавьж байж энэ асуудлуудыг шийдэхгүй болбол энэ их олон ийм гашиун сургамж байна. Энийг тийм эсхүл одоо нийслэл нь шийдэх ёстой юм уу тийм ээ, ямар ч байсан газар чөлөөлөлтийн асуудал төсвийн эх үүсвэрүүдийг нийслэл рүү ямар эх үүсвэр вэ гэдгээ шийдэж байж тодорхой шийдэл гаргах ёстой юм байна гэж харж байгаа.

Тэр Биокомбинатад барьж байгаа тэр сургууль бол бас л ер нь жаахан давгарчихсан компани л гэж бас би хэлэх

гээд байгаа юм. 97, яг л энэ 5 дугаар сургуулийн түрүүний Оюунчимэг гишүүний бид хоёрын байдалтай 5 дугаар сургуультай адилхан бараг 97 хувийн гүйцэтгэлтэй болчихсон. Тэгээд маш их том юуны барилгын материалынхаа юуг авчихсан зөрөөг авчихсан, одоо яг нөгөө нэг цалингийн зөрөө нэхээд сууж байгаа байхгүй юу. Цалингийн зөрөө, шатахууны зөрөө гээд, одоо энэ нөгөө ордны гадаа жагсаад байгаа бас л компаниудын нэг болчихсон байж байгаа. Тэгээд энэ дээр болбол яг энэ Барилгынхаа хуулиар яг магадлан хийх үндэслэлүүд хэр зэрэг үүссэн байна вэ гэдэг өөрөө зохицуулалттай учраас болбол ингээд энэ асуудал нэг ингээд яг юу гэдэг юм нэг гацчихсан байдалтай байгаа. Гэхдээ гэлээ гэхдээ энэ болбол би энэ цэвэр компанийн буруу. Хэрэв компани иймэрхүү байдлаар байх юм болбол яг 5 дугаар сургууль шиг бид нар гэрээг нь цуцлаад, хар жагсаалтад оруулаад, дахиж магадлан хийх ийм л нөхцөл байдал үүснэ.

**С.Одонтуяа:** Сарангэрэл гишүүн тодруулъя.

**Д.Сарангэрэл:** Тийм. Тэгээд Жавхлан сайд би түрүүнийхээ 2 ярьсан бүтээн байгуулалтынхаа ажлыг бол ажлын хэсэг дээр ярья гэж бодож байна. Цэцэрлэг худалдан авах тухай асуудал бол би хувь хүнийхээ хувьд аль нэг цэцэрлэгийг тоочиглохчоод авах тухай асуудал биш. Би энийг бол цэвэр Боловсролын яамтай бол ярина гэж ингэж бодож байгаа.

Миний дараагийн асуудал бол Хан-Уул дүүрэг дээр нэг том асуудал гарчхаад байгаа юм. Сайнзориг дарга ирчихсэн байна. Тэгээд энэ богино хугацаанд ажилтайгаа нэлээн танилцсан юм байна гэж би сая ойлголоо. Би бас Нийслэлээс гадна Хууль зүйн яаманд энэ асуудлыг тавьсан юм. Ямар асуудал вэ гэвэл 2019 онд орон сууцдаа орох ёстой байсан 500 өрхийн 5 мянган айл өнөөдөр гудамжинд байгаа юм. Бүрэн Өргөө гэж компани энэ айлуудаас 100 хувийн хөрөнгө оруулалтыг нь санхүүжилтийг нь аваад 2019 онд

ашиглалтад оруулна гээд, тэгээд энэ айлууд бол энд тэнд түрээсийн байртай ингээд амьдраад ингээд 5 жил гадуур ер нь тэнүүчилж амьдарч байна гэж хэлж болно доо. Маш хүнд байдалд орчихсон ингээд байж байгаа. Хууль зүйн яаманд би асуудал тавиад, Нямбаатар сайд маань тухайн үед шуурхай хандаж.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Сайнзориг дарга хариулъя.

**П.Сайнзориг:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Би яг энэ дээр бас танд бас тодорхой мэдээллийг өгөхөд бэлэн биш байна. Би эргээд бас танд жич мэдээллүүдийг нягтлаад шалгаад танд бас жичдээ танилцуулъя. Ер нь бол энэ газар чөлөөлөлт, хот дахин төлөвлөж зохион байгуулахтай холбоотой хууль, эрх зүйн асуудал дээр бас тодорхойгүй зүйл бол бий. Ерөнхийдөө төр яг иргэн хуулийн этгээд хоёрыг холбож өгөөд бас тодорхой хэмжээний зохицуулалт хяналтыг хаяснаас болоод ийм асуудлууд үүсэж байгаа зүйл байгаа. Энэ дээр цаашидаа бас аль алиных нь эрх ашгийг тэнцүү, эргээд энэ нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг хамтдаа л даван туулахын тулд бас хаана хаанаасаа хариуцлагатай, оролцоотой байя гэдэг энэ концепцоор бас хууль, эрх зүйн орчныг цаашидаа бүрдүүлж байж энэ бас газар чөлөөлөх, хотыг дахин төлөвлөх асуудлыг бас ултай суурьтай ярина гэдэг зүйлийг бас удахгүй бас хууль, эрх зүйн шинэчлэлүүдийг бас оруулж ирнэ. Тэгэхээр би бас энийг яг энэ Бүрэн Өргөө компанитай холбоотой асуудлыг танд бас жичид нь мэдээллийг өгье.

**С.Одонтуяа:** Сарангэрэл гишүүн тодруулъя.

**Д.Сарангэрэл:** Арга байхгүй одоо бас нэг хуулийн мэдлэгтэй, ийм хариуцлагатай хүн НЗД-ын 1 дүгээр орлогчоор очсонд би их маш их баярлаж байна. Ямар учиртай вэ гэвэл та сая хэллээ шүү дээ. Төр иргэн хоёрыг холбосон

гүүр, тэгээд өнөөдөр бол бидэнд хамаагүй гээд хаях ямар ч арга байхгүй. 5 мянган иргэн маш хүнд байдалд байгаа, 100 хувь орон сууцынхаа мөнгийг төлчихсөн, барилгын ажил 80 хувьтай, одоо нэг 20 хувийн асуудал байгаа. 15 тэрбум төгрөгийн асуудал байгаа гэж байгаа юм. Тэгээд Сайнзориг дарга минь энэ дээр нэг маш хариуцлагатай, сэтгэлээсээ хандаад, тэр 15 тэрбум төгрөгийг нь хаанаас гаргадаг юм байгаа юм, үгүй бол тэр компаниас нь хураадаг юм уу би мэдэхгүй байна энэ хуулийн асуудал. Ямар ч байсан энийг шийдэх ёстой. Тэгээд маш хүнд байдалд байгаа учраас хуулийн талаасаа ч тэр, иргэдээ бодох талаасаа ч тэр, зөвшөөрлийг нь нийслэл өгсөн талаас талаасаа ч тэр Бүрэн Өргөө компанитай холбоотой 500 өрхийн 5 мянган иргэн хохирч байгаа асуудлыг та бид хамтарч шийдэх ёстой. Тэгээд би таныг энэ чиглэлээр хариуцлагатай ажиллаж, хариу өгнө гэдэгт итгэж байна.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Пүрэв-Очирын Анужсин гишүүн асуултаа асууна.

**П.Анужсин:** Баярлалаа. Энэ удаагийн ЗГ-аас өргөн барьсан энэ төсөв бол бас тэмдэглэж хэлүүштэй ийм төсөв. Энэ юу вэ гэхээр Улсын Их Хурлын хаврын чуулганаар батлагдсан Нийгмийн даатгалын багц хуульд тусгасан өөрөөр хэлбэл ард иргэдийн зүгээс хамгийн их хүлээлттэй байгаа эдгээр төсвүүдийг болбол шингээж орж ирснээрээ болбол үнэхээрийн бас талархууштай ийм төсөв болсон. Ард иргэдийн хүлээж байгаа 7 жилийг 5 жил болгох, түүнээс чухал энэ бүхнээс бол илүү онцолж хэлэх нь Монгол Улс болбол хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоо руу шилжсэн том алхам хийсэн. Энэ болбол Монгол Улсын бас төсөвт нэлээн тодорхой хэмжээний ачаалал үүрүүлсэн ийм том төсвийн бас шинэчлэл, эрс шийдэмгий алхам хийсэн төсөв болсон гэдгийг би хамгийн түрүүнд бас онцлон хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Хэд хэд, 3 асуулт байна. Мэдээж улсын төсөвт шингээчихээр шийдэх ёстой үй түмэн асуудлуудыг гишүүд бол хэлж байна. Гэхдээ төсөвт шингээхэд аль нь чухал вэ гэдгийг чухал дарааллаар нь мэдээж эрэмбэлэх ёстой, эрэмбэлэхийн төлөө ч бас ЗГ ажилласан болов уу гэж бодож байна. Хүүхдийн хоолны асуудал байна зардлын. 3 жилийн өмнө би энэ ажлын хэсгийг ахлаад 900 төгрөг байгаа үдийн цайг үдийн цайнд зарцуулагдах мөнгийг үдийн хоол болсон, үдийн хоолны 900 төгрөг байсныг 1500 төгрөг болгож нэмэгдүүлсэн юм. Хуулиараа энэ хүүхдэд зарцуулах хоолны мөнгө маань инфляцтай уялдуулан жил бүр нэмэгдүүлэх тухай хуульд заасан байгаа. Гэтэл 3 жилийн өмнө нэмэгдүүлсэн энэ тоо хэмжээнээс нэг ч төгрөгөөр ахиж чадсангүй. Өөрөөр хэлбэл үдийн хоолны нэг хүүхдэд оногдох зардал 1500 төгрөг байна. Бодоод, зүгээр энгийн бодоод үзье, 1500 төгрөгөөр өнөөдөр бид яг юу авч идэх вэ? Энэ бол Монгол хүүхэд хоолны асуудал мэт сонсогдож байгаа хэдий ч энэ бол Монгол хүний ирээдүйн эрүүл мэндийн үндэс суурийг энд яриад байгаа юм.

Бид нар мега төслүүдийг дэмжих тухай, уул уурхай, зам ярьж байна. Энийг чинь ирээдүйд хэн хэрэглэх юм бэ, хэний төлөө бид нар энэ бүтээн байгуулалтуудыг хийж байгаа юм, эдгээрийг хүртчих эрүүл Монгол хүн өнөөдөр ер нь өсөж торниж байна уу гэдэг асуудлыг л би яриад байгаа юм. Тэгэхээр энэ 1500 төгрөгийг нэмэгдүүлэх гарц байхгүй юм уу? Энэ 1500 төгрөгийг яагаад ЗГ, Боловсролын яам нэмэгдүүлээд орж ирэхэд энэ Сангийн яам дээр үргэлж үл тоогдож хасагдаж байгаа юм бэ гэдгийг би асуумаар байна. Энэ 1500 төгрөгөөр хүүхдийн авах ёстой килокалорийн илч тэжээллэг хэмжээний 35 хувийг авна гэж байгаа юм. Хэдийгээр 35 хувь, бусдыг нь хүүхэд гэртээ авах ёстой гэж хэлж байгаа боловч энэ болбол энэ 35 хувийн тэжээллэгээр өдрийнхөө хоолыг өл залгуулдаг хүүхдүүд үй түмэн байна. Тэгэхээр энэ гэрт өгч байгаа цаад талын энэ хэдэн хувь дээр бол бид нар

найдалтгүй учраас улсаас өгч байгаа энэ хоолны чанарыг сайжруулах, төсөв зардлыг нэмэгдүүлэх асуудлыг би Сангийн яамнаас асуумаар байгаа юм.

Дараагийн зүйл Чинзориг сайд алга байна. Тэгэхдээ би ажлын хэсэг дээр бас асууна гэж бодож байгаа. Энэ ард иргэдэд бас нэлээн санхүүгийн хүнд дарамт болж байгаа, амьдралаа бараг зарж үрж байгаа нэг асуудал болбол Монгол Улсад эмчлэгдэхгүй гэж оношлогдсон хүүхдүүд байна. Бүх зүйлээ зараад гадагшаа явж байна. Эдгээр хүүхдүүдийн зардлыг Эрүүл мэндийн сангаас, Эрүүл мэндийг дэмжих сангаас бүрэн дагах боломж байхгүй юу? Хүүхэд хүүхэд л гээд нэг асуудал болохоор л бид нар энийг ярьж эхэлдэг. Тэгэхээр хэзээ бас бид нар энэ асуудал руу анхаарлаа, анхаарлаа хандуулах вэ гэж?

Дараагийн нэг асуудал Энх-Амгалан сайд бол ажиллаж байгаа. 12 дугаар сургууль. Та бараг бүх асуудлыг цээжээрээ мэднэ. Өөрөө очиж ажиллаж байсан. 18 тэрбум төгрөг шаардлагатай байгаа, 8 нь арай гэж шийдэгдэж орж ирсэн, 10 нь яах вэ? Энэ мянган хүүхдийн асуудал яах вэ? Хол замд яваад байдаг. Энийг хэдүүлээ яаж шийдэх вэ? Шийдэл гарцыг яриад явсан хэдий ч төсөв дээр ажил олж орж ирэхдээ өнөөдөр тал хувь, ахиад хэдэн жил шаардах вэ? Ард иргэддээ юу гэж хариулах вэ? Ноднин жил төсвийн үед ард иргэдийн саналаар.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Эхлээд хариулчих тийм. Хэн хариулах вэ? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Анужин гишүүний асуултад хариулъя. Тэр хүүхдийн хоолны асуудал болбол ийм юм байгаа юм шүү Анужин гишүүнээ. 1500 төгрөг гэдэг бол энэ чинь хоолны орцонд орж байгаа бараа материалыг худалдаж авах бөөний үнийн ийм санхүүжилт шүү дээ. Тэрнээс биш яг энэ хоолны меню дээр байдаг нэг хоолны үнэ бол биш. Тэр сургууль дээр байгаа бусад тэр хоолны газрын ажилчдын

цалин, гэрэл чийдэн, гэрэл цахилгааны зардал гээд л бусад бүх үйл ажиллагаатай холбоотой нэмэлт зардлууд бол сургуулийнхаа үйл ажиллагааныхаа зардалд нь шингээд орчихдог. Энэ бол зөвхөн хоолны орцны ийм үнэ гэдгийг худалдаж авах зардал гэдгийг та ойлгож байгаа байх гэж надад бодож байна.

Дээрээс нь тэгээд 1500-гаар нь яг энд хамрагдах үдийн хоол хөтөлбөрт хамрагдах хүүхдийнх нь тоогоор нь үржүүлээд л тавьчихсан байгаа ийм дүн. Ер нь болбол үр хүүхдүүдийн маань авах ёстой килокалорийн асуудал энэ хоол тэжээлийн асуудал дээр эцэг эх, гэр бүл тодорхой хэмжээний хариуцлага хүлээх ёстой шүү дээ. Хэрвээ тэрэн дотор нь боломжгүй, бүүр бүгдийг нь бүх хоол хүнс, тэжээл юмыг нь төрөөс хариуцах ёстой гэж та үзэж байгаа бол энэ тусдаа өөрөө халамжийн бодлогоор явах ёстой. Тэрнээс биш үдийн хоолонд хамрагдаж байгаа хүүхдийн тоогоор хавтгайруулж ийм байж бол болохгүй. Энэ төсвийг тэгж хамаагүй замбараагүй бид нар зарцуулж болохгүй. Тэгэхээр Булгантуяа сайд бас энэ дээр нэмэлт хариулт байвал нэмээрэй. Тийм халамжийн хэсэг дээр зарцуулагдах боломжтой ямар зардлууд танай дээр байдаг юм тийм. Хүүхдийн хоолон дээр тэгж л хариулъя даа.

**С.Одонтуяа:** Нэмж хариулах хүн байна уу? Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Анужин гишүүнд талархаж байгаа, бас хүүхдийн хоолны зардлыг үдийн цай байсныг үдийн хоол болгосон манай ЗГ. Ингээд ер нь бол яах вэ бид нар нөгөө хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ гэдэг шиг их л том тоо байгаа юм л даа. Үндсэндээ болбол 1-ээс 5 дугаар ангийн 388 мянган хүүхэд, энэ дээр чинь 74 тэрбум орчим байгаа, цэцэрлэгийн хоолны хүүхдийн зардал дээр бас 70 гаруй тэрбум төгрөг, дотуур байрны хүүхдүүд гэхээрээ 25 тэрбум гээд нийт 180-аад орчим тэрбум төгрөг л явж байгаа юм Анужин гишүүнээ. Энийг тэгээд 2 дахин үржүүлэхээр л 340 орчим, 350 орчим

тэрбум төгрөгийн л эх үүсвэр бид нарт л шаардлагатай гэсэн үг байхгүй юу. Тэгээд бид нар ерөнхийдөө энэ хүүхдийн мөнгийг ер нь юунд өгч байгаа юм бэ гэдгээ бас нэг эргэж хармаар байгаа юм. Эргээд бид нар сая нэг ярьж байгаад 100 хувь болчихлоо. Энэ хүүхдийн мөнгө хүүхдэдээ л зарцуулагдах ёстой шүү дээ. Хүүхдийнхээ боловсролд зарцуулагдах ёстой, хүүхдийнхээ эрүүл мэндэд зарцуулагдах ёстой. Тэгэхээр энийг ер нь.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Энх-Амгалан сайд гүйцээж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Энийг нэг ухамсарлах цаг нь болсон л гэж би ойлгож байна. Харин ч төр бас 1-ээс 5 дугаар ангийнхаа хүүхдийн 100 хувь ингээд хоолны зардлуудыг нь гаргаад ингээд явж байна. Цэцэрлэгийн хүүхэд дээр ч гэсэн адилхан. Саяхан хүртэл Алтанхуяг Ерөнхий сайд гаргаж ирээд л больчихсон болохоос биш сүүлдээ Алтанхуяг Ерөнхий сайд чинь өөрөө би хамгийн буруу юм хийсэн юм байна лээ гэдгээ Их Хурал дээр хэлсэн шүү дээ. Эцэг эхчүүдтэй нь хуваалцдаг байсан шүү дээ Алтанхуяг сайдыг Ерөнхий сайд болтол. Сая бид нар судалгаа хийж үзсэн. Эцэг эхчүүдийн дунд эцэг эхчүүдийн бараг 60 хувь нь хүүхдийнхээ цэцэрлэгийн хүүхдийн, би цэцэрлэгийн хүүхэд ярьж байна, цэцэрлэгийн хүүхдийн хоолны 60 хүртэл хувийг юу эцэг эхчүүдийн 60 хувь нь тодорхой бид нар хуваалцахад бас бэлэн байна л гэдэг л ийм л байгаа юм байна лээ. Мэдээж орлого багатай байгаа, эмзэг давхаргын хүнсний талон авдаг энэ эмзэг давхаргынхаа хүүхдүүдийн асуудал байвал төр өөрөө хариуцаад явах нь зүйтэй. Тэгэхээр бид нар энэ нэг өөх ч биш, булчирхай ч биш байхаар нэг тодорхой шийдэл гаргаж энэ гаргах цаг, шийдвэр гаргах цаг нь болжээ л гэж би харж байгаа юм.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд.



**Б.Жавхлан:** Тэр Чинзориг сайдаас асуусан асуулт дээр би зүгээр өөртөө байгаа мэдээллээсээ өгөх гэсэн юм шүү Анужин гишүүнээ уучлаарай дутуу хариулчихвал. Монголд эмчлэхгүй эмчлэгддэггүй ийм өвчний төлбөрийн тусламжид зориулж энэ жил 500 сая төгрөгийн ийм төсөв байгаа. Ирэх жил 1 тэрбум төгрөг тавьсан байгаа, ирэх одоо энэ шинэ орж ирсэн төсөв дээр. Энэ дэмжих сангийн 10 тэрбум төгрөгөөс үүнд зарцуулахаар ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл удахгүй ЗГ-аас Чинзориг сайд өргөн барина. Тэр үед бас хэдүүлээ энэ сэдвээр нэлээн дэлгэрэнгүй ярилцах боломж гаргах байх.

**С.Одонтуяа:** Анужин гишүүн тодруулъя.

**Д.Анужин:** Тийм ээ, бид нар улсынхаа төсөвт бас хэмжээтэй дамжаатай юмандаа бас энэ хязгаар дунд аль болохоор хийхийг зорьж байгаа ЗГ-ын энэ үйлдлийг бол ойлгож байгаа. Гэхдээ бид нар хуульдаа инфляцтай уялдуулж энэ хүүхдийн хоолыг хийх энэ бүтээгдэхүүнд зарцуулах мөнгийг нэмэгдүүлнэ гээд л заачихсан байгаа. Өнөөдөр 1500 төгрөгөөр яг ямар бүтээгдэхүүн, ямар үндсэн түүхий эд авч, ямар хоол хийх юм бэ гэдэг бол маргаад байх асуудал биш гэж би үзэж байна. Цаашид бол бид нар нэмэгдүүлэхийн төлөө л хичээх ёстой гэдгийг би хэлье.

Энх-Амгалан сайдаа нөгөө 12 дугаар сургуулийн асуудлыг асуусан. Ноднин D-парламент дээр хамгийн их саналыг авсан төсөв хэлэлцэх үед тийм ээ, тэгээд Их Хурлын дарга индэр дээрээс энийг бол бүүр үүрэг болгож өгсөн шүү дээ. Гэтэл юу ч өөрчлөгдсөнгүй, юу ч өөрчлөгдсөнгүй гэж хэлэхгүй тийм ээ 8 тэрбумын асуудал шийдэгдсэн, үлдсэн 10-ыг яах вэ гэдэг асуултдаа хариултаа гүйцээж авъя.

**С.Одонтуяа:** Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Яах вэ би энэ зун 5 сургуультай ноцолдож байгаа юм. Үр дүн гарсан болов уу гэж бодож байна. СХД-ийн 26 дугаар хорооны 2 сургууль, 1 цэцэрлэг өнөөдөр ашиглалтад орсон. 5 дугаар сургууль, 71 дүгээр сургууль, 62 дугаар сургууль, 12 дугаар сургууль гээд ингээд нэг энэ 5-ыг нэг хамгийн гал ассан 5 л даа. Тэгээд 12 дугаар сургууль дээр бид нар бас очиж бүтэн өдөржингөө ажилласан. Гүйцэтгэгч нь ямархуу ааш араншин авир гаргаж байсныг та бас өөрөө төсөөлж байгаа байх. Гэхдээ ямар ч байсан ЗГ-аар 2 удаа асуудал оруулаад, гүйцэтгэл муутай байгаа компаниудын юуг санхүүжилтийг гүйцэтгэл сайтай байгаа тэр тусмаа 3 ээлжийн, 3 ээлжийн эрсдэлд орох гэж байгаа сургуулиуд дээр би энэ санхүүжилтийг шийдээд явж байгаа. Энэ 12 дугаар сургуулийн хэсэгчилж, хэсэгчилж хүлээж авъя гэж бид нар тохирсон шүү дээ. Бүтнээр нь биш хэсэгчилж хүлээж авъя. Тэгээд бид нар гүйцэтгэлээр нь ингээд санхүүжүүлээд явж байгаа. Ямар ч байсан он дуустал болбол энэ нөхөр хэлсэн амандаа хүрэх юм болбол гүйцэтгэл сайн гаргах юм болбол бид нар тултал нь энэ санхүүжилтийг өгөөд явах л ийм боломжууд нь байгаа гэж бодож байгаа. Энэ чинь 25.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууна. Анужин гишүүн тодруулъя.

**П.Анужин:** Баярлалаа, Жавхлан сайдад баярлалаа. Тэр удахгүй өргөн баригдах Эрүүл мэндийг дэмжих сангаас сангийн зарцуулалтад тийм ээ нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг өргөн барих талаар бас Чинзориг сайд нэлээд ярьж байгаа. Энэ асуудлын талаарх ойлголт бол бас танд их сайн байгаа юм байна. Тэгэхээр энийг бол бас яаралтай оруулж ирэх нь олон өрхүүдийн тийм ээ, ялангуяа энэ хүнд өвчтэй ээж аав нарыг дэмжих бодитой алхам болох юм шүү. Тэгэхээр энэ хуулийг бас яаралтай шийдээж оруулж ирж байгаад бас

талархаж байгаагаа хэлье. Та гүйцээж хариулах юм уу тийм ээ, хариулт авъя.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Нэгэнт энэ сэдэв хөндөгдсөнийх би нэмэлт мэдээлэл өгөх гэсэн юм. Энэ жилийн манай төсөвт хамгийн том бүтээн байгуулалтын ажил яг төсөл төслөөр нь ярих юм бол эрүүл мэндийн салбарт байгаа шүү. Эрхтэн шилжүүлэх эмнэлгийг бид маш олон жил ярьсан. Монголдоо эмчилж чаддаггүй, бүрэн эмчилж чаддаггүй, манайх тэгэхдээ манай эмч, эмнэлгийн ажилтнууд болбол энэ төв Улаанбаатар хотын зарим поликлиник, клиник эмнэлгүүд маань эрхтэн шилжүүлэх, ялангуяа элэг шилжүүлэх мэс ажилбарыг бол маш амжилттай хийж байгаа.

Гэхдээ яг зориулалтын, яг олон улсын стандартад нийцсэн сайхан эмнэлэг бидэнд дутагдсаар л байгаа. Тийм бол бид сүүлийн 2 жил дамнаад энэ эрхтэн шилжүүлэх эмнэлгийн ТЭЗҮ-г маш сайн хийсэн. Ингээд нийтдээ 140 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий энэ эмнэлгийг ирэх жил 40 тэрбум төгрөгөөр эхлүүлнэ. Ингээд амжилттай хэдүүлээ хийгээд, 3 жилийн дараа ийм сайхан эмнэлэгтэй болно.

**С.Одонтуяа:** Нанзадын Наранбаатар гишүүн асууна.

**Н.Наранбаатар:** 2024 оны улсын төсвийг ерөнхийдөө хөдөөгийн хөгжлийг дэмжих, хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн гэж ойлгож байгаа. Тэгэхээр зэрэг энэ уул уурхайтай аймаг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг их хэмжээгээр төлж байгаа аймгийн хувьд энэ орж байгаа Орон нутгийн хөгжлийн санд хуваарилж байгаа энэ хэмжээг яаж нэмэгдүүлж байгаа вэ? Тухайлбал Өмнөговь аймаг өнгөрсөн жил энэ жилийнх дээр Орон нутгийн хөгжлийн санд хэд байгаад 24 оны ирэх жилийнх дээр хэд болж нэмэгдэж байгаа вэ? Энэ

уул уурхай түвшсэн энэ сумууд бол өнөөдөр ч тухайлбал Цогтцэций сум гэхэд сургууль ч хүрэлцээгүй, цэцэрлэг ч хүрэлцээгүй, цагдаа онцгой нь өөрийн байргүй, тоосжилтдоо дарагдсан ийм байдалтай л байгаа. Энэ дээр тодруулъя.

Мөн төрийн албан хаагчид энэ жилийн төсвөөс эхлээд орон нутгийн нэмэгдэл төрийн захиргааны албан хаагчид олгоод явж байгаа. Энэ их үр дүнтэй ажил болсон. Манай аймаг болбол энийг дэмжээд өөрийнхөө төсөвт тохируулаад бас тодорхой нэмэгдлүүдийг өгөөд, ингээд ажлын байрны сул орон тоонууд нөхөгдөөд, хөдөө сумдад нааштай үзүүлэлтүүд гарч ирж байгаа. 24 оны төсвийн төсөлд ТЗ дээр нэмээд ТҮ, улс төрийн албан тушаалтныг нэмж оруулж байгаа юм байна. Төрийн тусгай албыг нэмүүлж нэмж оруулах боломж байна уу? Боломжийг нь нээгээд өгчихвөл тийм, орон нутгийн нэмэгдлийг төрийн тусгай энэ цэрэг, цагдаа, энэ үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн ийм байгууллагуудыг нэмээд боломжийг нь нээгээд Төрийн албаны тухай хуульд оруулаад өгчихвөл бас зарим аймгууд нь ингээд бололцоондоо тулгуурлаад нэмээд цаашаа явах ийм боломж бол байна.

Дараагийн нэг асуудал энэ усны төслүүд дээр ерөөсөө төсөв хөрөнгө тавьсан юм би олж хараагүй. Нөгөө хөх морь, шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан Орхон, Онги, Хэрлэн, Тоонот төслүүдийг ирэх жил ер нь урагшилуулахад ямар төсөв хөрөнгө тавьж байгаа вэ?

Дараагийн нэг асуудал бол Улаанбаатар Даланзадгад чиглэлийн авто замын асуудал. Мидлингийн энэ нүүрсийг зөөж их хэмжээгээр эвдсэн. Аваар осол, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирох асуудал бол маш их гарч байгаа. Тэгээд ирэх жил болбол их засвар хийнэ гэж Зам, тээврийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайд бол мэдэгдэл хийсэн байгаа. Тэгээд энэ хэдий хэмжээний их засвар хийгдэхээр төлөвлөгдөж байгаа, эх үүсвэрийг нь

хаанаас шийдэхээр болж байгаа вэ гэсэн ийм асуудал байна.

Мөн Ерөнхий сайд орон нутагт ажиллахад Өмнөговь аймагт хөрөнгө оруулалтуудыг эрэмбэлсэн. Тэгээд манай аймагт болбол дулааны станцын асуудал их чухал тулгамдсан асуудал болчихоод байгаа юм. Тэгээд энэ дээр та бүхэн ямар төсөв хөрөнгө тавьж байна вэ?

Мөн Даланзадгадаас Гурвантэс сум хүртэлх 302 км замыг орон нутгийн хөрөнгө оруулалтаараа тавиад 160 км тавьчихаад байгаа. Тэгээд үлдсэн 160 км-ийн 80-ыг нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар, 80 км-ийг нь энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тавихаар ярьсан. Тэгээд энэ дээр ямар төсвийн хөрөнгө тавьж байгаа вэ гэсэн энэ асуултууд дээр хариулт аваад, дараа нь тодруулъя.

**С.Одонтуяа:** Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Өмнөговьчууддаа бид талархах ёстой. ЗГ-ын шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутгийн хөгжлийн энэ сэргэлтийн бодлого дээр маш том ахиц гаргаж, бусад аймгуудаа манлайлж үлгэр жишээ үзүүлж ингэж явж байгаа. Энэ дундаа орон нутгийн энэ нэмэгдлүүдийг бид энэ жилээс орон нутгуудад нь өөрсдөд нь эрх мэдлийг нь хариуцлагатай нь цуг өгсөн. Энэ хүрээнд орон нутгийн нэмэгдлийг тултал нь 80 хувиар нэмэгдүүлж, үндсэндээ 100 хувиар, төсвөөс шийдсэн 20 хувь ингээд 100 хувиар шийдсэн нь болбол маш талархууштай. Тийм учраас Өмнөговьд ажиллаж байгаа төрийн албан хаагч нар бол ажлынхаа байр энэ бүх зүйл дээр бол тогтвор суурьшилтай орон нутгийн ард иргэддээ төрийн үйлчилгээг маш чанартай, хүртээмжтэй хүргэх дээр бол 100 хувь нөхцөл бололцоо нь хангагдаж байгаа юм.

Төрийн тусгай гэлээ та. Төрийн тусгайгийнхан маань энэ нэмэгдлүүд нь

бол бүүр өмнө нь аягүй сайн нэмэгдчихсэн, хамгийн өндөр нэмэгдлүүд авдаг. Тийм. Тийм учраас одоо та яг өөрийнхөө аймгийн жишээгээр бас харж болохгүй. Танайх нөгөө 100 хувь тавьчихаар бусад яах вэ зарим нэг төрийн ТТ-нээс өндөр болчихож байгаа байх. Бусад аймгууд дээр чинь бол тийм биш шүү. Тийм учраас бас энэ зовлонг та ойлгоорой. Төрийн тусгай гэж ярих юм бол төрийн тусгай дотроо бүүр ийм юм байгаа шүү дээ. 5 жил тутам ТЗ-нүүд чинь 6 сарынхаа нэмэгдлийг авдаг, 6 сарын нэг удаа. Гэтэл ТТ-нүүд чинь 30 сарынхыг авдаг шүү дээ, 5 жил тутам 30 сарын нэмэгдэл авдаг. Энэ дотор манай гаалийнхан болбол ТТ мөртөө энд хоцорчихсон нэг ч нэмэгдэл авдаггүй. Яагаад гэвэл сайд нь хөөцөлддөггүй юм шиг байсан юм, одоо би ч гэсэн хөөцөлддөггүй байсан юм шиг байгаа юм. Энэ удаа харин дагасан хууль дээр ядаж 30 биш ээ 6 биш ТТ рүүгээ жсоохон ойртуулаад 12 сараар ядаж олгоё гээд ийм өөрчлөлт орж ирсэн байгаа. Та тэрийг бас л ТТ юм чинь дэмжиж өгөөрэй.

Тэр замын эх үүсвэр бол ийм байгаа шүү. Дэлхийн банкны 100 сая долларын эх үүсвэрийг бид бүгдийг нь зам засвар луу оруулж байгаа. Энэ дотор батлагдаад ороод ирэхээр ажлуудаа яаж хуваарилахыг болбол Зам, тээврийн сайдын тушаалаар ингээд явна. Тэрэн дотор танай энэ зам бол орчихсон яваа. Яг тодорхой төслүүд нэр зааж асуусан тэрэн дээр Чимидсүрэн дарга мэдээлэл өгөөдөх.

Орон нутгийн хөгжлийн сан ингэж байгаа шүү Наранбаатар гишүүнээ. Өмнөговь аймагт дээд тал нь л 28,7 тэрбум төгрөгийн дэмжлэг очдог байсан, ирэх жил 45,6 тэрбум төгрөг очно. Хуучин зарчмаараа явсан бол энэ 28-аараа л байх байсан. Ирэх жил бид нэлээн том бодлогын шилжилт хийж байгаа. Юу вэ гэвэл яг амнат төлдөг, төвлөрүүлдэг өөрөөр хэлбэл уул уурхайн эргэлтэд аль болох түлхүү оруулж байгаа аймгууд маань түлхүү авна энийгээ. Ийм шинэ

зарчим руу орж байгаа шүү. Жишээ нь Эрдэнэт байна. Манай Эрдэнэт өнөөдрийг хүртэл номер нэг улсын төсөвт төвлөрүүлдэг уул уурхайн ийм аймаг байсаар л байгаа. Гэтэл хамгийн өндөртөө 9,8 тэрбум төгрөг авч байсан, ирэх жил бүүр 30 тэрбум авна. Энэ нь өөрөө бас ингээд итгэлцүүр коэффициенттой томъёоллоороо явчихна. Шинэ томъёогоор бодогдож байгаа гэсэн үг. Тэгэхээр танай аймаг дээр бол ийм том Орон нутгийн хөгжлийн сан очих нь. Тийм учраас цаашидаа ч гэсэн энэ уул уурхайгаа дэмжиж байгаа, илүү эргэлтэд оруулж байгаа, улсын төсөвт илүү их мөнгө төвлөрүүлж байгаа энэ эргэлтээ улам сайн дэмжээрэй. Тэгээд амжилт хүсье.

**С.Одонтуяа:** Наранбаатар гишүүн тодруулъя.

**Н.Наранбаатар:** Энэ усны төсөл асуусан ерөөсөө усны төсөл дээр юу байхгүй байгаад байгаа. Ямар нэгэн төсөв тавигдсан юм байхгүй байгаад байгаа. Тэгээд тэр баруун тийшээ явсан зам, ДЦС-ын асуудал байгаа. Дээрээс нь нэмээд нэг зүйл тодруулаад асуухад энэ төвлөрлийг сааруулахад хөдөө орон нутагт хүмүүсийг шилжүүлж ажиллахад болбол энэ цалингийн асуудал бол чухал. Энэ дээр тодорхой арга хэмжээ аваад, орон нутгийн нэмэгдэл гээд ингээд цалингийн нэмэгдэл гээд явж байна. Нөгөө нэг асуудал нь аймгийн төвд сумд хүн очоод ажиллахад орон сууцын асуудал их хүндрэлтэй байгаа, хүрэлцээ хангамж. Тийм учраас энэ хөдөө орон нутагт барьсан орон сууцын ААН-үүдэд ямар дэмжлэг байгаа юм бэ? Аймаг, сум өөрөө орон сууцын ямар нэгэн хөтөлбөр хийгээд хэрэгжүүлэхэд улсын төсвөөс дэмжлэг үзүүлнэ гэсэн байгаад байгаа юм энэ төсвийн төсөл дээр. Энийгээ тодруулаач, ямар яг бодитой дэмжлэг үзүүлэх юм бэ?

**С.Одонтуяа:** Жавхлан сайд хариулъя. Дараа нь 81 Түвдэндорж дарга нэмж хариулна. Хэлчихсэн шүү дээ,

Жавхлан сайд. Та өнөөдөр микрофоноо бүр гацтал ярьсан байна.

**Б.Жавхлан:** Энэ Оюунчимэг гишүүнийг асаачих уу?

**С.Одонтуяа:** Таных асчихлаа.

**Б.Жавхлан:** Наранбаатар гишүүн ер нь ганц ч гишүүн асуугаагүй. Гэхдээ маш чухал асуулт тавилаа. Орон нутгийг орон нутагт орон сууцжуулах хөтөлбөрийг ирэх жилээс нэлээн тийм дорвитой бодит үр дүн гарсан ийм хэлбэр лүү явуулах гээд хичээнэ. Бид өнөөдрийг хүртэл орон нутагт орон сууцжуулах бол нэлээн л янз янзын л юм явуулсан. Ипотек гэж орон нутаг руу нэлээн чиглүүлж байгаа. Тэгэхээр худалдан авах талаас нь хэдүүлээ ингээд орон нутаг руу ингээд 20 хувь, 40 хувь, танай аймаг дээр бол бүүр ингээд 100 хувь ингээд дэмжээд явчихсан. Худалдан авах тал нь ингээд нэлээн сайжирчхаж байгаа юм. Тэгвэл нөгөө талаасаа ипотека болон газар, дэд бүтэц ийм асуудлууд үлдэж байгаа юм. Аймаг болгон, сум болгон асуудлууд нь өөр өөр байгаа. Өөр өөр байгаа. Тийм учраас бид энэ дээр 100 тэрбум төгрөг багцаар нь энэ жилийн төсөв дээр оруулсан байгаа шүү. Ингээд би батлагдмагц бид бүүр аймаг бүрээр нь, сум бүрээр нь судалгаа хийж байгаад өөр өөр байдлаар, өөр өөр схемээр хөтөлбөр гаргана, хөтөлбөр гаргана. Тэгээд энэ 100 тэрбум төгрөгийг ер нь бол голцуу дэд бүтэц рүү байгаа, голцуу дэд бүтэц рүү. Тэгээд зам юуны тэр газрын асуудлыг бол орон нутаг өөрсдөө шууд хариуцах ёстой. Газар чөлөөлөлт байна уу, тэр газар шийдэх ямар бүгдийг нь орон нутаг өөрсдөө хариуцах ёстой. Энэ дээр нэлээн хариуцлага хүлээх ёстой орон нутаг. Тэгээд бусад асуудлуудыг нь бүгдээрээ аймаг бүр дээр, сум бүр дээр тохируулж энэ асуудлуудыг шийднэ.

Өөрөөр хэлбэл тэнд барилгын компаниуд барилга бариад, ашигтай ажиллаад, тэгээд орон нутгийнханд ээлтэй байдлаар ийм санал болгох ийм

бизнесүүдийг нь дэмжиж өгөх ийм схемээр ерөнхий байдлаар явна гэсэн үг. Одоо ингээд төсвөө бид нар өргөн барьснаас хойш манай яамнаас, БХБЯ-наас хүмүүс гаргаад бид сум болгоноор ингээд хэд хэдэн ийм төсөл хэрэгжсэн сумуудаар багууд явуулж байгаа. Ингээд нэлээн бас бид нарын бас тооцоолж байсан, бодож байснаас нэлээн өөр өөр дүр зургууд гарч ирж байна. Тийм учраас их байгаа зөв оносон, энэ тийм сайн үр дүнгээ гаргасан ийм ажлууд руу хэдүүлээ ирэх жил яваад орчихъё л гэж бодож байгаа.

**С.Одонтуяа:** Хэн Түвдэндорж дэд сайд хариулъя, дараа нь Байгаль орчны дэд сайд Ганбаатар.

**Г.Түвдэндорж:** Тийм, юу тэгэх үү, за. Байгаль орчны яам хариулчихъя.

**С.Одонтуяа:** 1 дүгээр микрофон дээр очоод хэлчих.

**М.Ганбаатар:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Байгаль, БОАЖЯ-ны жуулчлалын сайдын багцад бол Ганга нуурын бохирдол, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат буюу 2024, 2025 онд 3 тэрбум төгрөг, санхүүжилтийн дүн 1,5 тэрбум төгрөг. Хэрлэн голыг бохирдол, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төсөл Хэнтий аймагт, Өгий нуурын бохирдол, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат Архангай аймагт тус тус 3 тэрбум төгрөгийн 2 он дамжсан төсөвтэйгөөр 1,5, 900, 1,5 гэсэн ийм төсвийг суулгаж өгсөн байгаа.

**С.Одонтуяа:** 86 Чимидсүрэн дарга.

**Ч.Чимидсүрэн:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Усны төслүүд бол ер нь бол нийтээрээ нэлээн том төсөл байгаа. Тэгээд энэ дээр болбол улсын төсвөөр 24 онд бол тавигдаагүй, ер нь болбол цаашидын төр хувийн хэвшлийн

түншилэл илүү тийм тодорхой болгох шаардлагууд бол бас байгаа.

Улаанбаатараас Даланзадгад явах замтай холбоотой асуудлыг бол сайд хариулсан. Түрүүний Дэлхийн банкны санхүүжилтээр 100 сая доллароос болбол шийдвэрлэгдэнэ гээд. Дулааны станцын асуудал дээр болбол бид ТЭЗҮ, зураг төсөв тавихаар болбол жагсаалтад болбол оруулж байгаа. Зүгээр энийг ер нь цаашид болбол төр хувийн хэвшлийн түншилэлээр хэрэгжүүлэх ийм чиг барих нь зөв байх. Даланзадгадаас Гурван тэс явах замын асуудал дээр болбол 80 км-ийг бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бол шийдвэрлэе гэж байгаа. Түүний 10 км-ийг нь болбол 24 оноос ингээд хэрэгжүүлээд явна. Нийт төсөвт өртөг нь бол 16 тэрбум, түүнээс 24 онд санхүүжих дүн нь болбол 8 тэрбум төгрөг байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Түвдэндорж хариулах уу? Гантөмөрийн Түвдэндорж 81 Эдийн засаг хөгжлийн дэд сайд.

**Г.Түвдэндорж:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Орхон Онги төсөл, Хэрлэн Тоонот төсөл усны маш чухал манай улс орны бас ийм 2 том төсөл байгаа. Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан ийм төслүүд байж байгаа. Тэгээд энэ 2 төсөл маань болбол Байгаль далай Юнескод бүртгэлтэй, тэгээд энэ хилийн усны хэлэлцээрийн 2 орны ЗГ хоорондын хэлэлцээрээр шийдэгддэг маш их хэцүү ийм төвөгтэй үе шатуудыг бас ингээд туулж явдаг ийм хэцүү төслүүд байж байгаа, хэрэгжихэд маш хэцүү. Зөвхөн манай Монголын тал ЗГ шийдвэрээ гаргаад шийдчихэж болдоггүй ийм асуудлууд байж байгаа. Тэгэхээр цаашид ер нь Орос, нөгөө талдаа санал төслөө урагшлуулахын тулд болбол бид болбол Байгаль орчны хүрээлэн буй орчны судалгааны төслийг болбол хэрэгжүүл.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Энхтүвшин гишүүн байгаа юм биш шүү.

Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн.  
Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Чухал асуудал учраас бас протоколд тэмдэглэгдэх байх, заавал асуух хэрэгтэй байна. 2 асуудал хоёулаа үндэсний аюулгүй байдалтай холбоотой ийм 2 асуудлыг асуумаар байна төсөвт хэрхэн туссан юм бэ? 1 дүгээрт газар хөдлөлтийг, газар хөдлөлтөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал дээр ер нь ямар бодлого барьж байна вэ? Энэ дээр мөнгө төгрөг төсөвлөх гэж байна уу?

2 дугаарт энэ хар тамхи мансууруулах бодис хэрэглэхтэй тэмцэх асуудал байгаа. Мэдээж энэ болбол яг хэдэн төгрөг суух, яах ийх нь бол Тусгай хяналт хяналтын дэд хороогоор хаалттай нууц хэлэлцэх учраас зүгээр ер нь энэ дээр юм тавьсан юм уу, үгүй юү гэдгийг бас сонсмоор байна. Миний ер нь ажлын арга барил бол би нэг цагийг нь тулгачхаад л төсөв рүү шахаад байдаг ийм бол арга барилтай хүн бол биш. Би болбол олон сарын өмнөөс судалгааг нь хийсэн, Байнгын хороод дээр асуулгуудыг нь тавьсан, энэ дээр энэ судалгаа дээрээ үндэслээд зайлшгүй арга хэмжээ авах ёстой гэхээр би холбогдох хүмүүст бүгдэд нь албан бичиг явуулсан байгаа. Энэ 2 асуудлаар би Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 гишүүнд бүгдэд нь явуулсан. Хэн Сангийн сайдад явуулсан. Дараа нь бүгдтэй нь нэг бүрчлэн уулзсан байгаа. Одоо болбол энэ шийдэхгүй болбол бас болохгүй. Энэ бол бас энэ 24 оны төсөв учраас.

Тэгэхээр би энэ асуудлыг яагаад ингээд авч үзээд байгаа юм бэ гэхээр энэ өөрөө их ноцтой хэмжээнд оччихсон байгаа байхгүй юу. Бид нар газар хөдлөлтийн асуудлыг хаалттай хэлэлцэхэд үнэхээр манай улс бол энэ газар хөдлөхөд бол баларна. Маши олон сургууль, цэцэрлэг нурвал яах вэ? Бид нар нэг хүүхэд амиа алдахад бүгдээрээ л одоо яана ийнэ гэж байна. Газар хөдлөхөд бол Туркийн та нар жишээг мэдэж байгаа шүү дээ. Дэлхийгээрээ уйлаад ч энэ хүүхдүүдийн

амийг босгож чадахгүй. Тэгэхээр маш олон хүн аюулд эрсдэх учраас энэ дээр ер нь арга хэмжээ авах юм уу яах юм бэ?

2 дахь нь бол энэ хар тамхины асуудал байгаа. Хар тамхи бол өнөөдөр үнэхээр Монгол Улсад маш ноцтой түвшинд хүрсэн. Монгол Улс бол зүгээр дамжуулдаг орон байснаа одоо бүүр хэрэглэгч орон болсон. Судалгаагаар 7-хон жилийн дараа 2030 он гэхэд энэ хэрэглэж байгаа байдал 43 хувиар өснө гэсэн ийм судалгаа байна. Тэгэхээр бид 43 хувиар өсгөх биш, 43 хувиар ядаж буулгачхаад сууж байх ёстой. Нэг боломжтой тал нь юу вэ гэхээр Монгол Улс өөрөө үйлдвэрлэгч орон биш, хэрэглэгч орон учраас яг хил дээр орж ирэхэд нь энэ крантуудыг бүгдийг хаах ёстой. Яг ингээд ажиллая гэхээр энэ дээр ажилладаг бүтэц орон тоо хангалтгүй байна, төсөв хөрөнгө хангалтгүй байна. Тийм учраас би та нарыг зүгээр ирээдүй үр хүүхдээ бодоод энэ үндэсний аюулгүй байдал, удмын сан олон зүйлийг бодоод энэ дээр нэг онцгой анхаараад өгөөч гэж Жавхлан сайдад хэлмээр байна. Тэгээд энэ Тусгай хяналтын дэд хороогоор орохоор өмнө нь яригдаагүй, номд ороогүй гээд хасагдчих болов уу гээд би зүгээр санаа зовж байна л даа. Энэ бол маш ноцтой асуудал шүү. Тэгээд энийг болбол би бол протоколд тэмдэглүүлнэ. Чадах өөрийнхөө зүгээс чадах бүх юмаа хийсэн, тэгээд одоо чадахгүй бол тэгээд улс төрөө л хийнэ гэж бодож байгаа шүү.

2 дугаарт энэ газар хөдлөх асуудал дээр Сайнзориг дарга та нэг анхаараад өгөөрэй. Би БГД-ийн хэд хэдэн барилгыг энэ газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх дээр төсөв хөрөнгө тавьж өгөөч, ядаж нэг хэдэн байруудыг нь хэмжилт хийлгээ гэсэн. Энэ болбол заавал нийслэлийн төсвөөр хийх ёстой гэсэн учраас нийслэлийн төсөв энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй. Сая үер болоход бид нар яаж сандарцаав ийм асуудал байна. Минут дуусчихлаа, хариултаа авч байгаад яая даа нэмэлт.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ?  
Болдын Жавхлан сайд хариулна.

**Б.Жавхлан:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Бид энэ дээр Гамшигаас хамгаалах хуультай, хуулийн дагуу энэ асуудал дээр тухайн байгууллага өөрөө энэ асуудлыг шийддэг. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүх юмаа оруулаад, байгууллага нь өөрөө дийлэхгүй өндөр эрсдэлтэй гэвэл сум дүүрэг нь, сум дүүрэг нь дийлэнхгүй болбол аймаг нь улс шийддэг ийм дэс дараатай явдаг ийм юм байгаа юм. Улсын онцгой комисс, улсын онцгой Онцгой байдлын ерөнхий газар гээд ийм байгууллагууд энэ нэг асуудлаа хариуцаад, тодорхой хэмжээний төсөв нөөцлөөд ингээд явдаг. Дээрээс нь яг ийм асуудал руу тухайлан зориулсан ЗГ-ын нөөц хөрөнгө гэж байгаа. Энийг бид нар жил ирэх тусам нэмээд ингээд явж байна. Энэ жил, хойтон бид нар 80 тэрбум. Өмнө нь болбол 30 тэрбум, 40 тэрбум гэж явдаг байсан. Ингээд энэ төсөв болбол зориулалтаараа үндсэндээ яг таны хэлж байгаа ийм эрсдэл рүү чиглүүлэх ёстой юм байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол бас улс ЗГ төсөв онцгой анхаарч ингээж явж байгаа гэдгийг хэлье. Би зүгээр мэргэжлийн дагуу дутуу юм хэлж байвал ОБЕГ-аас хүмүүс байгаа нэмж хариулаарай. Ер нь бодлогын хувьд та нар ямар тактиктэй ажилладаг юм бэ, ямар нөөц боломжууд байдаг юм бэ, боловсон хүчнүүд нь ямар байдаг юм гээд. Ялангуяа Одонтуяа гишүүний асууж байгаа зүйл болбол тэр урьдчилан сэргийлэх, урьдчилж тооцоолох, яаралтай иргэний хамгааллын чиглэлээр хариу арга хэмжээнүүд авах гээд ийм чиглэлээр хариултуудыг нэмж хэлээрэй.

Тэр мансууруулах, энд үнэхээр ард иргэдийн бидний сэтгэл эмзэглүүлсэн ийм асуудал. Энэ дээр мэргэжлийн байгууллага нь илүү тодорхой хариулбал зөв байх. Зүгээр энэ төсөв дээр бол юу гэдэг юм тусгайлсан хөрөнгө оруулалт байшин барилга гэж бол энэ дээр байхгүй. Бодлогын арга хэмжээ тийм ээ, соён

гээгээрүүлэхээс эхлүүлээд, хууль хяналтын байгууллагууд яаж энэ дээр чиглэл барьж байна вэ гээд ингээд салгаад ярих нь зөв болов уу гэж ингээж бодож байна. Тийм. Эрүүл мэнд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Тэгэхдээ нөгөө таны ирүүлсэн бичиг Тусгай хяналтын дэд хороонд хуваарилчихсан байгаа. Тэгэхдээ та нөгөө зөвхөн Тагнуулын ерөнхий газрын хар тамхитай тэмцэх ажлыг л яачихсан байна лээ. Цагдаагийн ерөнхий газар дээр хар тамхитай тэмцэх том тасаг, бүрэлдэхүүн байгаа. Тийм. Тэрнийг уул нь бараг Сайнзориг хариулчихмаар л юм байна. 1 номер Сайнзориг, 1 номер дээр хариулъя.

**П.Сайнзориг:** Одонтуяа даргын асуултад хариулъя. Нийслэлийн иргэдийг бас болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх энэ ажлыг бас тогтмол хийх, эргээд бас энэнээс зарлан мэдээлэх гэдэг юм уу, урьдчилан сэргийлэх, соён гээгээрүүлэх ажил дээр бас тодорхой ажлууд бол явдаг. Би бас яг надад байгаа мэдээллээр бас нийслэлийн хэмжээнд бас энэ газар хөдлөлтийн бүсэд байгаа барилга байгууламжийн бас нөхцөл байдлыг бас дүгнэж, тодорхой бас судалгаанууд хийгдсэн гэдэг ийм мэдээллүүд байгаа.

2 дугаарт бас үерийн барилга байгууламж буюу энэ далан шуудууг бас засварлах, эргээд энэ оновчтой төлөвлөх энэ асуудал дээр бас нийслэлээс бас чиг үүрэг нь оногдож байгаа. Энэ хүрээндээ бас ирэх жилийн төсөв дээр бас 15 тэрбум орчим төгрөгийг бас энд зарцуулахаар бас ингээд төлөвлөөд явж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Хар тамхитай зүйл дээр би зүгээр бас өмнө нь ажил хариуцаж явсны хувьд бас хэлье. Өнөөдөр бас ХЗДХЯ-наас бас яг энэ чиглэлийн хуулийн шинэчилсэн найруулгыг бас яамнуудаас санал авахаар бол гаргасан.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Салдангийн Одонтуяа гишүүнээр тасаллаа. Салдангийн Одонтуяа гишүүн үг хэлнэ.

**С.Одонтуяа:** Тэгэхээр ерөнхий төсөв дээр түрүүн Жавхлан сайд хэлсэн л дээ. Энэ НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн илтгэл дээр ингээд ДНБ-ий 76,2 хувьтай тэнцсэн гээд судалгаа байна гээд түрүүн манай гишүүд асуусан, тэгээд та үгүй ээ энэ олон улсын аргачлал нь өөр юм гээд. Ер нь бол бид нар аль болохоор энэ бүх зүйл дээр энэ олон улсын аргачлалаараа л цаашидаа явдаг байвал зүгээр байх. Жишээлэхэд тэр шүүхийн шийдвэргүй баривчилгаа гээд л тэгэхэд НҮБ-ынхан өөр аргачлалаар тооцчихсон байна лээ гээд л ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол цаашидаа бас энэ юугаараа олон улсын аргачлалаараа тооцоод явах нь зүйтэй гэж бодож байна.

Ер нь бол би зүгээр энэ төсвийг нэлээн сайн үзлээ. Ер нь бол аливаа улсын төсвийг ингээд шинжлэхэд 4 дүрмийг би бас харсан. Жишээлэхэд өрийн дүрэм, төсвийн тэнцлийн дүрэм, төсвийн орлого зарлагын дүрэм. Тэгэхээр энэ бусад орнуудад энэ төсвийн орлогын дүрэм дээр бол энэ татварын хэт ачааллаас бас урьдчилан сэргийлэх асуудлыг нэлээд анхаардаг. Тийм учраас энэ бусад орнуудын төсөв бол энэ татварын дарамтаас бол нэлээд ангид байгаа юм. Тэгэхээр би энэ төсвийн орлогын бүрдүүлэлтийг харсан чинь 21 онд 91,2, 24 онд 92,9 хувь нь татварын орлогоос бүрдэнэ гэж байгаа юм. 12,6 их их наядаар 3 жилд ААН иргэдийн татвар нэмэгдчихсэн байгаа байхгүй юу. Нэмэгдэхээр байгаа. Тэгэхээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ татварын дарамт бол үнэхээр их байна. Тэгэхээр тэр яах вэ та нэгэнтээ төсөв өргөн барьчихсан байсан учраас бас тэр НӨАТ-ын 5 хувь дээр нэлээд эмзэглэж байгаа байх. Ер нь болбол бид нар энэ НӨАТ-ын 5 хувь руу буцаан олголт руу явах нь бол би зүйтэй л гэж үздэг. Яагаад гэхээр 16 онд

бас анх энэ ажлын хэсэгт бол би ороод ажиглаж байсан.

Тэгэхээр аль болохоор иргэдийн татварын дарамтыг л багасгаж байх нь чухал гэж үздэг байхгүй юу. Гадуур явахад бүгд НӨАТ-тай баримт авах уу НӨАТ-гүй авах уу гээд л асуудаг, дахиад л далд эдийн засаг үүсчихсэн. Тийм учраас 2 хувьд хүмүүс цочрохоо больчихсон учраас дахиад 5 хувь руу очвол энэ нийт татварын сууриараа энэ таны энэ санаа зовоод байгаа 600 байтугай тэрбум би нөхөгдөх байх гэж үздэг юм.

Хэт тэлсэн төсвийн зарлагууд байна. Жишээлэхэд 3 жилд гэхэд л 13,5 их наядаар төсвийн зарлага нэмэгдсэн байна, хөрөнгийн зардал бас ингээд дандаа даблдчихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр энэ түрүүний тэр төсвийн зарлагын дүрмээр бусад оронд бол ингээд л 2 хувиар, 3 хувиар, 4 хувиар гээд л өсөж байтал манайд бол дандаа ингээд зарлага чинь 2 дахин, 2 дахин ингээд сүүлийн үед явчихсан байна л даа. Тэгэхээр аль болохоор энэ ард иргэдийн нуруун дээр үүрэгдэх энэ зарлага төсвийн алдагдал бол уг нь буурвал зүйтэй юм уу л гэж үздэг. Тэгээд бид хэдийгээр ийм их орлого олж байгаа ч гэсэн энэ нь эргээд ард иргэдийн тэр ачааллыг бууруулахгүй. Татварын орлого нь улам нэмэгдэж байгаа бол бараг ер нь энэ байгалийн баялагтай байсны ид шид гарах уу үгүй юу? Сая би бас БГД дээр иргэдтэй уулзсан. Үнэхээр өргүй айл алга, маш хэцүү байна бид нар тартагтаа тулж байна, хэдэн хүүхэд байгаа учраас л тэжээж байна, тэрнээс биш ямар ч амьдралд хүрэхгүй байна гэсэн ийм гомдол болбол бүх хороон дээр болбол байна. Тийм учраас бид энэ татварын орлогыг нэмэх, энэ их 2 их наядын алдагдалтай төсөв батлах тэр дээр бол би бол шүүмжлэлтэй хандаж байна. Ийм дүгнэлт хэлэх гэсэн юм.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Төсвийн төсөл Монгол Улсын Их



Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д заасан шаардлага хангасан талаар санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлдье. Одоо санал хураалт явуулна. Хэлэлцэж байгаа асуудлыг дундаас нь зогсоох дэг байхгүй. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д заасан шаардлага хангасан талаар санал хураалт явуулна. Санал хураалт. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д зааснаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлага хангасан байна уу, хангаагүй байна уу гэсэн санал хураалт явуулдаг дэгтэй болчихсон. Санал хураалт явуулах уу? Хэрвээ санал хураалтаар дэмжигдэхгүй бол Төсвийн төслийг буцаана. Санал хураалт. 8 гишүүн дэмжиж, 84 хувийн саналаар Төсвийн төслийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангаагүй байна гэж үзлээ.

Ингэхээр чинь дэгээрээ яах билээ? Таны баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар чинь буцаах болно тийм ээ. Төсвийн байнгын хорооны дарга яах юм бэ? Горимын санал гаргах хүн байна уу? Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Өнөөдрийн чуулган нэлээн уртасгасан цагаар суулаа. Өнөөдөр хамт байж, бид жилдээ нэг л удаа ингэж төсвөө ирэх жилийнхээ төсөв, эдийн засгийн чиг хандлага, энэ бүх юмаа ингэж ярьдаг. Энийг ард түмэн хүлээж суудаг. Эндээс бүх мэдээллээ авч, ирэх жил амьдрал ахуй, бизнесийн орчноо төлөвлөдөг, төсөвлөдөг ийм үйл явц. Тэгээд өнөөдрийг хүртэл одоо хэдэн цаг болж байна вэ энэ чинь? 9 цаг болтол тийм цуг байсан гишүүддээ талархлаа. Гэхдээ яг одоо санал хураах мөчид зааланд яг 8 гишүүн л яг кноп дээрээ байна.

Тийм учраас маргааши үргэлжлээд явах учраас өглөө ирц бүрээд, ирц бүрдээд,

маргаашийн чуулган эхлэхэд санал хурааж өгнө үү гэсэн ийм зарчмын горимын саналтай байна. Их Хурлын даргаа уучлаарай.

**Г.Занданшатар:** Өлзийсайхан даргаа энэ дундаас нь хойшлуулж болох ямар дэг байна вэ? Горимын санал хураана шүү дээ, горимын санал хураалт явуулахаар энэ чинь.

**Л.Өлзийсайхан:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69.7-д энэ хуулийн 69.5-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол Төсвийн төслийг ажлын 3 өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч, Засгийн газарт буцаана гэсэн ийм заалт байгаа.

**Г.Занданшатар:** Төсвийн байнгын хорооны дарга, аудитын дарга. 21 цаг болсон байна. Ингэж сунгаж хуралдах санал хураалт явуулаагүй байна. Тийм учраас ингээд маргааши өглөө хүртэл Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг хойшлууллаа. Сунгах цаг өгөөгүй учраас энийг ажлын цаг дууссан учраас хойшлууллаа. Маргааши өглөө санал хураалт явуулна. Маргааши өглөө 10 цагаас санал хураалт явуулна.

20.59 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

